



Техникийн туслалцааны зөвлөхүүдийн тайлан



ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

ЭЦСИЙН ТАЙЛАН

Төслийн дугаар: ТА6618

Огноо: 2023 оны 2 дугаар сарын 14-ний өдөр

МОНГОЛ УЛСАД ЦАХИМ ХУДАЛДААНЫ ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ НЬ



Төслийн 1 дэх үр дунгийн тайлан: Цахим худалдааг оновчтой, үр ашигтай явуулахад учирч буй эрх зүйн болон зохицуулалтын саад бэрхшээлийг тодорхойлж, сайжруулах талаарх зөвлөмж боловсруулах

Боловсруулсан:

- Жон Д.Грегори – олон улсын зөвлөх, Канад Улс
- Анбатын Дэлгэрмаа – дотоодын зөвлөх, Монгол Улс

Хүлээн авагч:

Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яам

Энэхүү зөвлөхийн тайлан нь АХБ болон Монгол Улсын Засгийн газрын байр суурийг тусгах албагүй бөгөөд АХБ болон Монгол Улсын Засгийн газар нь уг тайланд туссан зүйлийн төлөө хариуцлага хүлээхгүй.

Asian Development Bank

Азийн Хөгжлийн Банк

Төслийн дугаар: ТА6618

Огноо: **2023 оны 2 дугаар сарын 14-ний өдөр**

Зөвлөхүүд:

Жон Грегори (олон улсын зөвлөх) - худалдаа, технологийн хуульч, Канадын Онтарио хотод 30 гаруй жил мужийн Засгийн газрын хууль тогтоомжийг боловсруулсан, цахим харилцаа холбооны хууль тогтоомжийн чиглэлээр Канадын тэргүүлэх шинжээч. НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (UNCITRAL)-т цахим худалдааны ажлын хэсэг дэх Канадын төлөөлөгчөөр 16 жил ажилласан. 2016 онд Засгийн газраас тэтгэвэрт гарснаасаа хойш НҮБ-ын Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP), Төв азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээлэн зэрэг Азийн орнуудад болон АХБ-нд энэ чиглэлээр зөвлөхөөр идэвхтэй ажиллаж байна.

Анбатын Дэлгэрмаа (дотоодын зөвлөх) нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх албан ёсны зөвшөөрөлтэй, өмгөөллийн Монголиан легал эксперты ХХН-д гүйцэтгэх захирал, хуульч, өмгөөлөгчөөр ажилладаг. Үндэсний болоод олон улсын түвшинд эрх зүйн салбарт хуулийн зөвлөх, судлаачаар 20 орчим жил ажилласан туршлагатай мэргэжилтэн. Монгол Улсын яамдын захиалгаар хуулийн төсөл боловсруулах, судалгаа хийх чиглэлээр АХБ-ны санхүүжилттэй олон төслүүдэд зөвлөхөөр ажилласан арвин туршлагатай. Тодруулбал, барилга, хот байгуулалт, төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын зэрэг хэд хэдэн салбарын хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажилд мэргэжлийн зөвлөхөөр оролцож ажилласан.

АХБ-НЫ МОНГОЛ УЛС ДАХЬ ТӨСӨЛ

ТӨСЛИЙН 5 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ҮР ДҮН: ЭЦСИЙН ТАЙЛАН

Зохиогчид Жон Д.Грегори, Анбатын Дэлгэрмаа

2023 оны хоёрдугаар сарын 14

ТОВЧЛОЛ	6
ОРШИЛ	7
I. ЦАХИМ ХУДАЛДАА ГЭЖ ЮУ ВЭ?	10
А.Олон улсын тодорхойлолт	10
Б. Цахим харилцааны мөн чанар	12
В. Цахим худалдааны бизнес гэж юу вэ?	14
II. ЦАХИМ ГҮЙЛГЭЭНИЙ ХУУЛЬ	15
А. Цахим гүйлгээ	15
Б. Цахим гарын үсэг	18
1.Тоон гарын үсэг	24
2. Итгэлцлийн үйлчилгээ	25
3.Гадаад улсын гарын үсэг ба гэрчилгээ	26
В. Цахим худалдааны хуульд оруулж болох бусад асуудал: олон улсын жишиг загварууд	27
Г. Цахим худалдааны хуульд тусгаж болох бусад асуудал:	29
Монголын талын санал	29
III. ЦАХИМ ГҮЙЛГЭЭГ АШИГЛАХ	30
А. Хувийн хэвшил	30
Б.Төрийн байгууллагуудын хүрээнд	32
1. Нэг цонх	32
2. Төрийн үйлчилгээний цахим портал	34
В. Гаалийн байгууллага ба хил дамнасан цахим худалдаа	36
1. “De minimis” дүрэм	36
2. Цахим худалдааны тогтолцооны зарим жишээ	38
3. Биет бус хөрөнгө	39
4. Гарал үүслийн гэрчилгээ	44
IV. ОЛОН УЛСАД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ БА БОЛОМЖ	45
А. Цахим худалдаанд нөлөөлөхүйц худалдааны гэрээ	45
1. Одоо Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэлэлцээр	47
Б.Бус нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ	48
1. Одоо Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа нь	49
2. Монгол Улсын нэгдэж болох бус нутгийн худалдааны хэлэлцээрүүд	49
В. Цахим худалдааг өөрийг нь хөгжүүлэхэд шууд чиглэсэн гэрээ, хэрэгсэл	50
1. Монголд одоо байгаа цахим худалдааны хэрэгслүүд.....	50
а. Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай НҮБ-ын конвенц	50
б. TIR картын дагуу барааг олон улсын тээвэрлэх тухай гаалийн конвенц	51
2. Хэрэглэж болохуйц цахим харилцаа холбооны хэрэгслүүд.....	51
а. Цахим худалдааны тухай ДХБ-ын хамтын санаачилга.....	51
б. Цахим худалдаа болон цахим гарын үсгийн талаарх UNCITRAL-ын загвар хуулиуд...51	
в. UNCITRAL-ын Цахим шилжих бүртгэлийн тухай загвар хууль.....	52
Г.Одоогийн мөрдөж буй бусад хэлэлцээр, холбогдох гэрээ.....	52
1. Монгол Улсад одоо мөрдөж буй хэлэлцээрүүд	52

Д.Олон улсын стандарт	53
1.Одоо хүчин төгөлдөр нь.....	53
V. ЦАХИМ ХУДАЛДААНЫ ХҮРЭЭ, НӨХЦӨЛ	55
A.Цахим худалдааны тухай хууль.....	57
1. Худалдааны тухай, эсвэл Арилжааны тухай хуулийн цахим худалдаанд үзүүлэх нөлөө 58	
2. Цахим худалдааны нэр томъёоны асуудал.....	58
B.Цахим худалдааны бизнес.....	59
1. Олон улсын туршлагаас	61
2. Худалдааны платформ.....	65
3. Цахим худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаадын аж ахуйн нэгжүүд.....	67
3.1 Ерөнхий	67
3.2 Гадаадын аж ахуйн нэгжид тавих тусгай шаардлага	67
B. Хэрэглэгчийг хамгаалах	70
Г. Нууцлал (хувийн мэдээллийг хамгаалах)	73
1. Хувийн мэдээллийг хил дамнаж дамжуулах.....	75
Д. Мэдээлэл (бизнесийн болон албан)-ийг хамгаалах	76
Е.Зайнаас нотариатаар баталгаажуулах	77
Ё.Кибер гэмт хэрэг ба кибер аюулгүй байдал.....	78
Ж. Цахим төлбөр тооцоо	81
1. Гадаад төлбөр тооцоо.....	82
3.Маргааныг шийдвэрлэх	83
И.Иргэний хариуцлага: зөв үйлдлийг хувийн тал өөрөө хэрэгжүүлэх	86
VI. ХУУЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ	89
A. Хууль, эрх зүйн орчин.....	90
Б. Засгийн газрын урт хугацааны төлөвлөгөө.....	93
В. Олон улсын асуудал	93
ДҮГНЭЛТ	95
ХАВСРАЛТ	96

ТОВЧЛОЛ

ADB - АХБ	Азийн хөгжлийн банк
APEC – АПЕК	Ази Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа (байгууллага)
ASEAN-ACEAH	Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо
CAREC	Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (төсөл)
CEFACT	Худалдааг хөнгөвчлөх, цахим бизнесийн төв
CISG	Олон улсын бараа худалдах тухай НҮБ-н конвенц
ECC-ЦХХК	НҮБ-н Цахим харилцаа холбооны конвенц, албан ёсоор Олон улсын гэрээнд цахим харилцаа холбоог ашиглах тухай НҮБ-ын конвенц гэдэг
EIF	EIF-ийн сайжруулсан нэгдмэл хүрээ
ICT	Мэдээлэл харилцааны технологи
IETF	Интернетийн инженерчлэлийн ажлын хэсэг
ISO	Олон улсын стандартын байгууллага
JSI	ДХБ хамтарсан санаачилга (мэдэгдэл)
ITC	НҮБ-н Олон улсын худалдааны төв
ЦХХХЯ	Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яам
ГГЯ	Монгол Улсын Гадаад харилцааны яам
MLEC	UNCITRAL-н Цахим худалдааны тухай загвар хууль
MLETR	UNCITRAL-ын Цахимаар шилжүүлэх бүртгэлийн тухай загвар хууль
MLES	UNCITRAL-ын Цахим гарын үсгийн тухай загвар хууль
OECD-ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
RCEP	Бүс нутгийн иж бүрэн эдийн засгийн түншлэл
TFA-XXX	ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр
UN/ECE	НҮБ/ЕЭЗК, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс
UN/ESCAP	НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс
UNCITRAL	НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс
UNCTAD	НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал
WTO	ДХБ, Дэлхийн худалдааны байгууллага

ОРШИЛ

Дотоод, гадаад худалдааг илүү үр дүнтэй, үр ашигтай хийх зам нь цахим харилцаа холбоо мөн гэдгийг дэлхий өмнө нь мэддэг байсан бол Ковид-19 цар тахлын үед энэ нь илүү тодорхой харагдав. Гэхдээ ийм харилцаа холбоогоор хэрэгждэг бизнесийн шинэлэг аргууд нь ихэвчлэн цаасан, хэвлэмэл мэдээллийн хэрэгслийг зохицуулсан хууль, эрх зүйн орчинтой тулгарч байна. Энэ нь тодорхойгүй байдал үүсгэж, үр ашигтай гүйлгээнд саад учруулах талтай.

Сүүлийн 25 жилийн хугацаанд хууль, эрх зүйн орчныг цахим гүйлгээг дэмжих чиглэлээр ихээхэн өөрчилсөн. Улс орнууд эдгээр санаачилгыг цааш нь хөгжүүлэх, уялдуулах талаар олон улсын түвшинд баагүй хүчин чармайлт гаргаж байна. Ялангуяа НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (UNCITRAL), НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал зэрэг (UNCTAD) зэрэг олон улсын байгууллагууд олон дэвшил гаргасан. Бус нутгийн санаачилгыг НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP) болон Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо (АСЕАН)-с гаргасан. Энэхүү хамтын ажиллагаанд Азийн хөгжлийн банк (АХБ), Дэлхийн банк зэрэг олон улсын санхүүжилтийн байгууллагууд, сүүлийн үед Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) болон Сайжруулсан нэгдсэн тогтолцоо (EIF) байгууллагууд оролцож байна.

Технологи нь бизнесийн үйл ажиллагаанаас илүү хурдан хөгжиж байгааг зохицуулагчид болон худалдаа эрхлэгчид бүгд хүлээн зөвшөөрч байна. Бизнесийн үйл ажиллагааг дэмждэг хууль тогтоомж ч мөн хөл нийлүүлэхийн тулд нэгэн адил өөрчлөгдөх шаардлагатай. Арилжааны хуулийн зорилго нь голцуу ямар харилцааг хөгжүүлэхийг тодорхойлох биш харин практик дээр өөрчлөгдж буй харилцааг бататгах хандлагатай байдаг.

Өөрчлөлтийн хурд нь хууль дүрмийг цаг хугацаанд нь нарийвчлан тодорхойлоход хэцүү болгодог учраас үүнийг мэдэж ойлгосны үндсэн дээр уян хатан байх чанарыг эрхэмлэнэ. Дэлхий даяар цахим худалдааг зохицуулдаг хууль тогтоомж нь цаг хугацаа өнгөрөх тусам заавар багатай, илүүг зөвшөөрөх шинжтэй болж ирлээ. Хуулиар шинэ зүйл хийх тодорхой эрх мэдлийг нь хязгаарлахгүй байх, хамгаалах шаардлагатай ашиг сонирхлыг нарийн хамгаалах, мөн хувь хүмүүс, бизнес эрхлэгчдэд энэ хүрээнд аль болох чөлөөтэй гүйлгээ хийх боломжийг олгох нь тулгамдсан асуудал юм.

Монгол дахь цахим худалдааны эрх зүйн орчныг авч үзэж, тайлан гаргах, тус улсын хууль, журам, тогтоол, шийдвэрүүдийн агуулга нь тус улсын цахим худалдааны бодлогыг дэмжиж байгаа эсэхийг бататгах зорилгоор Азийн Хөгжлийн Банк (АХБ) биднийг татан оролцуулсан юм. Ялангуяа цахим худалдааг үр дүнтэй, ашигтай явуулахад тулгарч буй хууль, эрх зүйн болон зохицуулалтын саад бэрхшээлийг тодорхойлж, сайжруулах талаар зөвлөмж боловсруулах нь бидний үүрэг байлаа.

Ер нь Монгол Улс нь цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхах чиглэлээр олон сайн алхмыг хийжээ. Боломж гармагц асуудлыг тодорхой болгож, мөн хамгийн сүүлийн үеийн санаачилгүүд энэ чиглэлээр үргэлжилсээр байна.

Энэхүү тайландаа Монгол Улсын цахим худалдаатай холбоотой хууль, эрх зүйн орчныг цахим гүйлгээ, цахим гарын үсэг, итгэлцлийн үйлчилгээ зэрэг хэд хэдэн талаас нь судалж, худалдаа эрхлэгчид болон зохицуулагчид хуулийн хүрээнд ажиллах талаар авч үзсэн. Мөн импортлогч, экспортлогчдын анхаарах ёстой олон улсын эрх зүйн нөхцөл, үйл ажиллагааг өргөжүүлэхэд байж болох боломжуудыг судлав.

Жон Грегори, Анбатын Дэлгэрмаа

Дотоод хэрэгцээнд. Энэхүү тайлан нь АХБ-ны удирдлага болон ажилтнуудад нээлттэй.
Зохих зөвшөөрөлтэйгөөр АХБ-аас гадуур өгч болно.

Уг тайланд цахим худалдааны тухай хууль тогтоомжийн боломжит тогтолцоог тоймлон авч үзлээ, үүнд ийм бие даасан хууль байх хэрэгцээтэй эсэхээс эхлээд хэрэглэгчдийн эрхийг хамгаалах, нууцлал, кибер гэмт зэрэг анхаарал хандуулах ёстой цахим худалдааны хэд хэдэн хэсгүүдийг судалсан болно. Тайлангаа цаашид хийх хуулийн шинэчлэлийн чиглэлээр зөвлөмжөөр төгсгөж байна.

Монгол Улсад Иргэний хуулиас өөр бизнес хоорондын гүйлгээг зохицуулсан арилжааны тухай бие даасан хууль байхгүй. Одоогоор Хууль зүй, дотоод хэргийн яам арилжааны (өөрөөр хэлбэл, хувийн хэвшлийн хоорондын арилжааны харилцааг зохицуулах) хуулийн төслийг боловсруулах ажлыг хариуцан ажиллаж байна¹. 2022 оны аравдугаар сарын байдлаар хуулийн төслийг боловсруулах эцсийн шатандаа байна гэжээ². Эдийн засаг, хөгжлийн яам нь худалдааны бодлого, худалдааны хуулийн төсөл боловсруулах асуудлыг хариуцаж байна.

Дээрхтэй нэгэн адил Монголд хил дамнасан худалдааг зохицуулах хууль байхгүй. Худалдааны хуулийн төсөл боловсруулах чиглэлээр олон жил ажилласан, Азийн хөгжлийн банкнаас 2016 онд ийм хууль батлахыг зөвлөж, төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлжээ³, гэхдээ өнөөдрийг хүртэл батлаагүй байна.

Дотоодын бизнесийг зохицуулсан худалдааны хууль эсвэл олон улсын баримжаатай худалдааны хууль байхгүй учраас энэхүү тайланд цахим худалдаанд хамаарлтай, ажиллагааг нь зохицуулсан бусад хуулийг ач холбогдолоор нь авч үзсэн болно.

Энэхүү тайланд Монголд цахим худалдааг үр дүнтэй, үр ашигтай явуулахад одоо ашиглагдаж байгаа эсвэл шаардлагатай технологийг авч үзээгүй, үнэлгээ өгөөгүй болохыг тэмдэглээ. Нөгөөтээгүүр зах зээлд оролцогчид тоног төхөөрөмж буюу харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх, ашиглах чадвар дутмагаас болж хуулийн давуу талыг ашиглаж чадахгүй бол ямар ч шилдэг хуультай байгаад сайн үр дүнд хүрэхгүй.⁴ Үүний нэгэн адил, шинэ технологи зэрэг соёлын, эсвэл практикийн ач холбогдолтой биет бус хэрэгсэлд итгэхгүй бол бизнес болон хэрэглэгчид нь хамгийн үр дүнтэй шинэлэг бизнесийн зүйлийг ашиглах хүсэл эрмэлзэл бага байна.⁵

¹ Энэхүү төслийг Монголын өмгөөлөгчдийн холбоос 2020 оны 2-р сард гаргасан нийтлэлд дурджээ: Др. Хартмут Фишер: арилжааны эрх зүйг системчлэх нь эдийн засгийн ач холбогдолтой”, https://www.mqlbar.mn/news/3640?fbclid=IwAR0YHizkRTo4TKJmr4bb7hz2tqN1HvncBeuijRsjuNB_uCE5VufX9EwUD3k.

² Төслийн талаар 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Японы төлөөлөгчидтэй уулзахдаа ярилцсан гэв “Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг Японы Хууль зүйн яамны төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа”, <https://mojha.gov.mn/?p=8834&fbclid=IwAR2VwynirOH0KmyoZk2j2iMm7B21haLFy6cb95YaOa1POWUf1Vrs8j6nlxU>

³ АХБ, Монгол Улсын Гадаад харилцааны яам, “Монгол Улсын олон улсын худалдааны стратеги”, Роттердам, 2016 оны 7-р сар, 1-р хавсралт, худалдааны тухай хуулийн төсөл.

⁴ CAREC хүрээлэнгээс саяхан (2022 оны 3-р сард) CAREC хөтөлбөрийн гишүүн орнуудын, тэр дундаа Монголын цахим худалдааны дэд бүтцийн судалгааг нийтэлжээ. Технологийн төлөв байдал, хүмүүсийн итгэлийн талаарх олон статистик мэдээлэлтэй, сайжруулах зөвлөмжийн хамт. CAREC-ийн орнууд дахь цахим худалдаа: дэд бүтцийн хөгжил, CAREC хүрээлэн ба АХБ, 2022 оны 3-р сар <https://www.adb.org/sites/default/files/publication/781526/e-commerce-carec-countries-infrastructure-development.pdf>. Түүнчлэн уг төсөл нь НҮБ-ын UNCTAD-с хийсэн Монголын цахим худалдаанд бэлэн байдлын төслийн техникийн шинжилгээ (2023 онд удахгүй гарах)-ний үр дүнд үндэслэх боломжтой. Ийм судалгааны материал цахим орчинд байна <https://unctad.org/topic/ecommerce-and-digital-economy/etrade-readiness-assessments-of-LDCs>.

⁵ АХБ болон НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК). Манила, 2018. “Ази, Номхон далайн орнууд дахь цахим худалдааны хувьсгалыг хүлээн авах нь”. <https://www.adb.org/sites/default/files/publication/430401/embracing-e-commerce-revolution.pdf>.

Мөн хүн ам сийрэг суурьшсан Монголд бараа хүргэж өгөхөд ноцтой сорилтуудтай тулгардаг, онлайн худалдаа эрхлэгчид ч бараагаа хүргэх хүндрэлтэй байдаг. Энэ нь хууль тогтоомжоор даруй шийдвэрлэчихдэг асуудал биш юм, наад зах нь хаягжуулалтыг хэрэгжүүлэх техникийн дэд бүтцийг бүрэн бий болгосны дараа шийдвэрлэх боломжтой. Шуудангийн тухай хууль, Хаягжуулалтын тухай хууль энэ асуудлын тодорхой хэсгийг зохицуулсан. Энэхүү тайланг бэлтгэх үеэр холбогдох төрийн байгууллагуудын шинжээчид хаягжилтын тогтолцоон дээр ажиллаж байгаа бөгөөд одоохондоо ямар ч дүгнэлт гараагүй байна⁶.

⁶ Цахим мэдээлэл: Барилга, хот байгуулалтын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам хоорондын хамтын ажиллагааны талаар уулзалт хийлээ:

<https://www.facebook.com/Barilgiinyam/posts/pfbid02rTt7ctw8CAe97ZhRpG22Sqvo2Mqixpxszg7wWUTUbdv7JGrHYHt3QEEGQQSNEkqql>.

I. ЦАХИМ ХУДАЛДАА ГЭЖ ЮУ ВЭ?

A. Олон улсын тодорхойлолт

Цахим худалдааны эрх зүйн орчныг тодорхойлоход цахим худалдаа гэж юу болох талаар нэгдсэн ойлголтоос эхэлнэ. Олон улсын байгууллагуудын дунд энэ асуудлаар нэгдсэн зөвшилцэл байдаг, гэхдээ их өргөн хүрээтэй бөгөөд бүрэн бус.

Дэлхийн худалдааны байгууллага (WTO)-аас цахим худалдааг анх 1998 онд тодорхойлжээ:

Цахим худалдаа буюу цахим арилжаа нь “цахим хэрэгслээр бараа, үйлчилгээг үйлдвэрлэх, түгээх, зах зээлд гаргах, борлуулах, хүргэх ажлыг” хэлнэ гэж тодорхойлдог (1998). Цахим худалдааны гүйлгээ нь аж ахуйн нэгж, өрх, хувь хүмүүс, төрийн болон олон нийтийн, хувийн байгууллагуудын хооронд байж болно.⁷

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын 2011 оны арай товч тодорхойлолт нь:

Цахим худалдааны гүйлгээ нь захиалга хүлээн авах, байршуулах зорилгоор тусгайлан боловсруулсан компьютерын сүлжээгээр бараа, үйлчилгээг худалдах, худалдан авах үйлдэл юм. Бараа, үйлчилгээг эдгээр аргаар захиалах боловч бараа, үйлчилгээний төлбөр болон эцсийн хүргэлтийг онлайнаар хийх албагүй. Цахим худалдааны гүйлгээ нь аж ахуйн нэгж, өрх, хувь хүмүүс, төрийн болон нийтийн, хувийн байгууллагуудын хооронд байж болно⁸.

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын тодорхойлсноор “цахим худалдаа” гэдэг нь дараах үйлдлийг цахимжуулахын нэгэн төрөл юм “...бараа, үйлчилгээг худалдах, худалдан авах (үүнд тооцоо авах, хэлэлцээр хийх, захиалга өгөх, гэрээ байгуулах зэрэг орно); цахим өгөгдөл солилцох (EDI); хөдөлгөөнт худалдаа; захиалгын системийг үйлчлүүлэгч, нийлүүлэгчийн системтэй холбох; нэхэмжлэх шилжүүлэх, үйлчлүүлэгч төлбөр хийх; арын хадгалах системтэй бүрэн нэгтгэх; “extranet” сүлжээг ашиглах; гүйлгээг найдвартай шилжүүлэх; захиалга хүлээн авах, байршуулах зорилгоор тусгайлан боловсруулсан аргаар компьютерын сүлжээгээр дамжуулан ханган нийлүүлэгчдэд автоматаар төлбөрийг хийх⁹. Төлбөр, хүргэлтийг заавал онлайнаар хийх шаардлагагүй. Утасны дуудлага, факс эсвэл гараар бичсэн цахим шуудангаар хийсэн захиалга үүнд орохгүй. Цахим худалдааны гүйлгээ нь аж ахуйн нэгж, өрх, хувь хүмүүс, төрийн болон нийтийн, хувийн байгууллагуудын хооронд байж болно. ЭЗХАХБ нь биет байдлаар хийсэн мөн дижитал сүлжээний хэрэгсэл (веб хуудас, экстранет сүлжээ, цахим өгөгдөл солилцох EDI сүлжээ зэрэг) ашиглахгүйгээр хийсэн борлуулалт, худалдан

⁷ Дэлхийн худалдааны байгууллага:

https://www.wto.org/english/thewto_e/minist_e/mc11_e/briefing_notes_e/bfecom_e.htm

⁸ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Unpacking e-commerce (“Цахим худалдааг тайлбарлах нь”), 1 дэх бүлэг, “Understanding e-Commerce” (Цахим худалдааны ойлголт), OECD, Unpacking e-commerce, Chapter 1, “Understanding e-Commerce”, online: <https://www.oecd-ilibrary.org/sites/1885800a-en/index.html?itemId=%2Fcontent%2Fcomponent%2F1885800a-en>

⁹ https://unctad.org/system/files/official-document/dtlstict2021d2_en.pdf

авалтыг оруулаагүй. Жишээлбэл, утасны дуудлага, гараар бичсэн имэйлээр захиалгыг оруулаагүй байна¹⁰.

НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (UN/ESCAP) хил дамнасан цаасгүй худалдааг ижил төстэй байдлаар авч үздэг.

Цахим гаалийн мэдүүлэг, гарал үүслийн цахим гэрчилгээ гэх мэт цаасан бус цахим баримт бичгийн үндсэн дээр худалдааны ажиллагаа явуулахыг (эдгээр нь бүгд олон улсын худалдааны тогтолцоон дахь цахим худалдааны хэрэглээ юм, тухайлбал тоон гаалийн систем, цахим “Нэг цонх” эсвэл “цахим боомтын” удирдлагын систем)¹¹

Ер нь бол “цахим худалдаа” /electronic commerce/, “дижитал худалдаа” /digital trade/ зэрэг нэр томьёог ихэвчлэн ялгахгүй хэрэглэдэг. Жишээ нь, Австралийн Засгийн газар энэ хоёр нэр томьёог аль алийг нь “интернет ашиглан мэдээлэл, өгөгдөл дамжуулах, хилээр дамжуулан хийх бараа, үйлчилгээний худалдаа” гэж¹² тодорхойлжээ. Энэ нь дан ганц олон улсын худалдаанд хамааралтай биш.

АНУ-ын Олон улсын худалдааны комиссоос “дижитал худалдаа”-г “аж үйлдвэрийн аль ч салбарын нэгжүүд интернетээр интернетэд холбогдсон ухаалаг утас, мэдрэгч зэрэг холбогдох хэрэгслээр дамжуулах бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх” гэж тодорхойлсон.

Эдгээр дотоодын болон олон улсын байгууллагын тодорхойлолтуудын нийтлэг зүйл бол цахим худалдаа нь цаасан баримт бичиг, яриа гэхээсээ илүү цахим харилцаа холбоог ашиглан бараа, үйлчилгээ худалдан авах, худалдах энгийн худалдаа юм. Үүнд харилцаа холбооны ямар нэгэн тусгайлсан агуулга, тусгай технологи шаардлагагүй.

Зарим эх сурвалжууд энэ ойлголтыг худалдан авах, худалдахаас гадна илүү өргөн хүрээг авч үздэг.

Цахим худалдааг интернет, эсвэл онлайн нийгмийн сүлжээ ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдах, худалдан авах гэж тодорхойлдог. Энэ нь цахим харилцаа холбоогоор дамжуулан бизнес болон хувь хүмүүсийн хооронд шинэ үнэ цэнийн харилцааг бий болгодог (Рахман, 2014). Цахим худалдаа нь гар утсаар хийсэн борлуулалт, цахим гүйлгээ, нийлүүлэлтийн сүлжээний, онлайн гүйлгээний үйл явцыг багтаадаг (Sridhar, 2017).¹³ Цахим худалдаа нь интернетээр бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах, худалдах төдийгүй борлуулалтын үйл явцыг дэмжих бусад ажиллагааг хамаардаг (Банда, 2019)¹⁴

Өөр нэг эх сурвалжийн хэлснээр худалдаа нь гүйлгээнд төвлөрдөг; худалдаа нь илүү өргөн хүрээний эдийн засгийн үйл ажиллагаанд төвлөрч болно.

Худалдаа гэдэг нь худалдааг хөнгөвчлөхөд шаардлагатай бүх үйл ажиллагааг багтаадаг бөгөөд энэ нь бараа, үйлчилгээг үйлдвэрлэгчээс хэрэглэгчдэд хүргэх

¹⁰ Дэлхийн худалдааны байгууллага дахь цахим худалдаа: <https://www.iisd.org/system/files/publications/e-commerce-world-trade-organization-.pdf>

¹¹ НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс: <https://www.unescap.org/sites/default/d8files/2021-01/CPTA.pdf>

¹² Австралийн Гадаад харилцаа, худалдааны яам, “E-Commerce in the World Trade Organization” (Дэлхийн худалдааны байгууллагын цахим худалдаа) илтгэлд иш татсан байна, 9 дэх ишлэлийг үзнэ үү.

¹³ С.Бурмаа, Г.Урандэлгэр, Д.Авирамд “Analysis of E-commerce Adoption in Ulaanbaatar, Mongolia” (Улаанбаатар хотод цахим худалдааг нэвтрүүлэхэд хийсэн дүн шинжилгээ), 2021, 17 JI of Intl T&C No. 1 p. 68, <https://scholar.kyobobook.co.kr/article/detail/4010028162512>

¹⁴ 12 дахь ишлэлийг үзэх, 69-р хуудас

үе шатууд гэсэн үг юм. Энэ бүх явцыг амжилттай дуусгахын тулд тээвэрлэлтийг зохион байгуулах, банк, даатгалын үйлчилгээ үзүүлэх, сурталчлах замаар бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах, агуулахад хадгалах гэх мэт үйл ажиллагаа орно¹⁵.

Ингээд "цахим худалдаа" гэдэгт "худалдааны" нэг хэсэг байх эсэхээс үл хамааран цахим харилцаа холбооны хэрэгслээр хийж буй бүх үйл ажиллагааг илэрхийлэх хандлагатай болсон.

Гэхдээ эдгээр ажиллагаа нь цахим хэлбэрээр хийсэн тохиолдолд уламжлалт арга хэрэгслээр явуулж буйгаас нэмэлт хууль тогтоомж, зохицуулалт шаарддаггүй. Цахим гүйлгээ, цахим гарын үсгийг зохицуулсан Монголын хуулиар "борлуулалтыг дэмжих аливаа үйл ажиллагаа" цахим хэлбэрээр явуулахыг зөвшөөрсөн бөгөөд үүнийг дор авч үзье.

"Худалдааны хууль" нь хил дамнасан гүйлгээг илүүтэй зохицуулсан хууль болж хэрэглэгдэх магадлалтай. Энэ зорилгоор худалдааг хөнгөвчлөх, хамгаалах, тариф, гаалийн асуудлыг багтаадаг. Цахим худалдаа буюу цахим арилжааны олон улсын харилцааг доорх 3-р хэсэгт авч үзнэ.

Б. Цахим харилцааны мөн чанар

Цахим харилцаа холбоо нь цаасан дээрх харилцаанаас хэдэн чухал зүйлээрээ ялгаатай. Иймд түүнд уламжлалт худалдааны харилцааны хэм хэмжээг хамруулан хэрэглэхэд бэрхшээлтэй байж болно¹⁶. Эдгээр ялгааг олж ойлгох бол яагаад улс орнууд, тэр дундаа Монголд ч хууль тогтоомжкоо нийцүүлж, уялдуулж ирсэн, цаашдын хөгжилд ямар арга хэмжээ авахыг олж тогтооход тустай.

Нүдэнд үл үзэгдэх үйл явц. Цахим дохиог ашиглах, тайлбарлах замаар цахим харилцаа холбоо үүсдэг. Ийм харилцаа нь худалдаа, олон нийтэд олон талын ашигтай. Үүнд гол сорилт нь текст болон тоон мэдээллийг дамжуулахад ашиглаж буй тооцоолол нь нүдэнд үл үзэгдэх байдлаас үүдэлтэй. Хэрэглэгч нь компьютертоо итгэж, зөв үйлдэл хийнэ, үйлдэл хийх бүртээ ижил аргаар хийнэ гэж итгэдэг, тухайлбал, аудитор, зохицуулагч, татварын алба гүйлгээнд оролцогч талууд болон бусад сонирхсон бүх этгээдэд ижил текстийг дэлгэц дээр нь харуулах, зөв текстийг принтерт илгээж хэвлэнэ гэх мэт. Анхны цаасан баримт бичигт ул мөр үлдээхгүйгээр засварлахад хэцүү байдаг бол цахим бичигт оруулсан өөрчлөлтийг үл үзэгдэх маягаар хийж болно.

Технологийн хурдацтай хөгжил. Технологийн үйл ажиллагаа, эрсдэлийн талаар өнөөдөр ойлгож байгаа зүйл маргааш өөр болсон байх магадлалтай юм.

Хууль, эрх зүйн эргэлзээ. Харилцаа холбооны системд холбогдсон компьютерийг хэрэглэж буй хэн ч компьютерт нь хортой програм нэвтрэх, гэмт

¹⁵ Vedantu, "Difference between trade and commerce", [//www.vedantu.com/commerce/difference-between-trade-and-commerce](http://www.vedantu.com/commerce/difference-between-trade-and-commerce). See also Key Differences, Surbi S, "Difference between trade and commerce", 26 July 2018, online: <https://keydifferences.com/difference-between-trade-and-commerce.html>.

¹⁶ World Economic Forum, *Making Deals in Cyberspace: What's the Problem?*, White Paper, 2017 оны 10-р сар (Дэлхийн эдийн засгийн форум, Кибер орон зайд хэлэлцээр хийх нь: бэрхшээл юунд байна вэ?) <https://www.weforum.org/whitepapers/making-deals-in-cyberspace-what-s-the-problem>

хэргийн халдлагаас сэргийлэх шалтгаан байгаа нь мэдээж. Хэрэглэгчид онлайнаар худалдаж авсан зүйл болон өөрт нь ирсэн зүйл нийцэж байгаа эсэх, хэрэв ирсэн бүтээгдэхүүн нь муу байвал онлайн худалдаачид ямар нэгэн арга хэмжээ авч чадах эсэх талаар эргэлздэг. Харин худалдагчийн эргэлзээ бол цахим үйлчлүүлэгч мөнгөө төлөх эсэх. Ийм асуудлууд шуудан эсвэл утсаар захиалга гэх зэрэг онлайн худалдахад үүсдэг. Ер нь бол ийм тохиолдолд ч хэрэглэгчийн эрхийг хамгаалах төстэй арга хэмжээг хэрэгжүүлэх боломж байх нь зөв.

Хувийн мэдээллийг буруугаар ашиглах. Цахим харилцаа холбооны операторуудад харилцаа холбоонд орж буй хүмүүсийн мэдээллийг "цуглуулах" нь хялбар байдаг. Хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, задруулахыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах талаарх хуулийн хэмж хэмжээнд хүн бүр итгэдэггүй.

Өөр өөр газар өөрийн арга барил ба журамтай. Цахим мэдээлэл нь хилээр амархан дамждаг боловч түүний эрх зүйн байдлыг тодорхойлсон журам нь газар бүрд өөр бөгөөд гадаадын журмыг хүлээн зөвшөөрч мөрдөхийг зохион байгуулахад хүндрэлтэй. Түүнчлэн, маргааныг шийдвэрлэх арга замууд нь өөр өөр байж болно. Тэдгээрийг уялдуулах боломжийн талаар тайланд дор авч үзнэ¹⁷.

Дээрх болон бусад тодорхойгүй байдлаас болж зарим хүмүүс, бизнес эрхлэгчид цахим харилцаа холбоо, цахим худалдаанд итгэхийг хүсдэггүй, цаасан харилцаанд зориулсан хууль тогтоомж нь цахим харилцаа холбоонд бүрэн нийцэхгүй тул итгэлийг хангахад хангалтгүй гэж үздэг. Угтаа ч худалдааны салбарт цахим харилцаа холбоог анх ашиглаж эхлэхэд цаасан баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалсан хуулиуд нь тэдгээрт тохирохгүй эсвэл хэрэглэхэд хэцүү байсан билээ.

Харин 1990-ээд оноос хойш хууль зүйн орчныг цахим харилцаанд шилжүүлэх, зохицуулах талаар олон улсын зөвшилцэл бий болсон. Нэмж сануулахад, цахим худалдаа нь түүнийг дэмжсэн хууль тогтоомж байхгүй байсан ч дэлхий даяар тархсан билээ. Одоогийн гол асуудал бол үлдсэн саад тоторыг арилгах маягаар цахим гүйлгээг зөв удирдаж, цахим худалдааны аюулгүй, тогтвортой өсөлтийг хэрхэн дэмжих вэ?

Энэхүү тайланд олон улсын хууль тогтоомжийн болон бусад шилдэг туршлагыг жишээ болгож, Монгол Улсын хууль зүйн тогтолцоонд цахим арилжааны харилцааг удирдах тогтолцоог оновчтой болгоход дутагдаж байгаа зүйлийг хэлэлцэв.

Цаашдаа хувийн технологи нь цахим худалдааг илүү найдвартай хийх шинэ аргуудыг бий болгох нь гарцаагүй. Иймд зохих хууль нь хараахан байгүй ч төрийн зохицуулалт, захиргааны хяналтгүйгээр, төхөөрөмж, код, платформоор дамжуулан тэдгээрийг ашиглан боломжтой байх ёстой.

Хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын хоорондын, тэр дундаа хөгжлийн түншүүдтэй яриа хэлэлцээг үргэлжлүүлэх нь чухал. Тухайлбал, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD) нь дэлхийн хэмжээнд цахим худалдааг хөгжүүлэх

¹⁷ Энэ тайлангийн V.I дэх хэсэгт заасан 234-р тайлбарыг харах.

төрийн бодлогыг оновчтой болгох, дэмжих зорилготой хувийн хэвшлийнхнийг багтаасан “нийтийн цахим худалдаа” (“E-trade for all”) хөтөлбөрийг хэрэгжүүлж байна¹⁸.

UNCTAD одоогоор Монголын цахим худалдаанд бэлэн байдлын үнэлгээг хийж дуусаж байгаа юм байна. Түүний үр дүн нь энэхүү тайланд дурдсан зүйлийг тодруулах юм. НҮБ/АНДЭЗНК-ийн техникийн болон хуулийн зөвлөх ажлын хэсгүүд нь ч мөн адил үүрэг гүйцэтгэж чадна.

В. Цахим худалдааны бизнес гэж юу вэ?

Дээрх тодорхойлолтуудын өнцгөөс харахад хуульд нийцүүлэн үр дүнтэй гүйлгээ хийх чадвартай хэн ч цахим худалдаа эрхэлж болно. Зарим тохиолдолд илүү дэвшилтэт технологи шаардагдаж болох ч интерактив цахим хуудас хангалттай байх болно. Аж ахуйн нэгжүүд цахим бизнесээ онлайн худалдааны платформоор хийх тохиолдол олон байдаг, ийм платформууд ихэвчлэн сурталчилгаа, техникийн дэд бүтэц, гүйлгээний дэмжлэг үзүүлдэг. Эдгээрийн тухай энэ тайланд дор авч үзсэн болно. Ийм платформуудыг заримдаа “цахим худалдааны үйлчилгээ үзүүлэгч” гэж тодорхойлдог. Эдгээр нь цахим худалдааг явуулахад гол үүрэг гүйцэтгэдэг цахим худалдааны бизнесийн томоохон дэд хэсэг нь юм.

Засгийн газрууд бизнес эрхлэгчдийг онлайнаар ажиллах, үр ашгаа нэмэгдүүлэх, зардлаа бууруулахыг дэмждэг. Ингэхдээ засгийн газрууд онлайн гүйлгээ нь цаасан дээрх хэлцлээс илүү найдвартай бүртгэлийг бий болгох, цахим хуудас болон платформуудад нь аудит хийх боломжтой болгох, бизнес эрхлэгчид нь үйлчлүүлэгчдийн өмнө болон төрийн бодлогод хүрээнд хариуцлагаа хүлээх (жишээ нь, татвараа төлөх), нээлттэйгээр ажиллахыг дэмждэг.

Энэхүү тайланд хэнд ийм урамшуулал өгөх, үүнийг хэрхэн шийдэх, ийм шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар ярилцах болно.

¹⁸ “E-trade for all”, <https://etradeforall.org/>. Энэ тухай сүүлийн үеийн тайлбарыг D.Crosby, “Private Sector Views on Priorities for E-commerce” (Д.Кросбигийн “Цахим худалдааны тэргүүлэх чиглэлийн талаарх хувийн хэвшлийн үзэл бодол”) номноос харж болно.

https://unctad.org/system/files/non-official-document/dtl_eWeek2017p15_DanielCrosby_en.pdf

II. ЦАХИМ ГҮЙЛГЭЭНИЙ ХУУЛЬ

A. Цахим гүйлгээ

Олон улсын шилдэг туршилага

Энэ салбарын шилдэг туршилагуудыг зарчмын хувьд НҮБ-ын Цахим харилцааны загвар хуульд багтаан тусгасан¹⁹. Уг хуулийг Цахим худалдааны тухай UNCITRAL-ын конвенцоор баталсан²⁰. Загвар хуульд мэдээлэл нь зөвхөн мэдээллийн мессеж хэлбэрээр (өөрөөр хэлбэл цахим хэлбэрээр) байна гэсэн үндэслэлээр хуулийн хүчинтэйд үзэхээс татгалзаж, хэрэгжүүлэхийг угүйсгэж болохгүй гэж заасан байдаг.

UNCITRAL 1996 онд Цахим худалдааны загвар хуулийг (MLEC) баталсан бөгөөд дэлхийн 80 гаруй оронд хэрэгжиж байна²¹. Цахим худалдааны эрх зүйн шинэчлэлийн шилдэг загвар хэвээр байна. Энэ нь конвенц гэхээсээ илүү үлгэрчилсэн загвар хууль учраас MLEC-ийг ямар ч хууль, эрх зүйн тогтолцоонд хэрэглэж, ямар ч хуультай оронд тохируулан өөрчилж болно. MLEC нь материаллаг эрх зүйн хэм хэмжээ гэхээсээ илүү хэлбэрийн шаардлагуудыг голчлон авч үздэг. Энэ загвар хууль нь дүрмээ хэрхэн биелүүлэхээ шийдэх талуудын эрхийг өргөнөөр тусгасан байдаг.

Цахим баримт бичиг

Цахим баримт бичгийг хүчинтэй гэж үзэх, ашиглахад тулгардаг гол бэрхшээл нь зарим баримт бичгийг заавал бичгээр гаргах хуулийн шаардлага юм. UNCITRAL-ийн загвар хууль нь цахим баримт бичиг нь түүн дэх мэдээлэл нь хүртээмжтэй, дараа нь лавлагаа болгон ашиглах боломжтой бол шаардлага хангасан гэж үзнэ гэсэн байдаг. Цахим баримтыг ашиглахад саад болж буй өөр нэг бэрхшээл бол баримт бичгийн эх хувилбарыг бүрдүүлэх нийтлэг шаардлага юм. Загвар хуульд цахим хэлбэрийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргыг заасан, үүнд ийм өгөгдөл цаасан эх хувьтай дүйцэх эсэх, өөрөөр хэлбэл цахим хувилбар нь уламжлалт эрх зүйн чадамжтай бичиг баримтын зорилго (функц)-той ижил байж чадах уу? гэдгийг хэрхэн шинжлэх талаар. UNCITRAL-ийн үзэж байгаагаар үүнд бодит бичмэл зүйлтэй дүйцэхүйц эсэхийг тодорхойлох гол шалгуур нь бол мэдээллийг үүсгэсэн цагаасаа эхлээд дүн шинжилгээ хийх хүртэлх хугацаанд иж бүтэн байдлаа хадгалж чадах эсэх чанар юм.

Борлуулалт

Цахим худалдааны үндсэн ажиллагаа нь арилжааны гүйлгээ мөн бөгөөд ихэнхдээ нэг талаас нөгөө тал руу худалдах тохиролцооны хэлбэртэй. Борлуулалтыг зохицуулсан хууль голцуу "ялгаварлахгүй, төвийг сахисан" байдаг - энэ нь цаасан дээр суурилсан эсвэл онлайн гүйлгээнд адилхан үйлчилнэ гэсэн үг. Иймд талуудын гэрээ хийх чадвар (нас, саруул ухаан гэх мэт) эсвэл гэрээний санаа, хүсэл зоригийн хүчин зүйл (жишээ нь,

¹⁹ UNCITRAL, Цахим худалдааны тухай загвар хууль, 1996,

https://uncitral.un.org/en/texts/e-commerce/modellaw/electronic_commerce

²⁰ Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай НҮБ-ын конвенц, 2005,

https://uncitral.un.org/en/texts/e-commerce/conventions/electronic_communications

²¹ 20 дахь тайлбарыг үзнэ үү.

зөвшөөрөл, юуны төлөө гэрээ байгуулж байгаагаа ойлгох) зэрэг асуудлууд нь нь цахим худалдаа, цаасан дээр бичсэн гүйлгээнээс ялгаагүй.

Борлуулалтын ерөнхий хэм хэмжээг Монгол Улсын Иргэний хуулиар²² зохицуулдаг. Иргэний хуульд хэлцлийг бичгээр хийхийг шаардлаггүй, амаар ч байж болно. Хэрэв гүйлгээг бичгээр хийсэн бол ихэнх талууд гүйлгээний баримт бичигт заавал гарын үсэг зурах хуулийн шаардлага байхгүй ч болгоомжлол, бичиг баримтыг хуулийн хүчинтэй болгохын тулд гарын үсэг зурдаг: гарын үсэг нь гэрчлэл (гарал үүсэл)-ийг харуулна, мөн дараа нь маргаан гарвал гэрээ байгуулах санаа, хүсэл зоригийг нотолно.

Тайлангийн энэ хэсэгт Монголын хуулийн хүрээн дэх цахим гүйлгээ болон цахим гарын үсгийн мөн чанарыг авч үзэв.

Иргэний хуулийн зарим хэсэгт буй бичгээр байх шаардлага нь цахим харилцаанд саад учруулахаа больсон. Хуулиар бүртгүүлэх, нотариатаар гэрчлүүлэх, бичгээр баталгаажуулах шаардлагатай гүйлгээг цахим хэлбэрээр хийж болно гэж 2011, 2021 онд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан²³. Хуулийн хэд хэдэн хэсэгт тодорхой төрлийн гэрээнд нотариатаар гэрчлүүлэхийг заасан учир нотариатын хувийн хэрэг үүсгэх, цаашлаад Нотариатчидын танхимын архивд нотариатын гарын үсэгтэй бүртгүүлэн хадгалдаг. 2019 онд Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар нотариатч эдгээр ажлыг цахим хэлбэрээр гүйцэтгэх боломжтой болсон.

Нотариатч нь цахим бүртгэл үүсгэх, түүнд мэдээлэл оруулах, мэдээллийн санд байршуулах, баяжуулах ... улсын бүртгэлд шилжүүлэх замаар нотариатын цахим ажиллагаа эрхэлнэ²⁴.

Энэхүү заалтын талаар “ийм бүртгэл нь баримт бичгийг баталгаажуулахгүй, гэрчилсэн нотариатчийн цахим гарын үсгийг баталгаажуулахгүйгээр зөвхөн нотариатын үйлдлийг бүртгэж байна” гэж маргах магадлалтай юм. Харин үүний эсрэг үндэслэл бол “Иргэний хуульд нотариатаар гэрчлэх шаардлагатай гүйлгээг цахимаар хийхийг шууд зөвшөөрсөн нь нотариатч хүчин төгөлдөр гүйлгээнд шаардлагатай бүх алхмыг хийх, тэр дундаа цахим болон тоон гарын үсгийг баталгаажуулсан баримт бичгийг оруулах боломжтойг харуулж байна”.

Түүнчлэн Иргэний хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.4-т бичгээр хэлцэл хийхдээ цахим хэлцлийн хувьд талууд 2021 онд баталж, 2022 оноос хүчин төгөлдөр мөрдөж буй Цахим гарын үсгийн тухай хуульд²⁵ заасны дагуу цахим гарын үсэг зурна гэж заажээ. Ингээд харахад цаасаар хийсэн хэлцэлд заавал гарын үсэг зурахыг заагаагүй ч, нотариат оролцсон эсэхээс үл хамааран бараг бүх цахим гүйлгээнд гарын үсэг зурдаг болж. Удахгүй Монгол Улсын Цахим гарын үсгийн тухай хуулийг дахин авч үзэх харах магадлалтай байна.

Худалдааны платформ

Хувь хүмүүс болон бие даасан бизнес эрхлэгчид бараа, үйлчилгээ худалдах, худалдан авах явцад цахимаар харилцахдаа нэг интернет холболтыг ашиглаж болох ч, өөрөө шаардлагатай бүх зохицуулалтыг хийхэд хэцүү эсвэл хэт их цаг хугацаа шаардагдаж

²² Монгол Улсын Иргэний хууль: <https://legalinfo.mn/mn/editl/16147365399641>

²³ Монгол Улсын Иргэний хууль, 42¹.1 дэх хэсэг

²⁴ Монгол Улсын Нотариатын тухай хууль, 25.2 дах хэсэг, <https://legalinfo.mn/mn/detail/400>

²⁵ Цахим гарын үсгийн тухай хууль, 2021, <https://esign.gov.mn/law-of-signature>. Цахим гарын үсгийн талаарх хэлэлцүүлгийг дараагийн хэсэгт үзнэ үү.

болно. Иймд “арилжааны платформ” гэдэг байгууллагууд арилжааны зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг болжээ. Худалдааны платформ нь олон худалдагчийн барааг нэг “газар”-аас худалдан авагчдад санал болгож, борлуулах боломжийг олгож байна²⁶.

Amazon.com, alibaba зэрэг дэлхийн худалдааны гол платформууд Монголд ажиллаж байгаа ч тэдгээрийг ихэвчлэн онлайнаар юм худалдаж авахад ашиглаж байна. Харин гадаадаас төлбөр хүлээн авах найдвартай арга хараахан байхгүй байгаа тул ийм томоохон платформоор дамжсан хил дамнасан цаасгүй худалдаа, арилжаа ховор байна.

Монголд олон улсын арилжааны томоохон платформууд²⁷ дэлгэрсэн, гэхдээ өөрийн хэд хэдэн платформууд бий. Үүний нэг тод жишээ бол [shoppy.mn](#)²⁸ сайт юм. Тэд бүх зах зээлд өргөн хүрээний бараа, үйлчилгээг санал болгож байна. Тэд ихэвчлэн Улаанбаатарт хүргэх хязгаартай, шаардлага хангаагүй барааг буцаах, солих зэрэг хэрэглэгчийн эрхийг хамгаалах зарим арга хэмжээг хэрэгжүүлдэг.

[Бусад платформууд] Ard shop, Unegui.mn, Mart.mn, UBShop.mn зэрэг бий ... Мөн ихэнх сүлжээ дэлгүүрүүд өөрийн гэсэн цахим дэлгүүртэй. Нэмж дурдахад, COVID-19-н дэгдэлтэй холбоотойгоор сошиал сүлжээ нь цахим худалдаанд асар их үүрэг гүйцэтгэж эхэлсэн. Хүн амын дийлэнх нь олон нийтийн сүлжээ ашигладаг тул компаниуд тэдгээрээр дамжуулан хэрэглэгчдээ хүрэхэд маш тохиромжтой болсон. Улаанбаатар хотын 500 гаруй оролцогчдын дунд явуулсан судалгаагаар хэрэглэгчдийн 43 хувь нь Facebook, 6 хувь нь Instagram-ыг хувийн хэрэгцээндээ зориулж бараа, үйлчилгээ худалдан авдаг гэжээ²⁹.

Одоогийн байдлаар Shoppy.mn болон бусад платформууд нь өөрийн эзэмшлийн логистик, агуулах, тэр байтугай хэрэглээний зээлийн үйлчилгээ үзүүлдэг “цахим экосистем” болтлоо хөгжжээ. Тэд тусгай хуулиар зохицуулагддаггүй, зөвхөн иргэний болон эрүүгийн хуульд заасан арилжааны ерөнхий стандартаар зохицуулагдаж байна. Цахим худалдааны зохицуулалтыг нэмэх шаардлагатай эсэхийг дор Тав дахь хэсэгт авч үзнэ.

²⁶ Худалдааны платформ нь интернетийн хэрэглээг онлайн болгодог харилцаа холбооны зуучлагч, ялангуяа интернетийн үйлчилгээ үзүүлдэг харилцаа холбооны компаниудаас болон бусад этгээдээс ялгаатай байх ёстой.

²⁷ UNCTAD-н Монголын цахим худалдаанд бэлэн байдлын судалгааны төсөл, удахгүй буюу 2023 онд гарна.

²⁸ Shoppy-н тухай болон “Түгээмэл асуултууд”-ын хуудас нь: <https://shoppy.mn/about> ба <https://shoppy.mn/support>.

²⁹ Хаш-эрдэнийн Пүрэвсүрэн. “Монголын цахим худалдааны бодлого: Монголын хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор БНСУ-ын цахим худалдааны тухай хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх нь”, Солонгосын төрийн бодлогын чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан судалгааны ажил, БНСУ. 2021, 2-р хуудас. <https://archives.kdischool.ac.kr/bitstream/11125/42999/1/E-commerce%20policy%20in%20Mongolia.pdf>.

Б. Цахим гарын үсэг

Олон улсын шилдэг туршилага

Цахим гарын үсгийн олон улсын эрх зүйн орчны эхлэлийг UNCITRAL-ийн Цахим гарын үсгийн тухай загвар хуулиар (MLEC)³⁰ тавьжээ, уг загварыг НҮБ-ын Цахим харилцааны конвенц (ECC)³¹-эр 2005 онд шинэчлэн баталсан. Эдгээр баримт бичигт хуульд гарын үсэг зурах шаардлагатай гэж заасан бол цахим гарын үсэг зурсан этгээдийг найдвартай тодорхойлж байгаа бөгөөд холбогдох хүсэл зоригийг нь тодорхой илэрхийлсэн цахим гарын үсэг уг шаардлагыг хангана гэсэн байдаг.

MLEC загвар хууль болон ECC конвенц нь аль аль нь цахим гарын үсгийг найдвартай болгох журмыг тогтоосон. Гарын үсэг зурах төхөөрөмж нь зөвхөн гарын үсэг зурсан тухайн хүнтэй холбоотой байх; төхөөрөмж нь зөвхөн гарын үсэг зурсан хүний хяналтад байх ёстой бөгөөд гарын үсэг зурсны дараа гарын үсэг (заримдаа баримт бичиг нь) өөрчлөгдсөнийг харах боломжтой байх ёстой (MLEC 9.6) ³²

Найдвартай байдлын хувьд тоон гарын үсэг байна.“Найдвартай байх” болон “удирдахуйц байх” хоёрын хооронд зөрчил үүсэж болно. Нийгмийн болон бизнесийн янз бүрийн зорилго нь өөр өөр түвшний итгэлцлийг шаардаж болно. (Итгэлцлийн үйлчилгээний талаар дор үзнэ үү.

Монголд гэрээлэгч талууд гүйлгээний баримтад заавал бичгээр гарын үсэг зурах шаардлага байхгүй ч гарын үсэг зурах нь ухаалаг хэрэг юм. Харин Иргэний хуульд “цахим хэлбэрээр хэлцэл хийх бол талууд хүсэл зоригоо илэрхийлсэн цахим баримт бичиг үйлдэж, Цахим гарын үсгийн тухай хуульд заасан цахим гарын үсэг зурах” тухай заасан байдаг³³. Цахим баримт бичигт гарын үсэг зурсны дараа гарын үсгийг тухайн хуулиар зохицуулна.

Гарын үсгийн төрлүүдийн нэр томьёо нь хуулиуд болон тэдгээрийн тайлбар бичгүүдэд дурдсан байгаа нь хоорондоо сайн нийцэхгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй. “Electronic signature” гэсэн нь Монголоор цахим гарын үсэг юм. “Digital signature” гэдэг нь тоон гарын үсэг юм. Google Translate, Word зэрэг орчуулгын программууд нь хоёрыг оруулахдаа өөр өөрөөр орчуулж өгдөг, заримдаа бүр зөрчилдсөн байдлаар. Иргэний хуульд “цахим гарын үсэг” гэсэн нэр томьёог ашигладаг. Гарын үсгийн тухай хуулийг Цахим гарын үсгийн тухай хууль гэж нэрлэдэг ч Монголтой холбоотой англи хэл дээрх хэвлэлд “Тоон гарын үсгийн тухай хууль” гэж байнга дурджээ. Эдгээр нэр томьёог хэрэглэж байгаа нь зөвхөн орчуулгын асуудал эсэх нь ойлгомжгүй байна; текстүүд өөрсдөө заримдаа тодорхойгүй мэт.

Цахим гарын үсгийн тухай хуульд “цахим гарын үсэг” гэж цахим мэдээлэлд гарын үсэг зурсан, цахим тамга хэрэглэсэн этгээдийг тодорхойлох зорилгоор мэдээлэлд хавсаргасан, эсхүл нэгтгэсэн цахим өгөгдлийг” ³⁴ гэж тодорхойлжээ. Тодорхойлсон

³⁰ UNCITRAL-ын Цахим гарын үсгийн тухай загвар хууль (MLEC), 2001,

https://uncitral.un.org/en/texts/e-commerce/modellaw/electronic_signatures (Монгол хэлээр).

³¹ Цахим харилцааны конвенц (ECC), 20-р тайлбарыг харах.

³² MLEC-т зааснаар бол гарын үсэг зурах хуулийн шаардлагын зорилго нь түүнд хамаарах мэдээллийн бүрэн бүтэн байдлыг баталгаажуулах явдал юм гэжээ. Тухайн мэдээлэлд гарсан аливаа өөрчлөлтийг мөн илрүүлэх боломжтой. 6(3)(d) заалт. Улс орнуудын эрх зүйн тогтолцооны зөөнд нь л гарын үсгээр баталгаажуулсан мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахыг шаарддаг.

³³ Монгол Улсын Иргэний хууль, 22-р тайлбарыг харах, 43.2.4 дэх заалт. Цахим гарын үсгийн тухай хууль (2021), 24-р тайлбарыг харах.

³⁴ 22-р тайлбарыг харах, 4.1.10 дахь заалт.

хуулийн этгээдийг тексттэй утга учиртай холбох ямар ч цахим арга бол ийм гарын үсэг юм гэж дүгнэхэд л үлдсэн бололтой. Тодорхой этгээдийг түүний тексттэй холбох аливаа цахим аргыг ийм гарын үсэг гэж үзнэ.

Харин тоон гарын үсэг гэж “энэ хуулийн 6.2-т заасан шаардлагыг хангасан цахим гарын үсэг” гэж тодорхойлсон³⁵, тэгээд тэрхүү 6.2-т гурван шаардлагыг тусгажээ:

6.2.1.тоон гарын үсгийн хувийн түлхүүр /цаашид "хувийн түлхүүр" гэх/ ашиглан мэдээллийг шифрлэж хувиргалтад оруулж үүсгэсэн байх;

6.2.2.тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшигч /цаашид "гэрчилгээ эзэмшигч" гэх-/ийг тоон гарын үсгийн нийтийн түлхүүр /цаашид "нийтийн түлхүүр" гэх/ ашиглан таних, шалгах боломжтой байх;

6.2.3.мэдээлэлд тоон гарын үсгийг хавсаргасан, эсхүл нэгтгэсний дараа мэдээлэлд өөрчлөлт оруулсан³⁶, мэдээллийн бүрэн бүтэн эсэхийг мэдэх боломжтой байх³⁷.

Тоон гарын үсэг нь цаасан хэлбэрт байгаа мэдээлэлд зурсан гарын үсэгтэй адил хүчинтэй байна.³⁸

Цахим гарын үсэгт хамаарах төрийн ёсны цахим хуудсанд тоон гарын үсэг биш цахим гарын үсгүүд байгааг хүлээн зөвшөөрсөн байдаг ч³⁹ тийм цахим гарын үсгийг хууль (Цахим гарын үсгийн тухай хууль)-аар тогтоосон тодорхой шалгуурт нийцүүлэхийг заагаагүй байна. Үүнийг Иргэний хуулийн заалтын хүрээнд цахим гарын үсгээр гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр гэж нөгөө талаас нь тайлбарласан байдаг⁴⁰. Дор дурдсан 6.3-т заасны дагуу тоон гарын үсгийг баталгаажулахаас бусад тохиолдолд хэлцэл хийгч талууд ямар үндэслэлээр аль нэг гарын үсгийн төрлийг сонгох тухай ямар ч дүрэм, нөхцөл заагаагүй болно. Тоон гарын үсгийг хэрэглэх ямар ч зорилгыг угаасаа заагаагүй.

Хувь хүмүүс тоон гарын үсэг үүсгэх хэрэгсэлтэй байж болох бөгөөд ийм гарын үсгийг ашиглаж болно. Тоон гарын үсгийн шинж чанарыг хуулиар тогтоосон байдаг⁴¹. Аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгч этгээдүүд оронд нь тоон тамга ашигладаг⁴². Технологийн хувьд тэдгээр нь тоон гарын үсэгтэй нийцдэг. Үйл ажиллагааг хуульд

³⁵ 25-р тайлбарыг харах, 4.1.3 дахь заалт.

³⁶ Хуулийн энэ заалтанд тоон гарын үсгийг бий болгох арга хэлбэрийг “нэгтгэх” тухай ярьж байна: шахсан мессеж болон гарын үсэг зурах түлхүүрийг нэгтгэж, өвөрмөц тоон объект болох гарын үсэг юм.

³⁷ Гарын үсэг зурсан мессежийн бүрэн бүтэн байдлыг “хэш” (“hash”) гэх нэртэй математикийн шахалт буюу “digest” хийх замаар хангадаг. Хэш үүсгэх стандарт алгоритмууд байдаг, тоон гарын үсгийн төхөөрөмж нь ийм нэгээр тоноглогдсон байх ёстой. Хэрэв мессежид ямар нэгэн өөрчлөлт орвол бол энэ нь “хэш”-ид нөлөөгүй. Тиймээс хүлээн авагч нь тоон гарын үсгийг баталгаажулахын тулд мессежийн “хэш”-ийг дахин шалгах маягаар хийнэ. Үгүй бол дахин “хэш”-лэж боловсруулсан мессеж нь ихэвчлэн уншигдахуйц байдалтай харагдана. “Криптограф дахь “хэш” функц гэж юу вэ? Анхан хэрэглэгчдэд зориулсан гарын авлага” <https://www.thesslstore.com/blog/what-is-a-hash-function-in-cryptography-a-beginners-guide/>

³⁸ 25-р тайлбарыг харах, 6.3 дахь заалт.

³⁹ Цахим хөгжил, харилцаа холбооны яам, цахим гарын үсгийн сайт: <https://esign.gov.mn/?s=PKI&submit=>

⁴⁰ Иргэний хуулийн 196.1.8 дахь заалтыг харах.

⁴¹ 25-р тайлбарыг харах, 8-р зүйл.

⁴² 25-р тайлбарыг харах, 6.5 дахь заалт. Тоон тэмдэгт хамаарах дүрэм, түүний шинж чанарыг 7-р зүйлд тусгажээ. Зарим орчуулгад “тоон тамга” гэсэн байна (угтаа бол “тамга” ч гэсэн шууд утгаараа зөв биш, учир нь эдгээр үгс нь цаасан дээр хийсэн зүйлийг хэлдэг.)

ерөнхий байдлаар тодорхойлсон⁴³. Аж ахуйн нэгж нь ийм тамгагүй бол тухайн байгууллагын эрх бүхий этгээд хувийн тоон гарын үсгээр зурах журамтай.

Тоон гарын үсгийн техникийн ажиллагааны талаарх дэлгэрэнгүй хэлэлцүүлгийг энэхүү тайлангийн дараагийн дэд хэсэгт оруулав.

Тоон гарын үсгийг гэрчилгээ дагалддаг, үүгээр гарын үсэг зурсан өгөгдөл эзэмшигч ("Гэрчилгээ эзэмшигч") хэн болохыг гэрчилнэ. Гэрчилгээний бүрэн агуулгыг хуульд тусгасан⁴⁴. Гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүргийг мөн хуульд заасан⁴⁵. Итгэлцлийн үйлчилгээний талаарх хэлэлцүүлгийг доороос үзнэ үү.

Энэ бүхэн бодит амьдрал дээр юу гэсэн үг вэ гэвэл хүмүүс цахим хэлбэрээр бизнес хийхгүй, тэр ч байтугай энгийн хүмүүсийн хоорондын гүйлгээг ч гэсэн тоон гарын үсэггүйгээр, түүний гэрчилгээгүйгээр хийх боломжгүй болно гэсэн үг. Гэхдээ хуульд "тоон гарын үсгийн төхөөрөмжийн төрөлд хязгаарлалт тогтоож болохгүй" гэж заасан байдаг. ЦХХХЯ нь "шаардлагад нийцсэн тоон гарын үсгийн төхөөрөмж"-ийг бэлтгэж, нийтэд нээлттэй болгохоор заасан⁴⁶. Гэхдээ 2023 оны эхний байдлаар ийм зүйл хийсэн эсэх нь тодорхойгүй байна. Утгаа ямар ч тохиолдолд ямар төхөөрөмж байж болох нь ч тодорхойгүй. Гэхдээ ЦХХХЯ-ны ийм алхам нь бизнес хоорондын гүйлгээг энгийн эсвэл тоон гарын үсгийн хүртээмжтэй хэлбэрийг ашиглахад дөхөмтэй байх юм. Мөн цахим худалдааны платформ дээр гарын үсэг зурсан гүйлгээг зөвшөөрөх боломжтой⁴⁷.

Гарын үсэг зургийн сонгох аливаа эрхэнд дараах чадамж орно гэж үздэг: гүйлгээнд гарын үсэг зурсан этгээдийн компьютерын аюулгүй байдлыг үнэлэх, найдвартай байдлын зохих түвшнийг өөрөө сонгох, гарын үсгийн өгөгдлийг аюулгүй байлгах. Эзэмшигч нь аюулгүй байлгаагүй тохиолдолд гэрчилгээг түдгэлзүүлж, эсвэл хүчингүй болгож болно⁴⁸. Нэмж дурдахад хүн хүлээн авсан цахим баримт бичиг дэх цахим гарын үсгийн статусыг шалгах чадвартай байх шаардлагатай.⁴⁹

Цахим гарын үсгийн тухай Монгол Улсын хууль нь ямар ч төрлийн цахим гарын үсгийг ашиглах боломжийг олгодог гэдгээрээ олон улсын шилдэг туршлагад нийцнэ, "технологийн хувьд ялгаварлахгүй байх" зарчимтай⁵⁰. Гэхдээ энэ хууль нь тоон гарын үсгийг ерөнхийд нь илүүд үздэг атал энэ нь "технологийн хувьд ялгаварладаггүй биш". Ийм гарын үсэг нь тодорхой төрлийн криптографид тулгуурладаг, олон төрлийн техникийн стандарттай, ихээхэн хүлээлт үүсгэсэн. Энэ байдал нь гүйлгээ хийхэд саад

⁴³ 25-р тайлбарыг харах, 7-р зүйл.

⁴⁴ 25-р тайлбарыг харах, 10-р зүйл.

⁴⁵ 25-р тайлбарыг харах, 14-р зүйл.

⁴⁶ 25-р тайлбарыг харах, 8.5 дахь хэсэг. Өөр нэг орчуулгыг харахад ЦХХХЯ нь хүлээн зөвшөөрөх төхөөрөмжийг жагсаалтыг гаргана гэж байна. Ийм өвөрмөц байдал нь боломжгүй юм. Зарим орчуулгад цахим гарын үсэг үүсгэх "төхөөрөмж" гэхээсээ илүү "хэрэгсэл" гэсэн байна. Технологийн хувьд бол "төхөөрөмж" гэдэг нь илүү тохиромжтой нэр томьёо юм. Монгол хэл дээр энэ хоёр үг адилхан утгатай.

⁴⁷ Худалдан авах, худалдах нь ямар ч тоон гарын үсэг байхгүйгээр арилжааны платформ дээр боломжтой юм шиг байна. Ийм хэлцлийн талууд Иргэний хуулийн нийтлэг зөвшөөрөлд тулгуурладаг, эсвэл талууд нь албан бус аргаар хоорондоо найдвартай гэрчлэлийг хангаж байгаа нь энэ байх.

⁴⁸ 25-р тайлбарыг харах, 18.1.6 дахь заалт, зөрчлийн талаар 14.3 дахь хэсэг.

⁴⁹Хугацаа нь дууссан, хүчингүй болсон тоон гэрчилгээний жагсаалтыг яамны цахим гарын үсгийн цахим хуудсанд байршуулсан байдал: <https://esign.gov.mn/#intro>

⁵⁰ Дэлхийн худалдааны байгууллага, Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр:
https://www.wto.org/english/tratop_e/tradfa_e/tradfa_e.htm.

Үүсгэж байгаа эсэхийг дор цахим худалдааны практикийн талаар хэлэлцсэн хэсэгт авч үзнэ.

Цахим гарын үсгийн тухай Монгол Улсын хууль олон улсын стандартад зарим талаараа нийцэж байна гэж дүгнэж болно. Энэ нь гүйлгээ хийж буй талуудад маш их уян хатан байдлыг бий болгосон боловч удирдамж бага, жишээлбэл, ямар гарын үсгийн технологийг аль тохиолдол ашиглах талаар. Гарын үсэг зурах баримт бичгийн үнэ цэнэ, ач холбогдолтой хамааралгүйгээр технологийг сонгох боломжийг талуудад үлдээгээгүй. Энэ хууль нь иргэд төрийн байгууллагуудтай харилцахад ихээхэн тустай. Энэ талаар дор дэлгэрэнгүй авч үзэх болно.

Холбогдох талуудын тоон гарын үсгийг ашиглах талаар тийм ч хатуу зохицуулалтгүй. Цахим гарын үсгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д “Хуулийн этгээд дотоод үйл ажиллагаандaa нийтийн түлхүүрийн дэд бүтэц ашиглах бол тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй” (эрх бүхий байгууллагаас гэрчилгээ авна гэсэн үг) гэж заасан байдаг. Дотоод зорилгоор компани, байгууллага бэлэн тоон гарын үсгийн программ хангамжийг худалдан авах боломжтой.

Тоон гарын үсгийг хуулийн хүчинтэй цахим гарын үсгийн цорын ганц хэлбэр (хэд хэдэн давуу талтай олон төрлийн тоон гарын үсэг зурах төхөөрөмж байж болох ч) болгоход тулгарч буй нэг бэрхшээл бол олон тооны хүмүүс тоон гарын үсэг үүсгэх боломжтой байх явдал юм. Гарын үсэг зурах түлхүүр, гэрчилгээ авахад хэр хялбар байдаг вэ?

Төрөөс тоон гарын үсгийн мэдээллийг иргэдэд өгөх, гарын үсгийн өгөгдөл, гэрчилгээг иргэний үнэмлэхийн цахим хувилбарт оруулах хөтөлбөр хэрэгжүүлсэн. Иргэд болон бусад этгээдэд зориулсан гэрчилгээний агуулгыг хуулийн 10 дугаар зүйлд заасан байдаг. Ийм гэрчилгээ авах боломжтой иргэдийн хувьд тоон гарын үсэг нь асуудал үүсгэхгүй. Гэвч Улаанбаатар хотоос гадуур олон хүн гарын үсгийн мэдээллээ авч чадаагүй, ийм гарын үсгийн мэдээллийг үнэгүй өгөх үе шат дууссан бололтой.

Тоон гарын үсэг нь маш найдвартай, итгэхүйц байж болох ч ашиглахад хэцүү, тэр ч байтугай үнэтэй байдаг ч бүх гүйлгээнд тийм хэмжээний аюулгүй байдлыг хангах шаардлагагүй. Цахим гарын үсгийн чанарын талаарх шийдвэрийг гүйлгээ хийгч талуудад өөрсдөө шийдэж болно, ялангуяа гарын үсэг зурсан гүйлгээнд олон нийтийн сонирхол байхгүй бол.

Гүйлгээний ач холбогдлыг эсвэл гарын үсэг зурах шаардлагатай бусад тохиолдолд хэд хэдэн хүчин зүйлээр үнэлж болно: талуудын төрөл - аль нэг нь төрийн байгууллага уу? Гүйлгээний үнэ цэнэ: гарын үсэг худал, гүйлгээ бүтэлгүйтвэл хэр их эрсдэлтэй вэ? Талуудын дүгнэлтээр бүтэлгүйтэх эрсдэл: тэд бие биенээ таньдаг уу, өмнө нь бизнес хамт хийж байсан уу, гүйлгээний мөнгөний хэмжээ өндөр үү, эсвэл хууль ёсных уу?

Хууль нь эдгээр хүчин зүйлийг талуудад тооцоолох ёстой гээд үлдээж болно, эсвэл заримыг нь эсвэл бүгдийг нь зааж өгч болно. Үүн дээр бол Азийн хамгийн түгээмэл арга бол төр, эсвэл төрийн зарим хэсэгтэй харилцаада тоон гарын үсэгтэй байх шаардлагатай байдаг. Хэн зурсныг тодорхойлоход ч, гарын үсэг зурсан баримт бичгийн агуулгын бүрэн бүтэн байдал нь ч хоёулаа ач холбогдолтой гэж үздэг.

Хуульд нь заримдаа гүйлгээ хийж буй талуудад ердийн гүйлгээ хийхдээ гарын үсэг зурах эсэх, ямар технологийг ашиглах асуудлыг өөрсдөө шийдвэрлэхээр орхисон байдаг бол өндөр үнэ цэнтэй хэлцэл хийх, төрийн байгууллагуудтай харилцахад илүү найдвартай байхыг шаарддаг бөгөөд энэ нь илүү их технологи шаарддаг. Ийм хууль тогтоомжийг

ихэвчлэн "хосолмол" хууль гэж нэрлэдэг - зарим талаараа ердийн цахим гарын үсэг, заримдаа тоон гарын үсгийг шаардсан байдаг.

Жишээлбэл, Сингапурын Цахим гүйлгээний тухай хуульд өөр өөр нөхцөл байдалд тоон болон цахим гарын үсгийг хуульчилсан байдаг⁵¹. Япон⁵², Энэтхэг⁵³ ч мөн адил. Европын холбоо ижил төстэй шалгуураар "шаардлагад нийцсэн" болон "шаардлагад нийцээгүй" гарын үсгийг ялгадаг⁵⁴.

Бодит байдал дээр монголчууд хувийн гүйлгээнд бус, төрийн байгууллагуудтай харилцахдаа төрөөс олгосон тоон гарын үсгийг ашиглах байна⁵⁵. Бусад харилцан үйлчлэлийн хувьд гарын үсгийн төрлийг хэлцэл хийгч талууд өөрсдөө мэдэх нь зүйтэй.

Монголын хууль тогтоомжид Цахим гарын үсгийн тухай хуульд заасан гарын үсгээс өөр "гэрчлэх" хэд хэдэн аргыг тусгасныг тэмдэглэх нь зүйтэй. Тоон гарын үсгийг олж авах, ашиглахад хэцүү төвөгтэй байгаа арилжааны харилцаанд эдгээр аргуудын заримыг ашиглахыг хуулиар зөвшөөрөх боломжтой юм.

Эдгээр өөр аргуудын ихэнх нь одоогоор төрийн салбарт хэрэгжиж байгаа бөгөөд төрийн бүртгэлийн найдвартай байдлаас шууд хамаардаг. Тухайлбал, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай⁵⁶ хуулийн 19 дүгээр зүйлд "Төрөөс хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхдээ хүн, хуулийн этгээдийг цахим гарын үсэг болон Засгийн газраас тогтоосон арга, хэрэгсэл бүхий танилт, нэвтрэлтийн системийг ашиглан танина" гэж заасан. Энэ нь Засгийн газарт тоон гарын үсэг, эсвэл уламжлалт гарын үсэгтэй төстэй цахим хэлбэрээс бусад баталгаажуулах аргыг хүлээн авах боломжийг олгож байгаа мэт. Мөн 22.1 дэх заалтад "үндсэн системээр илгээсэн, хүлээн авсан мэдээллийг илгээсэн, хүлээн авсан хугацаа, илгээгч, хүлээн авагч, мэдээллийн агуулгыг илэрхийлсэн дахин давтагдашгүй утга болон бусад мэдээллийг мэдээлэл солилцооны бүртгэлийн системээр бүртгэнэ" гэжээ.

Хуулийн 24.4-т "Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс олгосон давтагдашгүй дугаар бүхий цахим баримт бичиг нь цаасан баримт бичгийн нэгэн адил хүчинтэй байна" гэж заасан. Гарын үсгийн талаар дурдаагүй. Баримт бичгийг хадгалагчаас олгосон өвөрмөц таних тэмдэг нь бичлэгийг бусад хүмүүс ашиглах боломжтойг хангалттай илэрхийлж байна. Түүнчлэн уг хуулийн 30 дугаар зүйлд "Хуульд өөрөөр заагаагүй бол цахим баримт бичиг нь цаасан баримт бичигтэй нэгэн адил хүчинтэй" гэж заасан байдаг. "Төрийн байгууллага, албан тушаалтан хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд цахим хэлбэрээр харилцахдаа албаны цахим шуудан болон энэ хуулийн 21, 23, 24 дүгээр зүйлд заасан дэмжих системийг ашиглана"

⁵¹ Сингапурын Цахим гүйлгээний тухай хууль, 2010 (2020 оны шинэчилсэн найруулга), <https://sso.agc.gov.sg/Act/ETA2010> Гарын үсгийн 8-р хэсэг, аюулгүй цахим гарын үсгийн 18-р хэсгийг үзнэ үү.

⁵² Adobe, Цахим гарын үсгийн хууль ба дүрэм - Япон, <https://helpx.adobe.com/legal/esignatures/regulations/japan.html>

⁵³ Adobe, Цахим гарын үсгийн хууль ба дүрэм - Энэтхэг, <https://helpx.adobe.com/legal/esignatures/regulations/india.html>

⁵⁴ Европын холбоо, цахим гарын үсгийн түгээмэл асуултууд, онлайн: <https://ec.europa.eu/digital-building-blocks/wikis/display/DIGITAL/eSignature+FAQ>

⁵⁵ ЦХХХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга З.Гантоогоотой хийсэн ярилцлагаас, 2022.10.17

⁵⁶ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601>

Үүний нэгэн адил Архивын тухай хуульд⁵⁷ цахим баримт бичгийг цахим гарын үсэг, эсвэл тусгай дугаараар баталгаажуулна гэж заасан нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан зарчим мөн.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд⁵⁸ бичгээр гэрээ байгуулан данс нээсэн харилцагчид тухайн данстай холбоотой хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж болно, цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд нууцлалын шаардлага хангасан нууц үг, нууц код, цахим гарын үсэг зэргийг ашиглаж болох бөгөөд эдгээрийг цахим хэлбэрээр хийсэн шилжүүлэг, зээлийн гэрээ, бусад хэлцэлд зурсан гарын үсэгтэй адилтгаж үзнэ гэжээ. Энэ хуульд хамаарах санхүүгийн байгууллага нь цаасан дээр гарын үсэг зурсан эрх олгох гэрээтэй харилцагчдадаа онлайн үйлчилгээ үзүүлж болохыг дурдах нь зүйтэй⁵⁹

Товчхон тайлбарлахад, Цахим гарын үсгийн тухай хуулийн дагуу тоон гарын үсэг ашиглахад нарийн төвөгтэй бас хяналттай байх талтай учраас зарим төрийн байгууллагууд баталгаажуулалтын өөр хэд хэдэн аргын ашиглахыг зөвшөөрдөг.

Ийм уян хатан (болон ихэвчлэн технологийн хувьд төвийг сахисан) зохицуулалтыг замаар хувийн хэвшлийн хэрэглэгчдэд мөн зөвшөөрч болох юм, ингэхдээ өөр өөр нөхцөл байдалд аюулгүй байдлын хангах баталгаажуулалтад зохих дүн шинжилгээ хийх. Зарим хүн цахим худалдааны платформоор хийсэн гүйлгээнд “тоон гарын үсэг ашигладаггүй” гэж боддог. Үнэн хэрэгтээ бол Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсгийн систем хараахан ашиглалтад ороогүй байна.

Хэрэв арилжааны платформууд гарын үсэг ашигладаг бол энэ нь уг тайланд хэлэлцэж: буй хуулиудын хамрах хүрээнээс гадуур мэт санагдаж байна. Иргэний хуулийн 196 дугаар зүйлийн 196.1.8-д Цахим гарын үсгийн тухай хуульд зааснаас илүү өргөн хүрээтэй уян хатан нөхцөл өгсөн нь харагдаж байна.

196.1.8.цахим хэлбэрээр гэрээ хийх бол талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлснийг харилцан хүлээн зөвшөөрч цахим гарын үсэг зурснаар.

Дээрх заалтын хоёр дахь хэсэг нь талууд өөрсдөө тохиролцон хүлээн зөвшөөрч болох шинэлэг санааг бий болгох боломжийг бүрдүүлжээ, энэ нь цахим гарын үсгийн талаар юм, тоон гарын үсэг биш.

Яам нь Цахим гарын үсгийн тухай хуулийн 8.5-д заасныг ашиглан платформуудын ашиглах тоон гарын үсгийн төрлийг тодорхойлж болохоор байна.

Худалдааны платформуудын хувьд бараа захиалах, онлайнаар төлбөр хийх чадвар нь практик зорилгоор хангалттай баталгаажуулалт байж болно. Худалдагч нь яг хэн гэдэг хэрэглэгчтэй харьцаж байгаагаа мэдэх шаардлагагүй, зөвхөн зарсан зүйлийнхээ төлбөрийг авах хүсэлтэй. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн

⁵⁷ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, 38 дугаар зүйл: <https://legalinfo.mn/mn/detail/15370>

⁵⁸ Банкны мөнгөн хадгаламж, мөнгөн гүйвуулга, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1 дэх заалт: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230554816671>

⁵⁹ 58-р тайлбарыг харах.

найруулгын төсөлд ямар этгээд өөр хэлцэл хийгч этгээдэд өөрийгөө таниулах ёстой, энэ үйлдлийн үр дагаврын талаар тодорхой зохицуулалтуудыг тусгасан байна.⁶⁰

Иргэний хуульд нотариатаар баталгаажуулах шаардлагатай олон тооны хэлцлийн талаар заасан нь (цаасан) гарын үсэгт үл итгэх байдлыг илэрхийлж байгаа мэт. Энэхүү хандлага нь цахим гарын үсгийг эрсдэл багатай гэж дэмжиж болох юм, тухайлбал зөвхөн технологид санаа зовдоггүйгээс гадна ерөнхийдөө гарын үсэг зурах, баталгаажуулах явцын хувьд тоон гарын үсгийг илүүд үзэх хандлага байна.

1. Тоон гарын үсэг

Монголд хэрэглэж буй цахим гарын үсгийн дийлэнх нь техникийн хэлээр бол "тоон гарын үсэг" гэж үзэж болох юм. Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т зааснаар тоон гарын үсэг нь "хувийн түлхүүр /цаашид "хувийн түлхүүр" гэх/ ашиглан мэдээллийг шифрлэж хувиргалтад оруулж үүсгэсэн мэдээлэл" юм⁶¹.

Тухайн шифрлэлтийг "хос түлхүүр" эсвэл "нийтийн түлхүүр" гэж нэрлэдэг. Математикийн хоёр түлхүүрийг хамтад нь үүсгэдэг (ихэвчлэн баталгаажуулалтын байгууллага) бөгөөд нэг түлхүүрээр ("хувийн түлхүүр") шифрлэгдсэн зүйлийг зөвхөн нэгөө түлхүүрээр ("нийтийн түлхүүр") тайлж чаддаг юм. Хоёр түлхүүрийн аль нэгийг нь эзэмшигч (ихэвчлэн гэрчилгээ эзэмшигч учраас) тухайн түлхүүрээр ямар нэгэн зүйлд гарын үсэг зурсан бол нэгөө түлхүүрээр гарын үсгийг тайлж байгаа этгээд нь гэрчилгээ эзэмшигч тал гарын үсэг зурсан гэдэгт итгэлтэй байж болно.

Энэ систем нь хувийн (гарын үсэг зурах) түлхүүрийг агуулсан төхөөрөмжийн (жишээ нь, компьютер, утас, таблет) аюулгүй байдлаас хамаардаг тул гэрчилгээ эзэмшигчээс өөр хэн ч юунд ч гарын үсэг зурж чадахгүй. Ийм учраас уг сэдвийн тухай хуулиуд, түүний дотор Цахим гарын үсгийн тухай хуулийн 14.3-т зааснаар гэрчилгээ эзэмшигч нь "хувийн түлхүүрийн нууцлал, аюулгүй байдлыг хангах", гарын үсэг зурах төхөөрөмж, эсвэл тоног төхөөрөмжид байгаа гарын үсэг зурах мэдээллийн аюулгүй байдал алдагдсан тохиолдолд гэрчилгээжүүлэх байгууллагад мэдэгдэх ёстой. Ингэснээр тухайн мэдээллийг ашиглан гарын үсэг зурах боломжгүй болно (тэр ч байтугай аюулгүй байдал алдагдахын өмнө зурсан гарын үсгийг найдвартай гэж үзэхгүй байгаа бол сүүлд зурсан гарын үсгийг ч хүчингүй болгоно.)⁶²

Энэхүү тайлангийн хамрах хүрээнээс гадуур тоон гарын үсгийн ердийн хэрэглээний бусад техникийн шаардлагууд байдаг.⁶³ Эдгээр шаардлагууд нь дэлхий даяар тоон гарын үсгийг хэрхэн зохицуулж байгаа үндсэн шаардлагууд юм⁶⁴. Монгол Улсын хууль

⁶⁰ Тайлангийн V.C хэсгийг харах, мөн 215-р тайлбар

⁶¹ 25-р тайлбарыг харах, ИХ-ийн 4.1.3 and 6.2.

⁶² Нэмэлт мэдээлэл. 25-р тайлбар, ИХ-ийн 14.3.2 and .3.

⁶³ Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны тухай багц журмын төсөл 2022 оны 9-р сард гарсан: Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтэц ерөнхий дүрмийн төсөл; Тоон гарын үсгийн гэрчилгээний мэдээллийн санг үүсгэх, ашиглах, хадгалах журмын төсөл; Бүртгэлийн журмын төсөл; ба Гэрчилгээний үйлчилгээний тарифыг тодорхойлох арга зүй. <https://mddc.gov.mn/mn/%d1%85%d1%83%d1%83%d0%bb%d1%8c-%d1%8d%d1%80%d1%85-%d0%b7%d2%af%d0%b9/>

⁶⁴ Кибер аюулгүй байдал ба дэд бүтцийн аюулгүй байдлын агентлаг (АНУ), "Тоон гарын үсгийг хэрхэн ашиглах вэ", 2020 онд хянан засварласан, цахим: <https://www.cisa.gov/uscert/ncas/tips/ST04-018>. UNCITRAL-aas 2007 онд "Цахим худалдаанд итгэх итгэлийг дэмжих нь: цахим баталгаажуулалт ба гарын үсгийн аргуудыг олон улсын хэмжээнд ашиглах эрх зүйн асуудлууд", гарын үсэг, баталгаажуулалтын тухай дэлхийн хууль тогтоомжийн хүрээнд тоон гарын үсгийн талаар илүү нарийчилсан тоймыг 2007 онд нийтлэв. Цахим: https://uncitral.un.org/sites/uncitral.un.org/files/media-documents/uncitral/en/08-55698_ebook.pdf. Тоон гарын үсгийн тухай 17-27-р хуудсанд өгүүлсэн буй.

тогтоомжтой дүйцэхүйц UNCITRAL-ийн Цахим гарын үсгийн тухай загвар хуулийг технологийн хувьд төвийг сахих зарчмаар, өөрөөр хэлбэл ажиллуулахад онцгой технологийг шууд шаардахгүй, амьдрал дээр, зурагдсан гарын үсгийн тухайд, нийтийн түлхүүрийн шифрлэлтийг ашиглан найдвартай байхаар тоон гарын үсгийг ихэвчлэн авдаг.

2. Итгэлцлийн үйлчилгээ

Итгэлцлийн үйлчилгээ нь цахим харилцааны баталгаатай байдлыг гэрчилнэ. Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгчид нь ихэнхдээ цахим гарын үсгийг бий болгоход ашигласан өгөгдлийг (код, шифрлэсэн түлхүүр) гаргагчид байдаг бөгөөд ихэнхдээ цахим гарын үсэг дотор кодолсон гарын үсгийн өгөгдлийг этгээд (иргэн, хуулийн этгээд), эсвэл гарын үсэг зурахаар өгөгдлийг ашигласан аж ахуйн нэгжтэй холбосныг гэрчлэх үйлчилгээ үзүүлэгч байна. Цахим гарын үсэг нь тааварлашгүй код байх бөгөөд тухайн гэрчилгээ нь “Энэ гарын үсэг бол “Х”-ийнх мөн” гэдгийг нотолно.

Монголд тус итгэлцлийн үйлчилгээг үзүүлэгч байгууллагыг (тоон гарын үсэг олгох, түүнийхээ үйл ажиллагаанд хяналт тавих зөвшөөрөлтэй) тусгай зөвшөөрөл бүхий гэрчилгээжүүлэх байгууллага гэнэ⁶⁵

Итгэлцлийн үйлчилгээ гэх үгний “итгэл” гэдэг нь тухайн цахим гарын үсэг нь гарын үсэг зурагч этгээдийнх мөн гэдгийг бататгана.

Зарим цахим гарын үсгийг ашиглах зориулалт нь илүү аюулгүй байдал шаардах учраас илүү найдвартай технологи, арга барилыг ч мөн шаарддаг⁶⁶

Түүнчлэн, зарим итгэлцлийн үйлчилгээ нь бодит байдал дээр бусдаасаа илүү найдвартай байдаг. Тиймээс цахим гарын үсгийн хуульд тусгай зөвшөөрөл эзэмшигч, гэрчилгээжүүлэх байгууллага үүсгэн байгуулах, тэдний үүргийн биелэлт, аюулгүй байдал болон үйл ажиллагааны хяналт, даатгал, гэрчилгээний агуулга зэргийг нарийвчлан тусгадаг.

Цахим гарын үсгийг олгох, аюулгүй байдлыг нь хангах, гэрчлэхтэй холбогдсон ажиллагаа, технологи болон дүрэм журмын тогтолцоог бүхэлд нь “Нийтийн түлхүүрийн дэд бүтэц” буюу Public Key Infrastructure - PKI гэдэг⁶⁷.

Тус хуульд цахим гарын үсэг олгогч болох гэрчилгээжүүлэх байгууллагуудад тавигдах шаардлагуудыг нарийн тодорхойлно⁶⁸. Эдгээр шаардлагууд нь ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай техникийн ур чадвар, санхүүгийн тогтвортой байдал /хэрэв тухайн байгууллага шүүхийн шийдвэрийг хангах шаардлага гарвал/ болон ажил үүргээ гүйцэтгэх хариуцлага тусгагдана.

Түүнчлэн, Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санхүүгийн сахилга бат,

⁶⁵ 25-р тайлбарыг хэрэх, 10-р зүйл (“гэрчилгээ”), 20-р зүйл (“Гэрчилгээжүүлэх байгууллага”) ба 23-р зүйл (“Гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”)

⁶⁶ Тоон гарын үсгийн тухай судалгаанд янз бүрийн төрлүүдийнх нь “баталгааны түвшин”-ийг тайлбарласан боловч өөр өөр итгэлцлийн үйлчилгээний нэгж нь өөрийн түвшнийг өөрөөр нэрэлдэг байж болно. Төрөл бүрийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийн баталгааны янз бүрийн түвшнийг ойлгох, улмаар тэдгээрийн найдвартай байдлыг харьцуулах нь төвөтэй бөгөөд цаг хугацаа их шаарддаг.

⁶⁷ Монголын PKI-ийн техникийн ажиллагааны талаар Цахим хөгжил, харилцаа холбооны яамны хуудсанд тайлбарласан болно: <https://esign.gov.mn/#intro i>

⁶⁸ 25-р тайлбарыг харах, 20, 21, 22-р зүйл

цаашилбал, гэрчилгээжүүлэх байгууллагуудын дүрэм журам, зохицуулалтыг бий болгож, РКИ-ийн үйл ажиллагааг гадаад улс орон, олон улсын байгууллагуудтай уялдуулах чиглэлээр ажиллана⁶⁹. Харилцаа холбооны зохицуулах хороо нь РКИ-г зохих стандарт, журамтай байлгахын тулд өндөр түвшний үүрэг хүлээнэ⁷⁰.

Итгэлцлийн үйлчилгээтэй холбоотой Монголын хууль нь бусад улс орнуудын ижил хууль дүрмүүдтэй төстэй бөгөөд гэрчилгээжүүлэх байгууллагуудын найдвартай байдлыг хангах үүднээс зарим талаар НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын цахим гарын үсгийн загвар хуулийг загварчилсан болно.⁷¹

Хамгийн сүүлд НҮБ-ын UNCITRAL-ийн Цахим худалдааны Ажлын хэсэг Иргэний үнэмлэх, итгэмжлэлийн үйлчилгээг ашиглах, хил дамнан хүлээн зөвшөөрөх тухай үлгэрчилсэн хуулийн төслийг⁷² боловсруулж, түүнийг 2022 оны 6-р сард НҮБ-ын UNCITRAL-ын нэгдсэн хуралдаанаар, 12-р сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей баталсан. Хувийн менежерүүд (арилжааны оролцогчдыг тодорхойлж, тэдний шинж чанарыг баталгаажуулсан хүмүүс) болон итгэмжлэгдсэн үйлчилгээ үзүүлэгчид (Загвар хуулийн төслийн 6, 10-р зүйл)-ийн гүйцэтгэсэн үүрэг хариуцлага нь НҮБ-ын UNCITRAL дүрмийг амжилттай боловсруулсан олон улсын шилдэг туршлага болж магадгүй юм. Монгол Улсын хувьд хууль тогтоомж нь энэхүү шинэ загвар хуультай зарчмын хувьд нийцэж байгаа эсэх, ялангуяа худалдааны түншүүд Европын хэм хэмжээний нөлөөнд автсан тохиолдолд авч үзэх нь зүйтэй болов уу. Энэ талаар хөдөлшгүй зөвлөмж өгөхөд эрт байна.

Монгол болон бусад улс орнуудад цахим гарын үсэгтэй холбоотой томоохон олон улсын санаачилга бол Дэлхийн худалдааны байгууллагын нэг хэсэг болох “Цахим худалдааны хамтарсан санаачилга”⁷³-аас саяхан боловсруулж тохиролцсон цахим гарын үсэг, баталгаажуулалтын тухай текст юм. Уг бичвэр нь хэрэгжүүлэхэд бэлэн хууль болоогүй байгаа ч хэдэн жилийн дараа эрх зүйн хөгжлийг тодорхойлно⁷⁴.

3. Гадаад улсын гарын үсэг ба гэрчилгээ

Монгол Улсын хуульдаа Цахим гарын үсгийн загвар хууль гадаадын гарын үсгийг хүлээн зөвшөөрөхийг заасан байдаг. Загвар хуульд гадаадын цахим гарын үсгийн найдвартай байдлын түвшин нь харьцуулж болохуйц байвал дотоодын цахим гарын үсэгтэй адил хүчинтэй байх ёстой гэж заасан⁷⁵. Монгол Улсын Цахим гарын үсгийн тухай хуульд гарын үсгийг гадаад улсын гэрчилгээ гэж нэрлэсэн. Энэ хуулийн 19 дүгээр зүйлд дараах хоёр нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд гадаадын гэрчилгээг Монгол Улсын гэрчилгээтэй адилтган хэрэглэж болно:

⁶⁹ 25-р тайлбарыг харах, 31-р зүйл.

⁷⁰ 25-р тайлбарыг харах, 32-р зүйл.

⁷¹ 25-р тайлбарыг харах, article 10-р зүйл.

⁷² Загвар хууль, 2022 оны 2-р сарын 21, A/CN.9/1112 баримт бичиг хэлбэрээр онлайн байна: https://uncitral.un.org/sites/uncitral.un.org/files/media-documents/uncitral/en/acn9-1112_e.pdf Загвар хуулийг 2022 оны сүүлээр НҮБ-н чуулганы нэгдсэн хуралдаанаар эцслэн батлах төлөвтэй.

⁷³ ДХБ, “Цахим худалдааны хэлэлцээ: гишигд нь цахим гарын үсэг болон баталгаажуулалтын тухай “эцсийн текст”-ийг эцслэв” 2021.04.21, www.wto.org/english/news_e/news21_e/com_20apr21_e.htm

⁷⁴ Баталгаажуулалт, гарын үсэг болон бусад асуудлын талаар илүү өргөн хэлэлцүүлгийг АСЕАН-аас 2022 оны 3-р сард онлайнаар хийсэн, түүний хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг эндээс үзнэ үү https://asean.org/wp-content/uploads/2022/03/Work-Plan-E-commerce-Agreement_endorsed_logo.pdf.

⁷⁵ MLEC конвенц, 30-р тайлбарыг харах, 13-р зүйл.

- Гадаад улсын гэрчилгээжүүлэх байгууллага нь хууль, холбогдох журамд заасан шаардлагыг хангаж байгаа талаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан;
- Монгол Улсын олон улсын гэрээгээр гадаад улсын гэрчилгээжүүлэх байгууллагын гэрчилгээг хүлээн зөвшөөрсөн.

Эдгээр шалгуур нь гадаадын цахим гарын үсгийн найдвартай байдлын түвшний ижил төстэй эсэхэд онцгой анхаарал хандуулдаггүй ч энэ нь аль ч талаараа лавлагааны анхаарлын төвд байх магадлалтай юм.

Гэтэл одоогийн байдлаар ийм албан ёсоор хүлээн зөвшөөрөөгүй, гэрээ байгуулаагүй учраас бодит байдал дээр гадаадын гарын үсэг буюу гадаадын гэрчилгээтэй гарын үсэг Монголд хүчин төгөлдөр бус байна.

В. Цахим худалдааны хуульд оруулж болох бусад асуудал: олон улсын жишиг загварууд

Цахим худалдааны тухай хуульд өнөөг хүртэл яригдсан хоёр том сэдвийг тусгасан байх ёстой: "цаасан" баримт бичиг цахим болсон үед түүний эрх зүйн байдал, найдвартай цахим гарын үсгийг хэрхэн бий болгох вэ. Монгол Улс энэ хоёр чиглэлээр хууль тогтоомж гаргасан бөгөөд эдгээр асуудлаар нэмэлт хууль тогтоомж гаргах шаардлагагүй байж магадгүй ч цахим гарын үсгийн тухай хуульд тоон гарын үсгийг бус цахим гарын үсгийг ашиглах, эсвэл эсрэгээр нь ямар тохиолдолд ашиглах талаар тодорхой болгох нь зүйтэй.

Харин НҮБ-ын UNCITRAL-ийн Загвар хуулиудад Монголын хуульд ороогүй байгаа бусад харилцааг авч үзсэн байдаг. Монгол улс нь эдгээр харилцааны заримыг тус улсын цахим худалдааны зорилгод нийцэж буй эсэхийг авч үзэх нь зүйтэй.

1. Мэдээлэл нь зөвхөн цахим хэлбэрт байгаа нь хуулийн чадал хүчин бага гэсэн үг биш

Үүнийг UNCITRAL-н "ялгаварлан гадуурхахгүй байх" зарчим⁷⁶ гэдэг. Хуулийн хүчинтэй аливаа мэдээлэл нь түүний хэлбэр, агуулгын талаарх дүрэмд нийцсэн тохиолдолд цахим хэлбэрээр байж болно гэсэн ерөнхий дүрэм мөн. Зарчим нь хил дамнасан цахим харилцаа холбоог хаана ч ижил хүчинтэй байлгах шийдэл юм. Цахим харилцаа нь цаасанд сууриссан уламжлалт харилцаатай ижил төстэй үйл ажиллагаа, иймд ижил хүчинтэй гэсэн зарчмыг дэмждэг.

2. Цахим нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх

Цахим баримт бичиг хүчинтэй байж болох ч талууд түүний хүчин төгөлдөр байдлыг нотлох шаардлагатай гэх асуудал гардаг, жишээ нь шийдвэр гаргагчид, эсхүл шүүхэд. Иймд цахим баримт бичгийг шүүх зэрэг эрх мэдлийн байгууллагууд хүлээн авдаг байх ёстой. Цахим харилцаа холбооны загвар хуульд (MLEC)⁷⁷ дахь UNCITRAL-ийн дүрэм бол нотлох баримтыг зөвхөн цахим хэлбэрт байна гэсэн үндэслэлээр хүлээн зөвшөөрөхгүй байж болохгүй. Цахим нотлох баримтын хүчинтэйг үнэлэх өөр шалгуурууд байдаг ч тэдгээрийг энэхүү тайлангийн хамрах хүрээнд оруулсангүй. Одоогийн байдлаар Монголын хуульд зарим эрүүгийн хэрэгт цахим нотлох баримтыг зөвшөөрдөг, мөн иргэний хэрэг

⁷⁶ MLEC конвенцын 19-р тайлбарыг харах, 5-р зүйл.

⁷⁷ MLEC 19-р тайлбарыг харах, 9-р зүйл.

хянан шийдвэрлэх ажиллагаанд ч хэрэглэж байгаа, гэхдээ ийм нотлох баримтыг хэрхэн шүүхэд танилцуулах талаар дэлгэрэнгүй зохицуулалт алга⁷⁸.

3. Баримт бичгийн бүртгэл хадгалах журам нь цахим орчинд мөн үйлчилнэ

Хууль тогтоомж нь хувь хүмүүс, бизнес эрхлэгчдээс татварын шалгалт, мэргэжлийн хяналт эсвэл шүүхийн маргаанд ашиглах зорилгоор баримтын бүртгэл хадгалахыг шаарддаг. Энэ талаарх UNCITRAL-ийн дүрэм⁷⁹ бол цахим баримт бичгийг цаасан баримт бичигтэй ижил зорилгоор, ижил хугацаанд зохих хүмүүс нь бүртгэн хадгалж, тэдгээрт хандан лавлагаа авах боломжтой байна гэсэн байдаг.

4. Цахим мессежийг илгээх, хүргэх хугацаа

Цахим мессеж нь ихэвчлэн “интернэт үйлчилгээ үзүүлэгч” (ISP) болон бусад компьютеруудаар дамжуулан илгээгчээс хүлээн авагч хүртэл дамждаг. UNCITRAL нь “жинхэнэ” илгээгч нь хэн болох, мессежийг хэзээ хүлээн авсан гэж үзэх талаар тодорхой дүрэмтэй⁸⁰.

5. Цахим гэрээг хүний оролцоогүйгээр хийж болно

Цахим биш бодит орчинд гэрээ хэлэлцээрийг худалдагч, худалдан авагч хоёр харилцан тохиролцсоноор хийдэг. Иргэний хуульд тодорхой нөхцөл байдалд тохиролцоонд хүрсэн гэж үзэх тухай тодорхой заалтуудтай. Хүмүүс цахим хуудастай харьцах үед тухайн этгээд хэзээ саналыг хүлээж авсан гэж үзэх, эсвэл цахим хуудас санал болгосон бол түүнийг хязгааргүй тооны хүмүүс хүлээж авах боломжтой ю? UNCITRAL нь автоматжуулсан гүйлгээ нь хүчинтэй гэрээ мөн гэдэг. Гэхдээ ийм гэрээ санал болгох чадамжтай цахим хуудаснууд саналыг дэлхий даяар дуртай нэг нь хүлээн зөвшөөрөхүйц санал тавьсан гэж үздэггүй. Эдгээр нь дэлхий дахинд санал тавьсан урилга мөн гэж үздэг. Харин цахим хуудас руу “худалдан авах” мессеж илгээж байгаа хүн хууль ёсны дагуу бас авах саналаа илэрхийлж байгаа болохоос сайтын саналыг хүлээж авсан гэсэн үг биш.⁸¹

6. Төхөөрөмжтэй харилцахад гарсан алдааг засах

Хэлэлцээрийн үеэр хүмүүс харилцахдаа заримдаа алдаа гаргадаг. Хэрэв гэрээг төхөөрөмж (жишээ нь веб сайтын компьютер)-өөр хийсэн бол залруулга хийх ямар нэг арга байна уу, эсвэл хэтэрхий оройтсон уу? Худалдагчийн компьютерт мессеж илгээсэн бол гэрээ нь эцсийн бөгөөд заавал биелүүлэх шинжтэй ю, буруу, алдаатай хийсэн ч үү? Загвар хуульд энэ асуудлыг зохицуулаагүй, гэхдээ Цахим харилцааны конвенцод тусгажээ⁸². Хүлээн авагч тал нь хянан засварлах боломж олгоогүй байсан бол илгээсэн тал нь алдаатай харилцааг эргүүлэн татах эрхийг заасан, ингэхдээ алдаа гаргаснаас болж аль нэг тал ямар нэгэн ашиг хүртээгүй бол.

⁷⁸ Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 37.2 дахь хэсэг <https://legalinfo.mn/mn/detail/302>

⁷⁹ MLEC 19-р тайлбарыг харах, 10-р зүйл.

⁸⁰ MLEC 19-р тайлбарыг харах, 13-р зүйл.

⁸¹ Цахим харилцаа холбооны ЕСС конвенц, 20-р тайлбарыг харах, 11-р зүйл

⁸² Цахим харилцаа холбооны ЕСС конвенц, 20-р тайлбарыг харах, 14-р зүйл

Монгол Улсын Иргэний хуульд хайхрамжгүй хандсан, буруу ташаа мэдээллээс үүдэлтэй алдааны талаар хэд хэдэн заалт бий, тэдгээр нь Цахим харилцааны ЕСС конвенцын 14-р зүйлтэй сайн нийцэж байна.

Г. Цахим худалдааны хуульд тусгаж болох бусад асуудал:

Монголын талын санал

UNCITRAL дээр дурдсан хоёр загвар хуулийг аль болохоор "минималист" байдлаар боловсруулсан ч мэдээж цахим худалдаанд бусад зохицуулах шаардлагатай асуудал байна гэдэг нь тодорхой. Заримыг нь дэлхийн түвшинд уялдуулах боломжгүй, заримыг нь хараахан зохицуулалтын туршлагагүй улмаас UNCITRAL шийдвэрлээгүй юм. UNCITRAL загвар хууль тогтоомж байхгүй нь ийм асуудлыг хуулиар зохицуулах нь олон улсын жишигт нийцэхгүй гэсэн үг биш юм. Жишгийг бусад эх сурвалжаас харгалзан авч болно.

2022 оны 6-р сард цахим худалдаанд оролцогч хувийн хэвшлийн болон төрийн байгууллагууд, онлайн бизнес эрхэлдэг, үүнд зохицуулалт хийх үүрэгтэй байгууллагуудын семинарыг зохион байгуулж, Монголын өнөөгийн цахим худалдааны хууль, эрх зүйн орчин, түүнийг сайжруулах талаар санал бодлоо солилцсон. Төрийн болон хувийн хэвшлийн оролцогчдын ихэнх нь биш ч гэлээ зарим нь Цахим худалдааны тухай тусгай хууль нь байх бол илүү тодорхой, нэгдмэл байдлыг бий болгоход тустай гэж үзсэн.

Тэдний санаа бодлын ихэнх нь хууль тогтоох гэхээсээ илүү практик эсвэл техникийн шинж чанартай байв. Жагсаалтыг дор оруулав. Зарим санаануудын талаар дэлгэрэнгүй хэлэлцүүлгийг цахим худалдааны зохицуулалтын тогтолцооны холбогдох хэсэгт дор оруулав. Практик асуудлуудыг нь үүний дараах хэсэгт тусгав. Хууль тогтоомжийн үр дагаврыг энэхүү тайлангийн дараагийн хэсгүүдэд дэлгэрэнгүй авч үзнэ.

- Албан ёсны цахим худалдагч болон нийгмийн сүлжээнд, онлайнаар хувиараа борлуулалт хийдэг хүмүүсийн хооронд шударга ёс, тэр дундаа татварын шударга байдал хэрэгтэй.
- Залилан, цахим гэмт хэргээс хамгаалах шаардлагатай. Эрүүгийн хуульд зарим зүйл заалт байгаа⁸³ бөгөөд 2021 оны (2022 оны 5-р сараас хэрэгжиж буй) Кибер аюулгүй байдлын тухай шинэ хууль энд өндөр ач холбогдолтой байна. Энэ сэдвийг энэ тайлангийн зохих хэсэгт авч үзсэн болно.
- Стандартыг зарим бүтээгдэхүүнд хамааруулах асуудлыг онлайн худалдаанд шийдвэрлэх шаардлагатай, жишээлбэл, эмнэлгийн хэрэгслийн хувьд.
- Цахим худалдааг төрийн нэг байгууллага хариуцах ёстой.
- Хууль тогтоомж нь олон улсын конвенцод нийцсэн байх ёстой.
- Цахим худалдааны хууль хараахан гараагүй байгаа тул энэ үйл ажиллагаа нь худалдааны ерөнхий хуульд нийцэх ёстой.

⁸³ V. Ё хэсгийг харах, 257-р тайлбар

III. ЦАХИМ ГҮЙЛГЭЭГ АШИГЛАХ

Монгол Улсын хууль тогтоомж нь сүүлийн арав гаран жилийн хугацаанд цахим худалдаанд илүү нийцэж эхэлсэн гэдгийг өмнө дурдсан билээ. Гэхдээ хуулийн заалтууд ямар нэг шалтгааны улмаас тэр бүр худалдааны ажиллагаанд нийцээд байдаггүй. Энэ нь бизнес эрхлэгчид цахим хэлбэрт шилжих боломжоо олж хардаггүй, техникийн ур чадвар дутмаг, эсвэл компьютер тоног төхөөрөмжийн хангалтгүй байдалтай нь холбоотой байж магад. Мөн худалдааны дотоод, гадаад түншүүдэд нь ч ижил асуудал тулгардаг байхыг үгүйсгэхгүй. Харин хуулийн заалтууд нь энэ байдлыг өөрчлөхөд хангалттай тодорхой биш ч байж болно.

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомж сайн нийцэж байгаа эсэхийг тогтоохоор манай төслийн баг (ялангуяа А.Дэлгэрмаа) хувь нэмэр оруулж Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран хувийн хэвшил болон төрийн оролцогч талуудыг хамарсан, цахим худалдааг хуульчлах тухай асуудлаар семинар зохион байгуулсан. Энэ хэсэгт тухайн семинараас олж авсан мэдээллүүд болон бидний ажиглалтын үр дүнг цохон тэмдэглэв.

Цахим худалдааг хялбаршуулахад шаардлагатай гэж үзсэн асуудлууд:

- Хилийн асуудал: бараа бүтээгдэхүүн импортлох болон экспортлоход хил хаагдах, удаашрах асуудал үүсдэг.
- Хүргэлтийн үйлчилгээ, ялангуяа алслагдсан бүсүүдэд төвөгтэй бөгөөд өндөр зардалтай
- Бүтээгдэхүүн үйлчилгээний чанарт итгэдэггүй
- Мэдээллийн аюулгүй байдалд анхаарал хандуулах шаардлагатай
- Цахим төлбөрийн хэрэгслүүд дээр хяналт тавих шаардлагатай
- Залилан мэхлэх, хуурамч цахим хуудсууд олон бөгөөд найдвартай системүүд нь өртөг өндөр
- Утасны СИМ картад суурилсан цахим гарын үсэг нь иргэний үнэмлэх ашиглахаас илүү хялбар. Монголд СИМ картад суурилсан цахим гэрчилгээ олгодог газрууд байдаг. Tridum e-security⁸⁴ болон Мобиком корпорацын⁸⁵ хамтын гэрээгээр тэд 2019 оноос эхлэн хэрэглэгчдээ СИМ картад суурилсан цахим гэрчилгээ санал болгож эхэлсэн.
- Иргэдээд цахим худалдааг сурталчлан, таниулах нь үйлчилгээг илүү хялбаршуулж өгнө.
- Хамтын ажиллагаа нь худалдаа эрхлэгч, худалдан авагч болон хууль тогтоо шатныханд эдийн засаг болон практик ач холбогдолтой байх болно.

A. Хувийн хэвшил

Олон монголчууд хувийн борлуулагчаас, эсвэл хувийн платформоос цахим худалдаа хийдэг. Тэд дэлхийд нэрд гарсан платформуудыг бас ашигладаг, зарим нь Монголд эсвэл Монголыг хамруулан ажиллаж байна⁸⁶.

⁸⁴ Tridum e-Security: <https://www.tridum.mn/eng> ("нийтийн түлхүүрийн дэд бүтэц" гэсэн хэсгийг харах)

⁸⁵ Мобиком ХК, <https://www.mobicom.mn/en?mid=453#/>

⁸⁶ Дээрх худалдааны платформуудын тухайн хэлэлцүүлгийг V.B.2, 202-р тайлбарыг үзнэ үү

Эдгээр платформуудын зарим нь худалдан авалт хийсэн хэрэглэгчдийн эрхийг хамгаалах боломжийг бүрдүүлсэн. Жишээлбэл, хязгаарлагдмал ч гэлээ бүтээгдэхүүнийг буцаах, солих эрх байдаг⁸⁷.

Цахим хэлбэрээр бизнес эрхлэхэд тулгарч буй бэрхшээлүүд нь хууль тогтоомжийн дутагдлаас биш харин практик, соёл, технологийн саад бэрхшээлээс үүдэлтэй болохыг нотлох баримт бий.

Цахим гарын үсгийг хуулиар зөвшөөрсөн ч зарим худалдан авагч цаасан дээрх мөр гаргаж зурсан гарын үсгийг илүүд үздэг соёлын асуудал бас байна. Бизнес эрхлэгчдийн хувьд гэвэл Цахим гарын үсгийн тухай хууль болон холбогдох бусад шинэ дүрэм журмын дагуух зохицуулалтууд өөрсдөд нь ашигтай эсэхийг харznаж, хүлээцтэй байж магадгүй. Одоогоор уг хуульд заасан нийтийн түлхүүрийн дэд бүтэц бий болоогүй байна.

Цахим гарын үсгийн тухай хуульд тоон гарын үсэг болон гарын үсэг зурсан мэдээллийг Монгол Улсын иргэний үнэмлэхэд байршуулж, цахим хэлбэрээр гарын үсэг зурах боломжтой байна⁸⁸ гэж заасан байдаг. Хотын хүн амын томоохон хэсэг нь үүнийг ашигладаг. Гэхдээ хялбархан олддог ийм тоон гарын үсгээр зурсан харилцааны ихэнх нь иргэд болон төрийн байгууллагуудын хооронд байдаг. Mash цөөхөн нь хувийн гүйлгээнд зориулагдажээ⁸⁹.

Хувийн хэвшилтэй, ялангуяа худалдааны платформоор эсвэл шууд худалдаачидтай гүйлгээ хийдэг хүмүүс бичгээр бус платформтой хэлэлцэн тохиролцдог. Хэрэв бичгээр гэрээ байгуулсан бол энэ нь Иргэний хуулийн 43.2.4-т хамаарна. Тэдний гарын үсэг нь баталгаажсан цахим гарын үсэг биш мөртлөө “Цахим гарын үсгийн тухай хуулийн дагуу” байж болно. Ийм гүйлгээ хийхэд нотариатч шаардлагагүй⁹⁰.

Иргэний хуулийн 196.1.8-д “цахим хэлбэрээр гэрээ хийх бол талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлснийг харилцан хүлээн зөвшөөрч цахим гарын үсэг зурснаар” гэрээг байгуулсанд тооцно гэжээ. Заалтын сүүлчийн хэсэг нь тоон гарын үсгийн бүрэн зохицуулалтгүйгээр гэрээ байгуулах боломжтой болгожээ.

Түүнчлэн Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу ЦХХХЯ янз бүрийн төрлийн тоон гарын үсгийг хүчинтэй гэж зөвшөөрөл олгодог. Тиймээс, арилжааны платформ дээр эсвэл платформтой гүйлгээ хийхэд ашиглаж буй тоон гарын үсгийн төрлүүд хүчинтэй эсэхэд эргэлзэж байвал хүчинтэй эсэхийг шууд нотолж болохуйц юм.

Хувийн хэвшлийн цахим худалдаанд учирч буй зарим саад бэрхшээл нь хууль, эрх зүйн бус харин техникийн, эсвэл эдийн засгийн шинж чанартай байдаг.

Технологийн тал дээр тус улсад хувьсах чанарын өргөн зурvas (broadband)-ын интернеттэй, түүнийг ялангуяа гар утасны холболтод ашиглаж байна. Малчдад зориулсан хиймэл дагуулын үйлчилгээ байдаг. Хэдийгээр сайн холболтой ч онлайн

⁸⁷ Жишээлбэл, [shoppy.mn](https://shoppy.mn/t/home) сайтаас: <https://shoppy.mn/t/home>. Тухайн сайтын түгээмэл асуултууд, буцаах, солилцоо зэргийг харж болно: <https://shoppy.mn/support/faq>

⁸⁸ 25-р тайлбарыг харах, 8.4 дэх хэсэг. Гадаадын иргэн 10.2.2-т заасны дагуу гэрчилгээтэй байж болох ч иргэний үнэмлэхтэй байж болохгүй. SIM карт, өөрөөр хэлбэл гар утсан дээр хадгалагдсан гэрчилгээ нь аль ч орны хүмүүст нэгэн адил үйлчилнэ.

⁸⁹ ЦХХХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга З.Гантоогоотой хийсэн ярилцлагаас, 2022.10.17-ны өдөр.

⁹⁰ Хэрэв арилжааны платформын тухай хууль гаргах шаардлагатай байсан бол платформ дээр ашигласан гарын үсгийг баталгаажуулах тухай заалт нь шаардлагатай хэн бүхэнд баталгаа болно.

худалдаагаар дамжуулсан хувийн мэдээллийн хувь заяанд үл итгэх байдал байдаг. Энэ тайландаа сүүлд дурдсан нууцлалын шинэ хууль нь сайн хэрэгжинэ гэвэл энэ асуудлыг шийдвэрлэхэд тустай.

Цахимаар худалдаж авсан зүйлийн хүргэлтийн өртөг өндөр, ганц нийслэлд ч гэсэн, энэ асуудал нь хотоос гадуур бол бүр ноцтой, иймд энэ нь цахим худалдаанд саад болж байна.

Б.Төрийн байгууллагуудын хүрээнд

Олон улсын шилдэг туршилага

Европын эдийн засгийн комиссын нэг хэсэг болох Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдааг хөнгөвчлөх төв (CEFACT) нь “нэг цонх”-ны тогтолцоог бий болгож буй орнуудад зориулан хоёр үндсэн удирдамжтай:

1. Зөвлөмж 33: Нэг цонх бий болгох⁹¹

2. Зөвлөмж 35: Нэг цонхны хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх⁹².

Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааны тухай АНДЭЗНК-ын суурь хэлэлцээр нь техникийн харилцаа холбоог хөнгөвчлөх, хэмнэлт гаргах зорилгоор нэг цонхыг бий болгохыг гишүүн орнууддаа уриалсан.

ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр (TFA) нь мөн адил гишүүн орнуудыг энэ зорилгоор нэг цонх бий болгохыг дэмждэг⁹³.

1. Нэг цонх

Хил дамнасан “цаасгүй” худалдааг хялбарчлахын тулд хийх чухал ажлуудын нэг нь импорт, экспортын зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт материал тушаах төв, харилцах цэг нь болох “нэг-цонх” үйлчилгээг байгуулах юм. Импортлогч, түүнийг төлөөлж тээвэрлэгч нь, эсвэл экспортлогч нь бүх бичиг баримтаа бараа хүлээн авах улсын нэг цэгт, цахим бол нэг цахим хаягт илгээх боломжтой. Тэндээс бичиг баримтууд автоматаар холбогдох захиргаанд шалгуулахаар илгээгдэнэ. Холбогдох байгууллага нь шийдвэрээ гаргасан хойно, тухайн шийдвэр бичиг баримт илгээсэн хаягаар нь дамжиж импортлогч, эсвэл экспортлогчид буцаан хүрнэ.

Импортлогч, эсвэл экспортлогч нь хил дамнуулж буй бараа бүтээгдэхүүн /ховор тохиолдолд үйлчилгээ/ зэрэгээс шалтгаалан олон захиргааны байгууллагад хамрагдана. Захиргааны байгууллага нь засгийн газрын ямар ч хэлтэс байж болно. Импортлогч, экспортлогч болон захиргаа хоорондын харилцаа нь цахим хэлбэрээр явагдах нь илүү үр ашигтай.

Эдгээр харилцааг цахим хэлбэрээр явуулахын тулд мэдээллүүдийг стандартын дагуу бэлтгэх /жишээ нь, цаасан маягтыг цахим маягт болгох/ шаардлагатай. Маягтууд нь нэг

⁹¹ https://unece.org/DAM/cefact/recommendations/rec33/rec33_trd352e.pdf

⁹² <https://digitallibrary.un.org/record/668437?ln=en>

⁹³ ДХБ-ын худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, 10(4) дэх хэсэгт:

<https://docs.wto.org/dol2fe/Pages/SS/directdoc.aspx?filename=q:/WTL/940.pdf&Open=True>. 10(4.1) дэх хэсэг: “Гишүүн орнууд нь барааг импортлох, экспортлох, транзит тээвэрлэхтэй холбоотой бичиг баримт, өгөгдлийн шаардлагуудыг нэг нэвтрэх цэгээр дамжуулан оролцогч эрх бүхий байгууллага, агентлагуудад ирүүлэх боломжийг худалдаа эрхлэгчдэд олгох нэг цонхыг бий болгох, хадгалахыг хичээнэ”

мэдээллийг олон дахин давтаж удаашрах, алдаа гаргах эрсдэлгүй буюу машинаар уншигдахуйц байвал зохино. Ийм маягтай байх нь нэг цонхны үйлчилгээг улам хялбаршуулна. Захиргааны олон байгууллагууд цахим хэлбэрт шилжиж байгаа бөгөөд, дараагийн дэд хэсгээс харвал, Засгийн Газар хоорондоо уялдаа холбоотой хамтын ажиллагаа нь үр дүнтэй болохыг сайтар ухамсарладаг болох нь харагдаж байна.

Гаалийн байгууллага импортлогчдод дараах бичиг баримтууд шаардлагатай гэж зөвлөдөг:

Хувь хүн, аж ахуйн нэгжүүд бараа болон тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхдээ дараах гаалийн бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

- Ачааны бичиг (манифест)
- Тээврийн бичиг баримт
- Гадаад худалдааны гэрээ
- Үнийн нэхэмжлэх
- Баглаа боодлын бичиг баримт
- Гарал үүслийн гэрчилгээ
- Холбогдох байгууллагын зөвшөөрөл, лиценз (шаардлагатай тохиолдолд)
- Бүтээгдэхүүний чанарын гэрчилгээ, тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний хариу (шаардлагатай тохиолдолд)
- Гаалийн татвар, хураамж төлсөн баримт
- Гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдсөн хэсэгчлэн эсвэл бүрэн чөлөөлөгдсөн бол албан тоот (шаардлагатай бол)
- Гаалийн мэдүүлэг
- Гадаад төлбөрийн баримт, үнийн мэдээлэл
- Шаардсаны дагуу бусад баримт⁹⁴

Эдгээр бүгдийг нь цахим хэлбэрээр нэг дор мэдүүлэх нь мэдээж чухал ч гэлээ гүйцээх нь тийм хялбар биш.

Импорт, экспортод шаардлагатай бүх зөвшөөрлийг авах боломжийг олгох нэг (цахим) цонхны талаарх санал, төлөвлөлтийн ажил Монголд аль 2005 оноос хойш яригдаж байгаа⁹⁵ ч өнөөг хүртэл ийм цонх ажиллагаанд ороогүй байна. Азийн Хөгжлийн Банкны 2016 оны тайлан⁹⁶ ийм үйлчилгээг үүсгэх нь маш хүндрэлтэй гэж дурдсан байдаг: "... нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэхийн тулд эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай⁹⁷." 2021 онд Дэлхийн худалдааны байгууллагаас⁹⁸ энэ чиглэлээр төрөл бүрийн хэсэгчилсэн санаачилга бас гарч байсан. Мөн Худалдааг дэмжих үндэсний зөвлөл (NFTC) нь тайландаа 2022 оны тэргүүлэх чиглэлээр нэг цонхны үйлчилгээний загварыг санал болгож байдаг. Үүнийг 2025 оны сүүлчээр ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй гэжээ⁹⁹

⁹⁴ Монголын Худалдааны мэдээллийн портал, Түгээмэл асуултууд, онлайн:

<https://mongoliatradeportal.gov.mn/index.php?r=site/display&id=5>

⁹⁵ 2005 оны тайлан <https://www.adb.org/sites/default/files/project-document/68678/36027-03-reg-tacr.pdf>

⁹⁶ ADB тайлан, онлайн: <https://www.adb.org/sites/default/files/project-document/182730/47174-001-rrp.pdf> 14-р догол мөр

⁹⁷ 96-р тайлбарыг харах, 16-р догол мөр

⁹⁸ ДХБ Монгол дахь худалдааны бодлогын тойм WTP/TRP/S/406

https://www.wto.org/english/tratop_e/tpr_e/s406_e.pdf

⁹⁹ ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх мэдээллийн сан: Монгол Улс, Нэг цонхны 10.4-р зүйл:

<https://tfadatabase.org/en/members/mongolia/technical-assistance-projects/article-10-4>

Тэргүүлэх яам нь хувийн хэвшлийнхний ашиг сонирхлыг харгалзан, импортлогч (эсвэл экспортлогч) нарын бараа үйлчилгээг шалгах, шинжлэх үүрэгтэй багийг засгийн газрын захиргааны голлох байгууллагуудаас бүрдүүлдэг. Тэр зохицуулах хороо нь тогтолцоог бүрдүүлэхэд хүн бүрийн чадавх болон сонирхол чиглэж байгаа эсэхэд хяналт тавина. Өнгөрсөн жилүүдэд хэд хэдэн хороо байгуулж байсан бөгөөд Худалдааг дэмжих үндэсний зөвлөл (NFTC) нь тус хороодын нэгэн хэлбэр нь юм.

Мөн нэг цонхны системд оролцох, хамтран ажиллах хууль ёсны эрхийг тодорхой болгох үүднээс журам нь боловсруулагддаг. Журам болон бусад яам хоорондын хэлэлцээрийн агуулгыг Худалдааг хөнгөвчлөх цахим бизнесийн төв CEFACT-ын гарын авлагаас санаа авсан бөгөөд, олон улсын стандартын талаар дор тэмдэглэв.¹⁰⁰

Нэг цонхны үндсэн зарчим, зөвшөөрлийг зохицуулсан хуулийг дэмжиж, оролцогч талууд нь иргэний хариуцлагын дагуу хэрэгжүүлэх гүйцэтгэлийн стандартыг дагаж мөрдөхийг заасан олон тооны хоорондоо холбоотой гэрээнүүдээр өөртөө үүрэг авах замаар цонхыг ажиллуулах болох юм.

2. Төрийн үйлчилгээний цахим портал

Монголын Засгийн газар иргэд, оршин суугчид төрийн бүх шатны байгууллагатай харилцах, гүйлгээ хийх цахим портал байгуулж байна. Одоо энэ хөтөлбөрийг Цахим хөгжил, харилцаа холбооны яам удирдаж байна.

“Цахим Монгол” /E-Mongolia/ систем нь 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд өнөөдөр төрийн 61 байгууллагын 656 үйлчилгээг багтаасан томоохон систем болж чадсан нь гол ололт юм. Энэ системээр нийтдээ 12 сая гаруй үйлчилгээг онлайнаар үзүүлжээ. Энэ систем одоогоор 1.3 сая хэрэглэгчтэй. Энэ нь хүн амын насанд хүрсэн хүний гуравны нэг нь “Цахим Монгол” платформыг ашигладаг гэсэн үг. Жолооны үнэмлэх авахаас эхлээд паспорт авах хүртэл хамгийн эрэлттэй 656 төрийн үйлчилгээг эндээс авах боломжтой. Үйлчлүүлэгчийн онцлогт тулгуурласан үйлчилгээг саяхан санал болгодог болжээ¹⁰¹

Иргэний өгөгдлийг иргэний үнэмлэхэнд суулгасан бөгөөд тоон гарын үсгээр (хувийн түлхүүр, гэрчилгээ) баталгаажуулах боломжтой гэдгийг өмнө дурдсан билээ¹⁰². Дээр цахим гарын үсгийн талаар авч үзсэн хэсэгт баталгаажуулалтын өөр аргууд байдаг гэж ярьсан: хувийн нэвтрэх системээр дамжих; төрийн албан ёсны цахим шуудангаар харилцах; албан бичиг солилцох нэгдсэн системээр дамжуулан мэдээлэл дамжуулах; мөн баримт бичгийн баталгаажуулалтад төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гаргасан баримт бичигт өвөрмөц тоон танигч ашиглах зэрэг. Өвөрмөц танигчийг хэд хэдэн хуульд тусгасан, үүний талаар өмнө энэ тайланд дурдсан буй.

¹⁰⁰ 168-р тайлбар харах

¹⁰¹ “Монгол улс цахим хөгжлийг шинэ түвшинд гаргана”, Telecomm Review сэтгүүл, 2022.06.10,

<https://www.telecomreviewasia.com/index.php/news/interviews/2791-mongolia-to-take-digital-development-to-a-new-level>.

¹⁰² 25-р тайлбарыг харах, 8.4 дэх хэсэгт. Монгол Улсын иргэн бус хүмүүс цахим гарын үсгийг ашиглах боломжтой гэхдээ иргэний үнэмлэх байхгүй учраас ийм үнэмлэхээр дамжихгүй - 10-р зүйл.

Цахим засаглалын эдгээр санаачилга, түүний давуу тал, эрх зүйн үр нөлөөний талаар цахим харилцааны хэрэглээтэй хүмүүст зориулж өрөнхий ойлголт өгөх хэрэгтэй болов уу. Ингэснээр хувийн хэвшлийн цаашдын хэрэглээ нэмэгдэх боломжтой.

Ийм “цахим засаглалын тухай” гэсэн нэртэй хууль байхгүй гэхдээ цахим үндэстэн хөтөлбөрийн янз бүрийн талыг дэмжих зорилгоор 2021 оны сүүлчээр хэд хэдэн хуулийг баталж, тэдгээр нь 2022 оны 5-р сард хүчин төгөлдөр болсон. Тэдгээрийг хамтад нь “цахим шинэчлэлийн гол хуулиуд” гэж нэрлэдэг болжээ¹⁰³.

“Цахим шинэчлэлийн гол хуулиудыг 2021 оны 12 дугаар сард Улсын Их Хурал баталсан. Эдгээр хуулиуд нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиас бүрдэнэ”.

Нарийвчилсан хуулийн орчин байхгүй байгаа нь уян хатан байдлыг хангасан давуу тал юм.

...эрх зүйн нарийн зохицуулалт байхгүй байгаа нь бидэнд чөлөөтэй өрсөлдөх, чөлөөтэй сэтгэх, бизнесээ чөлөөтэй хийх боломжийг олгож байна. Тухайлбал, орчин үеийн шинэ технологид суурилсан гарааны бизнес эрхлэхэд тусгай зөвшөөрөл шаарддаггүй. Бусад нь ч харилцаа холбооны бизнестэй ямар ч холбоогүй бол үүнийг чөлөөтэй хийх боломжтой..... [Бид] гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан татваргүй бүсийг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна. Хэрэв энэ хууль батлагдвал гарааны бизнес эрхлэгчид тусдаа, бага хэмжээний татвар төлнө¹⁰⁴

Дээрх санаачилга болон тэдгээрийн үр дагаврын талаар илүү нарийвчилсан бөгөөд дүрсэлсэн тайлбарыг НҮБ-ын Хүн амын хөгжлийн сангийн Монголын санаачилгын тухай тайлангаас олж болно. Энд олон жилийн санаачилга, төлөвлөгөөний талаар мөн тайлбарласан байна¹⁰⁵.

2015 оноос 2022 он хүртэл хууль тогтоомжийн дагуу “Ухаалаг төр” нэртэй үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлжээ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар үндсэндээ хэрэгжүүлэх асуудлыг хариуцжээ¹⁰⁶. Энэ нь чадавхыг бэхжүүлэх, иргэний оролцоо, дэд бүтэц, цахим үйлчилгээ, инновац, нээлттэй өгөгдөл, харилцан ажиллах чадвар зэрэг эдийн засаг, нийгмийн олон асуудлыг хамарсан харилцан уялдаатай бүрэлдэхүүн хэсгүүдтэй байв. Энэ хөтөлбөр нь интернэтээр дамжуулан төрийн үйлчилгээг хүн амд шууд хүргэх чиглэлийг голчлоогүй, харин эдийн засгийг бүхэлд нь цахимжуулах асуудалд гол анхаарлыг хандуулж ажиллажээ.

¹⁰³ 101-р тайлбарыг онцлон харах.

¹⁰⁴ 101-р тайлбарыг харах. Ийм татварын тогтолцооны талаар энэ тайлангийн V.B. хэсэгт хэлэлцсэн

¹⁰⁵ Худалдааг дэмжих үндэсний зөвлөл (NTFC), 2022 оны Дэлхийн форум, <https://unctad.org/system/files/non-official-document/GFS42-Davaa-TSEENDSUREN.pdf>. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг харна уу; Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл; Монгол Улсын 2021-2030 он хүртэл хэрэгжүүлэх хөтөлбөр “Алсын хараа-2050” нэртэй Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого.

¹⁰⁶ “Ухаалаг төр” хөтөлбөр, https://www.smart.gov.mn/en/sub_1/

“Ухаалаг төр” төслийг 2022-2027 онуудад¹⁰⁷ хэрэгжүүлэх “Цахим үндэстэн”¹⁰⁸ төслөөр амжилттай үргэлжлүүлж байна. Шинэ хөтөлбөр нь тоон дэд бүтэц, цахим засаглал, кибер аюулгүй байдал, цахим бичиг үсгийн боловсрол, инновац ба үйлдвэрлэл, улс орны хөгжлийг хурдасгагч гэсэн¹⁰⁹ зургаан зорилтод чиглэжээ. Дахин хэлэхэд “e-Mongolia”-тай нэгтгэхээсээ илүүтэй зэрэгцүүлэн уг хөтөлбөрийг явуулж байна.

Цахим засаглалын тухай, төрөөс иргэн, засгийн газар хоорондын харилцааны талаар нэмэлт хууль тогтоомж, зохицуулалт, тусгай заалт оруулах шаардлага буюу хэрэгцээ байгаа нь тодорхойгүй байна. Одоо мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд хэрэгжүүлэх боломжтой.

В. Гаалийн байгууллага ба хил дамнасан цахим худалдаа

Монгол Улс нь Гаалийн журмыг хялбарчлах, уялдуулах тухай шинэчилсэн Киотогийн конвенцод 2006 онд нэгдэн орсон. Энэхүү конвенцын гол онцлог нь гаалийн байгууллага импортын бараа бүтээгдэхүүнд эрсдэлд сууринсан хяналтыг нэвтрүүлэх явдал юм. Бүртгэл сайтай, үнэ багатай ачилтыг илгээгчид хил дээр шалган нэвтрүүлэх, эсвэл бөөнөөр нь хийх боломжтой бөгөөд ингэснээр орлогоо алдахад хүргэж болзошгүй шударга бус байдал, алдаа гарахаас сэргийлэх боломжтой. Ийм систем нь дэлхийн шилдэг туршлагыг тодорхой илэрхийлсэн. Гэхдээ Монголд эрсдэлд сууринсан гаалийн хяналтыг хараахан нэвтрүүлээгүй байна.

Зарим орны гаалийн байгууллагууд цахим худалдаанаас бий болж буй ачааллыг гүйцэхгүй байна, ялангуяа харьцангуй бага үнэ бүхий их хэмжээний илгээмжийг зохицуулахад бэрхшээлтэй тулгардаг. Үүнийг шийдвэрлэх гарц бол илгээмж болгоныг хянахгүйгээр цааш нь дамжуулахад хэр их эрсдэлтэй вэ гэдгийг үнэлэх чадавх юм. Үүнийг шийдвэрлэх нь Монголын хувьд хууль тогтоомж, зохицуулалтын шинэчлэлээс хамаарахгүй, Конвенцод нь ийм судалгаа дүгнэлтийг өөрсдөө хийхийг зөвшөөрсөн тул энэ асуудлыг зөв удирдлага, технологиор шийдвэрлэх асуудал юм. Монгол Улс эрсдэлийн удирдлагын ажиллагааны чиглэлээр Швейцар улс болон Дэлхийн гаалийн байгууллагаас тусламж авч байна¹¹⁰.

1. “De minimis” дүрэм

Цахим худалдааны урсгалаар хямд үнэ бүхий олон илгээмжийн дарамтыг бууруулах өөр нэг арга бол “шугам зурах” (буюу мөнгөн дүн тогтоох) арга юм, энэхүү шугамаас доош

¹⁰⁷ Уг хөтөлбөрийн талаар энд байгаа: <https://montsame.mn/en/read/302990>

¹⁰⁸ “Цахим үндэстэн” хөтөлбөр (Монгол хэлээр): <https://mddc.gov.mn/wp-content/uploads/2022/07/%D0%9024-20220518-%D0%A6%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC-%D2%AF%D0%BD%D0%B4%D1%8D%D1%81%D1%82%D1%8D%D0%BD-%D0%BD%D0%BC%D1%82%D0%BB%D0%BD%D0%BC%D1%85-%D1%87%D0%BD%D0%BC%D0%BB%D1%8D%D0%BD-%D0%BD%D0%BC%D1%82%D0%BB%D0%BD%D0%BC%D1%85-%D1%82%D1%83%D1%85%D0%BD%D0%BD%D0%BC%D1%85-1.pdf>

¹⁰⁹ Tara Neal, "Transforming Mongolia into a Digital Nation: Interview with the Ministry of Digital Development" (Тара Нил, "Монгол Улсыг цахим үндэстэн болгон хувиргах нь: Цахим хөгжлийн яамтай хийсэн ярилцлага"), <https://www.thefastmode.com/expert-opinion/26849-transforming-mongolia-into-a-digital-nation-interview-with-ministry-of-digital-development>

¹¹⁰ Дэлхийн гаалийн байгууллага, "Mongolia becomes part of the SECO-WCO Global Trade Facilitation Programme (GTFP) Family," July 2022, ("Монгол Улс нь Дэлхийн гаалийн байгууллагын SECO-н олон улсын худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр (GTFP)-ийн орнуудын гэр бүлийн нэгэн хэсэг боллоо") www.wcoomd.org/en/media/newsroom/2022/july/mongolia-becomes-part-of-the-seco-wco-gtfp-family.aspx

үнэ бүхий илгээмжийг “үл тоомсорлодог”. Үүнийг “*de minimis*” дүрэм гэж нэрлэдэг бөгөөд уг босгоос доогуурх илгээмжид анхаарал тавихгүй байж болно гэсэн үг юм¹¹¹.

Энэ мөнгөн утгыг тодорхойлох нь бас нэг асуудал билээ. Улс орнууд 1000 ам. доллараас эхлээд 100 ам.доллар буюу түүнээс бага дүнг өөрсдөө тогтоосон. Гэхдээ ихэнх улс орнууд 200 доллар ба түүнээс дооших үнээр тухайн шугамыг тогтоосон байдаг. Энэхүү мөнгөн утгыг тогтооход баримтлах ямар нэгэн зарчим байдаггүй юм шиг санагддаг. Босго үнэ бага байх тусам илүү олон тооны илгээмжийг шалгах шаардлагатай болох нь тодорхой бөгөөд энэ нь захиргааны зардлыг нэмэгдүүлэх боловч нөгөө талаас харахад энэ нь илүү олон тооны илгээмжид татвар ногдуулах боломжтой болгож байна. Нөгөөтээгүүр, өндөр *de minimis* босго нь гаалийн захиргааны зардал, ачааллыг бууруулж, цахим худалдаагаар тээвэрлэж буй бараа бүтээгдэхүүний хүргэлтийг хурдасгана, гэхдээ гаалийн тарифаас олох дотоодын орлогыг бас бууруулдаг.

Монголд одоогийн байдлаар “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй, ижил төрлийн хоёроос илүүгүй бараа бүхий хувь хүний нэр дээр илгээсэн улс хоорондын шуудангийн илгээмж”-ийг гаалийн татвараас чөлөөлөхөөр заасан¹¹² (энэ нь гаалийн хяналт шалгалтаас мөн чөлөөлсөн гэсэн үг, гэхдээ аюулгүй байдлын шалтгаанаар шалгах нь үүнд хамаarahгүй). Энэ хэмжээ нь Монголын хувьд *de minimis* босго юм¹¹³.

а. Хүргэлтийн тухай жич тэмдэглэх нь

Монголд *de minimis* дүрэм нь зөвхөн шуудангийн илгээмжид хамаарч буй тухай дээр дурдсан билээ. Ингэх нь цахим худалдаагаар борлуулсан барааны хүргэлт, өрсөлдөөн, үйлчилгээний түвшинд сэргээр нөлөөлж буй бололтой. Гадаадаас хямд бараа авах - их хэмжээний илгээмжийн урсгал бий болох - татвараас чөлөөлөлгөхийн тулд шуудангаар илгээх ёстой болж байна.

Шуудангийн үйлчилгээ нь ихэнхдээ төрийн өмчийнх бөгөөд тэр нь уг салбартаа зонхицж байгаа ч хэдэн жилийн өмнөөс Шуудангийн тухай¹¹⁴ хуулиар төрийн бус бизнес эрхлэгчид тусгай зөвшөөрөл авч захидал, бараа хүргэх боломжтой болсон. Бодит байдал дээр бол татваргүй илгээмж нэвтрүүлэх давуу талыг эдлэхийн тулд хүргэлтийн бизнес эрхлэгчид тэрхүү хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авах асуудал бий болдог. Ихэнх улс орнууд (Хятад бол хамгийн сүүлийн жишээ¹¹⁵, мөн Өмнөд Солонгос бол өөр нэг сайн жишээ¹¹⁶ юм) илгээмжийг нь гаалийн татвараас чөлөөлдөг болохоос түүнийг хүргэх тогтолцоог

¹¹¹ Ах латинаар “*de minimis non curat lex*” гэсэн дүрэм байжээ, энэ нь “хууль үл ялиг зүйлийг тоохгүй” гэсэн утгатай, гаалийн ажиллагаанд бол “жижиг үнэ бүхий илгээмжид хамаarahгүй” гэж ойлгоно.

¹¹² Гаалийн тариф, гаалийн татварын тухай, 38.1.5 дахь заалтыг харах, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208>. Мөн Нэмэгдсэн өртгийн татварын тухай хуулийн 13.1.24 дэх заалтыг харах, ижил үнийн заасан байдаг, гэхдээ энэ нь зөөврийн компьютерын арилжаанд хамаarahгүй: “зөөврийн компьютерын хувьд 30 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй, ижил төрлийн хоёроос илүүгүй бараа бүхий хувь хүний нэр дээр илгээсэн улс хоорондын шуудангийн илгээмж” гэжээ. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11227>

¹¹³ A full chapter on *de minimis* calculations is found in the ESCAP publication *Selected Issues in Cross-border e-Commerce Development in Asia and the Pacific. Studies in Trade Investment and Innovation No. 21, 2019*, online: <https://www.unescap.org/publications/studies-trade-investment-and-innovation-no-91-selected-issues-cross-border-e-commerce>.

¹¹⁴ Шуудангийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=92>

¹¹⁵ Хятадад худалдан авагч нь бараа захиалсны дараа аль ч боломжтой хүргэлтийн үйлчилгээг сонгож болно, энэ тухай Хятадын шуудангийн тайлбар энд байна: <https://parcelsapp.com/en/carriers/china-post>

¹¹⁶ Өмнөд Солонгосын Шуудангийн үйлчилгээний тухай хууль, 2(3) дахь хэсэг, https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=55495&type=part&key=43

нь биш, ингэх нь тээвэрлэгчдэд илүү сонголт, эрх чөлөө өгч байгаагаас гадна шуудангийн тээвэрлэлтийн захиргааны оролцоо багасаж байгаа юм.

Цахим худалдааны асуудал эрхэлсэн яамд нь Сангийн яамтай ярилцаж гаалийн татварын чөлөөлөлт нь зөвхөн шуудангийн үйлчилгээ болон шуудангийн илгээмжид хамаарах байдлыг өөрчлөх боломжтой эсэхийг судлах нь зүйтэй. Ийм өөрчлөлт нь гаалийн татвараас олох нийт орлогын хэмжээг өөрчлөхгүй¹¹⁷.

2. Цахим худалдааны тогтолцооны жишээ

Хил дамнасан цахим худалдааны эрэлт хэрэгцээг зохицуулах дүрэм, арга болон техникийг зөв хослуулах нь алдаа, туршилтаар зүгширнэ. Хятадад маш нарийн төвөгтэй тогтолцоотой бөгөөд түүнийгээ олон жилийн турш хөгжүүлж ирсэн юм. Дээр дурдсан ESCAP-ын гэрээ хэлэлцээрт заасан арга хэмжээнд суурилсан туршилтуудыг төслүүдийг тодорхой барааны төрлүүдээр хэрэгжүүлжээ¹¹⁸.

Вьетнамд ч тус улсын гаалийн байгууллага нь их хэмжээний барааны урсгалыг хэрхэн зохицуулах талаар шийдэхдээ ижил төстэй олон асуудлыг шийдэж байжээ. Хэсэг хугацаанд цахим худалдааг зохицуулсан эрх зүйн дэглэмгүй, бага үнэ бүхий багцад зориулсан тусдаа гарц замгүй, мөн батлагдсан заавар дутмаг байсан. Иймд цахим худалдааны удирдлагын тухай тогтоолын төслийг бэлтгэсэн байdag.

Тогтоолын төсөлд цахим худалдааны гүйлгээ болон барааны гаалийн тусгай журам, тэр дундаа гаалийн цахим мэдээлэл боловсруулах төрөлжсөн системээр дамжуулан урьдчилан мэдээлэл оруулах тухай заалтуудыг тусгажээ; мэргэжлийн удирдлага, хяналт шалгалт, импортын татвараас чөлөөлөх; бараа бүтээгдэхүүний ангилал; буцаасан барааны гаалийн журам зэрэг асуудлыг зохицуулсан байна¹¹⁹.

2021 оны 8-р сард боловсруулсан тогтоолын төсөл нь 2022 оны сүүлээр гэхэд төсөл хэвээр байна, энэ нь зохицуулах асуудлууд нь их ээдрээтэйг харуулж байна. Тогтоолын төсөл нь Вьетнам руу импортлох илгээмжид *de minimis* хамгийн бага үнийг тогтоох саналтай.

Энэ чиглэлээр олон улсын шилдэг туршлагыг Дэлхийн гаалийн байгууллага саяхан гаргасан “Хил дамнасан цахим худалдааны стандарт” баримт бичигт¹²⁰ нийтэлжээ. Стандартуудын эхнийх нь тээвэрлэлтийн өмнөх ажиллагаа, тээвэрлэлтийн талаарх мэдээлэл солилцоход хамаарах бөгөөд үүнд барааг зохицуулж буй холбогдох бүх талуудыг оролцуулж байна:

1.1. Нэг дэх стандарт: өндөр түвшний цахим мэдээллийн эрх зүйн орчин

Цахим худалдааны нийлүүлэлтийн сүлжээнд оролцож буй талуудаас өндөр түвшний цахим мэдээлэл солилцохыг шаардах бол холбогдох хуулийн орчныг

¹¹⁷ 2022 оны 12-р сарын 16-ны өдөр Улаанбаатарт болсон АХБ-ны цахим “Монголд үр дүнтэй цахим худалдаа эрхлэхэд учирч буй эрх зүйн болон зохицуулалтын саад тогторуудын талаарх хэлэлцүүлэг”-ийн үеэр Гадаад харилцааны яам, Сангийн яам хамтран улс хоорондын илгээмжийн гаалийн бүрдүүлэлтийн журмыг шинэчлэн боловсруулах шатандаа явж байгаа гэж мэдээлсэн. Үүнээс өөр мэдээлэл одоогоор байхгүй байна.

¹¹⁸ 113 дахь тайлбар, 19 – 22-р хуудас.

¹¹⁹ Global Compliance News, 2021 оны 10-р сар, "Вьетнам: Сангийн яам цахим худалдааны гүйлгээний импорт, экспортын удирдлагын тухай тогтоолын төслийг нийтэллээ"

www.globalcompliance-news.com/2021/10/14/vietnam-ministry-of-finance-releases-draft-decree-on-management-of-e-commerce-transacted-imports-and-exports061021/

¹²⁰http://www.wcoomd.org/-/media/wco/public/global/pdf/topics/facilitation/activities-and-programmes/ecommerce/wco-framework-of-standards-on-crossborder-ecommerce_en.pdf?la=en (2022 оны 6-р сар).

бий болгосон байна. Үүгээр гаалийн байгууллага болон бусад холбогдох төрийн байгууллагуудын энэхүү солилцоог хөнгөвчлөх, хяналтын арга хэмжээг сайжруулах зохицуулалтын тогтолцоог бүрдүүлнэ, ингэхдээ өрсөлдөөн, мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, хамгаалалт, өмчлөлтэй холбоотой хуулийг харгалзана¹²¹. Хил дамнасан цахим худалдааны хууль тогтоомжийн тогтолцоог бий болгох буюу өөрчлөхдөө улс орнууд Дэлхийн гаалийн байгууллагын одоогийн конвенц, хэлэлцээр, мөн ДХБ-ын холбогдох бүх гэрээ, ялангуяа худалдааг хөнгөвчлөх гэрээ (TFA), бусад олон улсын конвенц, стандарт, арга хэрэгслийг ашиглах ёстой¹²².

Монголын гаалийн байгууллага нь үйл ажиллагаагаа цахим интеграцилап руу чиглүүлж байна. Үүний жишээг цахим хуудсаас нь харж болно: "Гаалийн цахим үйлчилгээ"¹²³. Дэлхийн гаалийн байгууллагын стандартад нийцэхийн тулд илүү их зохицуулалт, хамтын ажиллагаа шаардлагатай. Гэхдээ харилцан яриа эрчимтэй өрнөж байна. Гадаад харилцааны яам, Сангийн яамнаас улс хоорондын илгээмжийн гаалийн бүрдүүлэлтийн журмыг шинэчлэн боловсруулах шатандаа явж байна¹²⁴. Хятад, Вьетнамын туршлагаас харахад ийм шинэчлэл хурдан эсвэл хялбар байхгүй. Вьетнамын тогтоолтой ижил Монголын төсөл боловсруулах, түүний агуулга зэрэг асуудал нь энэ тайлангийн хамрах хүрээнээс гадуур юм.

3. Биет бус хөрөнгө

Бараа бүтээгдэхүүний импорт, экспортын үнэ цэнэ, зохицуулалт нь гаалийн байгууллагын эрхэлдэг "уламжлалт" асуудал юм. Өмнө нь үйлчилгээг хувь хүнд зориулж үзүүлдэг, хэрэв гадаадын этгээд үйлчилгээ үзүүлэх гэж байгаа бол үйлчлүүлэгчдэдээ өөрөө хүрэх шаардлагатай байсан. Тухайн үед энэ нь голцуу хилийн болон цагаачлалын хууль тогтоомжтой ихээхэн хэлхээтэй байсан (зөвхөн гаалийн асуудал биш) бөгөөд үйлчилгээг мөн тухайн орон нутгийн хууль тогтоомжоор бас хамааруулан зохицуулж байжээ.

Интернет энэ бүгдийг өөрчилсөн. Үйлчилгээг одоо дэлхийн хаанаас ч алсаас үзүүлэх боломжтой. Төрийн албаныхан дижитал бүтээгдэхүүнийг цахим хэлбэрээр, үл харагдах байдлаар боловсруулж, хүргэж болно. Биет бус зүйл нь хилээр тээвэрлэж буй бараа бүтээгдэхүүний үнэ цэний нэг хэсэг байж болно, жишээлбэл, тэд оюуны өмчийн үнэ цэнэ (барааны тэмдэг эсвэл патент)-ийг агуулсан байх. Ийм бүтээгдэхүүнийг өмчлөгчөөс нь авсан зөвшөөрлийн дагуу ашиглуулж, ийнхүү ашиглах нь гадаадын өмчлөгчид орлого оруулдаг байж болно.

Энэ байдлыг хэлэлцэхлээр гол чиглэл нь үнэ цэнийг шилжүүлэх, шилжих асуудлыг заавал зохицуулах шаардлагатай нь ойлгомжтой болсон. Дэлхийн гаалийн байгууллага энэ сэдвээр гарын авлага¹²⁵ гаргасан байдаг. Үүнээс гадна Эдийн засгийн хамтын

¹²¹ 120 дахь тайлбар, 10-р хуудас. 9-р стандартад *de minimis* дүрмийн тухай дурдсан, ингэхдээ зөвхөн "Засгийн газар нь дотоодын онцлог нөхцөлд үндэслэн бүрэн мэдээлэлтэйгээр шийдвэр гаргана" гэсэн байдаг.

¹²² 120 дахь тайлбар, 8-р хуудас. Олон улсын зарим холбогдох стандартуудыг энэхүү тайлангийн дараагийн хэсэгт авч үзнэ.

¹²³ Гаалийн цахим үйлчилгээ, <https://gaali.mn/>

¹²⁴ 2022 оны 12-р сарын 16-ны өдөр Улаанбаатарт болсон АХБ-ны цахим семинар: Монголд үр дүнтэй цахим худалдаа эрхлэхд учирч буй эрх зүйн болон зохицуулалтын саад тогторуудын талаарх хэлэлцүүлэг.

¹²⁵ Дэлхийн гаалийн байгууллагын "Гаалийн үнэлгээ ба шилжүүлгийн үнэ тогтоох гарын авлага", 2018, <https://www.wcoomd.org/-/media/wco/public/global/pdf/topics/key-issues/revenue-package/wco-guide-to-customs-valuation-and-transfer-pricing.pdf>

ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудыг¹²⁶ гаргасан. Энэхүү баримтын VI бүлгийн хавсралт болгон үнийг хил дамнаж шилжүүлэх удирдамжийг оруулжээ. Энэхүү биет бус хөрөнгийн үнэлгээ, зохицуулалт бүхий VI бүлэг нь Азийн олон орны холбогдох хуулийн үндэс суурь болдог¹²⁷.

¹²⁶ Guidance for Tax Administrations on the Application of the Approach to Hard-to-Value Intangibles - BEPS Action 8 (Үнэ цэнтэй биет бус зүйлийн талаарх Татварын албаны удирдамж), 2018, <https://www.oecd.org/tax/transfer-pricing/guidance-for-tax-administrations-on-the-application-of-the-approach-to-hard-to-value-intangibles-beps-action-8.htm>

¹²⁷ Deloitte, Австрали: ATO [Australian Taxation Office] guidance on International Intangibles Arrangements (Делойт, Австрали: Олон улсын биет бус хөрөнгийн зохицуулалтын талаарх Австралийн татварын албаны удирдамж), 2021 оны 11-р сарын 18,

https://www.youtube.com/watch?v=YPG8_meiweQ&ab_channel=DeloitteDbriefsAP.

АНДЭЗХАБ-н гишүүн орнуудын арга барилын графикийг 13:33-аас слайд 7-оос үзнэ үү.

Асуулт	Австрали	Хятад	ХонгКонг	Энэтхэг	Япон	Шинэ Зеланд	Сингапур	Ө.Солонгос	Тайван
ЭЗХАХБ-ын зөвлөмжийн 6-р бүлгийг дагадаг эсэх.	Дагадаг	Дагадаг	Дагадаг	Ерөнхийдөө нийцэж байгаа	Ерөнхийдөө нийцэж байгаа	Дагадаг	Ерөнхийдөө нийцэж байгаа	Дагадаг	Дагадаг
Биет бус хөрөнгийн DEMPE-н талаар хууль, тусгай заавар, зохицуулалт бай-даг эсэх.	Зориуд биет бус хөрөнгөтэй холбоотой ажиллагаа, төлбөр, гүйлгээний зохицуулалтгүй. DEMPE-ийн үйл ажиллагаатай холбоотой олон шат дамжлага бүхий зохицуулалт үгүй.	Үнэ шилжүүлэх зохицуулалтыг орон нутагт хэрэгжүүлэхээр сурталчилдаг	ЭЗХАХБ-г дагадаг	ЭЗХАХБ-г дагадаг	ЭЗХАХБ-г дагадаг	Биет бус хөрөнгийн үнэлгээг тодорхойлох, түүнийг ашигласны төлбөр, эрсдэлний үнэлгээний 25% дүрэм, биет бус хөрөнгийг шилжүүлэх, хадгалах талаар удирдамж байдаг.	Оюуны өмчийн зардлыг хуваах талаар тусгай удирдамжийг баталсан. Сингапурын үнэ шилжүүлэх тухай ду-рэм журам нь голцуу ЭЗХАХБ-ыг зөвлөмжийг мөрддөг.	Дотоодын хууль нь биет бус хөрөнгийн тодорхойполт, түүнийг бий болгох, сайжруулах, засвар үйлчилгээ, хамгаалалт, ашиглалт, түүнийг шилжүүлэх тухай аргачлал (орло-гоос нь хамаарах) оруулсан.	Үнэ шилжүүлэх журмыг 2020 онд шинэчилсэн, үүнд биет бус хөрөнгийн DEMPE, түүний үнийг шилжүүлэх тухай аргачлал (орло-гоос нь хамаарах) оруулсан.
Татварын байгууллагууд нь биет бус хөрөнгийн зохицуулалтад анхаарал хандуулж байгаа эсэх.	Биет бус хөрөнгийн зохицуулалт нь одоогоор Австралийн татварын албаны хамгийн их анхаарлын төвд нь байна.	Тийм, ялангуяа компани хоорондын биет бус хөрөнгө ашигласны төлбөрийг үнэ шилжүүлэхтэй холбож шалгах нь нийтлэг юм.	Үнэ шилжүүлэх зохицуулалтыг тусгайлан онцолж байгаа, гэхдээ холбогдох журам нь биет бус хөрөнгийн талаар сүрхий дэлгэрэнгүй биш.	ЭЗХАХБ-ын шинэчилсэн 6-р бүлгийг хэрэгжүүлэн Энэтхэгийн татварын алба биет бус хөрөнгийн гүйлгээнд илүүтэй анхаарал хандуулж байна.	Сүүлийн үед татварын байгууллага нь биет бус хөрөнгийн зохицуулалтыг илүү анхаарч хэлэлцүүлэг зохион байгуулж байгаа.	Дотоод орлогын (СЯ)-ын 2021 оны удирдамжийн дагуу биет бус хөрөнгө ашигласны төлбөрийн талаар асуултыг зарим компаниудад илгээдэг болсон. Ийм төлбөрийг шинээр тайлгагнасан, эсвэл их хэмжээгээр нэмэгдүүлсэн бол эрсдэлийг хянах ажиллагааны хүрээнд шалгаж болно	Тэгж байгаа, энд оюуны өмчтэй байх нь эдийн засгийн хувьд ашигтай, хуулийг таатай орчинтой учраас. Оюуны өмчийг худалдан авах, худалдах, ашигласны төлбөр зэрэг оюуны өмчтэй холбоотой зохицуулалт нь нарийн.	Татварын албан шилжүүлгийн үнийг үнэлэх одоо-гийн бодлогын зохистой эсэхийг байнга шүүмжилдэг. Энэ нь ялангуяа биет бус хөрөнгийн эзэмшигчид болон тэдгээрийн хэрэглэгчдийн хоорондох компани хоорондын төлбөртэй холбоотой.	Татварын албан шилжүүлэх асуудлыг татвар талаас илүүтэй шалгадаг болох хандлагатай.
Татвар төлөгч биет бус хөрөнгийнхөө талаар мэдээлэх тусгай зохицуулалт бий эсэх.	Зарим томоохон татвар төлөгчид “үнэ шилжүүлэх” тухай гаалийн дүрмийн дагуу орон нууц	Татварын тайлан, мөн орон нутагт тайлганаадаа биет бус хөрөнгийн	Гүйлгээний үнэ нь босгыг давсан бол зохицуулалт хамаарна	Олон улсын хэмжээнд биет бус хөрөнгийг шилжүүлсэн тухай тодорхой мэдээлэл өгөх,	ЭЗХАХБ-ын зөвлөмжтэй нийцэж байгаа	Үгүй	Биет бус хөрөнгийн талаарх ЭЗХАХБ-ын стандарт шаардлагуудыг хэрэгжүүлнэ.	2020 оноос төлсөн буюу хүлээн авсан оюуны өмч ашигласны төлбөр, түүнийг худалдан авалт	Биет бус хөрөнгийг бий болгосон, шилжүүлсэн, ашиглуулахаар болсонтой холбоотой мэдээл-

Жон Грегори, Анбатын Дэлгэрмаа
Дотоод хэрэгцээнд. Энэхүү тайлан нь АХБ-ны удирдлага болон ажилтнуудад нээлттэй.
Зохих зөвшөөрөлтэйгөөр АХБ-аас гадуур өгч болно.

	тагт болон өөр-ийн үнэлгээний талаар мэдээлэх үүрэгтэй.	гүйлгээг тусгайлан оруулах шаардлагатай.		ил тод болгох ёстой, тусдаа маягт бий.				зэрэг биет бус хөрөнгийн хэлцлийн дэлгэрэнгүй мэдээллийг тусгах татварын ма-ягт бий болсон.	лийг орон нутгийг татварын албанад мэдээлнэ
Бусад холбогдох дурэм зохицуулалт байгаа эсэх.	Хамааралгүй.	Татварын байгууллага оюуны өмч, биет бус хөрөнгөд орон нутгийн хувь нэмэр оруулахыг дэмжих бол ашгийн хуваах аргыг орон нутагт ашиглахыг дэмждэг.	Энд бүртгэлтэй оффшор компаниудад хамаарах дэглэмийг эргэн харах гэж байгаа, ингэснээр энд эдийн засгийн үйл ажиллагаа явуулдаггүй, татвар төлдөггүй ч орлого олдог корпорацууд бэрхшээлтэй тулгарна гэж үзэг	Өндөр үнэтэй төлбөрийг гадаадын компаниудад төлсөн тохиолдлыг Энэтхэгийн татварын алба байнга илүүтэй анхаардаг.	Олон компаниуд "pillar 1/2" заалтыг хэрэгжүүлэх, түүний үр дагаврын талаар санаа зовж байгаа.	Биет бус хөрөнгөтэй холбоотой аливаа бүтцийн өөрчлөлтийг До тоод орлогын газар (СЯ)-ын удирдамжийн дагуу хэрэгжүүлэх ёстой.	Оюуны өмчийг худалдан авсны төлөөх татварын хөнгөлөлт, дэмжлэгийг авахын тулд зохих аргачлааар үнэлгээг нь хийсэн байх шаардлагатай.	Цахим гүйлгээнд ногдуулах татварыг биет бус хөрөнгийн ашиглалт, үнийг нь шилжүүлэх талаарх бодлогын хүрээнд дахин авч үзэх төлөвлөгөө-тэй.	Компаниудын орлогод ногдуулах татварыг биет бус хөрөнгийн ашиглалт, үнийг нь шилжүүлэх талаарх бодлогын хүрээнд дахин авч үзэх төлөвлөгөө-тэй.

Ази – Номхон далайн зарим орнуудын татварын хандлага

DEMPE – боловсруулж бий болгох, сайжруулах, түүний засвар үйлчилгээ, хамгаалалт, ашиглалт

Хил дамнасан худалдаа, тэр дундаа цахим худалдаа, заримдаа ялангуяа цахим худалдаанд үүсэж болох биет бус үнэт зүйлсийн жишээг дор харуулав¹²⁸.

Биет бус хөрөнгөд хамаарах зүйлүүдийн давамгайлах зүйлс нь:



Эх сурвалж: Deloitte Touche Tomatsu Limited, 2021

Эцэст нь, цахим худалдааны асуудлаар зохицуулах шаардлагатай асуудлууд, эрх зүйн болон зохицуулалтын эх сурвалжуудыг дор харуулав¹²⁹.



Эх сурвалж: Deloitte Touche Tomatsu Limited, 2021

Биет бус хөрөнгийн худалдааг үнэлж хэмжих, татвар, гаалийн зорилгоор уг худалдаанд үнэ цэнэ тогтооход тулгарч буй бэрхшээлүүд нь цахим баримт бичиг, цахим гарын үсгийн хуулийн үндсэн зохицуулалтыг өөрчлөхгүй юм. Биет бус хөрөнгийн асуудлыг бүрэн буюу хэсэгчлэн тохиролцсон гэрээний хүчин төгөлдөр эсэх байдалд тухайн гэрээний агуулга нөлөөлөхгүй. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хувийн нууцыг хамгаалах зэрэг хэм хэмжээнд нэгэн адил захирагдах талаар дор хэлэлцэнэ¹³⁰.

¹²⁸ Deloitte, 126 дахь тайлбар, 22:20-г үзэх

¹²⁹ Deloitte, 126 дахь тайлбар, 36:20-г харах.

¹³⁰ Ийм төрлийн үйлчилгээний олон улсын гэрээний хүчин төгөлдөр байх эсэх, үүнд Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэглэх эсэх асуудал нь тухайн гэрээнд аль талын хууль үйлчлэх талаарх олон улсын хувийн эрх зүйн дүрэм, тухайн орны заавал дагаж мөрдөхөөр заасан хэм хэмжээнээс хамаарна. Ийм дүн шинжилгээ хийх нь энэ тайлангийн хамрах хүрээнээс гадуур юм.

4. Гарал үүслийн гэрчилгээ

Монголд одоогийн байдлаар гаалийн мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргаж, дагалдах бичиг баримтыг сканнердсан байдлаар өгөх боломжтой.

Импортлох, экспортлох барааг дагалдах хамгийн чухал баримт бичгийн нэг бол түүний гарал үүслийн гэрчилгээ юм, түүгээр тухайн барааг үйлдвэрлэсэн улс, үнийн дүнгийн мэдээллийн ихээхэн хэсгийг гэрчилдэг. Энэ мэдээллийг үндэслэн гаалийн байгууллага нь барааг хэрхэн зохицуулах, ямар хэмжээний татвар ногдуулах (татвар ногдуулахаар бол) талаар мэдэх боломжтой. Үр дүнтэй байхын тулд тухайн орны гарал үүслийн гэрчилгээг хүлээн зөвшөөрүүлэх чиглэлээр худалдааны түнш орнуудтай хамтран ажилладаг.

Хэрэв ийм гэрчилгээг тоон хэлбэрээр (болон стандарт хэлбэрээр) байвал гаалийн бүрдүүлэлт илүү хурдан болно. Гарал үүслийн гэрчилгээг олгох эрх MYXAYT-д байдаг. Танхим нь одоогоор тэдгээрийг цахим хэлбэрээр олгодоггүй.

IV. ОЛОН УЛСАД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ БА БОЛОМЖ

Бусад улс орны нэгэн адил Монгол Улс олон улсын арилжааны хэд хэдэн гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон бөгөөд бусад хэлэлцээрт ч нэгдэн орох бололцоотой. Эдгээрийн ихэнх нь цахим харилцаа холбоог ашиглахыг шууд зөвшөөрдөг, эсвэл гэрээ хэлцлийн дагуу үйл ажиллагаа явуулж буй хүмүүс (аж ахуйн нэгжүүд, төрийн байгууллага) өөрсдөө цахим харилцааг сонгосон бол ашиглаж болох тухай заасан байдаг.

Хэрэв тухайн орны хууль нь цахим харилцаа холбоог хязгаарлах хандлагатай байгаа бол зарим тохиолдолд талууд олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд, ажлаа цаасгүй болгох боломжтой. Энэ нь Монголд ч үнэн, учир нь Монголын хуульд “дотоодын хууль олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгтэй зөрчилдсөн бол гэрээний үүрэг давамгайлна” гэсэн зарчмыг тогтмол баримтлан заасан байдаг. Олон улсын баримт бичиг нь дотоодынхаос илүү өргөн хүрээг хамарч, хил дамнасан шинэлэг практикт илүү ач холбогдол өгсөн байдаг.

Одоогоор Монголын хувьд энэ нь өнөөдөр тийм ч их санаа зовоосон хүчин зүйл биш, учир нь бодлого нь ийм харилцаа холбоог аль болохоор дэмждэг. Гэхдээ олон улсын хэлэлцээр нь цоорхойг нөхөж, мэдээлэл, харилцааны технологийг ашиглах уян хатан хандлагыг бий болгодог.

Түүнчлэн зарим гэрээнд цахим харилцааны талаар тусгайлан тусгасан байдаг.

Цаашилбал, цахим харилцаа холбооны технологийн үндэс суурь болох олон улсад хүлээн зөвшөөрсөн стандартыг аль нэг байгууллага хэрэглэх бол тухайн улс орон батлах, элсэх шаардлагагүйгээр стандартыг хуулийн үндэслэлтэйгээр ашиглах давуу талтай гэж үздэг¹³¹.

A. Цахим худалдаанд нөлөөлөхүйц худалдааны гэрээ

Олон улсын чөлөөт худалдааны хэлэлцээрүүд сүүлийн арван жилд оролцогч орнуудын цахим худалдааг зохицуулах эрх зүйн дэглэмийг уялдуулах заалтуудыг багтааж эхэлсэн. Энэ нь санамсаргүй, эсвэл зүгээр л хөнгөвчлөх зорилгоор хийгдээгүй юм; харин хэлэлцээр нь цахим худалдааны дотоодын эрх зүйг бий болгох, худалдааны хуулийн шинэчлэлийг дэмжих үүднээс ийнхүү заасан учиртай. Дэлхийн эдийн засгийн форум (World Economic Forum)-аас мэдээлснээр одоо хэрэгжиж байгаа худалдааны гэрээний талаас илүү хувь нь цахим худалдааг хөнгөвчлөх заалтыг тусгасан бүлэгтэй байна¹³².

Зарим тохиолдолд энэ заалтууд нь талуудыг ижил дэлхийн жишигийн түвшинд хүргэх зорилготой. Ийм стандартын нэг бол НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс

¹³¹ Энэ тайлбарын ихэнх хэсгийг АХБ-наас 2021 онд нийтэлсэн “CAREC-ийн цахим худалдааны хууль ба бодлого” (*E-Commerce in CAREC Countries: Laws and Policies*) гэсэн тайлангаас бага зэрэг тохируулан авав, тэрхүү тайлангийн үндсэн зохиогч нь мөн энэхүү тайлангийн олон улсын зөвлөх юм. <https://www.adb.org/publications/e-commerce-carec-laws-policies>.

¹³² Ази Номхон Далайн хамтын ажиллагааны төв, Цахим гарын үсгийн ажлын хэсэг, *Advancing Digital Transactions in APEC: Enhancing E-Signatures and digital Signatures* (АПЕК-н тоон гүйлгээг нэмэгдүүлэх: цахим гарын үсэг ба дижитал гарын үсгийг сайжруулах) 2022 оны 3-р сар, 15-р хуудас <https://ncapec.org/library/AdvancingDigitalTransactionsinAPECEnhancingE-SignaturesandDigitalSignatures.pdf>.

Арай илүү үнэн зөв томъёолол: “ДХБ-ын гишүүн орнуудын талаас илүү хувь нь цахим худалдааны бие даасан заалт агуулсан дор хаяж нэг [бус нутгийн худалдааны хэлэлцээрт] гарын үсэг зурсан”. A. Darsinouei and R.Kakaub (А.Дарсиноуэй, Р.Какауб нар), “Understanding E-Commerce Issues in Trade Agreements” (Худалдааны хэлэлцээр дэх цахим худалдааг ойлгох нь), Женев хот, CUTS International, 2017, №11. <https://www.cuts-geneva.org/pdf/STUDY%20-%20E-Commerce%20Towards%20MC11.pdf>

(UNCITRAL)-ын загвар хуулиуд юм. Мөн бусад тохиолдолд худалдааны гэрээний талуудыг маргаантай асуудлаар тодорхой нэгдмэл байр суурь баримтлахыг шаардах зорилготой, ийм маргаан нь тухайлбал, бизнесүүд мэдээлэл (ялангуяа хувийн мэдээлэл)-ийн гарал үүсэл, мэдээллийг зөвхөн тухайн улсдаа боловсруулах эсэх, ийм байгууламжийг байршуулах эсэх талаар байж болно¹³³.

Сүүлийн үед олон улсын худалдааны хэлэлцээрт цаасгүй худалдааг хөнгөвчлөх зарчмыг хэрхэн нэвтрүүлж буйг 2017 онд Азийн хөгжлийн банкны (АХБ) хүрээлэнгээс судалсан байна¹³⁴. Хувийн гүйлгээнд хамаарах эрх зүйн шинэчлэлээс илүүтэй цахим худалдааг хөнгөвчлөхөд төвлөрч байна гэж дүгнэжээ. Бусад баримт бичиг, тэр дундаа Дэлхийн худалдааны байгууллагын цахим худалдааны тусгайлсан заалттай хэд хэдэн хэлэлцээрийг тэмдэглэжээ¹³⁵.

Оролцогч талуудын хууль, эрх зүй, соёлын ялгааг харгалзан худалдааны хэлэлцээр ихэвчлэн өндөр түвшинд үүрэг хүлээлгэх, эсвэл зөвхөн эрмэлзлийн шинж чанартай бөгөөд тэдгээрийг нь бодитоор хууль тогтоомжид тусгах эсвэл практик хэрэгжилтийг нь хангах, шийдвэрлэхэд хүндрэлтэй. Эдгээр заалтууд нь талууд хэзээ нэгэн цагт ямар нэгэн байдлаар хүрнэ гэж найдаж буй илэрхийлсэн боловч хэрэгжүүлэхэд нь нэмэргүй.

Дижитал худалдааны ач холбогдол нэмэгдэж, цар тахлын улмаас бүр ч чухал болсон энэ үед худалдааны хэлэлцээрүүдэд тодорхой дүрэм суулгах нь тэргүүний зорилт болов. Австрали-Сингапурын цахим эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр¹³⁶, Чили - Шинэ Зеланд - Сингапурын хооронд байгуулсан Цахим эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр¹³⁷, Номхон далайн иж бүрэн дэвшилтэт түншлэл¹³⁸ зэрэг хэлэлцээрт нь цахим эдийн засаг дахь худалдааны саад тотторыг багасгах, дотооддоо тус бүр уялдсан стандартыг бий болгох, зохицуулалтыг дэмжих, цахим гүйлгээ болон хил дамнасан бизнесийг зохицуулсан дотоодын эрх зүйн орчныг сайжруулах зорилгыг онцолжээ.

Ер нь хил дамнасан цахим худалдааг бүрэн ашиглахын тулд цахим худалдааг худалдааны бодлогын салшгүй хэсэг болгох ёстай. Худалдааны хэлэлцээрт эдгээр заалтуудыг тусгах нь олон нийтийн нэр хүнд өндөр байлгах давуу талтай. Иймэрхүү заалтууд нь улс төрийн анхаарлыг татдаг, харин эрх зүйн техникийн шинэчлэл нь ингэж чадахгүй. Мөн дотоодын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх улс төрийн хүсэл зоригийг бий болгож чадна¹³⁹.

¹³³ Цахим худалдааны тухай загвар хууль, 18-р тайлбарыг харах, Цахим гарын үсгийн тухай загвар хууль, 29 дахь тайлбар.

¹³⁴ Дувал.Ю, К.Мэнжин нар. 2017. *Digital Trade Facilitation: Paperless Trade in Regional Trade Agreements* (Цахим худалдааг хөнгөвчлөх: бус нутгийн цаасгүй худалдаа. АХБ-ын хүрээлэн, ажлын баримт № 747, Токио, <https://www.adb.org/publications/digital-trade-facilitation-paperless-trade-regional-trade-agreements>).

¹³⁵ Monteiro, José-Antonio & Teh, Robert, 2017. *Provisions on electronic commerce in regional trade agreements* (Бус нутгийн худалдааны хэлэлцээр дэх цахим худалдааны тухай заалтууд) ДХБ-ын ажилтнуудын ERSID-2017-11 дугаартай ажлын баримт бичиг, Дэлхийн худалдааны байгууллага, Эдийн засгийн судалгаа, статистикийн хэлтэс, <https://ideas.repec.org/p/zbw/wtowps/ersd201711.html>.

¹³⁶ <https://wits.worldbank.org/GPTAD/PDF/archive/Singapore-Australia.pdf>

¹³⁷ Албан ёсны текстийн холбоос бүхий тоймыг энд үзнэ үү: <https://www.mti.gov.sg/Improving-Trade/Digital-Economy-Agreements/The-Digital-Economy-Partnership-Agreement>

¹³⁸ <https://www.dfat.gov.au/trade/agreements/in-force/cptpp/official-documents>

¹³⁹ J.D. Gregory, "Trade Agreements to Promote Electronic Commerce" (Ж.Д.Грегори, "Цахим худалдааг дэмжих худалдааны гэрээ), Slaw.ca blog: I дэх хэсэг, 2016, www.slaw.ca/?s=trade+agreements+electronic+commerce, II дахь хэсэг нь, 2018, <http://www.slaw.ca/2018/11/08/trade-agreements-to-promote-electronic-commerce-ii/>; III дахь хэсэг нь, 2019: <http://www.slaw.ca/2019/12/30/trade-agreements-to-promote-electronic-commerce-iii/>.

1. Одоо Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэлэлцээр

а. Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр¹⁴⁰

ДХБ-ын худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр нь гэрээлэгч орнууд цахим харилцаа холбоог дотоодын болон олон улсын хэд хэдэн зорилгоор ашиглахыг шаарддаг. Эдийн засгийн хөгжлийнх нь байдлаас шалтгаалж уг шаардлагыг биелүүлэх хугацаа өгсөн. ДХБ-ын энэ баримт бичиг технологийн хувьд төвийг сахих, ялгаварлахгүй байх зарчмыг аль болохоор илүүтэй тусгасан байдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Монгол Улс 2016 оноос хойш ДХБ-ын худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт нэгдсэн байна. Хөгжиж буй эдийн засагтай орны хувьд одоогоор цаасгүй харилцаа холбоо ашиглах үүргийнхээ 75 гаруй хувийг биелүүлээд байна¹⁴¹. Үүргээ бүрэн биелүүлэхгүй удааширч байгаа нь хуулийн шалтгаантай биш, харин бүрэн тогтолцоог бий болгож амжаагүй гэсэн технологийн асуудал юм. Ийнхүү бий болгох эрх мэдлийг уг худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр өөрөө заасан болно.

б. Киотогийн шинэчилсэн конвенц

Дэлхийн гаалийн байгууллагын гаалийн журмыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенц (шинэчилсэн найруулга). Монгол Улс энэ конвенцод 2006 онд нэгдсэн. 2006 оны шинэчилсэн найруулга¹⁴² нь гаалийн практикт боодол бүрийг шалгадаг байсныг өөрчилж, хууль бус бараа болон бусад тохиromжгүй барааны эрсдэл бага бол цахим маягтын хэрэглэхийг дэмжсэн. ДХБ-ын 2022 оны тайланд энэхүү мөрийн хөтөлбөрийг дахин хүлээн зөвшөөрч, үүнийг хэрэгжүүлэх Монголын чадавхыг дэмжиж байна¹⁴³.

в. Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай НҮБ/АНДЭЗНБ-ын суурь хэлэлцээр¹⁴⁴

Хэлэлцээрт хил дамнасан цаасгүй худалдаанд оновчтой, хүлээн зөвшөөрөгдөхүйц, уялдаа холбоотой хандсан зарчмуудыг тусгажээ. Хэлэлцээр нь оролцогч талуудыг цаасгүй худалдааны талаар бодлого бий болгох, янз бүрийн төрийн нэгж болон тэдгээрийн баримт бичгийг зохицуулах нэгдсэн цонх бий болгох, гишүүн орнууд (болон худалдааны бусад түншүүд) хооронд худалдааны баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрсөн тогтолцоог бий болгоход чиглэжээ. Хэлэлцээрийн тал бүр олон улсын шилдэг

¹⁴⁰ Дэлхийн худалдааны байгууллага, Худалдааг хөнгөвчлөх гэрээ

www.wto.org/english/tratop_e/tradfa_e/tradfa_e.htm

¹⁴¹ ДХБ-ын хэрэгжилтийн явцын хүснэгтийг эндээс үзнэ үү, <https://tfadatabase.org/implementation/progress-by-member> and <https://tfadatabase.org/en/members/mongolia>.

¹⁴² Шинэчилсэн Киотогийн Конвенцыг энд тайлбарласан болно: <http://tfig.unece.org/contents/revised-kyoto-convention.htm>. Түүний гарын авлагыг эндээс: <https://www.wcoesarocb.org/wp-content/uploads/2018/07/1.-WCO-Revised-Kyoto-Convention.pdf>

¹⁴³ Дэлхийн гаалийн байгууллага, “Монгол Улс SECO-WCO дэлхийн худалдааг дэмжих хөтөлбөрийн гэр бүлийн нэг боллоо”, <http://www.wcoomd.org/en/media/newsroom/2022/july/mongolia-becomes-part-of-the-seco-wco-gtfs-family.aspx>

¹⁴⁴ Суурь гэрээний талаарх мэдээллийн эх сурвалж энд байна: <https://www.unescap.org/kp/cpta>

туршлагад нийцсэн эдгээр алхмуудыг өөрийн хууль зүйн тогтолцоонд нийцүүлэн хэрэгжүүлэх ёстой юм.

Энэхүү суурь гэрээ нь шаардахаас илүүтэй урамшуулах хандлагатай бөгөөд энэ нь Монгол зэрэг АНДЭЗНК-ын гишүүн орнууд хил дамнасан цаасгүй худалдаа эрхлэхэд хэчинээн бэлэн байгаагаас үл хамааран нэгдэх боломжийг олгодог. Хэлэлцээрийн дүрмүүд нь эхний шатанд байгаа оронд бол удирдамж болно, харин ахисан шатанд байгаа орны хувьд хийсэн алхмуудын бататгаж өгдөг. Дотооддоо болон дэлхийн бусад улстай худалдаагаа хөнгөвчлөхийн тулд тууштай (гэхдээ өөрсдийнхөө хурдаар) ажиллах боломж, замыг бий болгосон. АНДЭЗНК нь оролцогч талуудад хил дамнасан цаасгүй худалдааг төлөвшүүлэхэд туслахаар нөөцийн эх үүсвэрийг санал болгох боломжтой.

г. Монгол-Японы чөлөөт худалдааны хэлэлцээр

Монгол-Японы хооронд 2016 оны байдлаар¹⁴⁵ “эдийн засгийн түншлэл” хэмээх чөлөөт худалдааны гэрээ байгуулсан бөгөөд энэ нь олон улсын стандартад нийцсэн, цахим худалдааны тухай бүлэгтэй. Энэ бүлэгт талууд “цахим худалдаанд технологийн төвийг сахих, ялгаварлахгүй байх зарчмыг” тунхагласнаар эхэлдэг (9.1(3) дахь заалт)

Цахим гарын үсэг нь цахилгаан соронзон бичлэгт хадгалах боломжтой, мэдээллийн хувьд авч хэрэгжүүлсэн бөгөөд ийнхүү хэрэгжүүлсэн этгээд баталгаажуулсан мэдээллийг илтгэсэн, уг мэдээлэл өөрчлөгдөөгүй болохыг батлан илэрхийлнэ гэж заажээ. Сүүлчийн функц нь ихэвчлэн энэ тайланд дурдсан “хэш функц”-ийг /hash function/ ашигладаг тоон гарын үсэгтэй холбоотой.

Хэлэлцээрийн 9.5-д талууд цахим гарын үсгийн талаар “цахим хэлцэлд оролцогч талууд өөрсдийн хэлцэлд тохирох цахим гарын үсгийн аргыг харилцан тодорхойлохыг хориглохгүй”; мөн цахим хэлцэлд оролцогч талууд өөрсдийн цахим хэлцлийг хууль, эрх зүйн аливаа шаардлагад нийцсэн гэдгийг шүүх дээр нотлох боломжгүй болох арга хэмжээг хэрэгжүүлэхгүй” гэжээ. Энэ нь гүйлгээ хийгч талууд тоон гарын үсгийн оронд харьцангуй ачаалал, зохицуулалт багатай цахим гарын үсгийг сонгох боломжтой гэсэн үг үү?

Цахим гарын үсгийн тухай хуульд буй цахим гарын үсгийн хэрэглээг дэмжсэн заалтууд энэ гэрээнд харшлах уу гэдэг нь ээдрээтэй асуудал. Энэ хууль нь тоон гарын үсгийн дэмжсэн боловч шаардаагүй. Баталгаажуулалтын өөр хэлбэрүүд байдаг гэж өмнө ярьсан билээ. Мөн уг хуулийн 2.2-т Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө гэжээ. Тэгэхээр Монгол - Японы хооронд хэлцэл хийх талууд чөлөөт худалдааны хэлэлцээрийн уян хатан нөхцөлийг ашиглах боломжтой.

Б.Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ

Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт оролцогч орнууд хамтын ажиллагаагаа илэрхийлэх, худалдааны асуудлаар хууль тогтоомжийн арга хэмжээ авахыг тусгаж болно. Эдгээр нь хувийн болон эдийн засгийн мэдээллийн хил дамнасан урсгал, кибер гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагаа гэх мэт нийтлэг ашиг сонирхлын асуудлуудыг хэлэлцэх замаар талуудын цахим худалдааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой.

¹⁴⁵ Япон, Монгол Улс хоорондын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр,
<https://www.mofa.go.jp/policy/economy/fta/mongolia.html>

1. Одоо Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа нь

а. Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ (CAREC)

CAREC хөтөлбөр нь бүс нутгийн хөгжлийг дэмжих, ялангуяа зам тээвэр, эрчим хүч, ядуурлыг бууруулах чиглэлээр төв Азийн арван нэгэн улсыг нэгтгэдэг¹⁴⁶. 2021 онд цахим худалдааны хууль тогтоомж, зохицуулалтын талаарх судалгааг (АХБ-тай хамтран)¹⁴⁷ нийтлэх, гишүүн орнуудын цахим худалдааны технологи, дэд бүтцэд дүн шинжилгээг саяхан хийснээс өөр цахим худалдааны талаар дорвитой ажил хийгээгүй байна¹⁴⁸. CAREC нь цахимжуулах хөтөлбөртэй хэдий ч гишүүн орнуудын хууль, зохицуулалтыг боловсруулах, уялдуулах заалтыг дагаж мөрдөөгүй, хүчин чармайлт гаргаагүй байна, CAREC-ээс энэ чиглэлээр зохицуулалт хийгээгүй¹⁴⁹.

2. Монгол Улсын нэгдэж болох бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүд

а. Бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэлийн хэлэлцээр (RCEP)¹⁵⁰

Бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэлийн хэлэлцээр (RCEP) нь БНХАУ, БНСУ, Япон, Сингапур, Австрали зэрэг Азийн томоохон эдийн засагтай орнууд байгуулсан, Ази Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) байгууллагын нэгэн хэсэг нь юм. RCEP нь 2022 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон бөгөөд 18 сарын хугацаанд бүс нутгийн аль ч "улс, нэгж" нэгдэн ороход нээлттэй¹⁵¹. Албан ёсны эх бичвэрт "бүс нутаг" гэж аль газар болохыг заагаагүй ч Азийн аль ч улс, тэр дундаа гишүүн улстай хил залгаа оршдог Монголын хувьд ч, Хятад улсад ч таатай байх болно гэх үндэслэлтэй.

Энэ бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэлийн хэлэлцээр нь гишүүдийнхээ дунд тариfyн саад тогторыг багасгахад чиглээгүй ч цахим худалдааны зохицуулалт бүхий бүлэгтэй¹⁵². Бүлгийн ихэнх хэсэг нь цахим худалдааны хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, уялдуулах хүчин чармайлт гаргана гэжээ. Тэд UNCITRAL-ийн Цахим худалдааны тухай загвар хууль, НҮБ-ын Цахим харилцааны конвенц, цахим худалдаатай холбоотой бусад загвар хууль тогтоомж, олон улсын конвенцуудыг "харгалзан" эрх зүйн орчноо шинэчилнэ (12.10 дахь хэсэг). Мөн хэрэглэгчийн эрхийг хамгаалах (12.7), хувийн нууцыг хамгаалах (12.8) болон хүснэгтэй арилжааны мессеж (спам) (12.9) зэрэг нийтлэг зарчмуудыг баримтлах ёстой. Хэлэлцээр нь үүргээ хэрэгжүүлэх талаар заалт олонтой.

RCEP-ийн бусад дүрэмтэй нэгэн адил цахим гарын үсэгтэй холбоотой дүрэм нь хатуу юм (12.6-р зүйл).

Талууд дотоодын хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд зөвхөн цахим хэлбэрээр гарын үсэг зурсан гэсэн үндэслэлээр гарын үсгийн хууль ёсны хүчинтэй гэж үзэхээс татгалзах эрхгүй.

¹⁴⁶ Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа, <https://www.carecprogram.org/>

¹⁴⁷ 131 дэх тайлбарыг харах.

¹⁴⁸ 4 дэх тайлбарыг харна уу.

¹⁴⁹ 2030 он хүртэлх Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны стратеги, https://www.carecprogram.org/?page_id=18952

¹⁵⁰ Бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэлийн RCEP хэлэлцээртэй холбоотой материалын эх сурвалж: <https://rcepsec.org/>. Үндсэн текст нь: <https://rcepsec.org/legal-text/>.

¹⁵¹ Бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэлийн RCEP хэлэлцээртэй холбоотой материалын эх сурвалж: <https://rcepsec.org/>. Үндсэн текст нь: <https://rcepsec.org/legal-text/>.

¹⁵² Бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэлийн RCEP хэлэлцээртэй холбоотой материалын эх сурвалж: <https://rcepsec.org/>. Үндсэн текст нь: <https://rcepsec.org/legal-text/>.

Цахим баталгаажуулалтын олон улсын хэм хэмжээг харгалзан улс орон бүр:

- (а) цахим гүйлгээний зохих цахим баталгаажуулалтын технологи, хэрэгжүүлэх загварыг цахим гүйлгээнд оролцогчид өөрсдөө тодорхойлохыг зөвшөөрнө;
- (б) цахим гүйлгээний цахим баталгаажуулалтын технологи, хэрэгжүүлэх загварыг хязгаарлахгүй;
- (в) цахим гүйлгээнд оролцогчдод цахим гүйлгээ нь цахим баталгаажуулалтын талаарх хууль тогтоомж, дүрэм журамд нийцэж байгааг нотлох боломжийг олгоно.

Гэхдээ тодорхой тохиолдолд зарим төрлийн гарын үсэг дээр стандартыг тогтоож болно (12.6(3)). Үнэн хэрэгтээ, RCEP-ийн ихэнх үүрэг нь гишүүн орнуудын дотоодын нийтийн ашиг сонирхлыг хүндэтгэн чухалчилж асуудлыг хэлэлцэх, зөвшилцэх маягаар шийдвэрлэнэ гэдэг. Дүрэм, хоригууд нь хатуу санагдсан ч үнэн хэрэгтээ тийм биш юм.

Товчхондоо, RCEP хэлэлцээр нь цахим худалдааны практикийг хөгжүүлэхэд Монголд зарим давуу талтай. Энэхүү хэлэлцээрт нэгдсэнээр хил дамнасан хамтын ажиллагааны гадаад дүрэм журмыг хэрэгжүүлэхийг шаардах илүү боломжтой болно.

В. Цахим худалдааг өөрийг нь хөгжүүлэхэд шууд чиглэсэн гэрээ, хэрэгсэл

1. Монголд одоо байгаа цахим худалдааны хэрэгслүүд

a. Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай НҮБ-ын конвенц

Цахим харилцааны конвенц эсвэл ЕСС гэдэг. Энэхүү Конвенцыг 2020 оны тавдугаар сард баталсан бөгөөд 2021 оны долдугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон¹⁵³.

Энэхүү конвенцод UNCITRAL-ийн Цахим худалдаа, цахим гарын үсгийн тухай загвар хуулиуд дахь цахим харилцааны олон дүрмийг дахин тусгасан. Монгол Улсын Засгийн газарт хүргүүлсэн санамж бичигт Монгол Улсын хуулийн зарим цоорхойг нөхөхөд ЕСС нь тус дөхөмтэй гэжээ.

“Монгол Улсын дээр дурдсан хууль, эрх зүйн зохицуулалт нь цахим баримт бичгийн эрх зүйн үндсийг тодорхойлоогүй, цахим баримт бичгийг цаасан суурьтай баримт бичигтэй ижил тэгш хүлээн зөвшөөрөөгүй, и-мэйл, компьютерын файл, гар утасны богино үсэгт мэдээ (мессеж), мэдээллийн сангийн цахим өгөгдлийг нотлох баримт, хууль зүйн чадамжтай баримт гэж тодорхойлоогүй”¹⁵⁴ гэж дурджээ.

Конвенцын 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт гэрээлэгч улс нь UNCITRAL-ийн цахим худалдааны зарчмуудын дагуу өөрийн нэгдэн орсон олон улсын арилжааны бусад конвенцуудыг тайлбарлах аргыг заасан байдаг. Гэхдээ цахим харилцаа холбоог зөвшөөрөхийн тулд ийм нэгдсэн конвенцуудад шууд өөрчлөлт оруулах шаардлагагүй. Энэхүү конвенц нь Монголын олон улсын эрх зүйн харилцааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

¹⁵³ Баталсан тухай UNCITRAL-ын хэвлэлийн мэдээлэл,
<https://unis.univieenna.org/unis/en/pressrels/2020/unisl309.html>

¹⁵⁴ Монгол Улсын Засгийн газрын “Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн танилцуулга”, 2022 оны 10-р сар <https://forum.parliament.mn/projects/10900>; <https://forum.parliament.mn/files/94591>

¹⁵⁵ Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай Нью-Йоркийн конвенц, Олон улсын бараа худалдах тухай НҮБ-ын конвенц нь дээрх Засгийн газрын санамж бичигт дурдсан хоёр жишээ юм.

б. TIR картын дагуу барааг олон улсын тээвэрлэх тухай гаалийн конвенц

“TIR конвенц” гэдэг, үүний 11 дэх хавсралт нь тоон баримт бичгийн тухай юм, 2021 оны 5-р сард хүчин төгөлдөр болсон ¹⁵⁶. 11 хэд хавсралт нь автоматаар хүчин төгөлдөр болох юм шиг байна, өөрөөр хэлбэл конвенцын гишүүн орнууд үүнийг хэрэгжүүлэхийн тулд тусдаа хууль бий болгох арга хэмжээ авах шаардлагагүй. Энэхүү конвенц нь арилжааны замын хөдөлгөөнийг хилээр хялбархан нэвтрүүлэхэд шаардлагатай баримт бичгүүдийг уялдуулдаг.

2. Хэрэглэж болохуйц цахим харилцаа холбооны хэрэгслүүд

а. Цахим худалдааны тухай ДХБ-ын хамтын санаачилга ¹⁵⁷

ДХБ-ын байгууллагын нэлээдгүй гишүүн орнууд цахим худалдааг хөнгөвчлөх талаар яриа хэлэлцээг 2017 онд эхлүүлжээ. Тэдгээр нь хэд хэдэн газарт, олон янзын хэлбэрээр үргэлжилж байна. Гэхдээ уг хэлэлцээнд Монгол улс албан ёсоор асуудал дэвшүүлж, санал гаргаагүй байдалтай байна.

Гишүүн орнуудын зүгээс 6 үндсэн асуудлыг дэвшүүлжээ: цахим худалдааг бий болгох, түүнийг илүү нээлттэй болгох, итгэлцэл ба тоон худалдаа, олон талыг хамарсан асуудлууд, харилцаа холбоо, зах зээлд гарах гарц¹⁵⁸.

2022 оны 10 дугаар сард болсон хамгийн сүүлийн уулзалтаар тухайн жилийн эцэс гэхэд хэлэлцээрийн бичвэрийг сайжруулах магадлалтай байна¹⁵⁹. Хэдэн жилийн дараа шинэчлэгдсэн ч олон улсад хүлээн зөвшөөрсөн хэлэлцээрийн бичвэртэй болох нь цахим худалдааг улам өргөжүүлэхэд маш их ач холбогдолтой юм. Үүнээс дүгнэхэд энэхүү бичиг баримт нь илүү ач холбогдолтой байх ч түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл нь байх.

б. Цахим худалдаа болон цахим гарын үсгийн талаарх UNCITRAL-ын загвар хуулиуд¹⁶⁰.

Эдгээр хуулиуд нь цахим худалдаанд буй дотоодын хуулийн хориг саадыг үгүй болгоход чиглэсэн олон улсын нэн сайн эрх зүйн баримт юм. Энэ хуулиудын зарим хэсэг нь Иргэний хуулийн цахим баримт бичигтэй холбоотой заалт, зохицуулалтанд хүлээн зөвшөөрсөн

¹⁵⁵ Бүх гүйлгээг эрх зүйн тэгш үндсэн дээр хийх үүднээс дотоодын цахим худалдааны хуулиа ЕСС-тэй уялдуулах нь зүйтэй гэсэн үндэслэл бас гаргадаг. Сингапур, Австрали улсууд үүнийг хүлээн зөвшөөрсөн, Канадад судалж байна.

¹⁵⁶ UN/ESCAP, Цахим гаалийн дамжин өнгөрөх TIR систем (eTIR хөтөлбөр), 2014 оны 9-р сар:
<https://www.unescap.org/sites/default/d8files/knowledge-products/brief12.pdf>.

¹⁵⁷ Цахим худалдааны тухай ДХБ-ын хамтын санаачилга,
https://www.wto.org/english/tratop_e/com_e/joint_statement_e.htm

¹⁵⁸ 159-р тайлбарыг харах, “Цахим худалдааны JI хэлэлцээрийг хэрхэн хийдэг вэ?” гэсэн хэсэгт

¹⁵⁹ Уулзалтын тайлан энд: https://www.wto.org/english/news_e/news22_e/com_28oct22_e.htm

¹⁶⁰ 19-р болон 30-р тайлбар

буй. Харин Иргэний хуулийн эдгээр заалтуудыг Цахим гарын үсгийн хуулиар дэлгэрүүлж зохицуулжээ. Эдгээрийг энэхүү тайлангийн өмнөх хэсэгт илүү өргөнөөр хэлэлцсэн билээ.

в. UNCITRAL-ын Цахим шилжих бүртгэлийн тухай загвар хууль

2017 онд баталсан Цахимаар шилжих бүртгэлийн тухай загвар хууль¹⁶¹ нь барааны үнэ цэнийг шилжүүлэх талаарх худалдааны чухал бичиг баримт юм. Хууль нь шилжүүлж буй бичиг баримтад тавих шаардлагыг хангах, үйл ажиллагааг зохицуулдаг. Ийм бичиг баримтын жишээ дурдвал барааны ачилтын болон агуулахын баримтууд юм. Эдгээр баримтууд нь тухайн бараа бүтээгдэхүүний эзэмшигчийг гэрчилдэг, ингэснээр аливаа хэсэг бараа бүтээгдэхүүнийг шилжүүлэхэд нэг л баримт хэрэгцээтэй болно. Энэхүү загвар хууль нь тухайн цахим бүртгэлийг бий болгох, бүртгэлийг найдвартай хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар үүсгэж, цахим хэлбэрээр аюулгүй шилжих баталгааг хангах (технологийн хувьд), үүнд үүсдэг хүндрэлийг шийдвэрлэхэд чиглэсэн. Цахимаар шилжих бүртгэлийн тухай загвар хууль нь одоогийн байдлаар дэлхийд дөнгөж хэрэгжүүлэх эхний шатандаа байгаа, түүнийг цахим худалдааны цогц эрх зүйн стратеги хэмээн цаашид авч үзэх хэрэгтэй.

Г.Одоогийн мөрдөж буй бусад хэлэлцээр, холбогдох гэрээ

1. Монгол Улсад одоо мөрдөж буй хэлэлцээрүүд

а. Бараа бүтээгдэхүүний олон улсын борлуулалтын конвенц (CISG)

Венийн Борлуулалтын конвенц гэдэг энэхүү хэлэлцээр нь өөр өөр оронд буй талуудын хооронд мөрдөх бараа бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой суурь дүрмийг тогтоожээ. 1980 онд батлагдсан бөгөөд цахим харилцаа холбоог илэрхий зохицуулаагүй. Гэхдээ Бараа бүтээгдэхүүний олон улсын борлуулалтын НҮБ-ын конвенцын Зөвлөх бүлэг нь энэхүү Конвенцыг цахим харилцаа холбоонд бүрэн нийцсэн, ашиглахад яг адил болохыг тогтоосон байдаг¹⁶². Дээр дурдсанаар CISG-н талаар илүү тодорхой тайлбарыг ЕЕС хэлэлцээрийн талаарх хэсэгт оруулж болно.

CISG-н хүрээнд түншилдэг Монгол улс шиг орнуудын хувьд энэ нь чухал үр нөлөөтэй баримт юм, учир нь гэрээлэгч өөрсдөө тусгайлан талууд татгалзсанаас бусад тохиолдолд хэлэлцээр нь олон улсын борлуулалтын гэрээнд шууд мөрдөгддөг. Өөрөөр хэлбэл энэ олон улсын хуулийг олон улсын хэлцэлд болон цахим борлуулалтын харилцааг заавал мөрдөнө. Ингэснээр цахим баримт бичгийн бүрдэл бүхий олон улсын худалдааг сонирхож буй бизнесүүдэд уян хатан байдлыг бий болгож байна, ялангуяа дотоодын хуулиа дагаж мөрддөг CAREC-ын ихэнх гишүүн орнуудад энэ нь илүү таатай эрх зүйн орчныг бүрдүүлж болох юм.

б. Ариун цэврийн болон ургамлын эрүүл ахуйн (SPS) гэрээ

Ургамлын талаар хэд хэдэн хэлэлцээрүүд байдгаас хамгийн нэртэй нь 1951 оноос мөрдөж эхэлсэн Дэлхийн хүнсний байгууллагын (FAO) Олон улсын ургамал хамгаалах конвенц

¹⁶¹Цахимаар шилжих бүртгэлийн тухай загвар хууль, 2017,

https://uncitral.un.org/en/texts/e-commerce/modellaw/electronic_transferable_records

¹⁶² Бараа бүтээгдэхүүний олон улсын борлуулалтын НҮБ-ын конвенцын Зөвлөх бүлэг, Дүгнэлт по. 1, 2003.08.15, <http://www.cisgac.com/cisgac-opinion-no1/>

(IPPC) болон үүнтэй уялдаа холбоотой Дэлхийн худалдааны байгууллагын Ариун цэврийн болон ургамлын эрүүл ахуйн (SPS) гэрээ юм¹⁶³. Монгол Улс 2009 онд IPPC-д нэгдэн орсон байдаг. Эдгээр хэлэлцээрт цахим байдлаар мэдээлэл солилцох талаар хүлээн зөвшөөрч, нарийвчлан зохицуулсан байдаг. Ялангуяа уг гэрээнд заасан “дотоодын мэдээлэх байгууллага” нь SPS мэдэгдэл хүргүүлэх систем (SPS NSS)-ийг одоо ашиглан мэдэгдлийг бөглөх, хүргүүлэх боломжтой болсон¹⁶⁴.

в.Ховордсон амьтан, ургамлыг худалдаалах тухай конвенц (CITES)

НҮБ-ын Ховордсон амьтан, ургамлыг худалдаалах конвенцоор¹⁶⁵ цахим маягтыг ашиглан худалдааны хоригоос чөлөөлөгдөх мэдүүлгийг цахимаар өгөхийг зөвшөөрсөн. Монгол Улс 1996 онд гишүүнээр элссэн.

г.Бараа бүтээгдэхүүний хилийн хяналтыг уялдуулан зохицуулах тухай НҮБ-ын конвенц

Энэхүү конвенцоор худалдаалж буй бүтээгдэхүүнтэй холбоотой стандартуудыг нэг хэлбэрт оруулж, цахим байдлаар уншихад хялбар болгож өгсөн¹⁶⁶. Монгол Улс нь 2007 онд гишүүнээр орсон.

д.НҮБ-ын худалдааны баримт бичгийн үлгэрчилсэн загвар

НҮБ-ын худалдааны баримт бичгийн үлгэрчилсэн загвар нь өөрөө конвенц биш хэдий ч НҮБ-ын конвенц (166 дахь тайлбарыг харах)-г уншиж буй уншигчид өөр хэлээр байсан ч ойлгоход хялбар маягтад оруулсан бичиг¹⁶⁷ юм. Маягуудыг стандартчилсан байдаг тул өөрийн хэлбэрээр ойлгогддог. Бараа бүтээгдэхүүний хилийн хяналтыг уялдуулан зохицуулах тухай НҮБ-ын конвенц гишүүн орнууддаа тэрхүү үлгэрчилсэн загварыг заавал ашиглахыг үүрэг болгодог. Худалдааг хөнгөвчлөх, цахим бизнесийн асуудал эрхэлсэн НҮБ-ын төв (UNE/CEFACT) нь энэхүү үлгэрчилсэн маягтыг цахим бичиг баримтыг дэлгэцээр дүрслэхэд ашиглаж болно гэжээ¹⁶⁸

Д.Олон улсын стандарт

1.Одоо хүчин төгөлдөр нь

а. НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх төвийн (CEFACT) зөвлөмж

Эдгээр нь конвенцуудтай адил заавал биелүүлэх шинжгүй боловч тэдгээр нь хэвшүүлэх боломжтой дүрэм, цахим арилжааг хэрэгжүүлэх олон улсын хэмжээний шилдэг туршлагыг агуулдаг¹⁶⁹. "Нэг цонх"-ыг бий болгоход эрх зүйн болон захиргааны талаас анхаарах

¹⁶³ Ер нь бол ДХБ-ын гишүүн болохоор түүний тогтоосон хууль журмыг бухэлд нь дагаж мөрдөх ёстой, ганц ганцаар нь биш. Энэ нь удаан ахиц дэвшил гарж буй тодорхой салбарт анхаарлаа төвлөрүүлэхэд тустай байх магадлалтай.

¹⁶⁴ ДХБ-ын сайт дээр нэмэлт мэдээлэл бий: https://www.wto.org/english/thewto_e/coher_e/wto_ippc_e.htm болон https://www.wto.org/english/tratop_e/sps_e/sps_e.htm.

¹⁶⁵ Ховордсон амьтан, ургамлыг худалдаалах конвенц, 1973 (1979, 1983 онд нэмэлт өөрчлөлт оруулсан). <https://cites.org/eng/disc/text.php>. See also <https://cites.org/eng/disc/what.php>.

¹⁶⁶ Тайлбар нь энд: <http://tfqg.unece.org/contents/Harmonized-frontier-controls-convention.htm> and the text here: <http://www.unece.org/fileadmin/DAM/trans/conventn/ECE-TRANS-55r2e.pdf>

¹⁶⁷ <http://tfqg.unece.org/contents/recommendation-1.htm>

¹⁶⁸ Зөвлөмжийн эндээс үзэх үү: <http://www.unece.org/tradewelcome/un-centre-for-trade-facilitation-and-e-business-uncefact/outputs/cefactrecommendationsrec-index/trade-facilitation-recommendations.html>

¹⁶⁹ UNE/CEFACT-н худалдааг хөнгөвчлөх талаарх зөвлөмж:

https://unece.org/trade/uncefact/tf_recommendations

зүйлсийн дээр тайлбарласан. Худалдааг хөнгөвчлөх олон стандартын хэрэгцээтэй цуглуулга мөн бөгөөд тэдгээрээс хуультай холбоотой заримыг нь зөвлөмж болгон бүлэглэсэн байдаг.

б. Олон улсын стандартын байгууллагын (ISO) стандартууд

ISO-н стандартууд нь хил дамнасан цахим худалдаанд олон талын хэрэглээтэй. Тэдгээрээс хамгийн чухал нь баталгаажуулалтын гэрчилгээ, мэдээллийн аюулгүй байдалд хамааралтай ISO 27000 тоот цуврал стандарт юм¹⁷⁰.

в. Интернетийн стандартууд

Интернет инженерчлэлийн ажлын хэсэг (IETF)¹⁷¹ нь сүүлийн хагас зуун жилийн хугацаанд интернетийн дизайныг илэрхийлэх, түүнийг ажиллуулахад шаардлагатай олон чухал стандартуудыг бий болгосон. Тоон гарын үсгийн чухал стандарт бол тоон гэрчилгээний X.509 стандарт¹⁷² юм. Монголын техникийн зураглал нь эдгээр стандартыг дагаж мөрдөх нь зүйтэй.

¹⁷⁰ Олон улсын стандартын байгууллага, ISO/IEC 27001 Мэдээллийн аюулгүй байдлын удирдлага: <https://www.iso.org/isoiec-27001-information-security.html>

¹⁷¹ Интернетийн инженерчлэлийн ажлын хэсэг, <https://www.ietf.org/>

¹⁷² Тоон гэрчилгээний X.509 дүгээр стандарт: <https://www.ssl.com/faqs/what-is-an-x-509-certificate/>

V. ЦАХИМ ХУДАЛДААНЫ ХҮРЭЭ, НӨХЦӨЛ¹⁷³

Монгол Улс нь арилжааны болон төр, иргэний харилцааг хамарсан цахим харилцааны хуулиудаа идэвхтэй шинэчилж ирсэн. Зарим хуулиуд саяхан гарсан: Цахим гарын үсгийн тухай хууль нь 2021 оны 12 дугаар сарт батлагдаж 2022 оны 5 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль 2023 оны эхээр шинэчилсэн найруулгаар гарах төлөвтэй. Бусад холбогдох хуулийн зохицуулалт ч мөн адил нэлээд шинэ, үр дүн нь бодитоор харагдаагүй байна. НҮБ-ын Цахим харилцааны конвенц 2021 оны долдугаар сард Монгол Улсын хувьд хүчин төгөлдөр болсон. Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай НҮБ/АНДЭЗБНХБ-ын суурь хэлэлцээрт 2022 оны долдугаар сард нэгдэн орсон.

Эдгээр хүчин зүйлсийн Монголын эдийн засагт, ялангуяа цахим эдийн засгийн эрх зүйн орчинд үзүүлэх нөлөөг үнэлэхийн тулд энэхүү тайланд цахим гүйлгээний зарчим, гадаадын эрх зүйн шилдэг туршлага зэрэг олон тодорхой асуудлыг авч үзсэн болно. Ийнхүү хэлэлцсэн нь дараагийн хэсэгт Монгол Улсын хуулийн шинэчлэлд өгөх зөвлөмжийн арга замыг бэлтгэнэ.

Эрх зүйн зохицуулалтын зарчим

Энэхүү тайлангийн эхний хэсэгт дурдсан цахим гүйлгээний тухай хэсэг нь НҮБ-ын Олон улсын худалдааны эрхзүйн комиссын цаастай худалдаанд зориулсан шаардлагуудаар дүүрэн эрх зүйн зохицуулалттай орчинд цахим гүйлгээг идэвхжүүлэх ажлыг дүгнэсэн болно. Ийнхүү идэвхжүүлэх арга хэмжээнүүд нь хэрэгцээ шаардлагатай болоод дэлхий улс орнуудад өргөн тархсан ч энэхүү ажлууд нь эрхзүйн орчныг цахим харилцаанд нийцүүлэхэд хангалттай гэж үзэхгүй. НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс нь хууль эрхзүйн зохицуулалтын асуудлаар ямар нэгэн байр сууриа илэрхийлээгүй байгаа нь одоогийн байгаа дүрмийг хүлээн зөвшөөрч байгаа эсвэл цахим худалдаа үзүүлэхийн тулд нэмэлт ямар нэгэн зүйл хийх хэрэггүй гэсэн мэдэгдэл аль аль нь биш юм.¹⁷⁴

Нийгэмд цахим худалдааг амжилттай хэрэгжүүлэх асуудал нь хэд хэдэн хүчин зүйлээс хамааралтай гэдэг нь тодорхой болоод байна. Цахим харилцаа, худалдааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд шилжүүлэг хийх, шилжүүлгийг хүлээн авах гэх мэт цахим харилцааны үйл ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмж, технологи нь бэлэн байх шаардлагатай байдаг. Түүнчлэн хамгийн шилдэг хууль бол байхгүй байгаа тоног төхөөрөмж, компьютерыг бүтээх болон тэр технологийг бүтээсэн хүнд хэрхэн ашиглахыг заах тухай явдал огтхон ч биш юм. Шинээр бий болж буй цахим бизнес, инновац, шинэчлэлүүд бүтэлгүйтэх үе байдаг тул хүлээн авагч зах зээл, эдийн засаг нь тухайн технологи, инновацыг дэмжих, хүлээн авах хангалттай хэмжээний нөөц бололцоо, идэвхтэй байх шаардлагатай байдаг.

Бас нэгэн чухал биет бус хүчин зүйл бол хүмүүсийн цахим худалдаанд итгэх итгэл юм, хүмүүс болон технологи. Интернэт, компьютер гээд итгэж болох уу? Үүний цаана хэн байгаа вэ гэх мэт асуудлууд байдаг.

¹⁷³ Энэхүү хэсэгт гарах тайлбарын ихэнх хэсгийг АХБ-ны Төв Азийн бус нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны төслийн Цахим худалдааг хуульчлах тухай 2021 оны тайлангийн хэсгээс хуулбарласан эсвэл бага зэрэг өөрчлөн оруулсан болно. 109-р тайлбар хэсгийг мөн харах

¹⁷⁴ НҮБ-ын Олон улсын худалдааны эрхзүйн комиссын Хууль тогтоомж боловсруулах аргачлалын 19 дүгээр хэсгийн 13-14 дүгээр хэсгийг харна уу.

Итгэлцэл гэдэг нь олон талтай. Энэ нь ирээдүйд учирч болох үйл явцын талаарх шүүмжлэл юм. Харьцангуй тайван, итгэж болох нийгэмд хүмүүс итгэл даах чадвартай, хийсэн гэрээ, хэлцэл болон тохиролцсон зүйлдээ хурдэг. Яагаад гэвэл энэ нь анхнаасаа л хүлээгдэж буй үйл явц учраас тэр.

Гэтэл эдийн засгийн харилцаанд биет байдлаар оролцоход бэрхшээлтэй, айдастай нийгэмд бол худалдаа хийж буй харилцагчийнхаа царайг ч харахгүй байгаа цахим худалдаанд итгэхэд бүр ч илүү төвөгтэй болдог байна.

Нөгөө талаас кибер аюулгүй байдлын зарим нэг үзүүлэлтүүд нь цахим шилжүүлгийг бодит хүнтэй харилцаж хийснээс илүү найдвартай, нотолгоотой болгодог талтай. Цахим гүйлгээ нь уламжлалт хүнтэй харилцах худалдаанаас илүүтэйгээр ил тод, хянан шалгах боломжтой байдаг. Энэхүү итгэл даахуйц байдлыг олж авахад суралцах хэрэгтэй байдаг.

Азийн хөгжлийн банк болон НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс хамтран Ази тивд өргөн тархаад буй цахим худалдааны талаарх судалгааг гаргасан байна.¹⁷⁵ Энэхүү судалгаанд цахим худалдаа нь эдийн засгийн хүчин зүйлүүд болон түүний нөхцөл байдал, институцийн болон хууль, эрхзүйн орчин, нийгмийн зан төлөв, ухамсар, хүлээн авах чадвар зэргээс хамааралтай байгааг тогтоожээ.¹⁷⁶

Дээрх гурван хүчин зүйлс нь дотоодын асуудал бөгөөд бүгд хоорондоо харилцан хамааралтай байдаг байна. Эдгээрийн аль нэг нь доголдолтойгоор цахим худалдааг бүрэн хөгжүүлэх нь хүндрэлтэй байдаг гэж тус судалгаанд үзжээ.

Монгол Улсын эдийн засгийн түвшнийг үнэлэх, нийгмийн зан төлөвийг судлах нь энэхүү тайлангийн цар хүрээ, агуулгад багтаагүй болно. Нөгөөтээгүүр НҮБ-ын Олон улсын худалдааны эрхзүйн комиссоос санал болгож буйгаас гадна бизнес эрхлэгчид, хэрэглэгч хооронд илүү үр ашигтай, аюулгүй болгох цахим худалдааг хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн өөр олон арга хэрэгсэл байдаг шаардлага, үзүүлэлтүүд байгаа.

АХБ болон Ази, Номхон далайн эдийн засаг нийгмийн комиссын судалгаа болон хэд хэдэн бусад судалгаанд¹⁷⁷ институцын болон хууль, эрхзүйн орчин, цахим орчны аюулгүй байдал, цахим гэмт хэргийн эсрэг хэрэглэгчийн аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалах дүрэм, журмын талаар хэд хэдэн удаа онцлон тэмдэглэсэн байдаг. Эдгээр асуудлууд нь хэрэглэгч, үйлчилгээ үзүүлэгчдийн хоорондын итгэлцлийн салшгүй хэсгүүд бөгөөд цахим худалдааны хөгжлийн суурь гэж үзсэн байна.¹⁷⁸

АНУ-ын ОУХА-аас Хэрэгцээтэй ерөнхий зарчмуудын талаар, ялангуяа цахим худалдаанд хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах тухай тусгайлсан тайланг 2021 онд гаргасан. “Цахим худалдааны кодчиллыг нэвтрүүлэх нь”, “Төв Азийн цахим худалдааг хөгжүүлэхэд гаргасан

¹⁷⁵2018 оны 6 сард хэвлэгдсэн “Ази, Номхон далайн орнуудад Цахим худалдааны эрин үеийг угтан авах нь” тайлангийн 5 дугаар хэсэг. Энэхүү тайланд ТАБНЭЗХАТ-ийн хэд хэдэн гишүүн орнуудын загвар жишиг багтаасан байгаа.

¹⁷⁶ 5 дугаар тайлбарыг харах, 13-р хуудас.

¹⁷⁷ Жишээлбэл, НҮБ-ын худалдаа хөгжлийн бага хурлын Буурай хөгжилтэй орнуудын цахим худалдаанд бэлэн байдлын дүн шинжилгээ: Бодлогын өөрчлөлт болон арга замууд (2019) цахим хувилбар:

https://unctad.org/en/PublicationsLibrary/dtlistict2019d7_en.pdf.

НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс, Цахим, тогтвортой худалдаа үйлчилгээ: Олон улсын тайлан 2019, цахим хувилбар: <https://unfsurvey.org/report>.

¹⁷⁸ Цахим холбоо, харилцааны хэрэглээнд хууль, эрхзүйн саад тогторыг арилгахад чиглэсэн хууль, эрхзүйн зохицуулалтууд тэр дундаа баталгаажуулалттай холбоотой заалтууд нь талууд хоорондын итгэлцлийг бий болгож байна гэж үзэж байна. Жон Д. Грегори, “Итгэлцлийг хуульчлах нь” (2014), 12 Хууль болон технологи Канадын сэтгүүл дугаар 1, цахим хувилбар: <https://digitalcommons.schulichlaw.dal.ca/cjlt/vol12/iss1/1/>

зөвлөмж”¹⁷⁹ болон “Цахим худалдаанд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай” 2021 оны тайлангуудын агуулга нь одоогийн тайлангийн агуулгатай нийцэж байгаа юм.

А.Цахим худалдааны тухай хууль

Цахим худалдааны тухай хууль, эрхзүйн орчны хамгийн эхний бүрэлдэхүүн хэсэг бол Цахим худалдааны тухай хууль өөрөө юм. Худалдах, худалдан авахтай холбоотой цахим гүйлгээ нь нийгэмд хэдийнээ хэрэгжээд эхэлсэн ч Иргэний хуульд эдгээр асуудлыг нарийвчлан зохицуулаагүй хэвээр байна. Засгийн газар эдгээр асуудлын зарим нэгийг нь хөндөж, Цахим харилцаа, холбооны конвенцод элсэх ажиллагааны үеэр дурдсан байна. Тухайлбал цахим нотлох баримт алга болох, гэрээгээр бус, хувь чатаар худалдаа, арилжаа хийх, мессэжний цаг хугацаа зэргийг хуулийн хүрээнд авч үзэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Ийм үр дүнд хүрэхийн тулд Цахим харилцаа, холбооны тухай Конвенцыг дотоодын хуульд дагаж мөрдөх нь хамгийн тохиромжтой арга гэж үзэж байна. Цахим харилцаа, холбооны тухай конвенцод Цахим гарын үсгийн тухай загвар хууль (MLEC)-ийн суурь заалтуудыг авч үзэх нь илүү ач холбогдолтой, учир нь яг эдгээр хуулийн заалт, зохицуулалт Монголд байхгүй. Цахим гарын үсгийн тухай Монгол Улсын хууль байгаа ч түүнийг шинэчлэх хэрэгцээтэй гэж хэлж болно. НҮБ-ын Цахим харилцаа холбооны Конвенцыг авч хэрэгжүүлэх бол цахим харилцаа холбоо болон цахим гарын үсэг аль алийг нь хамтад нь зохицуулах боломжтой юм.

Одоогийн байдлаар Монгол Улсад Цахим худалдааны тухай өрөнхий хууль байхгүй учраас нэр томьёоны хувьд дээрх Конвенцыг авч хэрэгжүүлэх нь илүү хялбар байх талтай. Гэхдээ үүнд нэг асуудал үүсэж болно: Иргэний хуульд гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр болно гэсэн зарчим байхад ковенцод цахим бичиг баримтад хүчин төгөлдөр гарын үсэг зурсан нь хуулийн хүрээнд хүчинтэй, цаашид нотлох баримт болох зориулалтыг нийтлэгээр голчилсон байдаг хоёрын хооронд асуудал үүсэж болзошгүй¹⁸⁰. Хэдийгээр гүйлгээ нь гарын үсэг зурсан эсэхээс хамаарах боловч эрхзүйн хувьд өрөнхий хүчин төгөлдөр байдал нь тухайн гүйлгээний эцсийн зорилго нь юу вэ гэдгээс хамаардаг байна. “Дараа нотолгоо, лавлагаа болох” нь “үүрд” байна гэсэн үг биш, цаасан баримтыг ч устгах боломжтой тул бас л үүрдийн хүчинтэй биш байдагтай адил. Бүртгэл хадгалах журам нь тогтвортой арга хэрэгслээс тусдаа асуудал бөгөөд НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын баримт бичигт бүртгэл хадгалах дүрмийн талаар тусад нь заалт оруулж өгсөн байдаг.¹⁸¹

НҮБ-ын Цахим харилцаа холбооны конвенцод цахим гарын үсгийн талаар хэд, хэдэн заалтуудыг тусгаж өгсөн байдаг. Энэхүү тайлан нь “Цахим гарын үсгийн тухай хууль”-д дүн шинжилгээ хийсэн бөгөөд зарим нэг сайжруулж болох арга замуудын талаар тайлангийн эхэн хэсэгт дурдсан болно. Мөн түүнчлэн цахим худалдаа, цахим гарын үсгийн тухай хуулийг өргөн цар хүрээнд бүрэн хэмжээгээр авч үзэх нь зүйтэй талаар тэмдэглэсэн байгаа.

“Цахим гарын үсгийн тухай хууль” нь “Цахим худалдааны тухай хууль”-ийн гадуур, тусдаа бие даасан хууль хэдий ч НҮБ-ын Цахим харилцаа, холбооны Конвенцыг дотоодод

¹⁷⁹ АНУ ОУХА, 2021. Хуулбарлуулах эрх нь зохиогч нарынх нь мэдэлд байгаа

¹⁸⁰ НҮБ-н Цахим харилцаа холбооны конвенц 20 дугаар тайлбар, 9.2 дэх заалт

¹⁸¹ Бүртгэл хадгалах дүрмийг Цахим худалдааны тухай загвар хуулийн 10 дугаар бүлгээс оруулж болох юм. НҮБ-н Цахим харилцаа холбооны конвенц нь олон улсын худалдаанд зориулагдсан тул бүртгэл хадгалах талаар тусгаагүй, эдгээр зохицуулалтыг дотоодын хуулиар зохицуулах шаардлагатай.

хэрэгжүүлж байгаа ямар ч загвартай нийцэж байх нь зүйтэй байна. 1.Д хэсэгт гарсанчлан энэхүү хуулийн цар хүрээний өөр нэг байж болох бүрэлдэхүүн хэсэг бол 2022 оны 6 дугаар сард болсон семинарын үеэр оролцогч талуудын зүгээс хөндөж байсан асуудлууд юм. Тэд эрхзүйн хүчин төгөлдөр байдал болон цахим харилцааны хэрэглээг төдийлөн онцлон авч үзээгүй бөгөөд шударга зохицуулалттай байх тал дээр гол анхаарлаа хандуулсан юм. Тус семинарт оролцогч талууд Цахим харилцаа, холбооны Конвенцыг хуулийн зэрэгцээгээр дагаж мөрдөх боломжтой гэж үзсэн.¹⁸²

1. Худалдааны тухай, эсвэл Арилжааны тухай хуулийн цахим худалдаанд үзүүлэх нөлөө

Монгол Улсад худалдаа болон арилжааг зохицуулах бие даасан хуультай болох эсэх асуудал 2000 оноос хойш яригдаж байгаа ч өнөөг хүртэл шийдэгдээгүй байна. Цаашид Худалдааны тухай хуулийн асуудлыг эцэслэж, батлах шаардлагатай. Үүнээс гадна Худалдааны тухай хуулийг бизнесийн эрх зүйн харилцааг зохицуулахаар боловсруулж буй Арилжааны тухай хууль болон одоо мөрдөж буй Иргэний хуультай харилцан уялдуулж, эрх зүйн орчныг эдгээрийн хооронд давхардалгүй, зөрчилгүйгээр бий болгох нь зүйтэй.

Энэхүү тайлан нь цахим худалдааны эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд Цахим худалдааны тухай хуулийн төслийг шинээр боловсруулахыг зөвлөж байна. Цахим худалдааны тухай хуулийн шинэ төсөл нь Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу анхдагч хууль болох юм. Уг хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн зарчим, шаардлагыг харгалзах шаардлагатай бөгөөд НҮБ-ын конвенцын суурь зарчмуудыг эх сурвалж, удирдлага болгох нь зүйтэй. Түүнчлэн бусад орнуудын харьцуулсан судалгаа, тэдгээрийн шилдэг туршлагыг анхаарч үзэх хэрэгтэй.

Худалдааны тухай хуулийн хүрээнд цахим худалдааг нэг бүлгээр зохицуулах боломжтой ч тусдаа бие даасан хууль гаргаснаар илүү тодорхой, үр дүнтэй байх магадлалтай. Цахим худалдааны өнөөгийн хурдацтай хөгжиж буй энэ үед эрх зүйн орчныг нь удаалгүй бэлэн болгох нь үнэ цэнтэй алхам болох юм. Зохицуулалтгүй хэвээр байгаа нь олон тодорхойгүй байдлыг бий болгож, хэрэглэгчид болон бизнесийг сөрөг үр дагаварт хүргэж байна. Арилжааны тухай хуулийг баталж, хэрэгжиж эхлэх хүртэл хэр хугацаа шаардагдах нь тодорхойгүй учир цахим худалдааны бие даасан хуулийг хэрэгжүүлэх нь илүү эзрэг нөлөөтэй байх болов уу.

Цахим худалдаатай холбоотой хууль тогтоомжийг татварын багц хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Эрүүгийн хууль, Хаягжуулалтын тухай, Шуудангийн тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжуудтай харилцан уялдаатай байлгах нь чухал болно. Ингэхийн тулд холбогдох яамд, тэдгээрийн ажлын хэсгүүд хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг хийх шаардлагатай. Хувийн хэвшлийн оролцогч талууд ч оролцох ёстай.

2. Цахим худалдааны нэр томъёоны асуудал

Монголд цахим худалдаа болон цахим харилцаа холбооны салбарт их олон гадаад нэр томъёог хэрэглэж байна. Жишээлбэл, electronic, digital, e-commerce, e-trade, platform, application, cyber security, digital signature, electronic signature, online, mobile app, QR код гэх мэт. Монголын хуулийн шаардлага (Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйл,

¹⁸² Анхны зохиогч нь НҮБ-н Цахим харилцаа холбооны Конвенцыг дотоодод нэвтрүүлэх талаар тайланг ТАБНЭЗХАТ-с гаргасан байна. Тус тайлан нь хавсралтад орсон болно. (Хураангуйлан оруулсан болохыг анхаарна уу.)

Монгол хэлний тухай хуулийн 4, 6 дугаар зүйл зэрэг)-ын үүднээс энэ салбарт хэрэглэгдэж буй олон гадаад үг, нэр томьёог монгол хэлэнд тохиромжтой байдлаар орчуулах шаардлагатай. Зарим нэр томьёо хоорондоо ойролцоо утгатай байдаг тул зөв утга санаагаар орчуулах нь зүйтэй. Нэг үгийг олон утгаар ашиглахгүй, нэг ойлголт нь түүнийг илэрхийлэх ганц үг, эсвэл үг хэллэгтэй байх нь зөв юм.

Жишээ нь, “trade” бол худалдаа, харин “commerce” гэдэг нь арилжаа гэх мэт эдгээр үгүүдийг монгол хэлэнд өөр, өөр үгээр орчуулж хэрэглэдэг. Гэтэл “E-commerce” гэдгийг монголоор бол “цахим худалдаа” гэж хэрэглэж байна, хуулийн зохих хэсэгт нь энэ нэр томьёоны тодорхойлолтыг оруулж болно. “E-trade” гэдгийг бас монголоор “цахим худалдаа” гэдэг. “Commerce” гэдэг үгийг нэг талаас “худалдаа”, нэгөө талаас “арилжаа” гэж орчуулна. Энэ хоёр үг тодорхой хэмжээгээр өөр өөр уттыг агуулдаг гэж үзэж болно. “Commercial law” гэсэн хуулийг Арилжааны хууль гэсэн нэрээр боловсруулах тухай яригдаж байсан. Ямар ч тохиолдолд хуульд яагаад яг энэ үг, эсвэл нэгөө үгийг хэрэглэж байгаа нь ойлгомжтой байх нь зүйтэй.

Монгол хэлний тухай хууль нь (21 дүгээр зүйлд) монгол хэл, бичиг үсгийг хэрэглэх, хамгаалах, түүний үгийн санг хөгжүүлэх, дүрмийг хариуцах, гадаад хэлнээс монгол хэлэнд хөрвүүлсэн нэр томьёог хэлэлцэн батлах асуудлыг Хэлний бодлогын үндэсний зөвлөлд хариуцуулсан. Тус Зөвлөлөөс цахим худалдааны нэр томьёог оновчтой болгох ажил хийсэн эсэх талаар тодорхой мэдээлэл алга байна. Үүн дээр хувийн хэвшлийн оролцоо маш үр дүнтэй байж болох юм, ингэснээр гадаадын болон одоогийн Монголын худалдаанд ашиглаж буй нэр томьёог нэг мөр ойлгоход хялбар болно.

Цахим худалдаа, цахим харилцааг зохицуулах хуулиудын хүрээ ихээхэн шинэчлэгдэж, боловсронгуй болж байгаа энэ цаг үе бол эдгээр болон бусад монгол нэр томьёоны асуудлыг шийдвэрлэхэд тохиромжтой цаг үе юм. Энэ зорилгоор тодорхой цаг хугацаа, хүчин чармайлт гаргах нь зөв.

Б. Цахим худалдааны бизнес

Цахим худалдааны хууль нь цахим хэрэгслээр хийсэн аливаа арилжааны гүйлгээнд хамаарна. Гэхдээ гүйлгээг хэн, ямар нөхцөлд хийж байгааг анхаарах бодлогын шалтгаан бий.

Нэг шалтгаан нь ил, танигдахуйц байх: төр нь эдийн засгийн ямар ажиллагаа явагдаж байгааг мэдэх статистикийн сонирхолтой байдаг. Тухайн орны эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх, өсөлтийг нь хангах үүрэгтэй менежерүүд, зарим талаараа татварын хүмүүс нь үүнийг мэдэх учир нь худалдаа нь улсын орлогын эх үүсвэр мөн, мөн өндөр ажил эрхлэлт, инновац, худалдааны харилцааг дэмждэгт оршино. Аж ахуйн нэгжүүдийг бүртгэх дүрмээр бүртгүүлэгчээс бизнесийнх нь төрлийг асуух маягаар нээлттэй ил мэдээлэл бүрдүүлж болно.

Бүртгүүлж буй аж ахуйн нэгжийг илүү тогтвортой, илүү үр нөлөөтэй мэтээр тодорхойлж, түүнд өөрийн гэсэн ангиллыг өгч болно. Жишээ нь, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд “Цахим бизнес эрхлэгч” гэсэн ангилалд “албан ёсны цахим хуудсаараа дамжуулан бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож, энэ чиглэлээр гэрээ байгуулдаг бизнес эрхлэгч, бараа үйлдвэрлэгч, бараа, үйлчилгээ борлуулагч” гэж тодорхойлсон байна. Иймээс арилжааны платформ эсвэл фэйсбүүк хуудсаараа бус зөвхөн өөрийн цахим хуудсаар дамжуулан бизнес хийх нь тухайн хүн, аж ахуйн нэгжийг ийм цахим оператор, цахим бизнес гэсэн шалгуурыг хангана.

Цахим хуудсууд нь бизнесийг олон нийтэд ойртуулдаг. Илүү ил, танигдахуйц болох тусам татварынхны анхаарлыг татна. Харин хувь хүн эсвэл жижиг нэгжүүд татварт өртөх магадлалаас болж бүртгүүлэхгүй байж болно, ялангуяа нийгмийн даатгалын шимтгэл болон бусад нийгмийн төлбөр төлөх нь хүндрэлтэй байж болно. (Аливаа бизнесийг бүртгүүлэх эсэх нь сонголтоор биш л дээ. Энд ярьж буй зүйл нь өөрийгөө цахим худалдааны нэгж гэж тодорхойлох эсэх талаар ярьж буй юм, мэдээж ингэж сонгох боломж хуульд байгаа бол. Монголын өнөөгийн байдал нь бүрэн тодорхойгүй учраас ийнхүү хэлэлцэж буй юм).

Бүртгүүлэх бизнес эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэх нэгэн арга бол цахим борлуулалтын татварын хэмжээг бууруулах зэрэг давуу талыг санал болгох. Жишээ нь, цахим худалдааны бизнесээр бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүд урамшуулал, татаас авах боломжтой байх.

Нэгж нь өөрөө үйл ажиллагаагаа цахим худалдааны бизнес гэж тодорхойлох болно. Бусад жижиг, хувиараа худалдаа эрхлэгч, магадгүй Facebook, Instagram хуудсаараа дамжуулан ажилдаг хүмүүс үйл ажиллагаагаа хуулийн дагуу бүртгүүлж баталгаажуулсны давуу талыг эдэлсэн ч нийтлэг журмаар татвар төлөх нь хэвээр байна. Тэд хэрэглэгчдийн өмнө үүрэг хариуцлага хүлээсэн хэвээр байх ч төрийн бодлогын хувьд бол ийм бизнес нь бага ач холбогдолтой юм¹⁸³. (Facebook-ээс явуулж буй бизнес нь заавал жижиг байдаг гэсэн үг биш, бодит хаягаар ажилдаг бизнесээс нэлээдгүй том байж болно. Үүнд албан бүртгэлтэй эсэх, бүтэц зэрэг шалгуураар авч үзэж болно.)

Зохицуулах шаардлагаатай "том, ноцтой" үйл ажиллагааг ялгах, эсвэл татварын хувьд урамшуулах бизнесийг салгаж тодорхойлох нэгэн хэмжүүр бол борлуулалтын хэмжээ юм, гэхдээ үүнийг шударгаар тайлагнасан бол л бодитой дүнг мэдэх юм. Цахим худалдааны нэгжийг тодорхойлоход бизнесийн хэмжээнээс хамааруулах бол борлуулалт дүнгийн нэгэн хязгаар, шугам тогтоох хэрэгтэй болох юм.

Негөөтээгүүр, төрөөс илүү уламжлалт аж ахуйн нэгжийг дэмжих бодлоготой байж болно, тухайлбал, биет байршилтай, оффис, үйлдвэр, дэлгүүр, ажилчидтай бизнесүүдэд илүү хандахаар шийдэж болно.

Ямартаа ч цахим бизнес мөн эсэхийг тодорхойлохын тулд бизнесийн хэдэн хувийг цахимаар явуулах шалгуурыг шийднэ. Үүнд санах ёстой нэгэн чухал асуудал бол цахим бизнесийн харилцаа холбооны системд шаарддагдах bandwidth-ыг тооцоолох нь тухайн төрлийн бизнесийн төлөх татварын орлогыг тооцоолохос огт өөр байж болзошгүй.

Төрийн дэмжлэгийг хүртэх боломжтой цахим этгээдийг ялгаж салгах талаарх маргааны жишээг дор дурдав:

1. Бүх цахим нэгжүүдийг адилхан авч үзэх: цахим худалдааны худалдагч этгээдүүдийн хооронд ялгах ямар ч хэрэг байхгүй. Хэрэв төр цахим худалдааг дэмжих бол дэмжлэг нь цахим арилжааны аль ч хэлбэрт ижил хамаарна. Ганц ялгах зүйл нь бүтээгдэхүүний хэмжээ, олон төрөл зүйл юм. Бүх хуулиуд ижил үйлчлэх ёстой, ижил хэмжээгээр татвар төлнө. Нийгмийн даатгалын шимтгэлийг ажилчдынх нь тооноос хамаарч төлүүлж болно. Татварын давуу тал байгаа бол

¹⁸³ Доор тайлбарласан Хятадын Цахим худалдааны тухай хуулийн хамрах хүрээг 188 дахь тайлбарт хавсаргасан тексттэй харьцуулж болно.

бизнесийн зохион байгуулалтаас нь болж эдлүүлэх биш харин борлуулалтын хэмжээтэй нь холбох.

2. Зарим төрлийн онлайн ажиллагаанд онцгой хандлагаар хандах: төрөл бүрийн цахим бизнест өөр өөрөөр хандах ёстой. Тэд нийгэмд өөр өөр нөлөө үзүүлдэг бөгөөд түүнийг хүлээн зөвшөөрч, урамшуулж, эсвэл бууруулж болно. Тэгвэл хэрхэн ялгах вэ? Бизнес эрхлэх зөвшөөрөл болон бүртгэлтэй эсэх, эсвэл шуудангийн тээвэрлэлтийн эрхтэй эсэхээр нь үү? Ямар нэгэн хэлбэр нь төрийн бодлогыг эрсдэлд учруулж байна уу: хэрэглэгчдэд, улсын ашиг сонирхолд, засгийн газрын хөтөлбөрүүдэд зэрэг, иймээс илүү чанга зохицуулалт хэрэгтэй юу? Эдгээр хэмжүүрээс болж тухайн үйл ажиллагааг урамшуулах, бууруулах үндэслэлтэй шалтгаан байж болно. Худалдааны платформ ашиглаж буй эсэхээр нь ялгах сайн арга биш. Аж ахуйн хэлбэрт орсон, зохион байгуулалттай эсэх нь бизнесийн “том, чухал”-ыг илэрхийлэх сайн үзүүлэлт байж болох юм. Зохих бүтэцтэй бизнес нь борлуулалтын тооноос гадна эдийн засгийн олон үр нөлөөтэй байж болно, жишээлбэл, ажлын байр, холбоотой эдийн засгийн үйл ажиллагаа, бизнестээ зарцуулсан зардал зэрэг.

Цахим худалдааны бизнесүүдийг тэдний гүйцэтгэх үүргээр нь ялгаж болно: үйлдвэрлэдэг, бөөний буюу жижиглэнгийн худалдаа эрхэлдэг, зуучлагч зэрэг. Цахим харилцаанд зуучлагч шаардлагатай, гэхдээ тэд юу хийж болох, юуг болохгүй вэ? Загвар хуульд итгэлцлийн үйлчилгээ үзүүлэхээс бусад төрлийн харилцаа холбооны зуучлагчдад бага үүрэгтэй байхаар заасан. Ийм зуучлагчид бусдын өмнөөс харилцаж байгаа зүйлийнхээ төлөө тодорхой хамгаалалттай байдаг (хариуцлагын талаар энэ тайлангийн доорх хэсэгт авч үзнэ.)

1. Олон улсын туршлагаас

Цахим худалдааны бизнесийг өөр орнуудад хэрхэн зохицуулдаг талаар авч үзэх нь сонирхолтой байж болох юм.

а. Цахим худалдааны бизнес

Ихэнх улс орнууд эдийн засгийн үндсэн нэгжийг ялгадаггүй, жишээлбэл, корпорац гэсэн нэгж нь цахим худалдаанд хамааралтай эсэх нь хамаагүй. ААН-ийн бүртгэлийн хуулиуд нь ямар ч төрлийн бизнесийн ажиллагаагаа явуулахын тулд бүртгүүлсэн байх шаардлага тавьдаг.

Жишээлбэл, Эстони улс зарим бизнесийг цахим худалдааны байгууллагаар бус, энгийн бизнес эрхлэгчээр бүртгүүлэхийг шаарддаг¹⁸⁴. Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын тогтолцоонд бүртгүүлэхдээ цахим худалдааны зарим бизнест зориулсан тусгай дүрэм журам байдаг ч тэдгээрийг ЕХ-ны түвшинд тогтоодог¹⁸⁵.

¹⁸⁴ Эстони улсад цахим худалдааны нэгжийг байгуулах нь, https://blog.incorporate.ee/e-commerce-business-in-estonia/#establishing_an_e-commerce_business_in_estonia. Мөн Бүгд Найрамдах Эстони Улс, Эстонийн татвар, гаалийн зөвлөл, Хувиараа бизнес эрхлэгчдэд зориулсан цахим хуудаснаас үзнэ үү: <https://www.emta.ee/en/business-client/registration-business/businesses/sole-proprietors>

¹⁸⁵ Эстонийн Татвар, гаалийн зөвлөл, цахим худалдаа, үйлчилгээний тусгай схем, онлайн: <https://www.emta.ee/en/business-client/taxes-and-payment/value-added-tax/special-schemes-e-commerce-and-services>

Төв Азийн улсууд (Казахстан, Киргизстан, Тажикстан, Туркменистан, Узбекистан) бизнес эрхлэгчдийг цахим худалдааны бизнес гэж бүртгүүлэхийг шаарддаггүй, аж ахуйн нэгжээ байгуулсны дараа цахим хэлбэрээр арилжаа хийх боломжтой¹⁸⁶.

АНУ-ын загвараар бол өрөнхий хэрэглээний хууль тогтоомжийн дагуу бизнесийг бүртгүүлсний дараа үйл ажиллагаа нь тодорхой эрсдэлийн эсрэг чиглэсэн хуулиудад захирагдаж болно, хувийн нууцлал, компьютерын аюулгүй байдал, цахим харилцааны дүрэм гэх мэт.

2020 онд АПЕК-ийн орнуудын журам, бодлогын өрөнхий судалгаа нь цахим худалдаанд буй янз бүрийн хөшүүргийг харуулсан гэхдээ тухайн бизнесийн мөн чанараас шалтгаалсан эсвэл өрөнхий үйл ажиллагааны ямар нэгэн тодорхой саад бэрхшээлийг дурдаагүй¹⁸⁷.

Цахим худалдааг идэвхтэй хянадаг Хятад улсад ч гэсэн "цахим худалдааны оператор" гэх байгууллагууд нь аливаа бизнест хамаарах "нийтлэг хууль тогтоомжийн дагуу зах зээлийн бүртгэлд хамрагдах ёстой" гэсэн байдаг¹⁸⁸. Ийм операторууд нь аливаа хэлбэрийн бизнесийн зохион байгуулалттай байж болно.

"Цахим худалдааны операторууд" гэж интернет болон бусад мэдээллийн сүлжээгээр дамжуулан бараа борлуулах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээд биш нэгжийг хэлнэ, үүнд цахим худалдааны платформын оператор, платформ дээр ажилладаг этгээд, цахим худалдааны оператор, эсвэл өөрсдийн цахим хуудас буюу бусад веб үйлчилгээгээр дамжуулан үйлчилгээ үзүүлэгч орно¹⁸⁹ [онцлон нэмсэн].

Энэхүү хуулийн дагуу маш жижиг бизнес эрхлэгчдийг бүртгэлээс чөлөөлдөг, эдгээр нь "хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл шаардлагагүй, ур чадвараа ашиглан хувийн энгийн гар урлал, хөлсөөр хөдөлмөрлөх үйлчилгээ, жижиг гүйлгээний ажил, эсхүл үйлдвэрлэл, худалдааны бүртгэлд хамрахгүй" этгээдийг хэлнэ¹⁹⁰. Гэхдээ мэдээж ийм жижиг этгээд нь нийтлэг журмаар татвар төлөх шаардлагатай хэвээр. Уг хуулийн 4 дүгээр зүйлд "Төрөөс цахим болон бодитоор хэрэгждэг арилжаанд тэгш эрх олгож, цогц хөгжлийг нь дэмжинэ" гэсэн өрөнхий зарчим бий.

Цахим худалдааны бизнест анхаарлаа хандуулж буй өөр нэг орны жишээ бол Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс юм, доорх харилцааг зохицуулсан тогтоол¹⁹¹ гаргасан байдаг. Энэхүү хуулиар цахим худалдаа нь дараах гурван хэлбэртэй байна.

- Худалдагч нь өөрийн цахим худалдааны сувгаар арилжаа хийх [жишээ нь. өөрийн цахим хуудсаар];

¹⁸⁶ Азийн хөгжлийн банк, CAREC орнуудын цахим худалдаа: хууль тогтоомж, бодлого, 2021 оны 8-р сар, <https://www.adb.org/publications/e-commerce-carec-laws-policies>. Энэхүү тайлангийн олон улсын зөвлөх нь уг нийтлэлийн гол зохиогч юм.

¹⁸⁷ АПЕК-ийн Цахим худалдааны удирдах ажлын хэсэг, Бүс нутаг дахь АПЕК-ийн БЖДҮ-ийн оролцоотой цахим худалдаа, тоон эдийн засгийн журам, бодлого, санаачилга, <https://www.apec.org/docs/default-source/Publications/2020/3/Regulations-Policies-and-Initiatives-on-E-Commerce-and-Digital-Economy/>

220ECSGRegulations-Policies-and-Initiatives-on-ECommerce-and-Digital-Economy-for-APEC-MSMEs-Particip.pdf.

¹⁸⁸ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Цахим худалдааны тухай хууль, 2018 он, 10-р зүйл, https://ipkey.eu/sites/default/files/documents/resources/PRC_E-Commerce_Law.pdf

¹⁸⁹ Дээрх 188 дахь тайлбар, 9-р зүйл

¹⁹⁰ Дээрх 188 дахь тайлбар, 10-р зүйл

¹⁹¹ Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын "Цахим худалдааны тухай" тогтоол, №. 296/GOV, 2021 он, 6 – 17-р зүйл

- Цахим зах зээлд худалдаа хийх [жишээ нь. худалдааны платформоор дамжуулан];
- Цахим зах зээлд худалдаа хийх боломж олгох [i.e. худалдааны платформ нь].

Цахим худалдааны үйл ажиллагааны төрөл бүр нь бизнес эрхлэх зөвшөөрөлтэй байх ёстой, үүний тулд бүртгүүлж, төрийн холбогдох байгууллагуудыг зохих мэдээллээр хангана. Уг тогтоолд төрөл тус бүрийн цахим худалдааны бизнес эрхлэгчдийн үргийг тодорхойлжээ, жишээ нь веб сайтад заавал тавих мэдээлэл, цаашлаад тэдгээрийн байгуулах цахим худалдааны гэрээний онцлогийг мөн заасан байна¹⁹².

б. Цахим худалдааны бизнесийг зохицуулах

Цахим худалдааны нэгжийг нийтлэг хууль тогтоомжийн дагуу байгуулж бүртгэдэгтэй адил бодитоор ажилладаг нэгжүүдийг удирддаг төрийн эрх бүхий байгууллагууд нь цахим нэгжүүдийг зохицуулдаг. Зөвхөн цахим худалдааг зохицуулах үүрэгтэй тусгай агентлагтай улс орон тун ховор. Гэхдээ ингэж бичсэн нь хоёр шалгуртай:

- эдийн засгийн нэгэн салбарын ААН-үүдийг ерөнхийд нь зохицуулдаг агентлаг нь эсвэл салбарын бизнесүүд нь цахим худалдааны үйл ажиллагааны тусгай дүрэм, эсвэл бүр хуультай байж болно. Мөн тухайн агентлаг нь энэ салбарын цахим харилцаа холбооны үр нөлөөний талаар тусгай мэдлэг хуримтлуулсан байж болно. Ер нь бол зөвхөн цахим операторуудыг хянадаг байгууллагыг салгаж бий болгосноос салбарын нэгдсэн эрх бүхий байгууллага байх нь захиргааны болон бодлогын олон талын ач холбогдолтой.
- Цахим худалдаанд тулгардаг бэрхшээлүүдийн заримыг тусгай зохицуулагчдад шилжүүлж болдог. Жишээлбэл, хувийн нууцлал, хэрэглэгчийн эрхийг хамгаалах зэрэг хэм хэмжээний хэрэгжилтийг зохицуулж хянадаг мэргэжлийн этгээд. Гэхдээ ийм байгууллага буюу мэргэжилтнүүд нь голцуу бодитоор хэрэгжиж буй ажлыг хангах, хянах чиглэлээр мэргэшсэн байдаг юм. Жишээ нь, хувийн мэдээлэлд цахим орчинд аюул занал учруулсныг хянадаг комисс байдаггүй мөртлөө бодит амьдрал дээр хүний эрхийг хангадаг комисс байдаг¹⁹³. Хэрэглэгчдийг хамгаалах агентлаг нь цахим хэлбэрээр, биечлэн, эсвэл шуудангаар бизнес эрхэлж байгаа эсэхээс үл хамааран хамгаалдаг. Өөр нэг жишээ гэхэд цагдаа нь арилжааны луйврыг цахим орчинд ч, цаасан дээрхийг ч, бодит амьдрал дээрхийг ч шалгана. Дахин хэлэхэд, салбарын агентлаг дотор цахим гэмт хэрэг үйлдэх аргаар мэргэшсэн мэргэжилтнүүд байж болно¹⁹⁴.

Ер нь цахим худалдааны бараа, үйлчилгээ нь уламжлалт худалдааныхтай ижил. Тиймээс тэдний зохицуулалтыг ижил эрх мэдэлтэй төрийн байгууллагад даатгаж болно. Зарим онцгой бараа байхад (текст, хөгжим, видео гэх мэт тоон бүтээгдэхүүн) түүнийг дэмжих арга

¹⁹² Тухайн тогтоол болон түүний үр нөлөөний тайлбарыг VDB/Loi, "БНАЛАУ-ын цахим худалдааны шинэ тогтоол – юг анхаарах вэ?", 2021 оны 10-р сарын 29, https://www.vdb-loi.com/laos_publication /lao-pdrs-new-e-commerce-decree-what-to-out-out-it/. Мөн Tilleke & Gibbins, "Лаос цахим худалдааны зохицуулалтаа шинэчилжээ", 2021 оны 7-р сарын 26, онлайн: <https://www.tilleke.com/insights/laos-issues-e-commerce-regulations/>.

¹⁹³ Жишээлбэл, АНУ-ын Холбооны худалдааны комисс (Federal Trade Commission) нь улсын хэмжээнд шударга худалдааг хангах үүрэгтэй. Тус байгууллага нь хэрэгжүүлэх үзэл баримтлалыг боловсруулсан бөгөөд энэ нь цахим болон бодит орчны аль алинд нууцлалыг хангах бодлогын өргөн шаардлагыг агуулжээ.

¹⁹⁴ Жишээлбэл, зарим компьютерын гэмт хэрэг нь үндэсний аюулгүй байдлын асуудал үүсгэсэн бол албаны нууцтай холбоотой асуудлаарх агентлагт асуудлыг шилжүүлэх нь зөв гэж үздэг.

нь арай өөр байж болно. Харин зохицуулалтын зарчим нь ялгаагүй. Тиймээс зохицуулагч нь өөр байх албагүй.

в. "Хамгийн сүүлийн үеийн ололт"

Зарим улс орнууд цахим эдийн засгаа илүү "амжилттай сайн" хөгжүүлсэн гэж үздэг. Эдгээр орнууд цахим хөгжил дэвшлийн олон улсын үнэлгээгээр тогтмол өндөрт эрэмбэлэгдэж байна. Тэднээс Монгол нь жишээ, сургамж авч болох уу?

Энэхүү тайланд Австрали, Шинэ Зеланд, Тайланд, Гүржийн туршлагыг товч тоймлон харуулах болно¹⁹⁵.

Эдгээр орнуудад цахим худалдааг хөгжүүлсэн гол "амжилт" нь хууль зүйн орчныг бүрдүүлэхээс илүүтэй энэ салбарын бодлогыг цогцоор нь хэрэгжүүлснээс үүдэлтэй гэж дүгнэж болно. Эдгээр орнуудад чөлөөт худалдааны гэрээ байгуулж хэрэгжүүлэх, цахим технологийг ашиглах замаар арилжааны саад бэрхшээлийг арилгахыг зорьж байна. Хууль нь цахим гүйлгээнд ашиглах технологийг талууд өөрсдөө сонгох боломжтой буюу нэлээд уян хатан байдаг аж.

Энэ тайлангийн гол сэдэв бол Монголын хууль байх тул цаашид жишээ болгож судлах чиглэл өгөхүйц зарим орны тодорхой баримтыг л дурдах болно.

Шинэ Зеландын Засгийн газрын цахим хуудаст тавьсан "NZ Trade Policy" нэртэй худалдааны бодлогын баримт бичигт чөлөөт худалдааг хүчтэй дэмжинэ гэж тодорхойлжээ¹⁹⁶. Шинэ Зеланд бол чөлөөт худалдааг болон түүнийг дэмждэг бүс нутгийн ба олон улсын байгууллагуудыг хүчтэй дэмжигч орон юм. Энэ нь хэд хэдэн үндсэн шалтгаантай:

- "Худалдаа бол Шинэ Зеландын эдийн засагт нэн чухал ач холбогдолтой.
- Нээлттэй зах зээлийг дэмжих нь эдийн засгийн мөн чанарын логик хариу үйлдэл юм.
- Чөлөөт худалдаа нь зөвхөн тус улсын экспортлогчдод ашигтай юм биш. Тус улсын нээлттэй эдийн засаг нь Шинэ Зеландын импортлогчид болон хэрэглэгчид илүү өргөн хүрээтэй, илүү өрсөлдөхүйц үнэтэй бараа, үйлчилгээг хүртэх боломжтой гэсэн үг юм.
- Бусад улс орнууд ч худалдаагаа нэмэгдүүлэхийг эрмэлзэж байна ... дэлхийн өрсөлдөгчид өөр хоорондоо худалдаа болон гэрээ хэлэлцээрийн шинэ сүлжээг бий болгохын хэрээр Шинэ Зеланд ч мөн чөлөөт худалдааны шинэ түншүүдийг олох хэрэгтэй юм, тэгэхгүй бол манай экспортлогчдод ашиггүй нөхцөл үүсэх эрсдэлтэй" гэжээ.

Австрали улс ч ижил төстэй чиг хандлагатай. 1999 онд UNCITRAL-ийн Цахим худалдааны тухай загвар хуулийг хэрэгжүүлсэн анхны орнуудын нэг бол Австрали юм, мөн Австралийн олон муж улсууд нь НҮБ-ын Цахим харилцааны тухай конвенцыг дотоодын хууль болгон ашиглаж байна.

¹⁹⁵ Эдгээр орнуудын жишээг 2022 оны 12-р сарын 16-ны өдөр Улаанбаатарт болсон АХБ-ны цахим "Монголд үр дүнтэй цахим худалдаа эрхлэхэд учирч буй өрх зүйн болон зохицуулалтын саад тогторуудын талаарх хэлэлцүүлэг"-ийн үеэр оролцогчид дурдсан.

¹⁹⁶ NZ Trade Policy, undated, online: <https://www.mfat.govt.nz/en/trade/nz-trade-policy/>. A deeper review of the issues and a report on extensive public consultations is on the Trade for All page: <https://www.mfat.govt.nz/en/trade/nz-trade-policy/trade-for-all-agenda/>.

Австрали нь цахим худалдааны стратегийн бичиг баримттай¹⁹⁷, бас цахим худалдаа, цахим эдийн засгийг илүү өргөн хүрээнд судалдаг¹⁹⁸ юм.

“... Худалдаанд цахимаар оролцоход хилийн цаана саад бэрхшээлтэй, эсвэл хэрэглэгчид болон бизнес эрхлэгчдийг цахим худалдаанд оролцоход үндэслэлгүйгээр саад хийдэг бол цахим худалдааны ашиг тусыг хүртэх, хуваалцах боломжгүй юм” гэж үздэг. Австралийн цахим худалдааг хөгжүүлэх чиглэл нь худалдааг хөнгөвчлөх, итгэлцэх, харилцан тооцоолох хэрэгслийн байршил, хил дамнасан мэдээллийн урсгал, хамтын ажиллагаа зэрэг юм. Түүнчлэн Австрали улс нь хувийн нууцлал, хэрэглэгчийн эрх, мэдээллийг хамгаалах зэрэг төрийн бодлогын хууль ёсны зорилтуудыг баталгаажуулсан хэм хэмжээг дэмждэг.

Тайланд мөн эдийн засаг, хууль эрх зүйн тогтолцоогоо цахим худалдаанд илүүтэй тохируулахаар ажиллаж байна. Худалдааны баримт бичгийн бүртгэл (“Trade Document Registry”) нэртэй дотоодын нэг цонхны тогтолцоог саяхан нэвтрүүлж¹⁹⁹, Япон, Сингапуртай хамтран блокчэйн технологид сууринласан Үндэсний цахим худалдааны платформ (“National Digital Trade Platform”)-ыг бий болгоод байна²⁰⁰.

Гүрж улс бизнесийн гүйлгээний маш уян хатан хуультай бол албан ёсны харилцаа холбоо нь Европын Холбооноос гаргасан дүрэм журмын дагуу хэрэгждэг²⁰¹. Хамгийн ирээдүйтэй гэх өөрийн орны зах зээлийг нээлттэй байлагах үүднээс Европын холбоотой “Чөлөөт худалдааны гүнзгий, иж бүрэн хэлэлцээр”-ийг²⁰² бас байгуулсан юм.

Эдийн засгийг дэмжих нээлттэй, шинэлэг эрх зүйн тогтолцоог бүрдүүлж амжилттай хэрэгжүүлж байгааг эдгээр улс орнуудын туршлага нь нотлохоос гадна манай энэ тайлангийн гол чиг хандлагыг мөн бататгаж байна.

2. Худалдааны платформ

Цахим худалдаа эрхэлдэг олон хүмүүс худалдаагаа хийхийн тулд тусгай төрлийн зуучлагч буюу худалдааны платформоор дамжуулдаг болохыг бид дээр дурдсан. Ийм платформын болон тэдгээрийн хэрэглэгч (худалдан авагчид, худалдагч нар)-ийн хоорондын харилцааг хуульчлах нь зүйтэй болов уу, ингэхдээ үйл ажиллагаагаа шударга, үр дүнтэй явуулах, олон нийтийн ашиг сонирхлыг харгалзах талаар тусгана, үүнд шударга өрсөлдөөн, оюуны өмчтэй холбоотой дүрэм, цаашлаад татварын зарим асуудал хамаарах магадлалтай.

¹⁹⁷ Australia, Digital trade Strategy, undated (Австрали улсын Цахим худалдааны стратеги): <https://www.dfat.gov.au/trade/services-and-digital-trade/e-commerce-and-digital-trade/digital-trade-strategy>.

¹⁹⁸ Australia, Digital Trade and the digital economy, undated (Австрали, Цахим худалдаа ба Цахим эдийн засаг): <https://www.dfat.gov.au/trade/services-and-digital-trade/e-commerce-and-digital-trade>

¹⁹⁹ United States International Trade Administration, “Thailand – Country Commercial Guide”, 2022 (АНУ-ын Олон улсын худалдааны газар, “Тайланд улс – Улс орны худалдааны хөтөч”, 2022): <https://www.trade.gov/country-commercial-guides/thailand-e-commerce>. Тайландын хууль зүйн тогтолцооны онцлогийн талаар Олон улсын харьцуулсан эрх зүйн тайлбар (ICLG)-ын цахим хуудаснаас үзэх боломжтой: <https://iclg.com/practice-areas/digital-business-laws-and-regulations/thailand>.

²⁰⁰ <https://www.ledgerinsights.com/blockchain-thailand-trade-tradewaltz-singapore-ntp/>. Албан ёсны мэдэгдэл энэ холбоосоор байна: <https://thaiembdc.org/2022/08/25/thailand-prepares-to-launch-national-digital-trade-platform/>

²⁰¹ United States International Trade Administration, “Georgia – Country Commercial Guide”, 2022, (АНУ-ын Олон улсын худалдааны газар, “Гүрж улс – Улс орны худалдааны хөтөч”, 2022): <https://www.trade.gov/country-commercial-guides/georgia-e-commerce>

²⁰² European Commission, “EU-Georgia deep and Comprehensive Free Trade Area” (Европын холбооны комисс, “EX-Гуржийн гүн, иж бүрэн чөлөөт худалдааны бүс): <https://trade.ec.europa.eu/access-to-markets/en/content/eu-georgia-deep-and-comprehensive-free-trade-area>

Shoppy.mn сайт ямар нөхцөл байдалд ажиллаж буй тухай бид өмнөх хэлэлцсэн. Хэрэглэгчийн болон хувь хүний нууцыг хамгаалахын тулд хууль нь шаардлага эсвэл тодорхой хязгаарлалт тавьж болно. Монголын бусад арилжааны платформууд ч мөн энэ дүрэмд захирагдана. Монголд оффис, хөрөнгөгүй бол гадаадын платформд тохирох дүрмийг энд хэрэгжүүлэх нь хэцүү байж магадгүй. Үүнийг цаашид судлах шаардлагатай. Нөгөөтээгүүр, хэрэв тухайн худалдааны сайтууд нь тухайн улс дахь үйл ажиллагаанаасаа ашиг тус олох, тухайн орны давуу талыг ашиглах (татварын тусгай зохицуулалт, хариуцлагаас чөлөөлөх талаарх хэм хэмжээ зэрэг)-ыг хүсэж байгаа бол тухайн орны шаардлагуудыг дагаж мөрдөх ёстой. Гадаад худалдааны платформыг зохицуулах талаарх өмнөх туршлага мэдээж бий. Вьетнамд ийм харилцааг зохицуулсан нарийвчилсан заалтуудтай, Япон²⁰³, Хятад²⁰⁴ зэрэг орнуудад ч бас бий²⁰⁵.

Жишээ болгож Вьетнамд 2022 оны 1-р сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон 85-р тогтоолд заасан шинэ дүрмийн тайлбарыг дор оруулав²⁰⁶.

²⁰³ Япон улс, Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам, Цахим платформуудын тухай тайлбар https://www.meti.go.jp/english/policy/mono_info_service/information_economy/digital_platforms/index.html

²⁰⁴ Брукингсийн хүрээлэн, "Хятадын цахим платформын талаарх шинэ журам", 2021 оны 9-р сарын 14-ний өдөр.

<https://www.brookings.edu/blog/techtank/2021/09/14/chinas-new-regulation-of-platforms-a-message-for-american-policymakers/>

²⁰⁵ Baker & McKenzie, "Вьетнам: Цахим гүйлгээний тухай хуулийн шинэ төсөл, дижитал платформыг чиглүүлэх," 2022 оны 5-р сарын 4-ний өдөр <https://www.connectontech.com/vietnam-new-draft-law-on-e-transactions-targeting-digital-platforms/>

²⁰⁶ ACSV Legal, Вьетнам: Цахим худалдааны үйл ажиллагааны шинэ ерөнхий болон импорт-экспортын дүрэм, 2022 оны 1-р сарын 28, <https://www.mondaq.com/international-trade-investment/1155266/new-general-and-importexport-rules-for-e-commerce-activities>

3. Цахим худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаадын аж ахуйн нэгжүүд

3.1 Ерөнхий

85-р тогтоол нь одоо ажиллаж буй цахим худалдаа эрхлэгч бүх гадаадын худалдагч, байгууллагуудад хамаарч байна. Тэдгээрийг гурван бүлэгт хуваажээ:

1. Вьетнамд цахим худалдааны үйлчилгээний цахим хуудастай гадаадын худалдагч эсвэл байгууллага;
2. Вьетнамын цахим худалдааны платформ дээр бараа борлуулдаг гадаадын худалдагч эсвэл байгууллага;
3. Цахим худалдааны салбарт хөрөнгө оруулсан гадаадын этгээд.

3.2 Гадаадын аж ахуйн нэгжид тавих тусгай шаардлага

“А” бүлэгт:

85-р тогтоолын дагуу гадаадын аж ахуйн нэгжүүд гэдэгт доорх этгээдийн аль нэг нь байна:

- Вьетнамын домэйн нэртэй (жишээ нь .vn);
- сайт дээр нь вьетнам хэлийг ашиглах боломжтой;
- жилд Вьетнам улсаас гаралтай 100,000 гаруй гүйлгээтэй.

Эдгээрийг Вьетнам дахь цахим худалдааны үйлчилгээний цахим хуудастай гадаадын худалдагч, гадаадын байгууллага гэж үзнэ. Үүний дагуу тэд холбогдох хууль тогтоомжид зааснаар “цахим худалдааны аж ахуйн нэгж” гэж бүртгүүлэх ёстой, мөн:

- Вьетнамд төлөөлөгчийн газраа байгуулах; эсвэл
- Вьетнамын хууль тогтоомжийн дагуу тус улсад итгэмжлэгдсэн төлөөлөгчөө томилох үүрэгтэй.

“Б” бүлэгт:

Вьетнамын цахим худалдааны платформ дээр бүтээгдэхүүнээ борлуулдаг гадаадын худалдаач, байгууллагууд нь шинэ журмын дагуу “үйлчлүүлэгчээ мэдэх журам”-д хамааралтай болсон. Ийм журмыг дотоодын цахим худалдааны платформын үйлчилгээ үзүүлэгчид өөрсдөө хэрэгжүүлдэг.

“В” бүлэгт:

Энэхүү 85-р тогтооюор Вьетнамын цахим худалдааны салбарт гадаадын хөрөнгө оруулалтад нэмэлт нөхцөл тавсан. Жишээлбэл, гадаадын хөрөнгө оруулагчид 2020 оны Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан зах зээлд нэвтрэхтэй холбоотой шаардлагыг дагаж мөрдөхөөс гадна уг 85 дугаар тогтоолд заасан зах зээлд нэвтрэх тодорхой шалгуур, нөхцөлийг биелүүлэх үүрэгтэй.

Тус улсад арилжааны платформуудыг илүү нарийвчлан хянадаг хууль тогтоомжийг 2002 онд баталж, “том платформ”-д тусгай үүрэг хүлээлгэжээ (Baker McKenzie)

Худалдааны платформын тухай хуулийн Азийн нэг жишээ бол Бүгд Найрамдах Киргиз Улсын Цахим худалдааны тухай хууль²⁰⁷ юм. Энд “худалдааны платформ” гэж “Интернэтээр дамжуулан бараа, ажил, үйлчилгээг борлуулах боломжийг олгодог программ хангамж, техник хангамжийн цогц” гэж тодорхойлсон. Худалдааны платформ нь интернет ашигтай ажиллах чадвар, төхөөрөмж байхгүй худалдагчдад бараа бүтээгдэхүүнээ зах зээлд гаргах гарцыг бий болгодог.

²⁰⁷ 2021 оны Киргизийн хууль, <https://cis-legislation.com/document.fwx?rgn=136937>

Энэ хуульд заасан арилжааны платформыг ажиллуулж байгаа этгээдийн үүрэг нь худалдагчийн бараа, үйлчилгээг бэлэн байлагх; худалдагч болон платформын операторын ашиг сонирхлыг салангид нь байлагх; хэрэглэгчдийн өмнө “бараа, үйлчилгээний чанарыг хангах”; “хувийн болон арилжааны шинж чанартай хэрэглэгчийн ашиг сонирхол, мэдээллийг хамгаалах” бодлогыг хэрэгжүүлэх; үнэ, борлуулалт болон бусад шалгуураар эрэмбэлсэн маягаар бараа, үйлчилгээг платформоос хайх боломжийг олгох; цахим гүйлгээнд оролцогчдод эрх, ашиг сонирхлоо хамгаалахад нь туслах.

Киргизийн хууль нь хилийн чанадад ажилладаг боловч дотор нь Киргизээс нэвтрэх боломжтой платформ болон Киргизийн нутаг дэвсгэрт ажиллаж буй платформыг ялгадаггүй, ижил үүрэг ногдуулсан. Зарим улсууд худалдааны платформыг зохицуулахаа Киргизээс хамаагүй илүү дэглэмтэй. Вьетнамын хуулийг дээр дурдсан. Энэ хуулиар олон төрлийн платформуудад өөр өөр дүрэм журамтай, мөн гадаадын болон дотоодын платформуудад аль алинд шууд хамаатай.

Хятадын хууль бүр илүү зохицуулалттай. 2018 оны Цахим худалдааны тухай хууль²⁰⁸ нь худалдааны платформтой холбоотой 20 зүйлтэй бөгөөд харилцааны хэд хэдэн дүрмийг тогтоож, оператор нь зөрчил гаргасан тохиолдолд иргэний болон захиргааны шийтгэл ногдуулахаар заажээ. Энэ хуулийг шүүмжлэгчид хэрэглэгч, худалдагчдад туслахаас илүүтэйгээр хэрэглэгчдийн мэдээлэл цуглуулах зорилготой, хяналттай гэдэг. Үнэндээ ч энэ хууль нь энгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах гэхээсээ илүү монополь байр суурийг урвуулан ашиглахыг хянахад чиглэгдсэн гэлтэй. Энэ хууль БНХАУ-ын зах зээл дээр ажиллаж байгаа дотоодын болон гадаадад байрладаг платформуудад ижил үйлчилнэ²⁰⁹

Гэхдээ хамгийн өргөн хүрээтэй эдийн засаг, эрх зүйн нөлөө бүхий платформуудын зохицуулалт нь Европын холбооны сүүлийн үеийн эрх зүйд тусгасан байдаг. Тоон зах зээлийн тухай хууль²¹⁰ болон Тоон үйлчилгээний тухай хууль²¹¹ нь платформын үйл ажиллагааг онцгой зохицуулжээ. Товч хураангуй нь²¹²:

[Нэг тоон зах зээл]²¹³-д хамаарах стратегид багтсан хуулиудын дотроос Тоон үйлчилгээний тухай хууль (DSA) болон Тоон зах зээлийн тухай хууль (DMA) нь нийлээд үйлчилгээний багцыг бий болгож, цахим худалдаанд онцгой үүрэгтэй. DSA нь онлайн зах зээл, сошиал орчинд ажиллаж буй платформ, APP дэлгүүр, захиалгын цахим хуудас зэрэг онлайн зуучлагчдад шинэ үүрэг хариуцлага ногдуулсан бол DMA нь томоохон онлайн платформуудад зориулсан шинэ дүрмийг нэвтрүүлсэн, ийм газруудыг уг хуульд “хаалгач” (gatekeepers) гэж нэрлэсэн. Эдгээр журмууд нь ил тод байдлыг хангах, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, тодорхой

²⁰⁸ БНХАУ, Цахим худалдааны хууль (2018), 188-р тайлбар.

²⁰⁹ Платформын журмын талаар Хятадын талыг баримталж бичсэн тоймыг Вэн Шэнг (Wen Sheng)-ийн “Хятад улс платформын эдийн засгийн зохицуулалтыг сайжруулж, сулруулахгүй” гэж Global Times, 2021 оны 8-р сарын 8-ны өдрийн цахим нийтлэл хэвлэснийг энэ хуудаснаас үзнэ үү www.globaltimes.cn/page/202108/1230851.shtml?id=11.

²¹⁰ Тоон зах зээлийн тухай хуулийн талаар ЕХ-ны хэвлэлийн мэдээ, 2022, https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip_22_1978

²¹¹ Тоон үйлчилгээний тухай хуулийн талаар ЕХ-ны хэвлэлийн мэдээ, 2022, https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip_22_2545

²¹² Digwatch, Цахим худалдаа арилжаа: <https://dig.watch/topics/e-commerce-and-trade>

²¹³ ЕХ-ны цахим зах зээлийн стратеги, Википедиа дахь тайлбар: https://en.wikipedia.org/wiki/Digital_Single_Market

хариуцлага хүлээх, ийнхүү хүлээлгэх дүрэм зэргийг тогтоож зах зээл дэх өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилготой юм.

ДХБ зэрэг олон улсын байгууллагууд нь цахим худалдааны талаарх хамтарсан санаачилгаараа (Монгол Улс үүнд оролцдог) цахим бизнесийн сонголтод аль болох бага зэрэг хөндлөнгөөс оролцох, зохицуулалтыг хөнгөвчлөх хандлагатай байдаг²¹⁴. Улс орнуудын байнга шинэчлэгдэж, нэмэгдэж буй арилжааны платформын хууль тогтоомж үүнийг дагаж мөрдөхгүй байна.

Дээрхтэй харьцуулбал Киргизийн загвар нь нэлээдгүй энгийн юм. Гэхдээ илүү амбицтайгаар өргөн хүрээтэй зохицуулалт тогтоовол хэрэгжүүлэх нөөц, чармайлт ихийг шаардана гэдгийг санах хэрэгтэй. Монголд аль арга нь хамгийн сайн тохирохыг шийдэхийн өмнө худалдагч болон хэрэглэгчид платформуудын ашигласан туршлагыг судалж үзэх хэрэгтэй. Ингэснээр цахим худалдааны том гүрнүүдээс тогтоосон томоохон платформын ажиллах дэлхийн стандартыг авч, улмаар дотоодын нэгдсэн байр суурьт буюу загвар заалтуудыг Монголын нөхцөлд хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Цахим худалдааны бусад асуудлуудыг зохицуулах

Гүйлгээний үндсэн хүрээг хуулиар тогтоосны дараа дурдсан зохицуулалтыг илүү нарийнаар зааж болно. Цахим худалдааг дэмжихийн тулд Монголд анхаарах ёстой зохицуулалт, тогтолцооны шилдэг туршлагыг тайлбарлах болно, үүнд гурван үндсэн чиглэл (хэрэглэгчийн эрхийг хамгаалах; хувийн нууцлал; аюулгүй байдал) байдаг, мөн бусад харилцааны эрх зүйн асуудлыг авч үзэв. Монгол улс эдгээрээс олон чиглэлд мэдэгдэхүүц ахиц дэвшил гаргасан, гэхдээ зарим асуудлаар илүү ихийг хийх боломжтой байна. Хэрэгжүүлсэн болон цаашид хийх зүйлээ уялдуулж хэрэгжүүлбэл цахим хэрэгслээр бус нутгийн өсөлтийг хангахад нэмэртэй.

Эцэст нь хэлэхэд, зохицуулалтын арга хэмжээ нь төрөөс тэдгээрийг удирдаж, хэрэгжүүлэх чадвараас ихээхэн хамаарна.

- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар зааж болгох ч хэрэглэгчийн үйлчилгээний товчоо зэргийг ажиллуулж, хүмүүст хэрэгцээтэй тусламж үзүүлж чадах уу? Эрхийг нь зөрчсөн хохирогчийн хандах шүүхийн тогтолцоо эсвэл маргаан шийдвэрлэх өөр арга хэрэгсэл нь найдвартай юу?
- Олон зөвшөөрөл авах, хувийн мэдээллийг найдвартай хадгалах талаар өндөр стандарт хэвшүүлсэн хуулиудыг баталж болох ч хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгах байцаагчдыг ажиллуулах, сургах боломж хэр вэ? Байцаагчийн шаардлагыг холбогдох албан тушаалтнууд нь заавал дагаж мөрдхүүтэй юу?
- Компьютерт зөвшөөрөлгүй нэвтрэх, хортой програм тараах зэрэг цахим гэмт хэргийн эсрэг хатуу хуультай болох ч ийм үйлдлийг таслан зогсоох чадвартай юу? Улс орныг хамарсан “харанхуй сүлжээ” ажиллах, дэлхийн өнцөг бүрд кибер гэмт хэрэгтнүүдийг дагаж мөрдөх техникийн мэдлэгтэй юу?

²¹⁴

ДХБ, Цахим худалдааны хамтарсан санаачилга:
https://www.wto.org/english/tratop_e/econ_e/joint_statement_e.htm. Энэ санаачлагын хүрээнд боловсруулж буй зарим эх бичвэрийн төсөл нь зуучлагчийн хариуцлагыг хязгаарлах талаар илүүтэй зохицуулсан бол зарим нь цахим худалдааны талаар ерөнхий дүрмийг заасан байдаг. Мэтгэлзээний “ялагч”-ийг тодруулах үлдлээ.

B. Хэрэглэгчийг хамгаалах

Олон улсын шилдэг туршлага

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зарчмуудын сайн эх сурвалж бол 2015 онд хамгийн сүүлд шинэчлэгдсэн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах НҮБ-ын удирдамж юм²¹⁵.

Гишүүн орнууд нь дараах зүйлийг урамшуулах замаар хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодит бодлогыг бий болгох ёстой:

- Бизнесийн сайн туршлага
- Хэрэглэгчид холбогдоход ойлгомжтой, шуурхай мэдээлэл өгөх
- Борлуулж буй бараа, үйлчилгээний талаар тодорхой, цаг алдалгүй мэдээлэл өгөх
- Тодорхой, товч бөгөөд ойлгоход хялбар, шударга гэрээний нөхцөл
- Захиалгыг цуцлах, барааг буцаах, буцаан олгох ил тод үйл явц
- Төлбөрийн найдвартай механизм
- Маргааныг шударгаар хурдан шуурхай шийдвэрлэх
- Хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал
- Хэрэглэгчийн болон бизнесийн боловсрол
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагууд хангалттай чадавх, нөөцтэй байх
- Бараа нь зориулалтын болон хэрэглээнд аюулгүй байх
- Үйлдвэрлэл нь тогтвортой байх

Монголын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль нь 2003 онд анх батлагдсан, гэхдээ шинэчилсэн найруулгыг нь бэлдэх ажил ахисан шатандаа явж байна²¹⁶. Энд байгаа саналууд нь хорин жилийн өмнөх хуулийн төсөл гэхээсээ илүү шинэчилсэн найруулгыг хуулийн төсөлд анхаарлаа хандуулж байна.

Шинэ төсөл нь “бизнес эрхлэгч” буюу бараа, үйлчилгээ борлуулагч, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн эрх, үргийг нарийвчлан тодорхойлсон орчин үеийн хуулийн төсөл юм. Энэ нь бараа (болон үйлчилгээний) чанар, тэдгээрээс үүдэлтэй эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх аюул, хүргэлтийн хугацаа, төлбөрийн асуудал болон бусад асуудлыг зохицуулжээ.

Одоогийн хуульд ч, шинэ төсөлд ч үнийн зохицуулалт хийх, худалдагч үргээ биелүүлээгүй тохиолдолд тorgууль ногдуулах зэрэг олон арга замаар хэрэгжүүлэхээр тусгасан. Бизнес эрхлэгч болон хэрэглэгчийн өргөдөл гомдлыг эхлээд хэд хэдэн үе шат, аргаар хянан шийдвэрлэх маш нарийн тогтолцоотой, Хэрэглэгчийн мэдээлэл, үйлчилгээний төв гэсэн төрийн бус байгууллага, цаашлаад “хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага”-ас туслалцаа авч болно. Одоогийн байдлаар энэ байгууллага нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар юм. Мөн улсын байцаагчийн алба гэж бий.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах ажлыг олон нийтэд сурталчлах, эсвэл хууль хяналтын болон хэрэгжүүлэх ажиллагаагаар дамжуулна: арбитр, шүүхийн ажиллагаа байж болно, мөн хувийн гомдол нэхэмжлэл эсвэл хамт олных аль аль нь байж болно. Хувь хүнд энэ ажиллагаа нь үнэтэй байж болох тул хэрэглэгчдэд туслах хэд хэдэн байгууллага, эх сурвалжууд байдаг. Төрөөс шүүгчдэд цалин өгдөг харин маргааны талууд нь арбитрчдаа

²¹⁵ https://unctad.org/system/files/official-document/ditccplpmisc2016d1_en.pdf.

²¹⁶ Эх сурвалж: Монгол Улсын Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар

мөнгө өөрсдөө төлөх ёстой учраас хэрэглэгчдэд энэ нь шүүхийн ажиллагаанаас илүү зардалтай.

Нэмж дурдахад, залилан мэхлэх, хуурамчаар үйлдэх, төөрөгдүүлэхийг хоригlosон эрүүгийн хуулийн нийтлэг зүйл заалтууд нь аливаа худалдаа, хэрэглэгчид хамаарна.

Зар сурталчилгааны тухай хууль²¹⁷ нь хэрэглэгчдийг төөрөгдүүлэх, шударга бус сурталчилгаанаас хамгаална²¹⁸. Энэ хуульд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлтэй нэгэн адил цахим сурталчилгааны үеэр хэрэглэгчдэд өөрийн нэр, хаяг, холбоо барих утасны дугаарыг мэдээлэхийг шаардаж байна²¹⁹. Энэ хуулийн бусад заалтууд нь тодорхой ажиллагаа, ашиг сонирхлын хүрээнд хэрэглэгчдийг хамгаалах зорилготой нь тодорхой.

Энэ хуулиар эмнэлгийн хэрэгсэл зэрэг тодорхой төрлийн барааг сурталчлах, хүүхдүүдэд зэрэг тодорхой ангиллын үзэгчдэд сурталчлахыг хязгаарласан буюу хоригlosон байдаг²²⁰.

Эдгээр хориг, хязгаарлалтыг хэрхэн зөв хэрэгжүүлэх талаар шүүмжлэл гарч байсан. Өөрийн гэсэн онлайн орчинтой бөгөөд тогтчихсон бизнес эрхлэгчид тэдгээрт захирагдаж болох ч олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглэгчид ийм хориг, хязгаарлалтын талаар мэдэх үү, эсвэл хууль хяналтын байгууллагууд цахим орчны сурталчилгааг хянах боломжтой юм уу? Бодлого (олон улс оронд дүрэм нь яг л ижил) нь шударга бус сурталчилгаанд хариу арга хэмжээ авахад илүүтэй чиглэсэн болохоос сурталчилгааны хүрээг багасгах зорилго агуулаагүй²²¹.

Өрсөлдөөний тухай хууль²²² нь зах зээл дэх ноёрхлоо хууль бусаар ашиглах гэх мэт эргэлзээтэй арилжааны үйлдлээс хэрэглэгчдийг хамгаалдаг²²³. Мөн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь хуралдааны хэлбэрээр шийдвэрээ гаргаж хэрэглэгчдийг хамгаалах олон чиг үүргийг хэрэгжүүлдэг²²⁴.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд худалдагчдад хүлээсэн үүргүүдийн ихэнх нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах ердийн арга хэмжээ, тухайлбал:

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд худалдагчдад хүлээсэн үүргүүд нь өөр хаана ч байдаг хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийтлэг арга хэмжээтэй ижил, тухайлбал:

- Худалдагчийн хууль ёсны нэр, холбоо барих мэдээлэл, төлбөрийн журмыг онлайнаар ил мэдээлэх
- Хэрэглэгч бараа, үйлчилгээний талаарх мэдээлэл авах эрхийг хангах
- Тохиролцсон журмаар, тохирсон хугацаанд бараа хүргэх буюу үйлчилгээ үзүүлэх
- Цахим гүйлгээнд оролцогчдын хүсэлтээр гэрээ, гүйлгээний түүхийг гаргаж өгөх.

²¹⁷ Зар сурталчилгааны тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=259>

²¹⁸ Дээрхи 217 дахь тайлбар, 7-р зүйл.

²¹⁹ Дээрхи 217 дахь тайлбар, 12-р зүйл.

²²⁰ 217 дахь тайлбарыг харах, Зар сурталчилгааны тухай хууль, 16-р зүйл.

²²¹ 217 дахь тайлбарыг харах, Зар сурталчилгааны тухай хууль, 13-р зүйл.

²²² Өрсөлдөөний тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12>,

²²³ Дээрх 222-р тайлбар, 7-р зүйл.

²²⁴ Дээрхи 222-р тайлбар, 14-р, 16-р зүйл, бусад зүйл

Хуулийн төслийн нэг бүлэгт алсын зайн болон цахим бизнесийн үйл ажиллагааны талаар тусгажээ²²⁵. "Алсын" буюу "зайны" гэх заалтууд нь цахим гүйлгээнд хамаарна. Энэ бүлэгт хэрэглэгчдэд бизнесийн байршил, үзүүлж буй бараа, үйлчилгээний талаар бүрэн мэдээлэл өгөх үүргийг онцолжээ. "Цахим бизнесийн операторууд" нь гэрээнээс татгалзах эрх болон мэдээлэл олгох, гомдолтой буюу сэтгэл ханамжгүй байдлыг арилгах зэрэг нэмэлт үүрэгтэй. Гэрээнээс татгалзах эрх, түүнийг хэрэгжүүлэхийг нарийвчлан тодорхойлсон байна, гэхдээ энэ нь худалдагчийн хувьд шударга бус байх бол ийнхүү татгалзах нь хязгаарлалттай²²⁶. Хэрэв Монголын хуульд "худалдааны платформ"-ыг хуульчлах гэж байгаа бол "худалдааны платформын оператор"-ын үүрэгт "хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах" үүрэг нь нэгэн адил багтах ёстой²²⁷.

Жишээлбэл, Киргизийн хууль нь арилжааны платформ дээр гүйлгээ хийхдээ худалдан авагчид "худалдан авахаар санал болгож буй бараа ба үйлчилгээний талаар бүрэн бөгөөд найдвартай мэдээлэл авах", "Бүгд Найрамдах Киргиз улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн дагуу эрхээ хамгаалах" эрхийг олгосон байна²²⁸.

Энэхүү тайланд хувийн нууцтай холбоотой асуудлыг хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлаас тус тусад нь авч үзсэн ч дээрх хуулийн хувийн нууцын асуудлыг хамтатган оруулах боломжтой гэсэн санал байна. Доорх зураг дээр нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон бодлогын харилцан хамаарал, үр дагаврын талаар санааг тод харуулж байна²²⁹.



Хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаарх дүгнэлт

Монгол Улсын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл нь олон улсын туршлагад сайн нийцсэн. Төсөл нь хэрэглэгчдэд хуулиар олгосон эрхээ мэдэх, ухамсарлан эдлэх, бодитойгоор цаг алдалгүй хэрэгжүүлэх боломжтой байдлаар тусгажээ.

²²⁵ Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, 4-р бүлэг, 17 – 21-р зүйлүүд, мөн 216-р тайлбар.

²²⁶ Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, 20, 21-р зүйл, мөн 216-р тайлбар

²²⁷ Тухайлбал, Бүгд Найрамдах Киргиз Улсын Цахим худалдааны тухай хууль, 6(4)е) заалт, мөн 207-р тайлбар

²²⁸ Дээрхи 207 дахь эшлэл

²²⁹ Эх сурвалж: Монгол Улсын Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар

Г. Нууцлал (хувийн мэдээллийг хамгаалах)

Олон улсын шилдэг туршилага

Хувийн нууцлалын талаарх анхны удирдамжийг 1980 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) нийтэлсэн байдаг²³⁰. Олон улсад уг удирдамжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хуульчилж түүнд заасан дараах үндсэн зарчмууд дотооддоо нэвтрүүлсэн:

- (i) мэдээлэл цуглуулах нь хязгаартай (шаардагдахаас илүү мэдээлэл цуглуулах ёсгүй),
- (ii) өгөгдлийн чанар (мэдээлэл аль болох найдвартай байх ёстой),
- (iii) мэдээлэл цуглуулах зорилгын тодорхойлолт (мэдээлэл цуглуулах зорилго, ашиглалтын талаар мэдээлэл өгсөн хүнд ил болгох ёстой),
- (iv) мэдээлэл ашиглах нь хязгаартай (өгөгдлийг тодорхой бус зорилгоор ашиглах ёсгүй),
- (v) аюулгүй байдлыг хангах (өгөгдлийг найдвартай хадгалж, удирдах ёстой),
- (vi) нээлттэй байдал (мэдээлэл цуглуулагчийн үйл ажиллагаа, бодлого нь холбогдох талуудад ойлгомжтой байх),
- (vii) хувь этгээдийн оролцоо (мэдээллээ өгсөн, ашиглуулж байгаа этгээд нь ямар мэдээлэл хадгалагдаж байгааг мэдэж, шаардлагатай бол засаж залруулах эрхтэй байх)
- (viii) хариуцлага (мэдээлэл цуглуулагч эсвэл хэрэглэгч дээрх дүрмийг зөрчсөн тохиолдолд холбогдох хувь этгээд нь бодитой арга хэмжээ авах эрхтэй байх).

ЭЗХАХБ 2013 онд дээрх удирдамжийг шинэчлэн найруулж²³¹, анхны зарчмуудын ихэнхийг хэвээр үлдээсэн. Чухал ач холбогдол бүхий өөрчлөлтүүдийг дурдвал, зарчмуудыг хэрэгжүүлэхэд илүү их анхаарал хандуулж, дэлхийн мэдээллийн сүлжээн дэх ахиц дэвшил, мэдээллийн эдийн засгийн үнэ цэнийг тусгасан, хувийн мэдээллийн хил дамнуулах урсгалыг илүүтэй зохицуулжээ.

Европын холбооны Мэдээллийг хамгаалах ерөнхий журам (GDPR)²³² 2018 онд хүчин төгөлдөр болсон. Энэхүү журам нь дэлхийн хамгийн том эдийн засгуудын нэг болох ЕХ-ны дотоод мэдээллийн харилцааг зохицуулаад зогсохгүй, хэрэгжүүлэх замыг тодруулжээ. Журам нь ЕХ-ны гишүүн орнуудаас дэлхийн бусад улс руу хувь мэдээлэл шилжүүлэх урсгалд илүүтэй нөлөөтэй болжээ. ЕХ-ны дотор ажиллаж буй олон улсын компаниуд хувь мэдээлэл цуглуулах ажиллагааг мөн GDPR журмаар зохицуулдаг. Одоогоор GDPR журмаас төрийн болон хувийн хэвшлийн мэдээллийг хянаагчдад ногдуулсан үүргүүд нь дээрх ЭЗХАХБ-аас 1980 онд анхны үүрэгтэй ижил байна.

Монгол Улсад хувийн нууцлалыг Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай²³³ хуулиар хамгаалж байна. Энэ нь 2021 онд батлагдаж, 2022 оны 5-р сараас эхлэн хүчин төгөлдөр

²³⁰ ЭЗХАХБ. 1980 (2013 онд нэмэлт өөрчлөлт). *Guidelines on the Protection of Privacy and Transborder Flows of Personal Data* (Хувийн мэдээллийн нууцлал болон хил дамнасан урсгалыг хамгаалах удирдамж) <https://www.oecd.org/internet/ieconomy/oecdguidelinesontheprotectionofprivacyandtransborderflowsofpersonaldatal.htm>. Удирдамжийг хүчтэй болгох зорилгоор баталсан Конвенцыг мөн үзнэ үү: Европын зөвлөл. 1981. *Convention for the Protection of Individuals with regard to Automatic Processing of Personal Data* (Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай конвенц) <https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/108>; мөн Европын Зөвлөл. 2018. *Modernised Convention for the Protection of Individuals with regard to the Processing of Personal Data* (Хувийн мэдээлэл боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах тухай шинэчилсэн конвенц). <https://www.coe.int/en/web/data-protection/convention108/modernised>.

²³¹ ЭЗХАХБ. 2013. *OECD Privacy Framework* (ЭЗХАХБ-ын нууцлалын тогтолцоо) www.oecd.org/sti/ieconomy/oecd_privacy_framework.pdf

²³² Европын парламент ба Европын Зөвлөл. 2016. *General Data Protection Regulation* (Мэдээлэл хамгаалах ерөнхий журам) <https://gdpr-info.eu/> болон <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/>. GDPR нь 1995 оны нөлөө бүхий ЕХ-ны “Мэдээллийг хамгаалах удирдамж”-ийг сольсон TXT/PDF/?uri=CELEX:32016R0679&from=EN.

²³³ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390288615991>

мөрдөж буй орчин үеийн иж бүрэн хууль юм. Энэ нь дараах хуулийн нийтлэг шинж чанартай:

- Олон нийтийн бүртгэл, эрүүл мэндийн зэрэг цөөн хэдэн зорилгоос бусад тохиолдолд хувийн мэдээллийг зөвхөн мэдээллийн эзний өөрийнх нь зөвшөөрөлтэйгөөр цуглуулна²³⁴. Ийнхүү мэдээлэл цуглуулж буй этгээдэд нарийвчилсан үүрэг ногдуулсан байдаг²³⁵.
- Зарим эмзэг мэдээлэл (эрүүл мэнд, шашин шүтлэг, бэлгийн дуршил) цуглуулж хадгалах нь илүү хатуу хяналттай²³⁶
- Архив, түүх, статистик гэх мэт зорилгоор хадгалж буй хувийн мэдээлэл хувь хүнийг дурдахгүй²³⁷.
- Хувь мэдээлэл цуглуулахад тухайн үед заасан зорилгоор хязгаарлагдах бөгөөд энэ зорилгод ашигласнаас илүү удаан хадгалж болохгүй²³⁸.
- Цуглуулсан этгээд нь (“мэдээлэл хариуцагч”) хувийн мэдээллийг аюулгүй хадгалах ёстой²³⁹. Хуульд үүний талаар нэлээд нарийн тусгасан.
- Мэдээллийн эзэн²⁴⁰ нь өөрийн хувийн мэдээлэлд хандах, засварлах, шинэчлэх, устгах эрхтэй, ийнхүү засварлах, шинэчлэх шаардлагатайг нотлох баримтаар нотолно²⁴¹. Устгах эрх нь буруу мэдээлэл орсон, алдаа гаргасан тохиолдолд л хэрэгждэг болохоос Европын утгаар бүрмөсөн “мартагдах” эрх биш юм шиг санагдаж байна²⁴²

Мэдээллийн боловсруулагчид (мэдээлэл хариуцагчийн талын этгээд юм) болон мэдээлэл хариуцагч нар аливаа зөрчил илэрсэн тохиолдолд тухайн хувийн мэдээллийн эзэнд мэдэгдэх ёстой²⁴³. Мэдээллийн эзэн үнэхээр зөрчил гарсан бол “хуулийн дагуу холбогдо байгууллагад гаргаж болно”²⁴⁴.

Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийг тууштай хэрэгжүүлэхийн тулд уг хуульд “мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага”-ар Хүний эрхийн үндэсний комисс болон Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг зааж, эрх, үүргийг нь тодорхойлсон.

Хүний эрхийн үндэсний комисс нь мөрдөн байцаах, маргаан шийдвэрлэх өргөн эрхтэй²⁴⁵. Хуулиа биелүүлээгүй хүн, аж ахуйн нэгжид үүрэг даалгавар өгөх эрх мэдэлтэй эсэх нь

²³⁴ 233-р тайлбар, 6, 7-р зүйл

²³⁵ 233-р тайлбар, 18-р зүйл

²³⁶ 233-р тайлбар, 9, 10-р зүйл

²³⁷ 233-р тайлбар, 6.2.5, 6.3 дахь хэсэг 11-р зүйл

²³⁸ 233-р тайлбар, 8.10 дахь хэсэг (зорилго), 15.1.3 дахь заалт (хугацаа заасан)

²³⁹ 233-р тайлбар, 20-р зүйл

²⁴⁰ Заримдаа хуульд “өгөгдлийн субъект” гэсэн нэр томьёог ашиглажээ, жишээлбэл, 16.1.1 дэх заалтанд. Энэ нэр томьёог хуульд тодорхойлоогүй болно. Бусад улс оронд энэ нь мэдээллийг эзэмшигч, тухайлбал, хувийн мэдээлэл нь асуудалтай байгаа хүнийг Монгол Улсад тэгж нэрлэдэг.

²⁴¹ 233-р тайлбар, 16-р зүйл

²⁴² 233-р тайлбар, 19-р зүйл

²⁴³ 233-р тайлбар, 22.1, 22.2 дахь хэсэг.

²⁴⁴ Мөн тэнд, 22.4. The “эрх бүхий байгууллага” гэдэг нь Хүний эрхийн үндэсний комисс –24.1.4 дэх заалтаас. Гэхдээ Хүний эрхийн үндэсний комисс нь “шаардлага, зөвлөмжийг холбогдо байгууллагад хүргүүлнэ” – 24.1.2 дахь заалтаас – мөн “холбогдо байгууллагад” – 24.1.3 дахь заалтаас.

²⁴⁵ 233-р тайлбар, 24-р зүйл.

бүрэн тодорхойгүй байна. Түүний эрх мэдэл нь голчлон зөвлөмж гаргах бололтой, гэхдээ хэнд зөвлөмжөө гаргахыг хуульд заагаагүй - хууль тогтоох байгууллагад хийдэг тайландаа дурдсан байх юм шиг байна²⁴⁶.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь “хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах”, энэ чиглэлээр “холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах” үүрэгтэй. Хэрэгжилтийг хангах гэдэг өгөгдөл боловсруулагч, эсвэл хянагч нарт зориулсан заавал биелүүлэх шинжтэй даалгавар өгөх эрхтэй эсэх нь тодорхойгүй байна.

Төрөөс хувийн мэдээлэл цуглуулсантай холбоотой гомдлыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу шийдвэрлэдэг. Бусад гомдол нь “эрх бүхий байгууллага” буюу Хүний эрхийн үндэсний комисст ирнэ²⁴⁷. Мөн эрүүгийн болон бусад төрлийн шийтгэлүүдийг бас хуульчилсан²⁴⁸.

Энэхүү хуулийг 2022 оны тавдугаар сараас мөрдөж байгаа тул дээрх эрх мэдлийг хослуулан амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлэхийг хэлэхэд арайхан эрт байна.

Нууцлалын асуудлыг зохицуулсан энэхүү хуулийн текст нэлээдгүй сайн байна. Үйлчлүүлэгчид буюу олон нийтийн хувийн мэдээллийг ашиглах хүсэлтэй зарим аж ахуйн нэгжүүд тухайн хуулийг хэрхэн дагаж мөрдөх талаар төрийн байгууллагаас, тухайлбал энэ хуульд заасан буй эрх бүхий байгууллагаас мэдээлэл авах шаардлагатай байж магадгүй юм.

Өмнөх хуультай нэгэн адил шинэ Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль нь хувийн нууцдаа санаа зовж буй хэрэглэгчдийг, ялангуяа хот суурин газраас гадуур буй хүмүүсийг тайвшруулах зорилготой юм. Ийнхүү санаа зовсноос болж онлайн гүйлгээнд оролцдоггүй хүмүүс бий.

1. Хувийн мэдээллийг хил дамнаж дамжуулах

Хууль нь хүлээн авагч улстай гэрээ байгуулсан тохиолдолд хувийн мэдээллийг хилээр дамжуулахыг зөвшөөрсөн. Мэдээллийг шилжүүлэн авч буй улс нь хувийн мэдээлэлд ижил хэмжээний хамгаалалтаар хамгаална гэсэн ердийн нөхцөл Монголын хуульд байдаггүй бөгөөд уг нь баймаар. Гэрээ байхгүй тохиолдолд шилжүүлгийг зөвхөн мэдээллийн эзэмшигчийн зөвшөөрлөөр хийж болно.²⁴⁹

Хувийн мэдээллийг хил дамнуулан шилжүүлэхтэй холбоотой өөр нэг анхаарах зүйл бол ийм шилжүүлгийг хязгаарласан, хориглосон дүрэм юм. Тухайн улсын иргэдийн (эсвэл оршин суугчдын) хувийн мэдээллийг зөвхөн тухайн улсдаа боловсруулж хадгалах санал байдаг. Үүнийг “өгөгдлийг нутагшуулах” гэдэг. Хятад, Вьетнам зэрэг хэд хэдэн орон ийм дүрмийг хэрэгжүүлсэн. Энэ нь иргэдэд нэмэлт хамгаалалт өгч байгаа мэт сонсогдож бусад орнуудын сонирхлыг татах талтай.

Өгөгдлийг нутагшуулах шаардлага нь үндэстэн дамнасан бизнесүүдийн мэдээллийг үр ашигтай боловсруулахад саад учруулдаг тул чөлөөт худалдааг эрхэмлэдэг хүмүүс үүнийг дэмждэггүй. Энэхүү “өгөгдлийг нутагшуулах” бодлого нь хил дамнасан аж ахуйн нэгжүүдэд үр ашиггүй юм: ийм дүрэмтэй улс орон тус бурд мэдээлэл боловсруулж хадгалах байгууламжийг тусад нь бий болгох шаардлагатай болно гэсэн үг. Энэ нь эдийн засагт ч

²⁴⁶ 233-р тайлбар, 24.1.6 дахь заалт.

²⁴⁷ 233-р тайлбар, 28 -р зүйл.

²⁴⁸ 233-р тайлбар, 30-р зүйл.

²⁴⁹ 233-р тайлбар, 14-р зүйл

ач холбогдолгүй. Нэмж дурдахад, мэдээллийг дотооддоо боловсруулах нэрээр иргэдийн онлайн үйл ажиллагааг хянах арга болгон ашигладаг, учир нь бүх өгөгдөл төрийн эрх баригчдад нээлттэй хэвээр байна. Энэ утгаараа Хятад, Вьетнамын энэ бодлогыг шүүмжилсэн²⁵⁰.

Монгол-Японы худалдааны хэлэлцээрээр болон чөлөөт худалдааны хэд хэдэн хэлэлцээрт ийм бодлого явуулахыг хориглосон байдаг. Гэхдээ өгөгдлийг нутагшуулах зарчмаас давамгай төрийн бодлогын шалтгаан байж болно, энэ нь ховор боловч тесөөлж хэрэгжүүлэхүйц юм²⁵¹.

Д. Мэдээлэл (бизнесийн болон албан)-ийг хамгаалах

“Өгөгдлийг хамгаалах” гэдэг нь мэдээллийн аюулгүй байдал, өгөгдлийн хүртээмж, хандалтын хяналт зэргийг багтаасан цогц нэр томьёо юм. Нууцлал эсвэл хувийн мэдээллийг хамгаалах гэдгээс илүү өргөн хүрээтэй.

Өгөгдлийг хамгаалах нь хөрөнгийг зөвшөөрөлгүй ашиглахаас хамгаалах зорилготой бол мэдээллийн нууцлал гэдэгт хэн хандах эрхтэйг ярьж байгаа юм.

Мэдээллийг хамгаалахад нэгэнтээ олж авсан аливаа өгөгдлийг ялгахгүйгээр хамгаалах үйлдэл юм (хувийн мэдээлэл, төлбөрийн мэдээлэл, өмчийн буюу арилжааны мэдээлэл зэргээс үл хамаарна) ²⁵².

Ийм мэдээллийг хамгаалах хэд хэдэн хууль зүйн арга бий:

- Худалдааны нууцыг хуулиар хамгаална. Үүнд хамаарахгүй зарим асуудлыг хуульд мөн тусгажээ:
 - 2021 онд баталж, 2022 оны тавдугаар сараас хүчин төгөлдөр мөрдөж буй Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд ²⁵³ төрийн албан тушаалтнууд арилжааны зарим нарийн мэдээллийг олон нийтэд ил болгохгүй байхаар тусгасан.
 - Худалдааны нууц нь угаасаа хамгаалалттай гэсэн үндэслэлтэй хүлээлт байдаг. Энэхүү хамгаалалт нь хуулиар хэрэгжихээс гадна зарим нэг бие даасан үйлдлээр хэрэгждэг мэт.
- Оюуны өмчийн тухай хуульд хэн нэгний мэдээллийг ашиглах, хуулбарлахыг хориглосон. Энэ чиглэлээр хуулийн ерөнхий хамгаалалтаас гадна арилжааны платформ болон худалдааны зуучлагчид хүний оюуны өмчийг зөрчихийг хориглосон заалтыг арилжааны платформын тухай хуульд оруулах боломжтой. Энэ нь оюуны өмч эзэмшигч нь түүний эрхийг зөрчсөн худалдагч, платформын оператор, зуучлагчид даруй мэдэгдэж, зөрчлийг таслан зогсоо арга хэрэгслийг хангаж чадна.

²⁵⁰ Ж.Фокс “Гадаадын хөрөнгө оруулагчид Вьетнамын “шинэ өгөгдөл нутагшуулах журам”-д хэрхэн хариулах вэ” товч танилцуулга, Вьетнам улс, 23.09.2002 www.vietnam-briefing.com/news/how-are-foreign-investors-hariuulaah-to-veetnams-new-data-localization-regulation.html

²⁵¹ Монгол – Японы чөлөөт худалдааны хэлэлцээр, 145-р тайлбарыг мөн харах, 9.10 дахь хэсэг.

²⁵² Forbes сэтгүүл, “Өгөгдлийн нууцлал ба мэдээллийн хамгаалалт: Өгөгдлөө хамгаалах ялгааг ойлгох нь” <https://www.forbes.com/sites/forbestechcouncil/2018/12/19/data-privacy-vs-data-protection-understanding-the-distinction-in-defending-your-data/?sh=281a6f6d50c9>

²⁵³ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601>

- Цахим гэмт хэргийн тухай болон Эрүүгийн хуулиар компьютерын системд зөвшөөрөлгүй нэвтрэх, систем дэх аливаа мэдээлэлд өөрчлөлт оруулахыг хориглодог²⁵⁴. Энэхүү хориг нь ransomware халдлагыг хамаарна.

Арилжааны болон албан мэдээллийг хулгайлхаас, хөндлөнгөөс нэвтрэхээс хамгаалсан нийтлэг хуулиуд нь цахим мэдээлэлд нэгэн адил хамаатай.

Монголд зориуд арилжааны мэдээллийг хамгаалсан бие даасан хэм хэмжээ бага байх шиг байна. Энэ бүлгийн сүүлчийн хэсэгт тайлбарласан нууцлалын талаарх хуулийн хэм хэмжээ нь хувийн мэдээллийг хамгаалахаас хэтрээгүй, бусад төрлийн мэдээлэлд хамаарал бага байна.

Олон нийтэд хаалттай аж ахуйн ажиллагааны болон хувь хүний мэдээллийн нууцлалыг хангах талаар илүү идэвхтэй, тодорхой болгох нь зүйтэй. Ийм хууль тогтоомж нь Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулттай төстэй байж болох ч мэдээллийн эзний шууд зөвшөөрснөөс бусад тохиолдолд арилжааны болон бусад нууц мэдээллийг цуглуулах, ашиглах, задруулахыг хориглох (арилжааны зорилгоор хамтран бизнес эрхэлдэг компаниуд ийм зөвшөөрөл олгох нь тийм ч ховор биш байдаг) эсвэл чухал олон нийтийн зорилгоор л ийнхүү ашиглаж болох талаар заах.

Одоогийн байдлаар энэхүү харилцаагаар жишиг болохуйц олон улсын шилдэг туршлага байхгүй ч мэдээллийг хамгаалах хууль талаар бусад орны хууль тогтоомжийг Монголд загвар болгон ашиглах боломжтой.

Е.Зайнаас нотариатаар баталгаажуулах

Гүйлгээг биеэрээ биш харин онлайнаар, "алсаас" хийдэг нь цахим худалдааны мөн чанар юм. Энэхүү тайланд өмнө нь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд цахим худалдаатай холбоотойгоор тухай "зайны болон цахим бизнесийн үйл ажиллагаа" гэсэн бүлэг оруулж байгааг дурдсан билээ.

"Алсын" гүйлгээний нэг асуудал бол оролцогчдыг нь баталгаажуулах явдал юм. Уламжлалт буюу биеэр гарын үсэг зурахаас зайлсхийдэг нь Ковид цар тахлын үед улам ач холбогдолтой болсон. Холбогдох хууль нь практик сорилтуудыг авч үзэх шаардлагатай: зайнаас хэлцэл хийж буй талууд эсвэл хууль ёсны "алсын" гэрчүүд (эсвэл нотариатч) тэдгээрийг хэн болохыг хэрхэн хангалттай баталгаажуулж чадах вэ? Гарын үсэг зурж байгаа нь гарын үсэг зурах ёстой этгээд мөн үү? үүнд яаж итгэлтэй байх вэ? Нотариатч гээд гарын үсэг зурж байгаа хүн жинхэнэ нотариатч мөн гэдэгт яаж итгэлтэй байх вэ?²⁵⁵ Товчхондоо, гарын үсэг зурах ажиллагаанд оролцогчид (гарын үсэг зурсан хүмүүс болон гэрчүүд), гарын үсэг зурсан баримт бичгийг тухайн үед болон дараа нь ашиглах үед найдвартай баталгаажуулалт шаардлагатай юм.

²⁵⁴ Эрүүгийн хууль (26.1, .2 ба .3 заалтууд). Цахим гэмт хэргийн талаар энэ тайлангийн зохих хэсэгт авч үзсэн.

²⁵⁵ Монгол Улсын Нотариатын тухай хуульд /24-р тайлбар/ цахим нотариатаар гэрчлэхийг шууд зөвшөөрсөн боловч биечлэн уулзахаас бусад тохиолдолд ийм үйлдлийг хийх боломжгүй бололтой. Харин хэд хэдэн оронд зайнаас нотариатаар гэрчлүүлж болох талаар зохицуулалт хийж байна, жишээлбэл, АНУ-д энэ талаар эрх зүйн орчныг бий болгосон. Монголд ч бусад алсаас гарын үсэг зурж болох системд тулгарч буй асуулттай зарчмын хувьд төстэй асуудал үүснэ.

Эдгээрийг ихэвчлэн паспорт, жолооны үнэмлэх гэх мэт таних бичиг баримтын хүчинтэй эсэхийг шалгах, тусгай программ хангамжаар зөв таниулах, алсаас гарын үсэг зурж, шууд видео бичлэг дээр гэрчлэх зэрэг хуулийн ажилбараар зохицуулдаг. Тоон гарын үсгийн системд дүрмээр нь бүртгэснээр гарын үсэг зурсны дараа тухайн баримт бичигт өөрчлөлт оруулахаас сэргийлж болно. Нотариатчдын бүртгэлийг баталгаажуулах шаардлагатай үед онлайнаар бодит цаг хугацаанд шалгах боломжтой.

Иргэний үнэмлэхэд оруулсан тоон баталгаажуулалтыг ашиглан баталгаажуулах системийг алсаас ашиглах боломжийг Монголын хуульд аль эрт оруулжээ. Хүмүүс биечлэн ирэхгүйгээр тоон гарын үсгийг бүртгүүлэх боломжтой. Одоогийн ашиглалтын түвшнээс эдгээр гарын үсгийг онцгой аюулгүй арга замаар ашигладаг болоход харьцангуй бага чармайлт шаардсан алхам болно. Наад зах нь үзэл баримтлалын хувьд үүнийг авч үзэх нь зүйтэй. (системд нийтээр нь хэрэглэгчийн тав тухыг хангах асуултууд байдаг ч тэдгээрийг шийдвэрлэхийн тулд хуулийн шинэчлэл шаардлагагүй гэж дээр ярьсан билээ.)

Ийм аргыг нэвтрүүлэхийн тулд Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

Ё.Кибер гэмт хэрэг ба кибер аюулгүй байдал

Олон улсын шилдэг туршилага

Стандартуудыг Европын Зөвлөлийн Кибер гэмт хэргийн талаарх Будапештын конвенцод (2001)²⁵⁶ заасан байдаг.

- Компьютерын системд зөвшөөрөлгүй нэвтрэхийг хориглох
- Компьютерын өгөгдлийг олон нийтэд дамжуулахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй хөндлөнгөөс оролцохыг хориглох
- Компьютерын өгөгдлийг зөвшөөрөлгүйгээр гэмтээх, устгах, муутгах, өөрчлөх, дараахыг хориглох
- Компьютерын системийн ажилд санаатай болон зөвшөөрөлгүй саад учруулахыг хориглох
- Дээрх гэмт хэрэг үйлдэх боломжтой төхөөрөмж, компьютерын нууц үг, нэвтрэх кодыг зөвшөөрөлгүй эзэмших, бусдад шилжүүлэх, ийм компьютерийг худалдахыг хориглох.
- Компьютерээр хурамч бичиг баримт шилжүүлэх, залilan мэхлэхийг хориглох
- Хүүхдийн садар самуунтай холбоотой олон төрлийн үйл ажиллагааг хориглох
- Зохиогчийн эрхийн зөрчлийн эсрэг үр дүнтэй арга хэмжээ авах.

Цахим худалдаанд олон нийтийн итгэлийг бий болгох өөр нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол онлайн шударга ёсыг төлөвжүүлэх явдал юм²⁵⁷. Монгол Улсад хуурамч мэдээлэл өгөх, залilan мэхлэх, хуурамчаар үйлдэх, хулгайлах зэрэг шударга бус үйлдлийн нийтлэг хэлбэрийг хориглосон Эрүүгийн хууль дахь зохицуулалт хэдийнээс хэрэгжиж байгаа.

Өрсөлдөөний хуульд заасан эдийн засгийн үйл ажиллагааны хүрээнд хуйвалдан үнэ тогтоох, үнийг ялгаварлан гадуурхах, үнээр “өгөөш” болгон хуйвалдах зэргээр монополь байдал, монополь шинжтэй үйлдлүүдийг цахим орчинд хамааруулан, хориглох зорилготойгоор авч үзэж болно. Өрсөлдөөний тухай хууль ийм заалттай²⁵⁸. Энэ хууль

²⁵⁶ Европын зөвлөл. Convention on Cybercrime (Кибер гэмт хэргийн тухай конвенц), 2001. <https://www.coe.int/en/web/conventions/full-list?module=treaty-detail&treatyid=185>. Албан ёсны тайлбар бичгийг мэн онлайнаар эндээс авах боломжтой: <https://rm.coe.int/16800cce5b>.

²⁵⁷ Энд байгаа ерөнхий хэлэлцүүлгийг АХБ-ны 2021 онд CAREC-ийн орнуудын хүрээнд хийсэн судалгаанаас авсан болно. Дээрх 131-р тайлбарыг мөн харах

²⁵⁸ Өрсөлдөөний тухай хууль: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12>

болон Монголын бусад холбогдох хууль нь ерөнхийдөө “төвийг сахисан байдаг”, өөрөөр хэлбэл цахим болон бодит орчны үйлдэл, гүйлгээнд нэгэн адил үйлчилдэг. Энэ асуудлаар хууль тогтоомжийн шинэ зүйл заалт шаардлагагүй байна²⁵⁹.

Цахим худалдаанд хэрэглэгчид болон бизнесийн оролцогчдын итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор цахим гэмт хэргийг хамарсан хамгаалалтыг нэмэх нь зүйтэй²⁶⁰.

Цахим гэмт хэргийн эсрэг олон улсын хуулийн үндсэн заалтуудыг өргөнөөр хүлээн зөвшөөрсөн байдаг. Энэ харилцааг зохицуулсан хоёр хэлэлцээр - нэг нь батлагдсан, нөгөө нь төсөл хэлбэрээр - олон нийтлэг зүйл заалттай боловч хэрэгжүүлэх захиргааны арга, хандлагууд нь өөр өөр. Цахим гэмт хэргийн тухай Европын зөвлөлийн конвенцод (2001 оны Будапештын конвенц гэдэг)²⁶¹ дотоодын эруүгийн хуулийг цахим үйл ажиллагаанд хэрэглэх талаар маш тодорхой заасан. Үүгээр Европын зөвлөлийн 47 гишүүн орнууд нь ердийн хуулийн дагуу хууль бус гэж үзэхгүй байж болох зарим төрлийн цахим үйлдлийг хориглосон юм.²⁶²

Конвенц нь гарын үсэг зурсан этгээдэд хориглосон гол онлайн гэмт хэрэг нь: мэдээллийн системд (компьютер, сүлжээ) хууль бусаар нэвтрэх, цахим харилцаа холбоог хууль бусаар саатуулах, өгөгдөл эсвэл системд хөндлөнгөөс оролцох, цахим төхөөрөмжийг зүй бусаар ашиглах зэрэг юм. Хүн компьютерээ ашиглах чадварт сөргөөр нөлөөлөх, үнэ цэнтэй мэдээллийг хулгайлж болзошгүй хортой программ үүсгэх, түгээхийг гэмт хэрэг мөн гэж заасан, үүнд вирус, bug, ransomware гэх мэт зүйлс орно.

Кибер гэмт хэргийн тухай НҮБ-ын конвенцын төсөл нь Европын зөвлөлийн Будапештын конвенцтой тун төстэй юм. Мөн л зохиогчийн эрх "болон холбогдох эрхийг" хамгаалдаг²⁶³. Бодит ялгаа нь хэрэгжүүлэх аргад оршдог. Энэхүү төсөл нь Будапештын Конвенцыг бодвол улс орнуудад өөрсдөө шалгах, мөрдөх эрхийг илүүтэй олгож, энэ асуудлаар бусад улс орнуудтай харилцах, хамтран ажиллахыг харьцангуй бага шаарддаг²⁶⁴. Гэхдээ энэ төсөл нь хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох, шилжүүлэн өгөх, холбогдох эрх мэдлийн талаар олон заалттай.

Компьютерын эсрэг гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэгт “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг”²⁶⁵ гэж заасан байдаг.

²⁵⁹ Түүнчлэн 2001 оны Будапештын конвенцод олон уламжлалт гэмт хэргүүдийг онлайнараар үйлдсэн бол гэмт хэрэг гэж хэвээр үзэх ёстой гэж гишүүн орнуудаасаа шаарддаг (256 дахь тайлбар).

²⁶⁰ Азербайжанд хийсэн судалгаагаар мэдээллийн аюулгүй байдлын (кибер гэмт хэргийн) хууль тогтоомжийг батлах нь “хэрэглэгчийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал тулхэц болсон” гэжээ. Азийн хөгжлийн банк (АХБ). 2016. Төв Азийн цахим худалдааны агшин зураг. Азийн хөгжлийн блог. Нэгдүгээр сарын 18-ны өдөр <https://blogs.adb.org/blog/snapshot-e-commerce-central-asia>.

²⁶¹ Европын зөвлөл. Convention on Cybercrime (Кибер гэмт хэргийн тухай конвенц), 256 дахь тайлбар.

²⁶² Жишээлбэл, зарим орны эрх зүйд өгөгдлийг өмчийн хэлбэр гэж үздэггүй. Тиймээс одоо мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу мэдээллийг зөвшөөрөлгүйгээр хуулбарлах нь хулгайд тооцогдохгүй бөгөөд хэн нэгний мэдээллийг устгах нь эд хөрөнгөд хохирол учруулсан гэж үзэхгүй байж болно.

²⁶³ Мэдээллийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтран ажиллах тухай НҮБ-ын конвенцын төсөл, <https://www.rusemb.org.uk/fnapr/6394>

²⁶⁴ A. Peters. 2019. “Russia and China are trying to set the U.N.’s Rules on Cybercrime,” (А.Питерс. 2019. “Орос, Хятад хоёр улс НҮБ-ын кибер гэмт хэргийн дүрмийг тогтоохыг оролдож байна”) Гадаад бодлого сэтгүүл, 09.06 <https://foreignpolicy.com/2019/09/16/russia-and-china-are-trying-to-set-the-u-n-s-rules-on-cybercrime>.

²⁶⁵ Монгол Улсын Эрүүгийн хууль <https://legalinfo.mn/mn/detail/11634>

226.1. Компьютер, компьютерын программ, түүний төхөөрөмжийг санаатайгаар өөрчилсөн, эвдсэн, гэмтээсэн, ашиглах боломжгүй болгосон, мэдээллийн сүлжээг сүйтгэсэн бол ял шийтгэхээр заасан. 226.2. Энэ хэргийг шунахайн сэдэлтээр, түүнчлэн урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг буюу албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн тухай заасан бөгөөд илүү хатуу шийтгэл хүлээлгэхээр заасан.

Хорих ял оноох гэмт хэрэг нь зохион байгуулалттай үйлдсэн, төрийн нууц, "чухал мэдээлэл" агуулсан компьютерын эсрэг үйлдсэн гэмт хэрэг юм. Хортой программ үүсгэх, худалдах нь 26.2-т заасан хууль бус хандалт өгсөн тохиолдолд, 26.3-т заасны дагуу бусад компьютерын мэдээллийг хулгайлсан буюу гэмтээсэн гэмт хэрэг болно.

Өнөө үед цахим гэмт хэрэгтэй тэмцэх нь туйлын хэцүү гэдгийг бараг хүн бүр ойлгоно. Кибер гэмт хэрэгтнүүд байршилаа далдалж, шууд бусаар халдах хандлагатай байдаг. Ийм үйлдлээс хамгаалахад хэрэглэгч өөрөө, ялангуяа хэрэглэгчийн мэдлэг нь тэмцлийн чухал хэрэгсэл юм. Гэмт хэрэгтэнтэй тэмцэх ба халдлагын байг хамгаалж халдлагыг хэцүү болгох нь аль аль адил чухал. 2021 оны Кибер аюулгүй байдлын тухай²⁶⁶ хуульд ийм ажиллагааг нарийвчлан тусгажээ. Хууль нь кибер эрсдэлд өртөж болзошгүй нийгмийн бүх хэсэгт, ялангуяа чухал дэд бүтэцтэй байгууллагуудын үүрэг, эрсдэл, аюулгүй байдлын хяналтын үүрэг хариуцлагыг тодорхойлсон.

Монгол Улсын цахим гэмт хэргийн эсрэг авч буй арга хэмжээ нь ижил нөхцөл байдалд олон улсын жишигт нийцэж байна. Цаашлаад хуулийн бичилтээс илүүтэй хэрэгжүүлэх талаарх захиргааны үйл ажиллагаа нь чухал юм. Цахим аюулгүй байдлын тухай шинэ хууль нь голцуу ийм захиргааны хэм хэмжээг агуулсан бөгөөд цахим гэмт хэргийн хэм хэмжээг Эрүүгийн хуульд үлдээсэн. Хэрэв Монгол Улс нь Будапештын конвенцод нэгдье гэвэл уг конвенцод заасан гэмт хэрэг болон хориглосон зүйлүүдийг нь нягт хуульдаа тусгах хэрэгтэй болно. Уг конвенцод бусад гишүүн орнуудтай хамтран ажиллах үүргээс бусад захиргааны хэм хэмжээг төдийлөн тусгаагүй.

2022 оны зургаадугаар сард болсон уулзалтаар Эрүүгийн цагдаагийн газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн төлөөлөгч сүүлийн үед Монголд цахим гэмт хэрэг ихсэж байгааг онцлон тэмдэглэж, цагдаагийн байгууллагаас түүнтэй тэмцэхэд учирч буй зарим хүндрэлийг дурдав.

- Эрүүгийн хуулийн зүйл заалтад цахим худалдааны талаар тусгайллан дурдаагүй.
- Мөрдөн шалгах явцад гадаадаас мэдээлэл хүсэх, хүлээн авах нь төвөгтэй бөгөөд удаан.
- Цахимаар үйлдсэн гэмт хэргийн талаарх мэдээллийг ялангуяа том арилжааны платформуудаас авах нь нэн хэцүү.
- Банкууд гэмт хэргийн талаарх мэдээлэлд удаан хариу үйлдэлтэй бөгөөд банкнаас тусламж хүсэх, зөвшөөрөл авах нь бас удаашралтай, иймд хулгайлагдсан хөрөнгийг цагдаа нар хүрэхээс өмнө хил даваад явсан тохиолдол их.

Цагдаагийн байгууллагаас цахим гэмт хэрэгтэй тэмцэхэд нь тустай хэд хэдэн санал гаргасан. Ихэнх нь бүх эх сурвалжаас мэдээлэл илүү сайн, хурдан авах бололцоотой болох, ингэснээр асуудалд цаг тухайд оролцох нь боломжтой болох юм гэв. Холбогдох

²⁶⁶ Кибер аюулгүй байдлын тухай хууль, 2021, 4-р бүлэг, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390365491061>

этгээдүүдтэй харилцааны сувгийг сайжруулах санаалаас гадна дараах гол санал дэвшүүлсэн:

- Гадаадад сервертэй цахим хуудас, олон нийтийн сүлжээ, платформоос хэрэглэгчийн мэдээлэлд хууль хяналтын байгууллагууд чөлөөтэй нэвтрэх, хязгаарлах, устгах, саармагжуулах зорилготой тусгай суваг бий болгох, энэ чиглэлээр эрх зүйн алхам хийх.
- о Ийм эрх мэдэлд маш нарийн тодорхойлолт, хязгаарлалт хэрэгтэй. Ийм алхам нь зөвхөн Монголоос гадуур сервертэй сайтуудаар хязгаарлагдсан ч хууль дагуу явагдаж буй харилцаа холбоо, гүйлгээнд саад учруулах эрсдэл өндөр байх юм.
- Гэмт хэргийн хохирогч запилуулж мөнгөн гүйвуулга хийсэн тохиолдолд мэдсэн даруйд нь түүний хүсэлтээр банкнаас гүйлгээг зогсоох арга хэмжээг яаралтай авах боломж.
- о хохирогч болсноосоо биш зүгээр л шийдвэрээ өөрчилсөн учраас гүйлгээгээ буцаах гэж оролдох бол яах вэ? үүнийг анхаарах хэрэгтэй. Хэрэв хүсэлтийн дагуу зогсоох шийдвэр гаргасан бол дараа нь үндэслэлгүй болсон нь тогтоогдсон бол уг шийдвэрийг үндэслэн хохирсон хэнийг ч нөхөн төлүүлэхээр хуульд тусгах нь тустай.
- Мөнгөний хөдөлгөөнд хяналт тавих, хязгаарлах зорилгоор прокурорын газраас зөвшөөрөл авах ажил удаашралтай байна. Цаг хугацааг багасгасан захиргааны ажиллагааг бий болгох хэрэгтэй.
- о Энэхүү бүтээлч алхам хийж хэвшүүлэх, холбогдох хуулийг өөрчлөх шаардлагагүй гэж санагдаж байна.

Ж. Цахим төлбөр тооцоо

Бүх худалдаанд төлбөр хийх шаардлагатай нь мэдээж, харин цахим худалдаанд цахим төлбөр хийх нь хамгийн тохиromжтой. “Бизнес-худалдан авагч” гүйлгээний хувьд бол дэлхийн стандарт зээлийн картаар дамжуулан төлбөр хийх явдал юм. Карт гаргагч нь карт эзэмшигчийг таних, баталгаажуулах үүрэгтэй бөгөөд худалдсан этгээдэд төлбөр төлсөн эсэхийг баталгаажуулж мэдээлдэг (энэ үйлдэл нь гэрээ хэлцлээр хязгаарлагдана). (Монголд хүмүүс зээлийн картаас илүүтэй дебит карт эзэмшдэг, ийм картыг дотоодын цахим гүйлгээнд мөн адил сайн ашиглаж болно.)

Карт ашиглах нөхцөлийг Visa, Mastercard зэрэг томоохон картын байгууллагууд дотоодынхоо хууль тогтоомжийг үндэслэн тогтоодог.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль нь цахим төлбөрийн систем зэрэг улсын бүх мөнгөний харилцааг зохицуулдаг. Үйл ажиллагааг нь Төв банк Монголбанкнаас тодорхойлсон²⁶⁷.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна²⁶⁸. Энэ хуулиар үндэсний төлбөрийн системийн эрх зүй, зохион байгуулалтын үндсийг тогтоосон; төлбөрийн үйлчилгээ үзүүлэх журам, үндэсний төлбөрийн системийн оролцогчдын үйл ажиллагааг зохицуулдаг; төлбөрийн

²⁶⁷ Монгол банкны төлбөрийн тогтолцооны талаар: <https://www.mongolbank.mn/eng/listpaymentsystem.aspx>

²⁶⁸ Үндэсний төлбөрийн системийн тухай хууль: <https://legalinfo.mn/mn/detail/12668>

үйлчилгээ үзүүлэгч, операторт тавих зохион байгуулалт, үйл ажиллагааны шаардлагыг заасан; дотоодын төлбөрийн системд тавих хяналт, хяналтыг хэрэгжүүлэх журмыг тогтоожээ. Мөн энэ хуулийн дагуу банк бус байгууллагууд үндэсний төлбөрийн системд оролцох боломжтой²⁶⁹.

Монголд одоогоор хэрэглэж байгаа төлбөрийн хэрэгслийг Монголбанкнаас ийнхүү тайлбарлажээ²⁷⁰:

- бэлэн мөнгө
- интернэт гүйлгээ
- төлбөрийн даалгавар, нэхэмжлэл
- гар утсаар гүйлгээ
- төлбөрийн карт
- мөнгөн гуйвуулга
- цахим мөнгө
- биллинг

Одоогийн байдлаар цахим төлбөрийн тулгамдсан асуудлууд нь эрх зүйн гэхээсээ илүү техникийн шинжтэй харагдаж байна. Банкуудын өөрийн журам нь онлайн гүйлгээний хэрэглээнд сөргөөр нөлөөлж байгаа хэрээр тэд урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ сулруулах эрх зүйн чадвартай²⁷¹.

1. Гадаад төлбөр тооцоо

Монголбанк гадаадын банкуудтай харилцдаг, тодруулбал, “үндэсний төлбөрийн системийг олон улсын жишиг, үндсэн зарчимд нийцүүлэн хөгжүүлэх зорилгоор Монголбанк нь гадаад улсын төв банк, олон улсын байгууллагатай хамтран ажиллана” гэсэн байна. Харин Монголд хийсэн бүх гүйлгээний үнийг монгол мөнгөн тэмдэгтээр илэрхийлэх ёстой.^{272,273}

Зээлийн картаар гадаадад төлбөр хийх боломжтой ч ийм төрлийн гүйлгээний шимтгэл маш өндөр байна.

Ингэхдээ гадаадаас орж ирж буй төлбөр тооцооны бэрхшээл нь монголчуудын цахим гүйлгээгээр экспортлоход саад болж байгаа бололтой. Одоогийн байдлаар гадаадад байгаа монголчуудын мөнгөн гуйвуулга голчлон орж ирж байна. Харин монголын бизнес эрхлэгчид гадаад руу ачуулсан барааныхаа төлбөрийг хүлээн авахад хамаагүй хэцүү.

Жишээлбэл, олон жил PayPal-г ашиглан Монгол руу төлбөр хийхэд хэцүү эсвэл огт боломжгүй байгаа тухай PayPal өөрөө 2017 онд мэдэгджээ:

²⁶⁹ Монголбанкнаас нийтэлсэн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн жагсаалт энд байна: <https://www.mongolbank.mn/eng/listpaymentsystem.aspx?id=4> Үүнд карт гаргагч болон хүлээн авагч, хөдөлгөөнт банкны үйлчилгээ зэрэг орно.

²⁷⁰ Монголбанкнаас гаргасан төлбөрийн тогтолцооны тухай тайлбар: www.mongolbank.mn/eng/listpaymentsystem.aspx

²⁷¹ Банкны тогтолцоог зохицуулдаг хууль, тогтоомж, тушаалуудын бүрэн жагсаалтыг онлайнаар авах боломжтой: <https://www.mongolbank.mn/listlawsandregulationsdb.aspx?id=5>

²⁷² Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, 2009, online: <https://legalinfo.mn/mn/detail/484>

²⁷³ Монгол банкны төлбөрийн тогтолцооны бодлого, 4.2 дэх хэсэг:

<https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/PolicyonPaymentSystem.pdf>

Харамсалтай нь энэ үйлчилгээг санал болгох нь биднээс бүрэн хамаарахгүй байна. PayPal-ыг ашиглан Монголд мөнгө хүлээн авах боломжтой болгох саналыг Монголын томоохон банкууд хүлээн аваагүй.

Гэхдээ бид харилцагчдадаа хамгийн сайн нөхцөлийг бүрдүүлэх талаар дотоодын банкуудтай хэлэлцээ хийж байна.

Тулгамдаж буй бидний гол бэрхшээл бол танай улсад цахим худалдааг бүрэн зохицуулаагүй байгаа бөгөөд төрөөс тодорхой алхам хийж хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хүртэл Монголд PayPal-г гадаад улс руу мөнгө илгээх, гадаадын дэлгүүрээс юм авахад ашиглаж болно, харин өөрөө борлуулалт хийж мөнгө хүлээн авах боломжгүй²⁷⁴.

Ингэж хэлэхдээ цахим худалдааг цаашид хэрхэн зохицуулах, Монголын хуульд ямар өөрчлөлт оруулах шаардлагатай PayPal заагаагүй байна.

UNCTAD-ийн Монгол дахь цахим худалдааны тухай тайлангийн төсөлд “Монголын хил дамнасан төлбөрийн зах зээлд Stripe болон PayPal-ийг нэвтрүүлэх талаар хэлэлцээ үргэлжилж байна” гэж Монголбанкаас мэдээлжээ²⁷⁵.

Эдгээр асуудлыг шийдвэрлэх нь экспортлогчдын үр ашгийг нэмэгдүүлэх түлхэц болно. Мөн Монголын валютын ханш сүрхий хэлбэлзэж бадаг нь мөнгөний үнэ цэний өөрчлөлт бий болгож, хил дамнасан худалдааг сааруулж болзошгүйг тэмдэглэжээ. Олон улсын мөнгөний зах зээлийг хил дамнасан цахим худалдаатай харьцуулах нь энэ тайлангийн хамрах хүрээнээс гадуур юм.

3. Маргааныг шийдвэрлэх

Олон улсын шилдэг туршилага

Эвлэрүүлэн зуучлах, арбитрын ажиллагаа явуулах, арбитрын шийдвэрийг биелүүлэх талаар олон улсын хүрээнд хүлээн зөвшөөрсөн эрх зүйн орчин бий. Харилцан худалдаа хийж буй улс орнууд энэхүү олон улсын тогтолцоог нэвтрүүлэхийг зөвлөж байна:

- UNCITRAL нь Эвлэрүүлэн зуучлалын олон төрлийн хэлэлцээр, бичиг баримттай бөгөөд энд тайлбарласан байдаг: <https://uncitral.un.org/en/texts/mediation>. Эдгээр нь шударга журам, төвийг сахисан байр сууринаас бие даасан байдлаар үр дүнтэй эвлэрүүлэн зуучлахад чиглэсэн.
- UNCITRAL-ийн Олон улсын арилжааны арбитрын тухай загвар хуульд ийм арбитрын журмыг тогтоож, арбитрч аль нэг талын дотоодын шүүхийн хараа хяналтгүйгээр ажиллах боломжийг баталгаажуулсан. Энэ ажиллагаанд дотоодын шүүхээс хөндлөнгөөс оролцох боломж маш хязгаарлагдмал.
- Гадаадын Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх тухай Нью-Йоркийн конвенц нь шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны олон улсын стандартыг тогтоосон. Уг Конвенцыг түүний 100 гаруй гишүүн орны алинд ч арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэх нь баталгаатай гэсэн үг. Монгол Улс 1996 онд энэхүү конвенцод нэгдэн орсон.

Хэрэгтэй үед хэрэгжүүлэх, эдлэх боломжгүй бол хуульд эрх заасан ч энэ нь ач холбогдол багатай. Эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой зөрчлийг тайван замаар шийдвэрлэх арга хэрэгсэл байх шаардлагатай. Ийм маргааныг шийдвэрлэх уламжлалт арга бол шүүхэд

²⁷⁴ PayPal /миний мөнгийг удирдах/мөнгө илгээх, хүлээн авах/Монгол (2017 оны 3-р сарын 26, 2014 оны архивыг харах) www.paypal-community.com/t5/Sending-and-receiving-money/Mongolia/td-p/772965.

²⁷⁵ UNCTAD-ын тайлангийн төсөл, дээрхийг харах, 27-р тайлбар, 60 дугаар хуудас.

иргэний маргаанаа шийдвэрлэх (энэ нь голчлон хувийн талуудын хооронд хувийн ашиг сонирхлыг хамарсан) болон шүүх эрүүгийн хэрэг шийдвэрлэх (нийтийн хэв журам, аюулгүй байдлын асуудал үүссэн тохиолдолд).

Гэхдээ шүүхийн ажиллагаа нь үнэтэй, удаан, зарим хүмүүст ойлгоход хэцүү байдаг. Олон улсын маргааны үед нэг тал нь нөгөө талынхаа орны шүүхэд итгэхгүй байж болно. Ийм ч учраас албан бус өөр маргаан шийдвэрлэх арга хэрэгсэл бий болсон түүхтэй. Маргаан шийдвэрлэх үндсэн аргууд нь эвлэрүүлэн зуучлал болон арбитр юм.

- Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд аль нэг талд хамааралгүй бие даасан этгээд маргагч талуудын хооронд хөндлөнгөөс оролцож, хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх, шийдвэрлэх хувилбаруудыг бий болгох, эвлэрүүлэн зуучлал амжилттай болсон тохиолдолд эцсийн буултыг бий болгох ажиллагааг ойлгодог. Эвлэрүүлэн зуучлагч нь шийдвэр гаргах, тулгах эрхгүй.
- Арбитрын ажиллагаанд мөн аль нэг талд хамааралгүй бие даасан этгээд маргагчдыг сонсдог боловч тэдний хууль ёсны эрхийг үндэслэн шийдвэр гаргахад илүүтэй чиглэж ажилладаг. Арбитрч шийдвэр гаргах эрх мэдэлтэй.

Эвлэрүүлэн зуучлал, арбитр хоёрыг Монголд хэрэглэж болно. Ээнэ хоёр нь шүүхээс давуу талтай нь маргааныг олон нийтийн анхаарлын төвд оруулахгүйгээр шийдвэрлэх, зардал гаргахгүй байх оршино, мөн талууд маргаанаа шийдвэрлүүлэхээр шинжээчийг өөрсдөө томилох боломжтой юм.

Монголд ихэнх арбитрын ажиллагааг Монголын олон улсын болон үндэсний арбитрын байгууллага хэрэгжүүлж байна²⁷⁶.

Эвлэрүүлэн зуучлах төвүүд нь анхан шатны шүүхийн дэргэд (шүүхэд сууринсан эвлэрүүлэн зуучлалын төв) ажиллаж байгаа. Ийм төвүүд төрийн байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод дээр ажиллаж болно (бусад эвлэрүүлэн зуучлалын төв)²⁷⁷.

Олон улсын маргааны үед эвлэрүүлэн зуучлах болон арбитрын ажиллагаанд зуучлагч, арбитрч нь аль нэг талынх биш, төвийг сахисан байдаг нь нэмэлт давуу талтай. Угтаа бол маргагчид өрсөлдөгчийнхөө дотоодын шүүхийн тогтолцоонд итгэх үүрэг байхгүй.

Талууд гаргасан шийдвэрийг шууд дагаж хэрэгжүүлэгүй бол эвлэрүүлэн зуучлах буюу арбитрын шийдвэрийг хэрэгжүүлнэ гэдэг нь баталгаатай байх нь чухал ач холбогдолтой. 2017 оны Арбитрын тухай хуульд²⁷⁸ ийм албадан гүйцэтгэх тухай заасан байдаг. Энэхүү хуульд UNCITRAL-ийн Олон улсын арилжааны арбитрын тухай загвар хууль²⁷⁹ бүхэлд нь нөлөөлсөн нь тодорхой байна. Мөн Монгол Улс нэгдэн орсон Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх тухай Нью-Йоркийн конвенцод²⁸⁰ (Монгол Улс нь энэ конвенцод нэгдсэн) заасны дагуу шаардлагатай бол албадан гүйцэтгэх асуудлыг

²⁷⁶ ХаанЛекс, Маргаан хянан шийдвэрлэх арга хэлбэр: <https://khanlex.mn/expertise/dispute-resolution/>

²⁷⁷ LehmanLaw Mongolia LLP, Маргаан шийдвэрлэх өөр арга: эвлэрүүлэн зуучлалыг эцэслэх нь: <https://lehmanlaw.mn/blog/alternative-dispute-resolution-finalizing-mediation/>

²⁷⁸ Арбитрын тухай хууль (2017 оны шинэчилсэн найруулга), <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12456>

²⁷⁹ Олон улсын арилжааны арбитрын тухай UNCITRAL-ын загвар хууль: https://uncitral.un.org/en/texts/arbitration/modellaw/commercial_arbitration

²⁸⁰ Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц: https://uncitral.un.org/en/texts/arbitration/conventions/foreign_arbitral_awards

шүүхээр шийдвэрлүүлэх, мөн Монгол Улсаас гадуур гадаадад гарсан шийдвэрийг гүйцэтгэх тухай заалтуудыг тусгаж өгсөн.

Олон улсын арилжааны арбитрын тухай НҮБ-ын загвар хуульд одоо арбитрын гэрээ, арбитрын шийдвэр гаргахад цахим баримт бичгийг ашиглахыг зөвшөөрдөг. Монгол Улсын Арбитрын тухай хуульд²⁸¹ ч үүнийг дагаж мөрддөг.

Энэ хуулийн 8.3-т арбитрын гэрээг бичгээр хийх ёстой гэж заасан гэхдээ үүнийг дараагийн хэд хэдэн заалтаар хангана:

8.5.Цахим харилцаа холбоонд агуулагдсан мэдээлэлд нэвтэрч, түүнийг ашиглах боломжтой бол энэ хуулийн 8.3-т заасан шаардлагыг мэдээллийн өгөгдөл солилцох хэлбэрээр хангасанд тооцно.

8.6.Цахим харилцаа холбоо гэдэгт талууд хоорондоо мэдээллийн өгөгдөл ашигласан аливаа харилцааг ойлгоно.

8.7.Мэдээллийн өгөгдөл гэдэгт цахим, соронзон, гэрлийн болон бусад ижил төстэй арга хэлбэрээр бий болгосон, илгээсэн, хүлээн авсан, эсхүл хадгалсан мэдээлэл, цахим өгөгдөл солилцоо, цахим шуудан, цахилгаан, телексийг ойлгоно.

Эвлэрүүлэн зуучлалын талаар үргэлжлүүлэн тайлбарлахад,

Шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын төвийн зуучлагчдын байгуулсан эвлэрлийн гэрээ нь шүүхийн шийдвэрийн нэг хэлбэр болдог, эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүхийн шийдвэрийг харьяа шүүхийн шүүгч гаргадаг учраас. Талууд эвлэрлийн гэрээгээр тохиролцон хүлээсэн үүргээ сайн дураар биелүүлэгүй бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэнэ. Нөгөөтээгүүр, бусад эвлэрүүлэн зуучлалын төвийн зуучлагчийн хөөцөлдөж байгуулсан эвлэрлийн гэрээ нь маргааны талуудын хувьд заавал биелүүлэх үүрэгтэй боловч шүүхийн харьяа зуучлагчийн байгуулсан эвлэрлийн гэрээтэй адил гүйцэтгэгдэхгүй. Хэрэв талууд ийм эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ сайн дураараа биелүүлэгүй бол талууд нэхэмжлэлээ өөр хэлбэрээр (шүүх, арбитрын шүүх гэх мэт) гаргах эрхтэй.²⁸²

Цаашилбал, олон улсын эвлэрүүлэн зуучлалыг зохицуулах гэрээний хэрэгжилтийг хангах олон улсын баримт бичиг байдаг²⁸³. Монгол Улс НҮБ-ын UNCITRAL-ийн 2018 оны Олон улсын арилжааны эвлэрүүлэн зуучлалын тухай хууль болон Эвлэрүүлэн зуучлалын үр дүнд тохиролцсон олон улсын эвлэрүүлэн зуучлалын гэрээний загварт нэгдэн орж, хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна²⁸⁴. Маргааны талууд эвлэрүүлэн зуучлалын эцэст аливаа шийдэл нь эцсийнх бөгөөд хурдан хэрэгжих болно гэж итгэж байвал эвлэрүүлэн зуучлалыг илүүд үзнэ. Харин эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дараа дахиад шүүх хурал эхлүүлэх шаардлагатай болох юм бол энэхүү зуучлал нь цаг хугацаа алдсан ажил гэж

²⁸¹ Арбитрын тухай хууль, 278 дахь эшлэлийг үзнэ үү.

²⁸² LehmanLaw, 277 дахь ишлэлийг үзнэ үү.

<https://legalinfo.mn/mn/detail/8689?fbclid=lwAR1ISAhAsGf9TPFyJRUtYymD40EXNaMgAOXMszAmdekmM7BmJeze-NPsCR4.7>, 8-р зүйлд шүүхийн харьяа эвлэрүүлэн зуучлагч болон бусад төрлийн зуучлагчийг ялгажээ, мөн 27-р зүйлд шүүхийн харьяа эвлэрүүлэн зуучлагчийн байгуулсан гэрээг гүйцэтгэх тухай тусад нь тусгаж өгсөн.

²⁸³ Ардчилсан институци, хүний эрхийн газар, Opinion on the Law of Mediation of Mongolia (Монголын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн талаарх санал), www.osce.org/files/f/documents/c/5/458395.pdf 98-р хэсэг.

²⁸⁴ Загвар хууль цахим хэлбэрээр: https://uncitral.un.org/en/texts/mediation/modellaw/commercial_conciliation

үзнэ. Ийм тохиолдолд зуучлалын зардал, цаг хугацаа алдахыг оронд шууд шүүхэд зарга үүсгэх нь илүү утга учиртай.

Маргааныг өөр аргаар шийдвэрлэх орчин үеийн хувилбар бол цахим маргаан шийдвэрлэх (ODR) арга юм. Заримдаа цахим маргаан шийдвэрлэх арга гэдэг нь интернетээр видео хурал тогтмол хийж зуучлал эсвэл арбитрын ажиллагаа явуулахыг хэлдэг. Гэхдээ ихэнхдээ энэ нь зохион байгуулалтын л асуудал юм: тодорхой асуулт, хариултаар дамжуулан талуудыг зөрчлийг тогтоож зуучлалд хөтөлнө, тэдгээрийн хоорондын ялгааг багасгана, заримдаа тохиролцоонд хүрдэг. Энэ ажиллагаа нь ашиглаж байгаа программаас хамааралтай байж болно. Ийм тогтолцоог зохиож хэрэгжүүлэх нь амар биш. Мөн тухайн маргааны сэдвээр мэргэшсэн зуучлагч шаардлагатай. Хоёр талын хооронд маргааныг үүсгэхээс өмнө ийм аргыг хэрэглэх нь аль аль талдаа хэцүү байж болно. Зарим орны эрх зүйн тогтолцоонд ийм тохиролцоо, гэрээ (маргаан үүсэхээс өмнөх)-г гүйцэтгэх боломжгүй байдаг. Бодлогын энэ ялгааг худалдааны платформуудын үйл ажиллагааны дүрмээр даван зохицуулж болох юм.

Одоогоор Монголд онлайн маргаан шийдвэрлэх аргыг нэвтрүүлэх төлөвлөгөө байхгүй.

И.Иргэний хариуцлага: зөв үйлдлийг хувийн тал өөрөө хэрэгжүүлэх

Иргэний хариуцлагын тухай хууль нь бусдын буруугаас болж хохирсон хүмүүст нөхөн төлбөр олгоход чиглэсэн²⁸⁵. Хариуцлага хүлээх учраас хүмүүс, тэр дундаа бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгчид нь юуны түрүүнд алдаа гаргахаас сэргийлдэг. Хил дамнасан цаасгүй худалдааны иргэний эрх зүйн тогтолцоог боловсруулж буй улс орнууд тухайн худалдаанд оролцох талууд, худалдааны түншүүд (худалдан авагч, худалдагч) хоорондын харилцаа, юу нь буруу байж болох, мөн ийм эрсдэлийг хэн хүлээх ёстойг судлах ёстой (жишээ нь, аль тал болзошгүй хохирлоос сэргийлэхийн хамгийн бодит байр суурьтай байна? эсвэл хохирлын эсрэг даатгалд хамрагдах боломжтой тал зэрэг).

Хил дамнасан цахим худалдааны харилцаанд үүнийг судлан тогтооход илүү төвөгтэй нэг шалтгаан нь: ийм харилцаанд оролцогчдын олонх нь гааль, хяналтын лаборатори зэрэг зэрэг төрийн байгууллага, эсвэл төрийн чиг үүргийг гүйцэтгэдэг байгууллагууд байдаг.

Цахим худалдааны гүйлгээнд оролцогчид харилцаа холбоогоо удирдах, дамжуулах олон зуучлагчдаас хамаардаг: интернет үйлчилгээ үзүүлэгч, цахим худалдааны платформ ажиллуулагч, итгэмжлэгдсэн үйлчилгээ үзүүлэгч г.м. Хил дамнасан худалдааны хувьд зохицуулах байгууллагууд бас бий, гаалийн байгууллага, мөн бараа, үйлчилгээг хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг зохицуулах “дотоодын нэгдсэн цонх” ажилладаг²⁸⁶.

Нөгөөтээгүүр бусад бодлого, эрх зүй нь хариуцлага хүлээлгэхэд хүндрэлтэй нөхцөл үүсгэж болно, жишээлбэл, зуучлагчид томоохон хариуцлагын шийдвэрт ногдуулахын оронд илүүтэйгээр бизнесээ үргэлжлүүлэхийг нь дэмжих бодлого, эсвэл зуучлагч нь төрийн байгууллагын шинж чанартай байх (“нэг цонх”, зохицуулах байгууллага гэх мэт). Олон оронд татвар төлөгчдийн мөнгөөр санхүүждэг байгууллагуудыг их мөнгөн дүнтэй шийдвэрт хамруулахгүй байх, хязгаарлах бодлого баримталдаг.

²⁸⁵ Энэ хэлэлцүүлгийг CAREC-ын орнуудын цахим худалдааны хууль тогтоомжийн талаарх АХБ-ны тайлангаас авав, 131-р ишлэлийг харна уу.

²⁸⁶ Монголын “нэг цонх” бол урт хугацааны төсөл бөгөөд нэгэн цагт зайлшгүй хэрэгжиж эхэлнэ.

Өнөөдрийг хүртэл Монгол Улсад цахим худалдааны зуучлагчдад иргэний хариуцлагыг хүлээлгэж байсан туршлага багатай гэж хэлж болно. Харилцаа холбооны зохицуулах хороо нь интернет болон бусад харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчдийн үйлчлүүлэгчдэд зориулсан зөвлөгөө өгдөг гэхдээ эцэстээ тэднийг өрсөлдөөний асуудал хариуцсан байгууллагад ханд гэдэг²⁸⁷. Одоогийн хамгийн чухал зүйл бол зуучлагчдын хариуцлага юм. Энэ зорилгын үүднээс тодорхойлоход, "зуучлагч" гэдэгт худалдагч, худалдан авагч, платформын ажиллуулагч зэрэг цахим худалдааны үндсэн оролцогчдод логистик, харилцаа холбоо (ялангуяа веб хостинг, өгөгдөл хадгалах, cloud тооцоолол зэрэг үйлчилгээ болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид багтана.

Энэ харилцааг зохицуулсан хуульд "зуучлагч нь харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэхдээ цахим мессеж, баримт бичгийн агуулгыг өөрчлөөгүй, гүйлгээг дамжуулсан буюу байршуулсан санаачлагч биш бол зуучлагч нь дамжуулж өгсөн эсвэл хадгалж авсан цахим мессеж, бараа, үйлчилгээний хууль ёсны байдал, үр дагаврыг хариуцахгүй" гэж заавал оновчтой.

Ийм заалтууд зарчмын хувьд хангалттай юм. Судалгааны баримтуудад худалдаачид болон бусад хүмүүсийн нэрийн өмнөөс үүнтэй холбоотой тодорхой бэрхшээл, асуудлыг дурдаагүй. Дэлхий даяар зуучлагчийн хариуцлагатай холбоотой үндсэн дүрэм нь ижил. Жишээлбэл, технологийн чиглэлээр ажилладаг олон талт байгууллага болох Дэлхийн сүлжээний санаачилга (Global Network Initiative) нь өөрийн харилцаа холбооны зуучлагчдад бусдад үзүүлсэн үйлчилгээнийх нь төлөө хариуцлага хүлээлгэхийг эсэргүүцдэг²⁸⁸. Улс орнуудын болон олон улсын тоон эрхийн байгууллагуудын хамтын бүтээгдэхүүн болох Зуучлагчийн хариуцлагын Манилагийн зарчмуудыг²⁸⁹ мөн үүнд авч үзэж болно (гэхдээ энэ тайлангийн бусад хэсгүүдэд "олон улсын хамгийн сайн туршлага" гэж жишин тайлбарласан утгаар үүнийг энд дурдаагүй).

Худалдаа эхлэхээс өмнө аливаа хариуцлагын хязгаарласан тусгай заалтуудыг хэлцэл эсвэл арилжааны харилцааны эхэнд ил болгох нь зүйтэй. Ингэснээр арилжааны харилцаанд орох гэж буй талууд (дотоод, гадаадын аль аль нь) эрсдэлээ урьдчилж үнэлэх боломжтой болно. Ийм хариуцлагын мэдээллийг ил харуулдаг арга нь худалдааны веб сайтууд мөн "нэг цонх зэрэг төрөөс санхүүждэг байгууллагуудад нэн тохиромжтой. Заримдаа хариуцлагын хязгаарлалтыг гэрээгээр тогтоож болно.

Харин оролцогчид нь хувийн арилжааны үйл ажиллагаа эрхлэгчид (хоорондоо өрсөлддөг байж болно) байх тохиолдолд иргэний хариуцлагыг ногдуулж нийлэг журмаар хэрэгжүүлэхэд илүү хялбар.

Маргааны талууд иргэний шүүхэд хандах боломжтой тохиолдолд л худалдааны тогтолцоо нь сахилга баттай, хариуцлагатай үйл ажиллагаагаа явуулах боломжтой. Түүнчлэн, хариуцлагыг тодорхойлох, түүнд татах, ногдуулахад дээр хэлэлцсэн шүүхийн бус маргаан шийдвэрлэх арга хэрэгслүүдийг оновчтойгоор хэрэглэх боломжтой байх.

²⁸⁷ Харилцаа холбооны зохицуулах хороо, "түгээмэл асуултууд", www.crc.gov.mn/list/customer/mn?show=134

²⁸⁸ Дэлхийн сүлжээний санаачилга (GNI), *Intermediary Liability and Content Regulation* (Зуучлагчийн хариуцлага ба зохицуулалт), огноогүй: <https://globalnetworkinitiative.org/policy-issues/intermediary-liability-content-regulation/>

²⁸⁹ Зуучлагчийн хариуцлагын талаарх Манилагийн зарчим, 2015 он: <https://manilaprinciples.org/principles.html>

Жон Грегори, Анбатын Дэлгэрмаа

*Дотоод хэрэгцээнд. Энэхүү тайлан нь АХБ-ны удирдлага болон ажсилтнуудад нээлттэй.
Зохих зөвшөөрөлтэйгээр АХБ-аас гадуур өгч болно.*

VI. ХУУЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ

Сорилтын хариу арга хэмжээ – бодлогын динамик²⁹⁰

Цахим худалдааг өргөжүүлэхэд хувийн хэвшил, төрийн хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн эдийн засагт оруулах хувь нэмрийг дэнсэлж үзэхэд хоёр гол асуудал байдаг. Эхнийх нь хувийн хэвшлийнхэн цаашид шинэчлэл хийхгүйгээр цахим худалдаа хийх боломжтой эсэх. Хоёр дахь нь цахим худалдааны талууд хэр их бие даасан байдалтай байх вэ. Аль аль нь эрсдэл ба давуу талтай, энэ хоёр үндсэн асуултыг дор авч үзье.

(i) Хуулийн шинэчлэл шаардлагатай юу? Дэлхийн олон оронд дотоодын хууль нь өөрчлөгдөхөөс өмнө цахим худалдаа хөгжиж өхэлсэн. Энэхүү нь бизнес эрхлэгчид хоорондын гэрээ (худалдааны гэрээ) болон шинэлэг зүйл хийх боломжийг олгодог мөрдөж буй хуулиудын уян хатан байдалд тулгуурласан байжээ. Гэхдээ хуулийн дүрмийг өөрчлөхгүйгээр дан ганц хувийн гэрээгээр худалдааг зохицуулах нь хязгаартай байсан бөгөөд одоо ч бий. Гэрээний зохицуулалттай харьцуулахад хуулийн шинэчлэл нь илүү хэмнэлттэй бөгөөд ерөнхий хэрэглээтэй дэглэмийг тогтоодог. Монгол зэрэг Азийн зарим орнуудад цахим баримт бичиг, цахим гарын үсгийг зөвшөөрсөн хуулиуд батлагдах хүртэл хувийн санаачилгаар цахим худалдаа эрхлэх нь бага хандлагатай байжээ. Энэхүү судалгаа нь хэлцэл хийж буй талууд өөрсдөө тохиролцоогоор зохицуулах хүрээнээс давсан цаашдын шинэчлэлийн талаар авч үзэв. Энэ хэсэг нь одоо мөрдөгдөж буй хуулиас өхэлж, үүн дээр тулгуурлан дараах асуудлыг авч үзэх болно.

(ii) Хэр хэмжээний зохицуулалт, эсвэл бие даасан байдал байх ёстой вэ? Аливаа тогтолцоонд хэр зохицуулалт шаардлагатай гэдэг нь тухайн тогтолцоо нь хэр их эрсдэлийг үүрэхэд бэлэн байгаа вэ гэдгээс ихээхэн хамаардаг. Эдгээр эрсдэлийг турван том ангилалд хуваадаг:

а. Гүйлгээ хийж буй талуудын эрсдэл. Талууд шинэлэг асуудлаар зөв оновчтой шийдвэр гаргах чадвартай юу? Тэд “шатах” эрх чөлөөтэй байж болно, эсвэл төр тэднийг буруу сонголтоос “аврах” үүрэгтэй юу? Хэрэв сүүлийнх нь бол эрсдэлд хүргэж буй сонголтыг төр зохицуулах магадлал өндөр байна. Эсвэл төр нь “аврах” талууддаа сонголттойгоор хангаж болно, жишээ нь, аж ахуйн нэгжүүдийн оронд илүү хэрэглэгчдийг хамгаалах зэргээр талуудыг ялгаж болно.

б. Бусдад эрсдэл учруулах. Зохицуулалт багатай тогтолцоонд нь бизнесээс бизнест (B2B), эсвэл бизнесээс хэрэглэгчдэд (B2C) харилцаанд эрсдэлтэй, хүмүүсийг залилан, алдаанд өртүүлж болзошгүй. Зарим оронд хувийн харилцаанд илүү итгэдэг, үнэнч шударга ажиллана гэж үздэг бол бусад оронд эдийн засгийн үйл ажиллагаанд илүү өргөн хүрээний төрийн хяналттай байдаг.

в. Төрийн бодлогын эрсдэл. Улс орнуудын засгийн газар нь хэр их тодорхой бус байдлыг зөвшөөрч тэвчих, аж ахуйн нэгжүүд “шатах”-ыг хэр их

²⁹⁰ Энэхүү бичвэрт АХБ-ны “CAREC орнуудын цахим худалдаа: хууль ба бодлого” нийтлэлтэй ихээхэн нийцэж байгаа, 131-р тайлбарыг харах.

зөвшөөрөх, энэ нь эдийн засагт ямар зардал, сөрөг нөлөө үзүүлэх зэргээрээ харилцан адилгүй байдаг. Инновац нь ашиг тустай ч зардалтай.

(iii) Эрсдэлд тэсвэртэй байх нь талууд болон улс орнуудын хувьд харилцан адилгүй байдаг. Энэ бол техникийн асуудал биш, харин бодлогын чанартай асуудал юм, хуулийн шинэчлэл нь эрсдэлийн хүлцэх түвшнийг тусгасан эрсдэлийн удирдлагын нэг хэлбэр мөн. Хувийн бизнесийн харилцаан дахь төрийн зохицуулалтыг багасгахын тулд Монголд эрсдэлийг удирдах талаарх хувийн хэвшлийн чадавхыг дэмжих хэрэгтэй юм.

Хэрэв Цахим худалдааны тухай хууль боловсруулах бол татварын тухай, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай (дор хэлэлцэнэ), эрүүгийн (мөн дор хэлэлцэнэ) болон бусад холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлтийг хамтад нь боловсруулах шаардлагатай болно. Монголын 60 орчим хуульд ямар нэгэн байдлаар худалдааны салбартай холбоотой гэж энэхүү тайлангийн Монголын хамтран зохиогч үзэж байна. Хуулиудыг уялдуулах, нэмэлт өөрчлөлт оруулах ажилд хэд хэдэн яам, агентлагийг урьж оролцуулах шаардлагатай.

Монгол Улсад Иргэний хуулийн холбогдох зүйл заалтуудаас гадна нийтлэг хэрэглээний шинжтэй худалдааны хууль буюу арилжааны хууль боловсруулах ажил нэлээд хэдэн жил үргэлжилж байна. Ийм ерөнхий хэрэглээний хууль бий болчихвол ийм хуулийн нэг бүлэг болгож энд тайланд ярьж байгаа цахим худалдааны тухай хуулийг оруулах боломжтой, ингэхдээ тэрхүү хуулийг яаж боловсруулсанас шалтгаална.

Нэр томьёо

Монголд цахим харилцаа холбоо, тэр дундаа цахим худалдаанд хэрэглэж буй технологи, цахим бизнесийн хэлбэрүүдийн ихэнх нь өөр оронд бий болж, интернэтээр дамжин Монголд орж ирсэн. Технологитой зэрэгцэн үүнийг дурслэх үгсийн сан бий болсон. Цөөн хэдэн жишээ гэхэд: цахим, дижитал, цахим худалдаа, платформ, программ, кибер аюулгүй байдал, тоон гарын үсэг, цахим гарын үсэг зэрэг. Эдгээр болон бусад холбогдох нэр томьёоны утгыг тэр бүр гүнзгий ойлгодоггүй бөгөөд англи хэлээр нь ч, монгол хэлээр орчуулсан байдлаар нь ч хэрэглэхдээ тэрийн болгон үнэн зөв хэрэглэдэггүй байж болзошгүй.

Үүнээс болж технологийн хэрэглээг тайлбарлах, ялангуяа үүнтэй холбоотой хууль боловсруулахад зарим нэг зөрүүтэй, ойлгомжгүй нэр томьёоны асуудал гарч байгааг дээр дурдсан билээ. Бодит утга буюу үзэгдэл болон түүний нэр томьёо, үгийг талаар нэгдсэн зөв ойлголттой болох, холбогдох үгийг зөв туштай хэрэглэдэг болохын тулд хучин чармайлт гаргах шаардлагатай нь гарцаагүй. Монгол хэлний тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль хоёулаа энэ чиглэлд түлхэц болно.

Хэдийгээр энэ тайланд дээрх ажилд хэн оролцох, хэрхэн хамгийн зөвөөр хэрэгжүүлэх талаар ямар нэгэн зөвлөмж өгөөгүй ч ийм шаардлага байгаа нь тодорхой юм. Энэ ажлыг гүйцэт хэрэгжүүлэхгүй бол зорилтыг нь анхнаасаа буруу нэр томьёогоор илэрхийлсэн учраас зорьж төлөвлөснөөс өөр үр дагавартай байж болох хууль батлагдах эрсдэлтэй байдаг.

A. Хууль, эрх зүйн орчин

Одоогоор Монголд цахим худалдаа, цахим гарын үсэг, цахим засаглал, олон нийтийн мэдээллийн хүртээмж, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, хувийн нууцыг хамгаалах, кибер гэмт хэргийн асуудлыг тусгасан хууль тогтоомж бий. Цахим худалдааны тухай тусгайлсан хууль байхгүй, хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль нь удалгүй шинэчлэгдэнэ. Тэдгээр нь цахим худалдааны зарим харилцааг зохицуулж байгаа, харин тэдгээрийг нэгтгэж, цахим харилцааны тухай нэг цогц хууль болгох нь утгагүй юм.

Жон Грегори, Анбатын Дэлгэрмаа

Дотоод хэрэгцээнд. Энэхүү тайлан нь АХБ-ны удирдлага болон ажилтнуудад нээлттэй.
Зохих зөвшөөрөлтэйгөөр АХБ-аас гадуур өгч болно.

Мэдээж төрөл бүрийн хууль дүрмүүд нь өөр өөрийн үндсэн сэдэвтэй, тодорхой төрлийн харилцааг зохицуулдаг. Асуултынхаа хариултыг нэгэн "бүхнийг агуулсан" хуулиас олох нь илүү амар, тус тусдаа хууль дүрмээс олох нь илүү хэцүү. Үүнд хамгийн чухал асуулт бол нийцэл юм: эдгээр тус тусдаа хуулиуд нь хоорондоо зөрчилдэж байна уу, нийцээд хамтдаа харилцааг сайн зохицуулж чадаж байна уу?

Бодит амьдрал дээр хууль дүрмээ тууштай харилцан уялдаатай байлгаж иржээ. Нэг нь нэмэлт өөрчлөлт оруулахад түүнтэй холбоотой бусад нь нэгэн зэрэг нэмэлт өөрчлөлт оруулж ирсэн. Жишээлбэл, 2021 оны сүүлээр холбогдох дөрвөн хуульд нэгэн зэрэг нэмэлт өөрчлөлт оруулж, тэдгээр нь 2022 онд хамтдаа хүчин төгөлдөр болсон.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үед тухайн өөрчлөлтийн эдийн засгийн нөлөөнд өртөж болзошгүй бүх салбараас санал авах нь чухал. Төрийн болон хувийн хэвшлийн оролцоотой төсөл боловсруулах ажлын хэсгийг ажиллуулдаг. Тус бүрий хариуцлагыг нь тогтоож цэгцлэх нь хүндрэлтэй байж болох ч холбогдох бүх яамдыг татан оролцуулах хэрэгтэй. Сонирхлын бүлгүүдийг ширээнд урих хэрэгтэй. Ихэнх тохиолдолд санхүүгийн байгууллагууд хэлэлцүүлэгт оролцох шаардлагатай болдог, ялангуяа цахим төлбөрийг хөнгөвчлөх асуудлаар.

Цахим худалдааг зохицуулдаг одоогийн олон хууль тогтоомжийг нэгтгэх шаардлагагүй, харин тэдгээрийн аль нэгийг нь өөрчлөх үед бусдыг нь мөн уялдуулах замаар хуулийн шинэчлэлийг хэрэгжүүлэхийг **ЗӨВЛӨЖ БАЙНА**. Энэхүү хуулийн шинэчлэлийг боловсруулах ажлын хэсэгт санал болгож буй нэмэлт, өөрчлөлтөд голчлон өртөх буюу эрх ашиг нь хөндөгдөх төрийн болон хувийн хэвшлийн салбарын төлөөллүүдээс оролцуулах хэрэгтэй.

Дээр дурдсан хуулийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд дор дурдсан асуудлуудыг санаачлан хамруулах нь зүйтэй юм. Үүнд:

1. Цахим гүйлгээ, цахим худалдаа ба арилжааны платформ

Арилжааны зорилгоор ашиглаж буй цахим харилцаа холбооны хэрэглээний хэд хэдэн асуудлыг зохицуулахад чиглэсэн цахим худалдааны хуультай болох хэрэгтэй. Иргэний хуулиар сайн зохицуулсан байдаг энгийн арилжаа, хэлцлийн асуудлаас гадна шинэ хуулиар цахим худалдааны асуудлыг UNCITRAL-ийн Цахим худалдааны тухай загвар хуульд үндэслэн, шаардлагатай тохиолдолд Цахим гарын үсгийн тухай хуулийн зарим сэдвүүдийг багтаан зохицуулах нь зүйтэй. Үүнд НҮБ-ын Цахим харилцааны конвенцоор баталсан загварыг²⁹¹ дотоодын хэрэглээнд тохируулж хэрэглэх боломжтой юм. Мөн цахим арилжааны платформыг ажиллуулах үндсэн дүрмийг тогтоож, ийм платформ дээр "худалдах, худалдан авах гэрээ"-г нь хуульд чанд нийцүүлэн байршуулах ёстой. Эдгээр заалт нь шаардлагатай тохиолдолд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд заасантай холбоотойгоор, ижлээр зохицуулж болно.

2. Цахим гарын үсэг

Цахим гарын үсгийн тухай хуульд хэлцэл хийгч талууд хоорондоо ямар тохиолдолд тоон гарын үсгийн шаардлага хангаагүй цахим гарын үсгийг хэрэглэж болох, зөвшөөрөхийг тодорхой болгох ёстой. Үүнд аль түвшний баталгаажуулалт хэрэгтэй вэ? Өөр ямар хууль,

²⁹¹ Энэ зорилгоор түүнийг тохируулж зохицуулах асуудлыг энэхүү тайлангийн хавсралтад авч үзсэн болно

эрх зүйн баталгаа байж болох вэ? Технологийн хувьд аль нэг зүйлийг илүүд үзэхгүй төвийг сахих талаарх UNCITRAL зарчмууд нь наад захын тохиолдлуудад хэрэгжих ёстай.

E-Mongolia санаачилгын аюулгүйн баталгаажуулалтын арга нь одоогоор тохиромжтой мэт санагдаж байна. Уг санаачилгын ирээдүйд гарах асуултуудыг аль болохоор одооноос энэхүү тайланд заасан зарчмуудын дагуу шийдвэрлээд явах ёстай.

3. Хувийн мэдээллийг хамгаалах

Монгол Улсын иргэн, оршин суугчдын хувийн мэдээллийг Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадуур шилжүүлэх тухай хуулийн зохицуулалт нь түүнийг шилжүүлэн авч байгаа улс нь тухайн мэдээллийг адил эрх зүйн хамгаалалтаар хамгаалахыг баталгаажуулсан байх, энэ нь тухай улстай байгуулсан гэрээ, эсвэл тухайн орны дотоодын хууль тогтоомжоор хангасан хамгаалалт байж болно. Хувийн мэдээллийг эзэн нь ийнхүү шилжүүлэх зөвшөөрлийг өгөхдөө ийм ижил хамгаалалт байдаг, эсвэл байхгүйг мэдэж байх ёстай.

Нөгөөтээгүүр, Монгол Улсын оршин суугчидтай холбоотой хувийн (эсвэл арилжааны) мэдээллийг зөвхөн Монгол Улсад боловсруулж, хадгалахыг шаардах нь асуудалтай юм. Энэхүү "өгөгдлийг нутагшуулах" бодлого нь хил дамнасан ажиллагаатай аж ахуйн нэгжүүдэд үр ашиггүй байдлыг бий болгодог: ийм дүрмүүдтэй улс бүрд мэдээлэл боловсруулж хадгалах тусдаа байгууламжтай байх шаардлагатай болж байгаа юм. Аливаа ийм бодлогыг Монгол-Японы чөлөөт худалдааны хэлэлцээр шиг шууд хязгаарлах ёстай²⁹².

4. Мэдээллийг хамгаалах

Олон нийтэд угаасаа нээлттэй биш мэдээлэл (арилжааны, хувийн)-ийн нууцлалыг идэвхтэй хамгаалах үүднээс Монгол Улс хууль тогтоомжкоо илүү тодорхой болгох нь зүйтэй. Хувийн хэвшлийн нууц болон холбогдох арилжааны мэдээллийн одоо байгаа хуулийн хамгаалалтад тулгуурлаж дэлгэрүүлэх замаар хийж болно, эх сурвалжийг нь олоход илүү хэцүү байдаг. Ийм хууль тогтоомж нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулттай төстэй байж болно. Ийм хуулиар өмчлөгч илт зөвшөөрснөөс бусад тохиолдолд арилжааны болон бусад бизнесийн нууц мэдээллийг цуглуулах, ашиглах, задруулахыг хориглох ёстай.

5. Кибер гэмт хэрэг ба кибер аюулгүй байдал

Хууль хяналтын байгууллагууд нь илэрхий буюу залilan байхуйц сэжигтэй гэмт үйлдлийн дагуу мөнгө шилжүүлэхийг нэн даруй таслан зогсоох чадвартай байх хэрэгтэй, гэхдээ ийнхүү зогсоох алхмын үргэлжлэх хугацаа нь хатуу хязгаартай байх ёстай. Мөн тухайн залilanд зүй бусаар өртсөн хүнд шилжүүлгийг зогсоосноос болж хохирол учирсан бол залilангийн гэмт хэргийн эсрэг арга хэмжээ авч буй этгээд нь хохирлыг нь барагдуулах шаардлагатай байж магадгүй юм. Бүх оролцогч талын ашиг сонирхолд нийцсэн хамгаалалт, зохистой механизмыг бий болгох чиглэлээр холбогдох санхүүгийн байгууллагуудтай зөвлөлдөх нь зүйтэй.

6. Иргэний хариуцлага

Харилцаа холбооны зуучлагчийн хариуцлагыг үйлчлүүлэгчидтэй байгуулсан гэрээгээр хязгаарлахын зэрэгцээгээр дамжуулсан зүйлийнх нь улмаас учруулсан хохирлын хариуцлагыг хуулиар тодорхой болгох, ялангуяа хэрэглэгчийн үүсгэсэн агуулгатай

²⁹² 145 дахь тайлбар, мөн V.Д хэсэг, 233 дахь тайлбарыг харах

холбоотойгоор. Зуучлагчдын хариуцлагын талаарх Манилагийн зарчмууд ийм хуулийн удирдамж болж чадна.

Б. Засгийн газрын урт хугацааны төлөвлөгөө

Монгол Улсын Засгийн газар саяхан “ухаалаг төр” хөтөлбөрөө дуусгаж, 2027 он хүртэлх Цахим үндэстэн” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэ талаар дээрх I.3 дахь хэсэгт хэлэлцсэн билээ. Технологийн хэрэглээ нэмэгдэж байгаа учраас уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийг өөрчлөх замаар дэмжих шаардлага гарах эсэх нь одоогоор тодорхойгүй байна. “Цахим үндэстэн” хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг нь: Цахим дэд бүтэц, Цахим засаглал, Кибер аюулгүй байдал, Цахим бичиг үсгийн мэдлэг, Инновац ба үйлдвэрлэл, Үндэсний хөгжлийн хурдасгуур. Зөвхөн “цахим засаглал”, “кибер аюулгүй байдал” гэсэн хэсгүүдийг хэрэгжүүлэхэд хууль тогтоомж, дүрэм журмыг өөрчлөх шаардлагатай бөгөөд энэ талаар дээр ярьсан билээ. Хиймэл оюун ухааныг энэ хөтөлбөрт тодорхой хэмжээгээр ашиглаж байгаа бол үүний зохицуулалт бас хэрэгтэй болох биз ээ. Энэ салбарын хууль тогтоомж ба зохицуулалтыг технологийн хүчин чадлын хойноос гүйцэж шинэчлэх нь төвөгтэй байдаг. Дэд бүтэц, цахим боловсрол зэрэг бусад хүчин зүйлүүдийг төрөөс нэгэн адил дэмжих нь ач тустай байх ч үүнийг заавал хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай эсэх нь одоогоор тодорхойгүй байна.

В. Олон улсын асуудал

Хууль болон цахим худалдааны талаарх аливаа судалгаанд хөрш орон болон худалдааны түншүүдийнхээ хууль тогтоомжтой харилцан уялдуулах талаар байнга чухалчлан анхаардаг. Цахим худалдаа нь цахим харилцаа холбооны системээр дамжин хил дамнан хэрэгждэг бөгөөд хоёр талын хууль тогтоомж илүүтэй нийцэх тусам худалдаа нь хялбар байдаг. Энэхүү тайланд Монгол Улс нэгдэх боломжтой олон улсын хэлэлцээр, баримт бичгүүдийн талаар тайлбарласан болно.

Монгол Улс нь олон улсын нэлээдгүй тооны үндсэн хэлэлцээр, баримт бичигт аль хэдийн нэгдэн орсон буюу баталсан байдаг, тэр дундаа

а. Ази - Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай суурь хэлэлцээр. Суурь хэлэлцээр нь цаасгүй худалдааны хуулийн сайн нийтлэг стандартыг дэмжихээс гадна туршлага солилцох нөхцөлийг бурдүүлж, хэрэгжүүлэхэд санхүүгийн зарим тусламжийг санал болгодог.

б. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр – Монгол улс нь Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг зохих ёсоор, дэс дараатайгаар үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.

в. Олон улсын гэрээнд цахим харилцаа холбоог ашиглах тухай НҮБ-ын хэлэлцээр. Энэ нь UNCITRAL-ийн анх боловсруулсан Загвар хуульд заасан зохицуулалтыг олон улсын гэрээнд тааруулж стандартчилсан юм. Мөн гэрээнд хамаарах бусад олон улсын гэрээг жигд нийцүүлэн, ижил тайлбарлах боломжийг олгодог. Энэ хэлэлцээрийг цахим гүйлгээний тухай дотоодын хуулийн үндэс болгон ашиглах боломжтой, энэ талаар өмнө дурдсан буй.

Дараах хэлэлцээр, баримт бичгүүдийг Монгол Улсын зүгээс нэгдэн орох, батлахыг **ЗӨВЛӨЖ БАЙНА**, ингэхдээ эдгээрийг хүлээн зөвшөөрөх болон батлах ач холбогдол нь буурах дарааллаар тайлбарлав.

1. НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх, цахим бизнесийн төвийн “дотоодын нэгдсэн цонх”-ны талаарх зөвлөмж

Дотоодын нэгдсэн цонхыг бий болгох хууль батлахдаа НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх, цахим бизнесийн төв (CEFACT)-ийн стандартыг анхаарч үзэх хэрэгтэй, эдгээрийг олон улсын бизнесүүд хүлээж буй. Стандартууд нь зөвхөн зах зээлийн үндсэн оролцогчдын хоорондын харилцан уялдаатай хэд хэдэн гэрээнд үндэслэх биш заавал биелүүлэх шинжтэй байх ёстай.

2. UNCITRAL-ын Цахимаар шилжүүлэх боломжтой мэдээллийн тухай загвар хууль

Худалдаа эрхлэгчид ачаа тээврийг дагалдах бичиг, агуулахын баримт болон бусад зүйлийн цахим хувилбарыг хүлээн зөвшөөрч, хүлээн авахад бэлэн болсон тул загвар хуульд²⁹³ заасан найдвартай байдлын талаарх стандартыг Монголын хууль тогтоомжид хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Энэхүү загвар хуулийг дэлхийн улс орнууд дотооддоо харьцангуй удаан баталж байгаа юм. Худалдааны гол түншүүдээс ийм хуультай болох цаг хугацааны талаар зөвлөлдөж болно.

3. Олон улсын стандартын байгууллага

Монгол дахь технологийн үйл ажиллагаанд ISO 27000 багц стандартыг хэрхэн, хэзээ нэвтрүүлэх талаар мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй. Энэ стандарт бол олон улсын дэвшил юм.

4. Бүс нутгийн иж бүрэн эдийн засгийн түншлэл (RCEP)

Монголын худалдааны түншүүд Бүс нутгийн иж бүрэн эдийн засгийн түншлэл RCEP-д нэгдэж байгаа эсэхийг авч үзэх; хэрэв нэгдэж байгаа бол чөлөөт худалдааны давуу талыг эдлэх зорилгоор мөн нэгдэх. RCEP-ийн цахим худалдааны заалтууд нь Монгол Улсын одоогийн хууль тогтоомж болон өмнө дурдсан ESCAP Framework Agreement (Ази - Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссийн суурь хэлэлцээр)-ийн стандартуудтай үндсэндээ нийцэж байна.

5. UNCITRAL-ийн “Identity Management and Trust Services” (Онцлог шинжийг зохицуулах ба итгэлцлийн үйлчилгээний тухай) загвар хууль (2022)

Худалдааны гол түншүүдтэйгээ харилцахдаа Монгол Улсын хууль тогтоомж нь итгэлцлийн үйлчилгээний зохицуулалттай нийцэж байгаа эсэхийг авч үзэх.

²⁹³ 163 дахь тайлбар.

ДҮГНЭЛТ

Монгол Улс нь сүүлийн жилүүдэд цахим худалдаатай холбоотой хууль тогтоомжоо бүтээлч, оновчтойгоор шинэчилсэн байна. Монголын холбогдох хууль тогтоомжийн багцыг нь дотоодын хэрэгцээтэй нь, мөн худалдааны гол түншүүдийн хууль тогтоомжтой харьцуулж шинжлэхэд нэлээдгүй сайн байна.

Олон улс оронд цар тахлын болон түүний дараах үед цахим худалдааг дэмжих, иргэд, бизнес эрхлэгчид болон төрийн зохицуулагчид нь түүнд оролцох боломжтой байх чиглэлээр ижил төстэй бодлогыг баримталж байна.

Тиймээс уялдуулах нь нэн тэргүүний зорилт юм. Харилцааг уялдуулах үүрэг бүхий байгууллагууд албан болон албан бус харилцаа холбоогоо хөгжүүлэх нь чухал байна.

Энэхүү тайланд Монгол Улсын хууль тогтоомжийг олон улсын жишигтэй харьцуулан судалж, уялдуулах цаашдын боломжийг авч үзэв. Үнэлгээ нэлээд сайн байна, цахим баримт бичгийг илүү өргөн хүрээнд дэмжих чиглэлээр цөөн хэдэн алхам хийх шаардлагатай. Дотоодод болон хил дамнасан цаасгүй худалдаа явахгүй байгаа бол шалтгаан нь хууль тогтоомж, зохицуулалтын цоорхой, дутагдал биш, харин байгаа боломжийг ашиглах технологи, соёл, санхүүгийн эх үүсвэрийн дутагдалтай холбоотой байдаг.

Гэхдээ шинжээч бидний мэдэл, ажлын даалгавар хууль тогтоомж, зохицуулалтыг шинжлэх ажлаар хязгаарлагдаж байна. Бидний үзэж байгаагаар тайлангийн сүүлийн хэсэгт өгсөн зөвлөмжийг дагаж мөрдвөл Монгол Улс цахим эдийн засгийн мөрийн хөтөлбөрөө хөршүүд болон худалдааны түншүүдтэйгээ алхам алхмаар урагшлуулахад тустай. Хэрэгжүүлсний үр дүн нь бидний өөдрөг үзэл зөв байсныг нотолно гэдэгт итгэлтэй байна.

---oOo---

ХАВСРАЛТ

[“CAREC-н орнуудын цахим худалдааг хөгжүүлэх зохицуулалт”

тайлангаас]

Цахим харилцааны Конвенцыг дотоодын хууль болгон ашиглах

Жон Д.Грегори

2020 оны гуравдугаар сарын 22-ны өдөр

Цахим харилцааны Конвенцыг дотоодын хууль болгон ашиглах

Цахим харилцааны конвенц нь цахим худалдааг идэвхжүүлэх, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандарт текстийг бий болгох замаар дотоодын болон олон улсын эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог нэмэгдүүлэх зорилготой юм, ингэхдээ нэгдсэн бүх талуудыг заавал дагаж мөрдөх жишиг хууль болохгүй, харин дэлхийн улс орнууд өөртөө нийцүүлэн өөрчилж болно.

Энэхүү конвенц нь Цахим худалдааны тухай загвар хуульд суурилдаг (гэхдээ Цахим гарын үсгийн тухай загвар хуульд суурилдаггүй боловч түүнтэй нийцэж байгаа юм.) Энэ нь хуулийн зохицуулалтын хэрэглүүр гэхээсээ илүү дэмжих зорилготой загвар юм.

Цахим худалдааны тухай загвар хууль болон конвенц хоёр хоорондоо ялгаатай. Загвар хуулийн тухай дээрх хэсгүүдэд ярьсан билээ; зарим жилүүдэд хийсэн дүн шинжилгээнд үндэслэсэн сайжруулсан эсвэл боловсронгуй болгосон хэм хэмжээнүүд юм. Загвар хуулийг батлах, эсвэл дотооддоо зүгээр л шинэчлэн хэрэглэх сонирхолтой улс нь конвенцын хэллэг, заалтыг дагаж мөрдөх нь тустай.

Бусад ялгаа нь тухайн хоёр бичиг баримтын өөр өөр зорилгоос үүдэлтэй.

- Конвенц нь зөвхөн гэрээнд хамаарна, загвар хуультай адил эрх зүйн бусад салбарт хамаарахгүй.
- Конвенцын хамрах хүрээнд хувийн, гэр бүлийн болон ахуйн зориулалттай гэрээ, бусад хэрэглээний гэрээг (зөвхөн эдгээр биш) оруулаагүй²⁹⁴.
- Конвенцод хамрах хүрээнд ихэвчлэн өөрсдийн системийн дүрмээр зохицуулагддаг тодорхой зохицуулалттай санхүүгийн гүйлгээг оруулаагүй болно.

Конвенцыг сонирхож буй улсууд түүний дэглэмийг худалдааныхаа дотоодын буюу олон улсын харилцаанд хамруулж хэрэглэх эсэхээ шийдэх хэрэгтэй. Зарим орнууд үүнийг шийдвэрлэн тогтоосон. Хэрэв ийм орон нь Загвар хуулийг баталж дотоодын хууль болгон хэрэглэж байгаа (энэ нь одоогийн ердийн практик юм²⁹⁵) бол тухайн хуулийг конвенцод нийцүүлэн өөрчлөх шаардлагатай. Хэрэв загвар хуулийг батлан хэрэглэдэггүй бол

²⁹⁴ http://www.uncitral.org/pdf/english/texts/electcom/06-57452_Ebook.pdf para 74

Цахим харилцаа холбооны конвенц, НҮБ-ын UNCITRAL-ын нарийн бичгийн дарга нарын газрын тайлбар

²⁹⁵ Жишээлбэл, Сингапур, Шри Ланкаад энэ ажлыг эхлүүлсэн, Австралиид бүх муҗид нь энэ ажил хараахан дуусгаагүй байна.

конвенцод хамаарахгүй зарим заалтыг нөхөж тухайн хуулийн холбогдох заалтуудыг батлах шаардлагатай болно.

Зарим орнууд конвенцод нэгдэн орохгүйгээр зөвхөн ерөнхий зориулалттай цахим худалдааны хууль болгон ашиглаж байна. Тухайн орны дотоодын хуулийг олон улсын зохицуулалтад ашиглаж байгаа бол конвенц нь ашигтай, учир нь дотоодын хууль тогтоомж нь конвенцод нийцтэй, эсвэл гэрээний нөгөө тал нь уг конвенцын гишүүн улс бол тухайн Конвенцыг хэрэглэхээр заасан байдаг.

Конвенцыг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй улс нь загвар хуулийг аль хэдийн мөрдөж байгаа гэсэн төлөв дээр үндэслэж доорх дүн шинжилгээг боловсруулав. Хэрэв загвар хуулийг батлахаар төлөвлөж байгаа бол доорх дүн шинжилгээний ихэнх нь нэгэн адил хамаарна.

Зарим оронд цахим харилцаа холбоог өөрийн системдээ хуулийн хүчинтэй ашиглаж болно гэж заагаагүй байдаг. Харин үүнийг заасан орнууд түүнийгээ өөр өөр үг хэлээр илэрхийлсэн эсвэл өөр ойлголтоор хэрэглэдэг байж болно. Хил дамнасан гэрээ байгуулахдаа аль нэг орны дотоод хуулийн дагуу байгуулна гэдэгтэй талууд төдийлөн санал нийлэхгүй. Тиймээс олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарттай байх нь давуу талтай юм.

ЯАГААД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Энэхүү Конвенцыг баталсан гол шалтгаан нь олон улсын гэрээнд цахим харилцаа холбоог ашиглах талаар дэлхий нийтийн тогтвортой дүрэм бий болгоход оршино. (Конвенцыг гарын үсэг зурахад нээлттэй байхад нь гарын үсэг зурсан улс орнууд соёрхон баталж болно; бусад нь нэгдэн орж болно. Хууль, эрх зүйн үр дагавар нь адилхан; иймээс "батлах" гэсэн үг нь энэ хоёр үйл явцыг хамарна.) Загвар хуультай хэлэлцээрт нэгдсэн оронд дотоод Цахим худалдааны тухай хууль ч юм уу, эсвэл конвенцын дүрмийг тусад нь батлан гаргах шаардлагагүй, өөрийн хууль тогтоомжийг үндэслэн хэлэлцээр хийх, гэрээ байгуулах, гүйцэтгэхэд цахим харилцаа холбоог ашиглах бүрэн боломжтой. Үүний нэгэн адил, худалдааны томоохон түншүүдийн хууль тогтоомж нь цахим харилцаа холбоог зохицуулсан байх ч үргэлж ижил нөхцөлтэй байдаггүй.

Нэгөөтээгүүр олон орнууд цахим харилцаа холбоог өөрийн хуулийн тогтолцоонд чөлөөтэй ашиглах боломжтой гэж заагаагүй, харин ингэж тодорхойлсон улсууд өөр өөр заалт, үг хэлээр эсвэл өөр ойлголтоор бичсэн байдаг учраас гэрээ байгуулж буй өөр өөр орны талууд өөрийн дотоодын хууль хэрхэн үйлчлэх талаар санал нийлэхгүй тохиолдол гардаг. Тиймээс олон улсад хүлээн зөвшөөрсөн нэгдмэл журам, стандарттай байх нь давуу тал болно.

Цахим худалдааны хуультай, ялангуяа ийм хуулиуд нь НҮБ-ын Цахим худалдааны тухай загвар хуулиас санаа авсан улс орнууд конвенцод нэгдэн орох нь утга учиртай. Ингэснээр тэд өөрсдийн туршлагадаа үндэслэн конвенцын дүрмийг хүлээн зөвшөөрч буйгаа олон улсад тунхаглах юм.

Конвенцын дүрэм нь олон улсын гэрээ байгуулах эрх зүйн хэрэгсэлд хамаарна. Түүний дүрмийг дотооддоо нэгэн зэрэг батлах эсэх нь тусдаа асуудал болно. Конвенцын дүрмүүд тийм ч тохиромжтой биш, шаардлагагүй гэж үзэх хүмүүс бий, тэд дотооддоо эсэргүүцэж болно. Гэхдээ энэ үзэл бодол нь конвенцын дүрмийг олон улсад хэрэглэхэд саад болох ёсгүй. Олон улсын гэрээнд хамаарах дотоодын хууль нь олон улсын практикт сайн нийцнэ

гэсэн баталгаа байхгүй. Ийм тодорхой бус тохиолдолд уг Конвенцыг дотооддоо хэрэглэх нь илүү дээр гэж үздэг.

КОНВЕНЦЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Нэг ёсондоо талууд нь өөр өөр улс оронд байгаа гэрээнд тухайн конвенц хамаарна. Ийм нөхцөлд Конвенцыг яаж хэрэглэх вэ? Эдгээр хоёр талын харилцаанд Конвенцыг хэрэглэж болно, учир нь энэ конвенц нь хоёр талын аль ч улсад хэрэглэхээр хууль болчихсон, эсвэл аль нэг талын улсад ийм байдлаар дотоодын хууль болчихсон бөгөөд гэрээний талууд өөрсдийн сонголтоор түүнийг хэрэглэхээр тохиролцож болно.

Яг үүнийг конвенцын 19-р зүйлийн 1-д заасан байdag: “тэрээлэгч талууд нь зөвхөн хоёр талын улсууд уг хэлэлцээрийн гишүүн байх тохиолдолд түүнийг хэрэглэнэ гэж зааж болно, эсвэл талууд сонголтоороо Конвенцыг хэрэглэнэ гэж тохиролцсон бол хэрэглэнэ” гэжээ.

3-р зүйлд талууд конвенцоос татгалзахыг зөвшөөрдөг тул хэрэв тэд үүнийг хэрэглэхийг хүсэхгүй бол түүнээс гарах боломжтой. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Борлуулалтын Конвенцыг хэрэгжүүлэхэд яг ийм дүрэмтэй. Энэхүү конвенцод нэгэнтээ нэгдэн орсон улсууд уг Конвенцыг хэрэглэхэд бэрхшээлтэй тулгарсан эсэх, хэрхэхэ шийдэж болно. Хэлэлцээрт оролцогч талууд түүний хэрэглээг хязгаарлах боломжтой байх нь харин ч улс орнууд конвенцоос татгалзах нь багасна, эсвэл хамрах хүрээг нь хязгаарлах магадлал буурна гэж үздэг.

Энэхүү конвенц нь гэрээ байгуулахад технологийг ашиглахад тустай. Олон улсын худалдааг хязгаарлах арга замыг эрэлхийлэхээс илүү өргөн хүрээтэй ашиглахыг дэмжих нь ашиг тустай гэж үздэг.

БУСАД КОНВЕНЦОД ХАМААРАХ НЬ

Энэхүү конвенц нь олон улсын гэрээний харилцааг зохицуулж буй бөгөөд тэрхүү гэрээ нь талуудын аль нэг улсын нийтлэг хуульд захирагдана. Мөн бусад конвенцоор зохицуулсан олон улсын гэрээний харилцааг журамласан. 20-р зүйлд НҮБ-ын зургаан Конвенцыг дараах төрлүүдэд хуваажээ: Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай Нью Иоркийн конвенц²⁹⁶, НҮБ-ын борлуулалтын конвенц²⁹⁷, Хөөн хэлэлцэх хугацааны тухай конвенц²⁹⁸, Тээврийн терминалуудын үйл ажиллагааны хариуцлага²⁹⁹, бие даасан зээлийн баталгаа болон бэлэн аккредитив³⁰⁰, авлагын эрх шилжүүлэх³⁰¹.

Эдгээр конвенцыг Цахим харилцааны конвенцтой уялдуулан ашиглахын тулд тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах гэсэн үг биш, тэр бүгдийг шинэчлэн өөрчлөх нь цаг шаардсан төвөгтэй ажил болно. “Гэрээнд цахим харилцааг уялдуулан ашиглавал тус гэрээг Цахим

²⁹⁶ Гадаадын Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц (Нью-Йорк, 1958 оны 6-р сарын 10)

²⁹⁷ Олон улсын бараа худалдааг гэрээний тухай НҮБ-ын конвенц (Вена, 1980 оны 4-р сарын 11)

²⁹⁸ Олон улсын бараа худалдааны хөөн хэлэлцэх хугацааны тухай конвенц (Нью-Йорк, 1974 оны 6-р сарын 14) ба Протокол (Вен, 1980 оны 4-р сарын 11)

²⁹⁹ Олон улсын худалдааны тээврийн терминалын хариуцлагын тухай НҮБ-ын конвенц (Вена, 1991 оны 4-р сарын 19)

³⁰⁰ НҮБ-ын бие даасан баталгаа ба бэлэн аккредитивийн тухай конвенц (Нью-Йорк, 1995 оны 12-р сарын 11)

³⁰¹ Олон улсын худалдаанд авлага шилжүүлэх тухай НҮБ-ын конвенц (Нью-Йорк, 2001 оны 12-р сарын 12)

харилцааны конвенцоор зохицуулж байна гэж үзнэ" гэсэн байдаг. Ингэснээр цахим харилцааны хууль, эрх зүйн хувьд хүчин төгөлдөр болох юм. НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (UNCITRAL)-ын үзэж буйгаар тухайн Конвенцыг хүлээн зөвшөөрсөн орнууд цахим харилцааг тус конвенцын дагуу зохицуулснаар аливаа эрсдэл гарах магадлал бага гэжээ.

Энэхүү конвенц нь хүчин төгөлдөр болсон үедээ НҮБ-ын гэрээнд хамрагдсан эсэхээс үл хамааран конвенцод нэгдсэн эсвэл дараа нь нэгдэн орсон бусад олон улсын конвенцоор зохицуулагддаг олон улсын гэрээнд ижил төстэй байдлаар үйлчилнэ (20-р зүйлийн 2 дахь хэсэг)

Түүнчлэн хэлэлцэгч орнууд энэхүү конвенцын заалтуудыг зөвшөөрөх, эсвэл татгалзах замаар бусад конвенцтой нийцүүлж болно. Үүний үр дүнд хэлэлцэгч орнууд бусад конвенцод өөрөөр заагаагүй бол тус конвенцын дагуу ажиллах боломжтой. Өөрөөр тусгасан заалт гэдэгт дээр жагсаасан зургаан конвенц болон нэрлэгдээгүй бусад конвенцуудыг хамруулахгүй байж болно. Товчхон тайлбарлахад, гэрээлэгч орнууд нь өөр ямар ч конвенцыг сонгосон бай цахим орчинд гэрээ байгуулах, гүйцэтгэхтэй холбоотой харилцаа холбоог зохицуулахад тус Конвенцын хүрээнд ажиллах үүрэг хүлээнэ.

Аливаа улс орон уг конвенцод нэгдсэн бол бусад олон улсын гэрээ хэлэлцээр, бусад конвенц нь үүнтэй нийцэж буй эсэхийг нягтлах шаардлагатай юу? Эсвэл ямар ч заалтыг нь хасахгүйгээр элсэн орох боломжоо ашиглах уу? Цахим харилцааны конвенц нь хэлэлцэн тохирогч улсууд ямар ч үед шинэчилж өөрчлөх хийх боломжийг олгодог учраас ирээдүйд конвенцтой холбоотой ямар нэг асуудал үүсвэл тухайн үеийн конвенцоор зохицуулагдсан гэрээнээс чөлөөлөгдөх боломжтой. 2009 онд Сингапур улс дараах гурван шалтгааны улмаас тус Конвенцыг бусад бүх конвенцтой нийцэж байгаа эсэхийг нягтлах шаардлагагүй гэсэн дүгнэлт гаргажээ³⁰²:

А. бусад конвенцуудад нийцэж байхын сацуу Сингапурын хуулиар зохицуулагдаж байна гэж үзэхүйц гэрээнд дотоодын цахим худалдааны хууль угаасаа хамаарна

Б. Конвенцын 19-р зүйлийн 2-ийг ашигласнаар цахим худалдааны харилцаанд үүсэж болох асуудлуудыг тусгасан заалтыг дотоодын хууль тогтоомж болон конвенцоос хасаж болно. Доорх хэлэлцүүлгийг харна уу.

В. Тус Конвенцыг бусад конвенцод нийцүүлье гэх нь төдийлөн үр дүнгүй. Энэ нь зөвхөн бусад конвенцод хамаарах цахим харилцаа холбооны гэрээ, түүний хэрэгжилтийн ижил тэгш байдлыг л хангана. Харин тэдгээр конвенцоор зохицуулсан дотоодын эрх зүйн үндэслэлд нөлөөлөхгүй.

Конвенцод нэгдэн орсон улстай цахим харилцаа холбоо тогтоох бол Цахим харилцааны конвенцын дагуу гэрээ хийх нь талуудад илүү дөхөм байх болно. Тус Конвенцыг бусад конвенцод уялдуулан ашиглах нь харилцаанд ямар нэг эрсдэл гарахаас сэргийлэх болно.

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНД БОЛОН ДОТООДОД ХЭРЭГЛЭХ

³⁰² Сингапур (Мэдээллийн харилцаа холбооны хөгжлийн газар ба Ерөнхий прокурорын танхим), IDA-AGC-н хамтран боловсруулсан "Цахим гүйлгээний тухай хуулийн 2009 оны нэмэлт өөрчлөлтийг хянан үзэх нь" тайлан, LRRD No.1/2009, догол. 2.10.6 дахь заалт, http://app.agc2.agc.gov.sg/DATA/0/Docs/PublicationFiles/ETAResult_LRRD1of2009.pdf дээрээс авах боломжтой.

UNCITRAL-н бүрэн эрх нь олон улсын худалдааны эрх зүй учраас Конвенцыг олон улсын гэрээнд хэрэглэхээр боловсруулсан болно. Гэхдээ гэрээлэгч оронд яг тухайн харилцааг зохицуулсан хууль тогтоомж байхгүй тохиолдолд конвенцын заалтыг дотоодын хууль болгон ажиллаж болохоор боловсруулсан.

Тухайн улсад энэ чиглэлийн сайн хуультай, тухайлбал Цахим худалдааны тухай загвар хуулийг дотооддоо хэрэглэдэг бол яах ёстай вэ? Олон улсын гэрээний харилцаанд нэг хууль, дотоодын гэрээний харилцаанд нөгөөхөө хэрэглэдэг “давхар тогтолцоотой” байх ёстай юу? Эсвэл бүгдэд ижил хуулийг хэрэглэхийн тулд дотоодын хуулиа олон улсын дүрэмд нийцүүлэх үү?

Угтаа бол конвенцын зарим нэр томьёо нь Загвар хуульд тодорхойлсон нэр томьёоноос арай өөр гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Конвенцод нэгдэн орсон болох нь түүний нөхцөлийг бичигдсэн байдлаар хэрэглэх ёстай; хэрэглэж буй улс нь тэдгээрийг өөрчлөх эрхгүй. Хэрэв нэгэн улс нь конвенцын аль нэг, уг хэллэгийг эсэргүүцэж байгаа бол түүнийг дотоодын хууль тогтоомждоо тусгаж хэрэгжүүлэх ёсгүй.

Нэг хуультай болохыг дэмжсэн санаа (жишээ нь, конвенцод нийцүүлэн дотоодын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах)

- Энэхүү конвенц нь Цахим худалдааны тухай загвар хуультай үндсэн агуулгаараа бараг адилхан тул түүний заалтууд нь нэгдэн орсон улсад практикт хэрэглэгдэх боломжтой, туршиж үзсэн.
- Конвенцын дүрмүүд шинэ байх хэрээрээ Загвар хуулиас илүү сайн байна.
- Нөгөө тал хаана байгаагаас шалтгаалаад янз бүрийн журамтай байгаад талууд гайхах ёсгүй. Энэ нь гадаадын талуудыг татах цахим гүйлгээнд онцгой ач холбогдолтой юм (хэдийгээр талууд өөр улс оронд байгаагаа мэдэж байгаа эсвэл мэдэх ёстай тохиолдолд конвенц үйлчилнэ – 1(2) зүйл).
- Конвенц болон дотоодын хууль тогтоомжийг уялдуулах нь зүйтэй, ингэснээр ижил төстэй гүйлгээнд хоёр өөр багц журамтай байхаас зайлсхийнэ гэж үздэг.

Давхар дэглэмтэй байхыг дэмжсэн санаа (жишээлбэл, олон улсын гэрээний конвенц, дотоодын гэрээний загвар хууль)

- Дотоодын хуулийн хэм хэмжээний хүрээнд ажиллаад тогтсон, өөрчлөлт хийхийг хүсдэггүй, өөрийн гэсэн ашиг сонирхолтой бизнес эрхлэгчид байж болно.
- Конвенцын эрх зүйн үр нөлөө нь Загвар хуулийнхтай бараг адилхан тул конвенцод олон улсын дэглэмийн хүлээн зөвшөөрөх гэж ажил удах нь ач холбогдол бага.
- Талууд уг нь бол конвенцын бүх хэм хэмжээнээс юм уу аль нэг хэсгээс нь татгалзаж болно, жишээ нь өөр гэрээний төсөл боловсруулах гэх мэт үйлдлээрээ. Тэд өөр хувилбар дээр тохиролцож болно, ямар ч тохиолдолд хязгаараар баригдахгүй. Угтаа ч конвенц нь өөрөө заавал дагаж мөрдөх шинжтэй биш: хэрэв талууд үүнийг дагаж мөрдөхөөр шийдсэн бол цахим харилцаа холбоог тухайн хэм хэмжээгээр зохицуулна гэж заасан байдаг. Энэ нь цахим харилцаа холбоог сонгохоор шийдсэний дараа түүний зарим дүрмийг заавал дагаж мөрдөх ёстай, гэхдээ заавал цахим хэлбэрээр мэдээллийг ашиглах, хүлээн авахыг шаарддаггүй.

Практик дээр бол конвенцод нэгдэн орсон зарим улс нь дотоодын хууль тогтоомжоо түүнд нийцүүлсэн байхад зарим нь тийм нийцүүлэх арга хэмжээг аваагүй байна. Загвар хуулийг конвенцтой зэрэгцүүлэн хэрэгжүүлсэн нь цөөн.

ҮЛ ХАМААРАХ ЗҮЙЛ, ЗӨВШӨӨРӨЛ АВАХ

А. Конвенц болон дотоодын хууль тогтоомжоос хассан харилцаг нэгэн адил уялдуулах

Энэхүү конвенцын хамрах хүрээнээс хэрэглээний гэрээ (хувийн, гэр бүлийн болон ахуйн зориулалттай гэрээ), "зохицуулалттай хөрөнгийн биржийн" гүйлгээг (цахим харилцаанд оролцох хууль ёсны эрхээ өмнө нь авсан байсан байгууллагуудын хоорондын санхүүгийн нарийн гүйлгээг), мөн солилцооны бичиг, вексель болон бусад шилжүүлж болох эрхийн бичгийн харилцааг хасдаг.

Улс орнууд ямарч гүйлгээ, баримт бичгийн жагсаалтыг гаргаж тухайн конвенцын хамрах хүрээнд оруулахгүй байхыг зөвшөөрдөг. Конвенцод нэгдэн орохоор төлөвлөж буй улс орон бүр жагсаалтаа конвенцын жагсаалттай харьцуулах ёстой. Зарим хасалт нь олон улсын хэмжээнд биш харин дотоодод тохиромжтой байж болох. Харин зарим асуудлыг хасах нь тухайн орны хувьд аль аль түвшинд хэрэгтэй байж магадгүй.

Конвенцын 19-р зүйлийн 2-ыг ашигласнаар гишүүн улс нь олон улсын болон дотоодын гүйлгээнийхээ хувьд дотоодын хуулийн хүрээнд аливаа үл хамаарах зүйлийг тухайн конвенцын хэрэгжүүлэхэд үл хамаарах зүйл болгож болно, учир нь ингэх нь зарчмын хувьд зөв гэж үзэж байгаа тул, эсвэл дотоодын болон олон улсын хуулийн хэм хэмжээг нийцүүлэхийн тулд.

Харин дотоодын хуулийн хүрээнээс хасаагүй боловч конвенцод үл хамаарах асуудлуудыг тухайн орон нь конвенцод нийцүүлэх ёстой. Үүнийг дэлхий даяар уялдсан хэм хэмжээг тогтоох маягаар шийдвэрлэдэг бөгөөд жишээлбэл дотоодын хуулийн заалт, олон улсын хэлэлцээрт зааснаас өөрөөр заасан бол Конвенцыг хэрэгжүүлэх зарчмыг дотоодын хуульд заан мөрддөг.

В. Зөвшөөрлийг дотоодын хуульд болон конвенцод нийцүүлэх

Дотоодын хууль тогтоомж нь конвенцоос илүү цахим харилцаанд нээлттэй байхад яах ёстой вэ гэдэг нь ээдрээтэй асуудал байж болно. Илүү нээлттэй байхын хэд хэдэн жишээ бий:

- Загвар хууль нь хэрэглээний гэрээнд хамаарна (хэдийгээр үүнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах тусгай хэм хэмжээ үйлчилдэг ч), харин Конвенцын хамрах хүрээнд ийм гэрээг оруулаагүй.
- Цахим гарын үсгийн хүчинтэй байдлын талаарх дотоодын хэм хэмжээ нь конвенц эсвэл загвар хуулиас илүү өргөн хүрээтэй байж болно.
- Цахим мессеж илгээх хугацааг загвар хуульд мессеж илгээгчийн хяналтаас гадуурх системд хүлээн авснаас хойш хэмждэг бол конвенцод мессеж илгээгчийн хяналтад байгаа системээс гарах үеэс эхлэн хэмждэг болсон. Энэ нь ямар ч ялгаагүй мэт байж болно. Загвар хуульд өөр системд нэвтрэх цагийг сонгосон шалтгаан нь системийн бүртгэлд мессеж орж ирсэн цагийг бүртгэдэг, харин гарах цагийг биш гэж үздэг байсан. Энэ ялгааг голцуу нотлох баримтын зориулалтаар л авч үздэг, бодит цаг хугацааны

хувьд мэдэгдэхүйц ялгаа огт биш юм³⁰³. Нөгөөтээгүүр, энэ асуудал нь эрсдэлийн хуваарилалттай холбоотой байж болно: мессеж нэг системээс гарсан эсвэл нөгөө систем рүү орох үед хэн нотлох ёстой буюу нотлох нь дээр вэ?

- Цахим мессежийг хүлээн авах хугацааг Загварын хуульд тухайн мессежийг хаяг хүлээн авагчийн зориулалтын буюу ашигласан мэдээллийн системд нэвтэрч, татаж авах боломжтой үеэс хэмждэг. Харин конвенцод мессежийг хүлээн авагчийн заасан цахим хаягаар авах боломжтой гэж заасан байдаг. Энэ ганц нэг өөр үг хэллэгийн асуудал мөн бөгөөд өөр үг дагавартай байх магадлал маш бага.

Гэрээлэгч орнууд нь олон улсын гэрээ, хэлэлцээрийг оролцохдоо цахим харилцаа, холбоог конвенцод хүлээн зөвшөөрөгдсөн хэм, хэмжээнээс өргөн хүрээнд ашиглаж болох уу? Гэрээлэгч талууд Конвенцыг өргөн хүрээнд ашиглаж болох ч харилцаа, холбооны үндсэн зарчмыг алдагдуулахгүйгээр ашиглах хэрэгтэй байдаг.³⁰⁴

Олон улсын гэрээнд оролцогч талууд конвенцын стандартад нийцэхгүй цахим гарын үсэг зурж, эсвэл нэг талын алдаанаас болж гэрээгээ хүчингүйд тооцох, эсвэл конвенцын зөвшөөрөсөн, нээлттэй үлдээсэн хэм хэмжээг ашиглахын оронд хязгаарлалтын хэм хэмжээнд найдна гэдэг нь эргэлзээтэй. Гэхдээ талууд Конвенцоос бүрэн буюу хэсэгчлэн татгалзах эрхтэй тул хэрэв тэд үүнийг илүүд үзэж хассан хэм хэмжээг, өөрөөр хэлбэл конвенцод заасан буй хязгаарлалтыг, буцаан "сэргээгээд" даган мөрдөх боломжтой.

Хэлэлцэн тохирогч улсууд конвенцын заалт, хамрах хүрээг өөрчлөх эрхгүй, тэгвэл конвенц нь дотоодын хуулийг хэр хэмжээгээр "халж" болох вэ? Конвенцод зааснаар бол дээр тайлбарласан цахим гарын үсгийн жишээ шиг ижил дүрмийг баримтална. Гэхдээ конвенц огт хэрэгжихгүй асуудлаар бол дотоодын холбогдох хууль тогтоомж нь түүнийг нөхнө. Энэ нь жишээлбэл иргэний хариуцлага эсвэл гэрээний бодит хүчинтэй байдал зэрэг асуудлуудын ердийн хэм хэмжээнүүд юм; Конвенцод ийм асуудлыг дотоодын хууль тогтоомжоор зохицуулна гэж заасан байдаг.

Энэхүү конвенц нь хэрэглээний гүйлгээнд хамаarahгүй. Тэгвэл олон улсын гэрээнд ийм төрлийн хэлцлийг зохицуулсан дотоодын хууль үйлчлэх үү? Эдгээр гэрээний талууд олон улсын хэрэглэгчийн гэрээг хэн нэгний дотоодын хууль тогтоомжоор зохицуулах ёстой юм байна гэдгийг олж мэдвэл гайхах ёсгүй. Конвенцын хамрах хүрээнээс хэрэглээний гүйлгээг хассан нь зөвхөн UNCITRAL-ийн бүрэн эрхэд хамаарах хязгаарлалт гэж үзэх ёстой. Хэлэлцэн тохирогч улсын цахим харилцааны тухай өрөнхий хууль тэдгээр харилцаанд үйлчилдэг, иймээс талууд тухайн хуульд, тухайлбал, холбогдох хуулийн нэг хэсэг болох хэрэглэгчийн эрхийг хамгаалах заалтуудад найдаж болно.

³⁰³ Энэ асуудлаар Австралийн Мэдээллийн салбарын нийгэмлэг: илгээгч нь "програм хангамжийг үйлчилгээ болгон" эсвэл үүлэн тооцоолол ашиглаж байгаа ч өөрийн ашиглаж буй системээ техникийн хувьд хэзээ ч хянаж чадахгүй байх үед илгээгчийн системийн хяналтаас хамааран тестийг хэрхэн хэрэгжүүлэх (угтаа тодорхойлолтоороо өөр этгээдийн систем учраас) талаар гайхаж байв. Холбооноос Хелен Даниэлст илгээсэн захидал (2009 оны 1-р сарын 28):

<http://www.ag.gov.au/Documents/Submission%20from%20the%20Australian%20Information%20Industry%20Association.PDF> "Хяналтад" хамаарах систем гэдэгт илгээгчийн зааврыг заавал дагаж мөрдөх гэрээний үүрэгтэй системийг багтаасан гэж ойлгож болно

³⁰⁴ Цахим харилцаа холбооны конвенцын тайлбар тэмдэглэл, 19-р тэмдэглэл болон 14, 85, 86, 137-р догол мөрийг харна уу